

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ ДЭХ НИЙГЭМ БА ЖЕНДЭРИЙН СУДАЛГАА

Ази Тив-Суралцах Судалгаа ба Сургамж

Хянан эмхтгэсэн Ронный Верной



БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ ДЭХ НИЙГЭМ БА ЖЕНДЭРИЙН СУДАЛГАА

Канад улсын Олон Улсын Хөгжлийн
Судалгааны Төвтэй хамтран хэвлүүлэв

Номын тухайд

«Байгалийн нөөцийн менежмент дэх нийгэм, жендэрийн дүн шинжилгээ» ном нь байгалийн нөөцийн менежментэнд нийгэм болон жендэрийн асуудал ямар байдлаар тусаж байгааг улс орнуудын¹ ялгаатай жишээн дээр тайлбарлан харуулсан энгийн, ойлгомжтой ном юм. Энэхүү асуудлыг судлахдаа нутгийн иргэд, олон нийт болон бэлчээр, байгалийн нөөцийн менежментийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг хамруулсан оролцооны аргад тулгуурласан байна.

Мөн Азийн улс орнуудын соёл, уламжлал, зан заншлын өвөрмөц байдлаас хамааран тухайн нийгэм дэх жендэрийн талаарх ойлголт, эмэгтэйчүүдийн статус, нийгэмд эзлэх байр суурь, цаашлаад байгалийн нөөцийг хүртэх, хэрэглэх, холбогдох шийдвэр гаргах бүх үйл ажиллагаанд жендэрийн асуудал өвөрмөц байдлаар хөндөгдөж байгааг харуулсан байна.

Х.Ыханбай

¹ Канадын Олон улсын хөгжлийн судалгааны төвийн төсөл хэрэгжиж байгаа улс орнууд

Байгалийн Нөөцийн Менежмент дэх Нийгэм ба Жендэрийн Судалгаа

Ази Тив - Суралцах Судалгаа ба Сургамж

Хянан эмхтгэсэн:
РОННЫЙ ВЕРНОЙ



Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, Амарын гудамж-2
Admon компани

DDC
333.9516'517
Б-175

© Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төв. 2006 он

Бүх эрх зохиогчийн эрхээр хамгаалагдсан болно. Энэхүү номны аль ч хэсгийг зохиогчоос албан ёсны зөвшөөрөл авахгүйгээр хуулбарлах, ямар ч хэлбэрээр ашиглахыг хориглоно. Үүнд, электрон болон цаасан дахь фото зургийн хуулбар, хальсанд бичих мөн мэдээллийн аль ч хадгалалтын болон сэргээн засварлах хэлбэр орно.

Энэхүү нийтлэлийн газрын зургууд дээр гарч буй нэрс болон нутаг дэвсгэр нь Канад улсын Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төвөөр дамжуулан ямар нэгэн албан ёсны баталгаа болон сайшаал, зөвшөөрлийг агуулаагүй болно.

Энэхүү номын анхны эх нь Англи хэл дээр 2005 онд Канад улсын Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төв (ОУХСТ), Sage India болон China Agricultural Хэвлэх компаниар хэвлүүлсэн ба мөн www.idgc.ca гэх цахим хуудаснаас үзэх боломжтой юм. Тус номны Монгол орчуулгыг ОУХСТ-өөс итгэмжлэн эрх олгосноор [орчуулагчид **З.Бархас, С.Одмаа, Н.Мөнхтуяа нар**] хийж гүйцэтгэсэн болно.

(Ном хэвлэх тухай ОУХСТ ба Admon ХХК-ийн хооронд байгуулсан гэрээнээс)

Номыг монгол хэл дээр
“ADMON” хэвлэлийн
үйлдвэр хэвлэв, 2006 он



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж-2, Admon компани.
Ш/х- 92. УБ-13. www.admon.mn

Байгалийн Нөөцийн Менежмент дэх Нийгэм ба Жендэрийн Судалгаа: Ази тивээс гарсан суралцах судалгаа ба сургамж / Хянан эмхэтгэсэн Ронный Верной Холбогдох ном зүй болон товъёог.

1. Хөлөөгийн хөгжил – Ази - Жишээ судалгаа . 2. Эмэгтэйчүүд ба хөгжил - Ази - Жишээ судалгаа . 3. Байгалийн нөөц—Менежмент- Судалгаа . I. Ронный Верной, 1963-

ISBN: 978-99929-0-118-7 (Монгол)

0-761-3462-6 (Hb)

0-761-3463-4 (Pb)

81-7829-612-8 (India - Hb)

81-7829-613-6 (India - Pb)

Номыг монгол хэлэнд хянан тохиолдуулсан: Х. Ыханбай, Ц. Одгэрэл, Б. Нарантулга,
А. Туяажаргал

Гарчиг

Хүснэгт

Зураг

Хайрцаг

Өмнөх үг

Талархлын үг

1. Нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээг байгалийн нөөцийн менежментийн судалгаанд тусгах нь 17
Ронный Верной, Лиз Фажбер
2. Цагаан гааны үйлдвэрлэл, худалдааны явц дахь нийгэм, жендэрийн байдал: Рей, Лепча ба Брехмин-Чхетрид хийсэн жишээлсэн судалгаа Чанда Гурунг ба Навраж Гурунг 41
3. Ногоо тариалагч эмэгтэйчүүдийн зах зээлийн уялдаа холбоог бэхжүүлэх: Энэтхэг, Нагаландын Кохма дахь туршлагаас Венгота Накро ба Чозуле Кики 77
4. Фермерүүдийн чадавхийг дээшлүүлэх ба нутгийн үрийн тогтолцоог бэхжүүлэх: Бара мужийн биологийн олон төрлийн нөөцийг ашиглах болон хадгалж хамгаалах талаарх судалгаа Дипа Сингх, Анил Сүбэди, Питамбер Шреста 117

5. Эмэгтэй фермерүүдийг чадавхижуулах ба нутгийн үрийн тогтолцоог бэхжүүлэх: Хятадын Гуанжид хийсэн үйл ажиллагааны судалгаа 157
Ичин Сон, Линшү Жан, Ронный Верной
6. Өөрчлөлтийн боломжийг бий болгох: Вьетнамын Хью мужийн эмэгтэйчүүд, ядуусын нийгмийн капиталыг бэхжүүлэх нь 191
Хоан Ти Сен, Ле Ван Ан
7. Малчин эмэгтэйчүүд ярьж байна: 225
Х.Ыханбай, Ц.Одгэрэл, Э.Булган, Б.Наранчимэг
8. Адил төстэй болон ялгаатай зүйл: 255
Ронный Верной, Линшү Жан
9. Нийгэм ба жендэрийн дүн шинжилгээ зайлшгүй хийгдэх зүйл юм: 277
Ронный Верной, Линшү Жан
- Номын зохиогчдын тухай 292

Хүснэгтүүд

1.1. “Эмэгтэйчүүд ба хөгжил” болон “Жендэр ба хөгжил” хандлагын үндсэн шинж чанарууд	34
1.2. Зургаан судалгааны онцлог шинжүүд	36
1.3. Зургаан жишээлсэн судалгаанд хэрэглэсэн арга зүй, хэрэглүүр, ур чадвар	37
2.1 Судалгааны 2 мужийн хүн ам зүйн мэдээллийг үндэсний мэдээлэлтэй харьцуулсан нь, 2001 он	47
2.2 Сонгогдсон тосгонуудын өрх айлын тоо, үндэстнүүдийн эзлэх хувь хэмжээ	56
3.1 Кохиماغийн хүнсний ногооны худалдааны байгууллагуудын тойм	91
3.2 Кохима Хотын Хорооноос хүнсний ногоо худалдаачдад гаргаж өгсөн захууд	95
3.3 Фолами тосгоны эмэгтэй худалдаачдын сар бүр борлуулж буй хүнсний ногооны төрлийн тоо	97
3.4 Худалдаачин 1-ийн Кохима зах руу явах аяллын орлого, зардал	102
3.5 Худалдаачин 2-ын Кохима зах руу явах аяллын орлого, зардал	103
3.6 Фолами тосгоны худалдаачдын авсан ногоо, жимсний жижиглэнгийн болон бөөний нэгжийн үнэ (рупи)	104
3.7 Мерема, Цисе баса тосгонуудын зах зээлд борлогддог хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжууд	111
4.1. Үрийн нөөцийн эх үүсвэр, нийгмийн давхаргаар	144
4.2. Үрийн үйлдвэрлэл дэх эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн оролцоо	148

5.1	Анхуй, Кингхай ба Гуанши муж дахь гадагшаа чиглэсэн шилжих хөдөлгөөн (1997-2003)	163
5.2	Таван судалгааны бүс нутгийн талаарх үндсэн мэдээлэл	170
5.3	Судалгааны 5 бүс нутаг дахь эрдэнэ шишийн үйлдвэрлэлийн шинж чанар	172
5.4	Өрхийн нөөц болон үйл ажиллагааны удирдлагын талаарх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үзэл хандлага	173
5.5	Өрхийн нөөц болон үйл ажиллагааны удирдлагын талаар шийдвэр гаргах асуудлаарх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үзэл хандлага	173
5.6	Гуанши мужийн тосгодын эрэгтэй болон эмэгтэй фермерүүд үрийн төрлийг шилж сонгох үзүүлэлтүүдийн харьцуулалт	176
6.1	Хонг Ха болон Хүонг Нгүений хамтлагуудын газар ашиглалт	202
6.2	Хонг Ха болон Хүонг Нгүений хамтлагуудын хүн ам	202
6.3	Хамтлагийн өрхүүдийн хөрөнгө чинээний байдал	203
6.4	Хоёр хамтлагийн чинээлэг ангилалын өрхийн сургалтанд хамрагдалтын боломж	207
7.1	Бэлчээр болон байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд хамтлагийн эмэгтэй, эрэгтэй гишүүдийн оролцоо	241
7.2	Аржаргалант хамтлагийн эмэгтэйчүүдийн бүлгийн зохиосон бэлчээр сэлгэх төлөвлөгөө	245
7.3	Малчдын өрхийн орлогын бүтцийн өөрчлөлт 2001, 2003 оноор	246

Зургууд

1.1 Үйл ажиллагааны онол	33
2.1 Сикким мужийн судалгааны нэгжүүдийн байршил	46
3.1 Судалгааны бүс дэх Нагаландын байршлыг харуулсан газрын зураг	82
4.1 Судалгааны бүсийг харуулсан Балбын газрын зураг	122
4.2. Шинэ төрлийн цагаан будаа ургуулах болсон шалтгаан	141
4.3 Мужийн сортын цагаан будааг ургуулах болсон шалтгаан	141
4.4. Үрийг сэлгэх/орлуулах үе фермерүүдийн бүлгээр	142
4.5 Качорва тосгоны үрийн худалдааны тогтолцоо	145
4.6 Үрийн арилжааны харьцаа, нийгмийн давхаргаар	146
4.7 Үрийг шигшин сайжруулах арга	146
4.8 Үрийн үйлдвэрлэл дэх ажиллах хүч ашиглалт	149
4.9 Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах болон худалдаанд оролцож уй байдал	150
5.1 Анхуй, Кингхай ба Гуанши муж дахь гадагшаа чиглэсэн шилжих хөдөлгөөний өөрчлөлт, хүйсээр	163
5.2 Судалгаанд хамрагдсан Өмнөд Хятадын байршил	169
6.1 Вьетнамын судалгааны бүс	203
6.2 Сургалтанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувь	208
6.3 Сургалтын сэдвүүдийн талаар шийдвэр гаргасан эх сурвалжууд 210	
7.1 Судалгааны бүсийн байршил	234
7.2 Мал ахуй, гэрийн ажилд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцож буй байдал (n=84)	241

ӨМНӨХ ҮГ

Энэ бол шууд болон шууд бус утгаараа жишээ, уулзалтуудын тухай маш энгийн ном юм. Номын есөн бүлэгт зохиогч болон тэдний хамтран зүтгэгчид өөр хоорондоо болон хөдөөгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллагад ажиллаж буй хүмүүстэй хийсэн уулзалтын тухай өгүүлнэ. Газар зүйн хувьд Өмнөд Ази, Зүүн Өмнөд Ази, болон Төв Азийн зарим улс орнуудыг хамарч байна. Зохиогч, хамтран ажиллагчдын зарим нь өөрсдөө засгийн газар, төрийн бус байгууллагын ажилтнууд юм. Ерөнхийлөн дүгнэсэн гурван бүлэг, жишээлсэн зургаан судалгаагаар дамжуулан байгалийн болон нийгмийн шинжлэх ухааныг, түүнчлэн нийгмийн шинжлэх ухааны дүрслэн үзүүлэх зорилго бүхий судалгаа болон өөрчлөгч шинж чанар бүхий оролцооны судалгааг, орон нутгийн шинжтэй судалгааны “төсөл” болон нийгэм-эдийн засаг, нийгэм-улс төрийн бүтэц, үйл явцыг хооронд нь аль болох холбон авч үзэхийг оролдлоо.

Тус номыг бүтээхэд хувь нэмэр оруулсан бүх хүмүүсийг нэгтгэн холбож буй нэг зүйл нь амьдарч, ажиллаж буй нийгмээ илүү сайн ойлгох гэсэн сонирхол юм. Ялангуяа нийгэмд өдөр тутам гарч буй ялгаа, тэгш бус байдал, цаг хугацаатай зэрэгцэн явагдаж буй өөрчлөлт (нийгмийн ялгаа гарах үйл явц) зэрэгт бид санаа зовж байна. Мөн бид бүгд нийгэмд өөрчлөлт хувьсал хийх боломжийг эрж, нээн илрүүлэхийг тодорхой хэмжээгээр хүсч байгаа билээ. Тус номонд хамтарсан судалгааны төсөл төдий биш илүү их зүйлийг

хамран тусгахыг зорьж байсан ч өдөр тутам хийдэг ажил, туулж өнгөрүүлж буй өөр хоорондоо асар ялгаатай амьдралын туршлага дээрээ үндэслэн энэ бол хийхэд хэцүү, хэлэхэд хялбар зүйл гэдгийг ойлгосон билээ. Нийгмийн өөрчлөлт хувьсалд оролцоно гэдэг нь улс төр, эрх мэдэл, мэдлэгийн тэмцэлд орно гэсэн үг бөгөөд үндсэндээ ухралт хийх, бэрхшээлтэй асуудалтай тулгарах нь бараг зайлшгүй зүйл билээ.

“Суралцах судалгааны” төслийг бүрдүүлж буй зургаан жишээ нь нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг байгалийн нөөцийн менежментийн судалгаанд тусгах янз бүрийн хүчин чармайлтыг дүрслэн харуулна. Тэдгээр жишээ нь тухайн “орон нутгийн” түүх, нөхцөл байдлыг харгалзан үзэхийн чухлыг, мөн “орон нутгийн,” болон “анхан шатны түвшний” хүчин зүйлс хоорондоо улам нягт холбоотой болж байгааг харуулж байна. Эдгээр зургаан жишээ нь харьцуулан дүн шинжилгээ хийх боломж олгохын зэрэгцээ зарим шинж чанар, асуудал бүгдэд нь түгээмэл тохиолдож байгааг ч дэлгэн харуулж байна.

Байгалийн нөөцийн менежмент дэх анги давхарга, үндэс угсааны асуудал зэрэг нийгэм жендэрийн дүн шинжилгээний судалгааг хэрэгжүүлж буй судлаачдын авсан арга хэмжээг мөн харуулна. Жишээ бүр ойлголтоо гүнзгийрүүлэх, дадал практикаа сайжруулахад тус дэм болох, “суралцах”, санаа авах түүх юм.

Бүс хоорондын хамтын ажиллагааг хэрэгжүүлснээр судалгааны зургаан баг харилцан бие биеэ дэмжин, урам өгч ажилласан бөгөөд дадал практикаа эргэцүүлэн бодож, онол ойлголтоо шүүн тунгааж байхыг эрмэлзсэн. Сонгон авсан эдгээр жишээ нь нийгэм жендэрийн дүн шинжилгээ хийхэд тулгарч буй бэрхшээл, боломж, амжилт, алдааны амьд жишээг тод томруун дүрслэн харуулж байгаа юм. Түүнчлэн Азийн бүс нутаг дахь олон янзын нөхцөл байдалд тохируулан ашигласан хэд хэдэн аргыг ч дээрх жишээнүүд онцлон дурдсан болно.

Эдгээр жишээлсэн судалгаа нь нийгэм жендэрийн дүн шинжилгээг үйл ажиллагаа, судалгаанд нэгтгэн авч үзэх чадавхийг бэхжүүлэх талаар юу хийгдээд байгаа, юуг одоо хийж байгааг

эргэцүүлэх боломж олгож байна. Мөн үүнийг чухам яаж хийсэн, хийж байгааг судлахын зэрэгцээ тухайн үйл явцад эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлийг авч үзлээ. Түүнчлэн ирээдүйд чадавхи бэхжүүлэх ажилд хэрхэн дэмжлэг үзүүлж болох вэ гэсэн асуултыг хөндөн тавьж байгаа юм.

Тус номын зохиогч, хамтран зүтгэгчид гурван жил гаруй үргэлжилсэн энэхүү санаачлагын хүрээнд хийсэн цуврал ажлууд нь тодорхой үр дүнд хүрч, өөрчлөлт хийж чадсан гэсэн үнэлгээтэй санал нэгдэж байна. Тэдгээр ажил бидний нийгмийн тухай мэдлэгийг гүнзгийрүүлж, (үйл ажиллагаанд чиглэсэн) судалгааг хийж гүйцэтгэх үр чадварыг сайжруулж чадсан гэдгийг дараа дараачийн бүлэг харуулах буйзаа. Мөн энэхүү номыг бүтээх явцад бидний нөхөрлөл үүсч бэхжих сайхан боломж бүрдсэн билээ.

Ронный Верной

ТАЛАРХЛЫН ҮГ

Тус номонд баримтжуулан оруулсан судалгааны ажлыг гүйцэтгэх, уг ном маань хэвлэгдэн гарахад маш олон хүн дэмжлэг үзүүллээ. Хөдөө аж ахуй эрхэлдэг эмэгтэй, эрэгтэй хүмүүс, малчид өөрсдийн санаа бодол, үзэл, хүсэл мөрөөдөл, санаа зовниж явдаг зүйлсээ судалгааны багтай хуваалцаж, Балба, Хятад, Вьетнам, Монголд хэрхэн амьдарч буй арга ухаанаасаа бидэнд заасан билээ. Бусад судлаач, засгийн газрын ажилтнууд ч хамтран ажилласан бөгөөд ойлголт болон авах арга хэмжээгээ сайжруулах замд нэгдсэн. Судалгаанд оруулсан тэдний хувь нэмэр, тэвчээр, зочломтгой зан, нөхөрлөлд бид талархаж байна.

Олон улсын хөгжлийн судалгааны төвийн хөтөлбөрийн ажилтан байсан Жонн Грэмд маш их баярлаж байгаагаа илэрхийлье. Жонн эхнээс нь дуусах хүртэл судалгааны талбар дээр ч, сургалтын үеэр ч, алсын зайнаас харилцах үед ч урам зориг нэмсэн санал, шүүмж өгч байсан билээ. Тэрээр бүх бүлгийг нягтлан уншиж, орхигдсон зүйл, тодруулах шаардлагатай тайлбар, англи хэлний тийм ч зөв биш хэрэглээ зэргийг тэмдэглэж өгсөн. Түүний саналыг бид аль болох тусгахыг хичээсэн бөгөөд аливаа алдаа үлдсэн байх аваас түүний алдаа биш юм.

Олон улсын хөгжлийн судалгааны төвийн бусад ажилтнууд болох Биологийн төрөл зүйлийн тогтвортой хэрэглээ, Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн баг, Жендэрийн нэгж, харилцааны баг, мөн Сингапур, Шинэ Дели,

Оттава дахь тус байгууллагын ажилтнуудад дэмжлэг үзүүлж, урам өгч байсанд баярлалаа.

Бээжин дэх Хятадын Хөдөө аж ахуйн бодлогын төвийн ажилтнуудад туслалцаа дэмжлэг, алиа хошин зан, дуулах авьяасаа айх эмээх зүйлгүй үзүүлсэнд тань талархаж байгаагаа илэрхийлье. Зургаан жишээлсэн судалгааны харьцуулсан дүн шинжилгээг анхлан хийх үед Пен Гуанкианы өгсөн саналд бид талархаж байна.

Бидний англи хэлний бичих чадварыг Сандра Гарланд үлэмж сайжруулж өгсөн билээ. Харин хэвлэлтийн урлахуйг Энэтхэгийн Sage Publications-ий гүйцэтгэх захирал Тежешвар Сингх, Хятадын Хөдөө аж ахуйн хэвлэлийн газрын захирал, ахлах редактор Ке Уенву, Олон улсын хөгжлийн судалгааны төвийн ерөнхий редактор Билл Сарман нар амжуулсан. Түүнчлэн редактор Омита Гояалын дэмжлэгийг бид тэмдэглэхийг хүсч байна.

Сикким/Баруун Бенгалын баг тэдний амьдардаг бүс нутгийг олон улсын хөгжлийн байгууллагууд удаан хугацааны туршид орхигдуулж ирсэнийг дурьдсан билээ. Олон улсын хөгжлийн судалгааны төв тус бүс нутаг, хүн ардыг сонирхон, түүнийг олон улсын хөгжлийн тавцан дахь анхаарлын төвд хүргэсэн цөөн байгууллагын нэг юм. Тэд Олон улсын хөгжлийн судалгааны төвд талархлаа илэрхийлж байна. Энэхүү судалгааг явуулах үйл явцад тосгон руу маш олон удаа явж, хөдөө аж ахуйтнуудаас ярилцлага авах, асуулт тавихад цаг их шаардагдаж байв. Энэ бүх хугацаанд асар их тэвчээр мөн санаачлага гаргаж байсан найрсаг, зочломтгой хөдөө аж ахуйтнууддаа судалгааны багийн зүгээс баярлаж байгаагаа илэрхийлье. Түүнчлэн талбар дээр ажилласан 6 туслах ажилтандаа үнэлж баршгүй тус дэмжлэг үзүүлсэнд талархаж байна. Лиз Фажберт (Олон улсын хөгжлийн судалгааны төв) зөвлөгөө, чиглэл өгч байсныг онцлон дурдах хэрэгтэй болов уу. Сикким дэх Энэтхэг-Швейцарын төслөөс Науражид энэхүү төсөлд оролцох боломж олгосон гэдгийг тэрээр талархан дурьдахыг хүсч байна.

Нагаландийн судалгааны багийнхны зүгээс Олон улсын судалгааны төвийн ажилтнууд, Ронный Верной, Лиз Фажбер, Жонн Грэм нарт нийгэм жендэрийн дүн шинжилгээний судалгааг

Нагаландад хийх боломж олгон, судалгааны явцад дэмжлэг үзүүлж байсанд талархаж байна. Түүнчлэн алдаа дутагдалтай зүйлсээ илрүүлэх, суралцах чадвараа дээшлүүлэх, ур чадвар, өөртөө итгэлтэй байх чадвараа сайжруулах зэрэг чиглэлээр семинар, ярилцлага явуулж, харилцах үед идэвхтэй оролцож байсанд нийт оролцогч бүлгийнхэндээ талархаж байна. Энэхүү судалгааны үр дүнд Эдийн засгийн хөгжлөөр дамжуулан хүмүүсийг чадавхижуулах төсөл бусад байгууллагатай жендэрийн чиглэлээр хамтран ажиллах болсон билээ. Төслийн ахлагч Алемтемши Жамир, төслийн бусад ажилтнууд, түүнчлэн дөрвөн тосгоны эмэгтэй худалдагчид, Кохимагийн хотын зөвлөл, хөдөө аж ахуйн хэлтэс, далайн ургамал үржүүлгийн хэлтэс, захиргааны хэлтэс зэрэг хамтран ажилласан бүх хүмүүст талархал илэрхийлье. Эцэст нь, сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, зарим үед судалгааны талбар руу хамт явж, орой болтол компьютер дээр суун ажиллах үед ойлгон дэмжиж байсан гэр бүлийнхэндээ судалгааны баг баярлалаа гэж хэлмээр байна.

Төслийн явцад санхүүгийн болон мэргэжлийн туслалцаа үзүүлж байсанд “Агро-биологийн төрөл зүйлийг хадгалах шинжлэх ухааны үндсийг бэхжүүлэх нь” судалгааны төслийн зохиогчид Олон улсын хөгжлийн судалгааны төвд талархаж байгаагаа илэрхийлье. Качорва дахь хөдөө аж ахуй эрхлэгчдэд хамтран ажилласанд чин сэтгэлээсээ баярлаж байна. Карна Чаудхари, Фул Кумари Чаудхари нарт судалгааны талбар дээр ажиллах үед байнга дэмжлэг үзүүлж, тусалж байсанд талархаж байна. Тэдний дэмжлэг байгаагүй бол энэхүү судалгааг хийж чадахааргүй байв.

Хятадын багийнхны зүгээс Гуанши дэх нийгэм жендэрийн дүн шинжилгээний баг болон хоёр тосгоны бүх фермийн аж ахуйтнуудад судалгаанд оролцож, хувь нэмрээ оруулсанд талархал илэрхийлье. Мөн Олон улсын хөгжлийн судалгааны төв, Хятадын Хөдөө аж ахуйн бодлогын судалгааны төвөөс үзүүлсэн дэмжлэгт талархаж байна. Ялангуяа Ронный Верной, Лиз Фажбер, Кьюнин Пан, Бэйлин Хуан, Ченфан Лю нарт төслийн туршид байнга дэмжлэг үзүүлж байсанд баярлалаа. Суралцах явцад туршлагаа хуваалцаж байсан судалгааны бусад 5 багтаа баярлалаа.

Судалгааны явцад тусалж дэмжсэн бүх хүмүүс, байгууллагад Вьетнамын баг гүн талархал илэрхийлье. Санхүүгийн дэмжлэг үзүүлж, чиглэл өгч, зөвлөж байсанд Олон улсын хөгжлийн судалгааны төвд тусгайлан талархал илэрхийлье. Мөн Хью Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн их сургууль урам зориг өгч, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж байсанд баярлалаа. Хон Ха, Хьюон Нгуен мужийн фермерүүд, Лью мужийн Хөдөө аж ахуйн хөгжлийн газар болон сургалтын хэлтсийн ажилтнуудын хамтын ажиллагаа, дэмжлэг байгаагүйсэн бол энэхүү судалгаа хэрэгжиж чадахгүй байв. Судалгааны багийн бүх гишүүдэд хамтран ажиллаж, туршлагаа хуваалцаж байсанд талархаж байна.

Монголын багийн хувьд энэхүү судалгаа нь малчин эмэгтэйчүүдийн дуу хоолой, хүсэл эрмэлзлийг судалгаанд болон бэлчээрийг илүү зохистой ашиглах хамтын удирдлагын зохион байгуулалтанд анхааран авч үзсэн анхны хүчин чармайлт юм. Тэд Олон улсын хөгжлийн судалгааны төвийн ажилтан Ронный Верной, Лиз Фажбер, Жонн Грэм, Хайн Малли нарт үнэтэй санал өгч, цаг алдалгүй тус дэм болж байсанд, мөн 2003 онд Улаанбаатарт Нийгэм жендэрийн дүн шинжилгээний талаар туршлага солилцох олон улсын хоёрдугаар уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэнд баярлалаа гэж хэлж байна. Орон нутгийн эмэгтэйчүүдийн бүлгүүд, Лүн, Хотонт, Дэлүүн сумын засаг захиргааны ажилтнуудад судалгааны явцад хамтран ажилласанд талархаж байгаагаа илэрхийлье.

1

НИЙГМИЙН БА ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭГ БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН СУДАЛГААНД ТУСТАХ НЬ



ЗУРАГ АВСАН: РОННЫЙ ВЕРНОЙ

РОННЫЙ ВЕРНОЙ, ЛИЗ ФАЖБЕР

Байгалийн Нөөцийн Менежментийн Нийгмийн Шинж Чанар

Дэлхийн ихэнх бүс нутагт байгалийн нөөц, түүний дотор биологийн төрөл зүйлийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд нийгмийн янз бүрийн төлөөллийн оролцоо шаардагдаж байдаг. Оролцогч талуудын оролцоо гэдэг нь хөдөөгийн жижиг аж ахуйтан (эрэгтэй, эмэгтэй аль аль нь), фермийн томоохон аж ахуй эрхлэгчид, бизнес эрхлэгчид, орон нутгийн захиргаа, орон нутгийн бүлгүүд, төрийн бус байгууллага болон бодлого боловсруулагчид байгалийн нөөцийн хэрэглээ, менежмент, хадгалалтын талаар шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй, утга учиртай оролцохыг хэлж байгаа юм. Тухайн бэрхшээлтэй асуудал болон боломж бололцоог шинжлэх үзэх, судалгаа ба хөгжлийн ямар арга хэмжээ авч болохыг тодорхойлох, түүнчлэн үйл ажиллагаа, төлөвлөгөөгөө хянан, үнэлэх асуудал багтана. Санаа бодол, сонирхол зөрж байгаа бол түүнийгээ хамтран хэлэлцэж, шийдвэрлэх асуудал ч багтана. Ялангуяа төрийн бус байгууллага, орон нутгийн захиргаа, анхан шатны түвшний бүлгүүд, хөдөө аж ахуйтны холбоодын идэвхтэй оролцоо нь оролцоонд тулгуурласан байгалийн нөөцийн менежментийн олон санаачлагын түгээмэл шинж болоод байна.

Ийм арга хандлагын хувьд, байгалийн нөөцийн менежментийн экологийн болон нийгмийн талын асуудлыг хамтад нь авч үзэх зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ нь усны ай сав, ой, бэлчээрийн газар зэрэг тухайн газар орчныг бүхэлд нь авч үзнэ гэсэн үг. Мөн байгалийн нөөцийн систем болон газар тариалан, загас, ойн аж ахуй, мал аж ахуй, хүнсний зүйл түүж цуглуулах зэрэг үйлдвэрлэлийн системийн янз бүрийн бүрдэл хэсгүүдийн өөрчлөлт, харилцан үйлчлэл зэргийг системтэй авч үзэхийг шаардана. Үүний зэрэгцээ дээрх харилцан үйлчлэлд нөлөөлж буй түүх, нийгэм-эдийн засаг, улс төрийн хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Эргээд эдгээр хүчин зүйлд анги давхарга, жендэр, нас, яс үндэс зэрэг хувьсагч нөлөөлж байдаг.

Эдгээрээс хамгийн чухал нь, уулархаг газар нутаг, цөл, далайн

эрэг орчмын нутаг зэрэг эмзэг бүс нутагт амьдардаг, маш хэцүү нөхцөлд аж амьдралаа залгуулдаг эмэгтэй, эрэгтэй хүмүүсээс суралцах явдал юм. Бидний хариулах ёстой гол асуулт бол, эдгээр хүмүүс нутаг орондоо болж буй зүйлийг хэрхэн хүлээн авч, ойлгож байна вэ гэсэн асуулт юм. Бидний байгалийн нөөцийн менежмент гээд нэрлээд байгаа зүйлийг тэд юу гэж үзэж байна вэ? Оролцоонд тулгуурласан үйл ажиллагаанд чиглэсэн судалгааны тухайд тэдний сонирхож буй зүйл юу вэ, тэд үүнийг ямар нэг арга хэмжээ авах, эхлүүлэх боломж гэж үзэж байна уу? Газар тариалан, загас агнуур эрхлэгч эмэгтэйчүүд өөрсдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, улмаар шинэ эсвэл сайжруулсан менежментийн практикийг нэвтрүүлэх зорилгоор мэргэжлийн судлаачидтай хамтран ажиллахыг сонирхож байна уу?

Үүнд хариулахын тулд мэдлэг хэрхэн бий болж, тархан түгж, хэрэглэгдэж байгааг судлах хэрэгтэй болно. Ялангуяа байгалийн нөөцийг ашиглах боломж, эзэмшил, ашиглах эрх зэрэгт нөлөөлж буй нийгмийн болон жендэрийн харилцаа, түүний дотор өөрчлөлт, дасан зохицол, эсэргүүцэл хэрхэн явагдаж байгааг судлах хэрэгтэй байдаг. Мөн судалгааны арга, практикийн соёлын болон улс төрийн шинж чанартай холбоотой асуудал хөндөгдөнө.

Энэхүү номонд анги давхарга, яс үндэс зэргийг авч үзсэн байгалийн нөөцийн менежментийн нийгэм жендэрийн дүн шинжилгээг хийхийн тулд судлаачдын авсан арга хэмжээг баримтжуулан, эргэцүүлсэн бөгөөд энэ чиглэлээр Энэтхэг, Балба, Хятад, Вьетнам, Монголд ажилласан зургаан өөр багийн суралцах судалгааг танилцуулна.

Ази Дахь Байгалийн Нөөцийн Хэрэглээ: Хандлага ба Тулгарч Буй Бэрхшээл

Азид үйлдвэржилт, хотжилт түргэн явагдаж байгаа ч ихэнх хүмүүсийн амьжиргаа байгалийн нөөцөөс шууд хамааралтай хэвээр байна. Харамсалтай нь, тэрхүү нөөцөд учирч буй дарамт улам бүр нэмэгдэж байна. Хотын үйлдвэржилт, нөөцийн экспортонд оруулж

буй олон улсын хөрөнгө оруулалт, түүнд тухайн орон нутаг хяналт тавьж чадахгүй байгаа зэрэг нь байгалийн нөөц сүйдэж, хомсдоход хүргэж байгаа билээ. Нүүлгэн байршуулалтанд өртөх, сайн дураараа шилжин суурьших (ялангуяа Хятадын эрэгтэйчүүд), түүхийн удаан хугацааны туршид үргэлжилж буй зөрчил мөргөлдөөн зэрэг нь асуудлыг улам хурцатгаж байна. Эрүүл мэндийн суурь үйлчилгээ, амьдрах орчин сайжирсан тул хөдөөгийн хүн ам хурдацтай өсч байна. Энэ нь тариалангийн газраа өргөжүүлэх, тэр ч байтугай экологийн хувьд эмзэг, байнгын тариаланд хэрэглэж болохооргүй газар нутаг руу нэвтрэн ороход хүргэж байна. Нутгийн иргэдийн дунд эмзэг бүлэг үүсэх нь түгээмэл боллоо. Нөөцийн эзэмшил, нөөцийг ашиглах боломжийн тогтолцоо маш төвөгтэй, учир нь уламжлалт, соёл заншилд суурилсан тогтолцоог колонийн болон төрийн дүрэм журмаар өөрчилсөн бөгөөд эдийн засгийн бодлогын шинэчлэл хийгдэхийн хэрээр өөрчлөгдөн хувирч байна.

Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн асуудал өндөрлөг болон эрэг орчмын нутагт илүү хурцаар тавигдаж байна. Учир нь эдгээр газарт байгалийн нөөц хумигдан багассанаар хүнсний эх үүсвэрээ эргэлт буцалтгүй алдахад хүрч, ургамал, амьтан цөөрснөөс экологийн систем тасалдах аюултай юм. Азид ой, эрэг орчмын нутаг зэрэг өмнө нь хамтын эзэмшилд байсан байгалийн нөөцийг хувьчлах явдал өргөн тархаад байна. Хувьчлал богино хугацаанд бүтээмжийг нэмэгдүүлж болох боловч ядуу хүмүүсийг өмнө нь авч хэрэглэж байсан байгалийн нөөцөөс холдуулан салгадаг тул ихэнх тохиолдолд ядуурал улам ихэсдэг. Аливаа бодлого, судалгааг боловсруулж, хэрэгжүүлэхдээ ихэнх тохиолдолд нутгийн иргэдийн үүргийг орхигдуулдаг бөгөөд нийгмийн ялгаварлалыг олж харж чадахгүй байна.

Хэдийгээр нөхцөл байдал улс орон бүрт өөр өөр боловч орон нутгийн нөөцийн менежментийн тухайд сонирхол бараг адил байна. Зарим улс оронд бүтцийн өөрчлөлт хийснээр төрийн зүгээс хэрэгжилтэнд хяналт тавих чадавхи суларсан. Мөн зарим оронд бодлогын томоохон өөрчлөлт явагдаж, эдийн засагт оролцох төрийн оролцооны бүхий л чиглэлд нөлөөлж байна. Худалдаа, хөрөнгө

оруулалт өргөжиж, өмнө нь олон улсын зах зээлээс хол байсан бүс нутагт хөгжлийн томоохон төсөл хэрэгжиж эхэлснээр орон нутаг дахь байгалийн нөөцөд ихээхэн нөлөө үзүүлж байна. Нөгөө талаар, орон нутгийн засаг захиргаа, анхан шатны байгууллагууд илүү өөртөө итгэлтэй болж, нөөцийн асуудлаа босгон тавьж, үзэл бодол, сонирхлоо илэрхийлдэг болж байна.

Байгалийн Нөөцийн Менежментийн Судалгаанд Нийгэм Жендэрийн Дүн Шинжилгээг Тусган Авч Үзэхэд Тулгардаг Бэрхшээлтэй Асуудлууд

Ази тивийн улс орнууд дахь нийгэм нарийн төвөгтэй бөгөөд байгалийн нөөцийн менежмент энд нэлээд анхаарал татсан асуудал юм. Жендэрийн талаарх ойлголт (тухайн соёл заншилд эрэгтэй, эмэгтэй хүмүүст нийгмээс оноодог үүрэг, шинж чанар), анги, давхарга, каст, яс үндэс, нас зэрэг нь байгалийн нөөцийн нөөцийг ашиглах боломж, хэрэглээ, менежменттэй холбоотой нийгмийн харилцаа, шийдвэр гаргах үйл явцыг ойлгоход нэн чухал юм. Нийгмийн ялгаа, тэгш бус байдлыг зөв ойлгох нь өмнөх хэсэгт сөхөн тавьсан асуултуудын хариуг олоход гол түлхүүр болж өгнө. Хариулт энгийн байхгүй нь лавтай бөгөөд Кабир (2003; 193) дараах зүйлийг дурдсан байдаг. Үүнд:

Жендэрийн харилцаа нь нийгмийн бусад бүхий л харилцааны нэгэн адил олон талтай. Санаа бодол, үнэт зүйл, бусдаас ялгарах онцлог шинж зэрэг нь түүнд нэвт шингэсэн байдаг, мөн жендэрийн харилцаа нь янз бүрийн ажил, үйл ажиллагаанд хөдөлмөрийн хуваарь хийж өгдөг, нөөцийн хуваарилалт, эрх мэдэл, шийдвэр гаргах эрхийг оноодог. Тиймээс жендэрийн тэгш бус байдал олон талтай бөгөөд түүнийг материаллаг эсвэл ёс суртахууны хүчин зүйлээр хязгаарлаж болохгүй. Мөн эдгээр харилцаа нь тэр бүр дотроо нэгдмэл, зөрчилгүй байж чаддаггүй бөгөөд ялангуяа нийгэм-эдийн засгийн ерөнхий хүрээнд өөрчлөлт явагдсан бол зөрчилдөөн, тэнцвэргүй байдал үүсч байдаг.

Хөгжлийн (судалгааны) ажил, төсөл, хөтөлбөр, бодлогод хэн

оролцож байна вэ? Чухам яаж оролцож байна вэ? Түүнээс хэн ашиг тус хүртэж байна вэ? Хэн оролцохгүй үлдэж, орхигдож байна вэ? Байгалийн нөөцийн тэгш, тогтвортой хэрэглээг дэмжихийг зорьж байгаа бол дээрх асуултуудыг үйл ажиллагаандаа тусган авч үзэх нь нэн чухал.

Тус бүс нутгийн зарим бодлого боловсруулагч, идэвхтэн, судлаачид нийгмийн болон жендэрийн тэгш эрхийн асуудлыг ялангуяа оролцоо, хамрагдалт, шийдвэр гаргах болон эрх мэдлийн харилцааны тухайд авч үзэж, тусгах хэрэгтэй гэж үздэг. Агарвал (2001: 1623) нутгийн иргэдээс бүрдсэн ойн бүлгийн үүсгэл, ажиллагааны жишээн дээр тулгуурлан явцын дунд хэн нэгнийг орхин үлдээх явдал гардаг асуудалд анхаарлаа хандуулсан байна.

Хоршооны зарчмаар ажиллах ёстой ийм бүлгүүд (ойн бүлэг) уг нь тухайн орон нутгийн бүхий л хэсгийг хамарч, ашиг тусаа өгч байх ёстой. Гэтэл эмэгтэйчүүд гэх мэт иргэдийн нэлээд хэсгийг оролцуулалгүй орхигдуулах тал гардаг. Эдгээр “оролцооны орхигдол” буюу өөрөөр хэлбэл, оролцооны институт маань өөрөө хэн нэгнийг оролцуулалгүй орхигдуулах явдал нь зөвхөн цаг хугацааны асуудал биш, харин тогтолцооны шинжтэй хүчин зүйлээс үүдэлтэй бөгөөд тэгш эрх болон тухайн институцийн ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Агарвалын судалгаатай адил төстэй судалгаанууд нь бидэнд энэхүү нийгэм, улс төрийн үйл явц болон түүнд нөлөөлж буй жендэрийн болон бусад хүчин зүйлийг ойлгоход тусална. Гэхдээ биологийн төрөл зүйл, байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр нийгмийн асуудлыг тусгасан судалгаа, хөгжлийн үйл ажиллагааг газар дээр нь, тухайн орчин нөхцөлтэй нь уялдуулан хэрэгжүүлэхэд маш хэцүү. Байгалийн нөөцийн менежмент дэх нийгэм жендэрийн дүн шинжилгээ нь ихэвчлэн онолын түвшинд байна. Хэрэглээний судалгаанд нийгэм жендэрийн дүн шинжилгээ хийх чадавхийг системтэй хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр маш цөөн байна. Иймэрхүү чадавхи бэхжүүлэх үйл явцыг системтэй баримтжуулж, дүн шинжилгээ хийсэн тохиолдол бүр ч цөөн байна.

Ийм учраас байгалийн нөөцийн менежмент, биологийн төрөл зүйлийн судалгаанд нийгэм жендэрийн дүн шинжилгээг нэгтгэн тусгахад тулгарах бэрхшээл нэлээд олон байна (Верной, Фажбер 2004:210). Үүнд:

1. Байгалийн нөөцийн менежментийг судалдаг судлаач, судалгааны менежерүүдийн нийгмийн шинжлэх ухааны мэдлэг, туршлага бага.
2. Ихэнх судалгаанд нийгмийн ухааны бүрдэл хэсэг нь байгалийн ухааны бүрдэл хэсэгтэйгээ сайн уялдаж, нэгтгэгдээгүй байдаг.
3. Судлаач, судалгааны байгууллагуудын нийгэм, жендэрийн асуудлын талаарх сонирхол, туршлага харилцан адилгүй түвшинд байдаг.
4. Судалгаа, судалгааны бодлогод “жендэрийн хараагүйдэл” буюу жендэрийн асуудлын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах байдал түгээмэл байдаг.
5. Богино хугацааны сургалтын үр нөлөө хязгаарлагдмал.
6. Нийгэм жендэрийн дүн шинжилгээ, байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр зарцуулах хөрөнгө нөөц Азид хязгаарлагдмал.
7. Сүлжээ байгуулж ажиллах нь тустай боловч хэрэгжүүлэхэд хялбар амар биш байдаг.

Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг нэгтгэн авч үзэхийн тулд өрхийн болон орон нутгийн түвшинд үйлдвэрлэл, нөхөн үйлдвэрлэл хэрхэн зохион байгуулагдсан, энэ нь зах зээл, засгийн газарт хэрхэн харилцан нөлөөлж байгааг зохих ёсоор шинжлэн үзэх шаардлагатай. Сүүлийн үед хийгдсэн хэд хэдэн судалгаанд үүнийг хэрхэн гүйцэтгэхийг дурьдсан байна. Янз бүрийн улс орны дэлгэрэнгүй жишээнд тулгуурлан Ховард (2003) жендэрийн харилцаа нь биологийн төрөл зүйлийн менежмент, хадгалалтанд хэрхэн нөлөөлдөг, яагаад зарим тохиолдолд, тухайлбал, орон нутгийн ургамлын төрөл зүйлийн менежментэд эмэгтэйчүүд түлхүү оролцдогийг харуулсан. Үр тариа ба биологийн төрөл зүйлтэй

холбоотой нэг жишээндээ Фарнворт, Жиггинс (2003:5) нар “Яагаад эрэгтэй, эмэгтэй хүмүүс эсвэл өөр өөр гарал намтартай эмэгтэй хүмүүс, өөр өөр зүйлийг илүүтэй эрхэмлэдэгийн нэг гол шалтгаан нь тэд *хүнсний гинжин цувралд* өөр байдлаар, өөр цаг хугацаанд, өөр байршилд оролцдогтой холбоотой” гэж үзсэн байдаг.

Тоймлон хэлбэл, нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг нэгтгэн авч үзэх нь байгалийн нөөцийн нөөцийг ашиглах боломж, хэрэглээ, хяналтыг зохицуулж буй нийгмийн болон эрх мэдлийн харилцааг илүү сайн ойлгож мэдэхэд нэн чухал юм. Энэ нь нийгмийн оролцогч талуудын ялгаа, тэгш биш байдлыг сайтар ойлгоно гэсэн үг бөгөөд тэрхүү байдал нь тухайн орон нутгийн нөхцөлөөс шалтгаалан өөр өөрийн онцлогтой байна.

Тодорхой тогтмол зүйлд биш эрх мэдэл буюу эрх мэдэлгүй байдал руу анхаарлаа хандуулах нь тэгш эрхийн асуудлыг шийдвэрлэх шинэ боломж, бололцоог нээн өгч байна. Практик дээр энэ нь оролцооны арга хандлагыг илүүтэй баримталж, аль нэг урьдчилан тодорхойлсон бүлгийн “хэрэгцээ” биш харин хүмүүсийн ялгаатай байдлыг дүгнэн шинжилж, түүнийг бодолцон ажиллана гэсэн үг юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн ялгаатай байдлыг мэдэрдэг, урьдчилан тодорхойлсон бүлэгтэй биш харин байгаа ялгаан дээр тулгуурлан ажиллах хэрэгтэй (Корнволл 2000:28-29).

Түүнчлэн технологи, бодлого, арга хэмжээний нийгмийн болон жендэрийн шинж байдлыг харгалзан, хүлээн зөвшөөрч байх нь чухал. Бодлого, технологи бол тодорхой үнэт зүйл дээр суурилсан байдаг бөгөөд эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд түүнд өөр өөр байдлаар оролцдог. Тэдэнд тусах нөлөө нь ч янз бүр байдаг.

Бодлого, төлөвлөлтөнд жендэрийн мэдрэмжтэй байна гэдэг нь жендэрийн болон бусад тэгш биш байдал хэрхэн үүсч, үргэлжилж байгааг ойлгохын тулд тухайн гэр бүл, зах зээл, төр, нутгийн иргэдийн дунд үйлдвэрлэлийн нийгмийн харилцаа хэрхэн явагдаж байгааг урьдчилан шинжилж үзэх хэрэгтэй гэсэн үг юм (Кабир 1997: 280-81).

Нийгэм жендэрийн дүн шинжилгээг судалгаанд нэгтгэн авч

үзэхийн өөр нэг шалтгаан бол эмэгтэй, эрэгтэй хүмүүст ямар нэг арга хэмжээ авах, орхигдсон буюу гадуурхагдсан бүлгийнхний хэлэлцээ хийх, тохиролцох эрх мэдлийг дээшлүүлэх, улмаар чадавхийг бэхжүүлж, өөрчлөлт хувирал хийн, байгалийн нөөцөөс хүртэх, түүнд хяналт тавих, үр шимийг нь хүртэх боломж олгох явдал юм.

Эдийн засагч, эрүүл мэнд, хөдөө аж ахуй салбарын төлөвлөгөө боловсруулагчид, байгаль орчны чиглэлээр ажиллагчид төлөвлөгөөндээ эмэгтэйчүүдийг зорилтот бүлэг болгон тусгахдаа эмэгтэй хүн юу хийж байна гэсэн явцуу утгад тулгуурласан байдаг. Гэтэл асуудлын гол нь эмэгтэйчүүд, ялангуяа ядуу эмэгтэйчүүд энэ бүх үүргийг зэрэг гүйцэтгэж, ихэвчлэн түүнийхээ төлөө ямар ч төлбөр авалгүй, олон цагаар ажилладагт оршиж байна. Салбар тус бүр өөр хоорондоо уялдаагаа хангалгүй хөгжлийн янз бүрийн арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлдгээс эмэгтэйчүүд цаг зав, эрч хүчээ өөр өөр зүйлд зарцуулах хэрэгтэй болдог. Тийм арга хэмжээ нь нэг бол амжилтгүй болно (энэ тохиолдолд төлөвлөгчид эмэгтэйчүүдийн биеэ авч явахдаа рациональ хандаж чаддаггүй гэсэн ойлголтоо улам бататгана), эсвэл эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг улам мөлжихөд хүргэх юм (дээрхтэй адил:270).

“Суралцах Судалгааны” Төсөл

Энэхүү нөхцөл байдлыг залруулах, түүнчлэн манай Ази судлаачдын судалгааны бүс нутагт тулгуурласан сургалт зохион байгуулж, нийгэм жендэрийн дүн шинжилгээг хэрэгжүүлэх практик туршлага, солилцох талаар тавсан хүсэлтийн шууд хариу болгон Олон улсын хөгжлийн судалгааны хоёр хөтөлбөрөөс нэлээд олон бүрдэл хэсэг бүхий чадавхийг бэхжүүлэх цогц хөтөлбөрийг боловсруулсан юм. Энэ хоёр хөтөлбөрийн нэг нь Олон нийтэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент (ОНТБНМ), нөгөө нь Биологийн төрөл зүйлийн тогтвортой хэрэглээ гэсэн хөтөлбөр байв. Азид биологийн төрөл зүйл болон байгалийн нөөцийн менежментэд нийгэм жендэрийн дүн шинжилгээг хийх чадавхийг дэмжих нь: Малгай төсөл гэдэг энэхүү шинэ хөтөлбөр нь 2002 онд батлагдсан бөгөөд шат дараатай

хэрэгжсэн билээ (Верной, Фажбер 2004:209-210).

Азийн улс орнуудын соёл заншил, хэл маш олон янз тул тухайн орон нутагт учир холбогдолтой арга, сургалтын арга барил шаардагдана гэсэн асуудлыг Олон улсын хөгжлийн судалгааны төвтэй хамтран ажиллагчид маань илэрхийлж байв. Ихэнх арга, онолын ойлголт зэрэг нь “барууны” гаралтай байдаг бөгөөд орон нутгийн нийгэм, соёлын орчин нөхцөлд тэр бүр таарахааргүй байдаг. Тиймээс чадавхи бэхжүүлэх тус хөтөлбөр нь тэдгээр орны судлаачидтэй нягт хамтран ажиллаж, тухайн орчинд арга хэрэгслээ тохируулах, ялангуяа үг хэллэг, суралцах үйл явцын жишээ зэргээ өөрчлөн зохицуулах зорилго тавин ажилласан юм.

Тус хөтөлбөрийн зорилгыг дурьдвал:

1. Сургалт болон дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдээр дамжуулан нийгэм жендэрийн дүн шинжилгээг нэгтгэн авч үзэх, анхан шатны түвшинд хэрэглэдэг болоход дэмжлэг үзүүлэх
2. Байгалийн нөөцийн менежментийн судалгаанд нийгэм жендэрийн дүн шинжилгээг нэгтгэн авч үзэхэд ашиглах тухайн соёл заншилд тохирсон арга барил, хэрэгслийг боловсруулах
3. Нийгэм жендэрийн дүн шинжилгээг байгалийн нөөцийн менежментийн судалгаанд нэгтгэн авч үзэх асуудлыг сонирхдог хөгжиж буй орны судлаачдын дунд өөр хоорондоо холбоо тогтоон ажиллах, мэдээлэл солилцох явдалд дэмжлэг үзүүлэх
4. Байгууллагууд өөрсдөө төсөл, үйл ажиллагаандаа жендэрийн асуудлыг нэгтгэн тусгадаг байх чадавхийг бэхжүүлэх
5. Азид байгалийн нөөцийн менежментийн судалгаанд нийгэм жендэрийн дүн шинжилгээг тусган авч үзсэн судлаачдын сайн практик, ахиц дэвшлийг баримтжуулах

Тус хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн нэг үйл ажиллагаа нь “Суралцах судалгаа” төсөл байв. 2002 онд эхэлсэн тус төсөл нь байгалийн нөөцийн менежментэд нийгэм жендэрийн дүн шинжилгээг нэгтгэн авч үзэх талаар судлаачдын өмнө нь хийж ирсэн арга хэмжээг илрүүлэн, тэрхүү үйл явцад юу сурч мэдсэнийг

харуулах амжилт, алдааны аль алийг нь баримтжуулах явдал байв. Тус төслийн хүрээнд Азийн таван орны сургалтын болон бусад салбарыг төлөөлсөн зургаан өөр баг оролцон ажиллав. Тэд биологийн төрөл зүйл, үр тариа болон мал аж ахуйг сайжруулах, бэлчээрийн тогтвортой хөгжил зэрэг байгалийн нөөцийн менежменттэй холбоотой хэд хэдэн асуултыг хамран судаллаа.

1. Сикким/Баруун Бенгал, Энэтхэг: Зүүн Гималайн сүлжээ. Энэ багт жендэрийн ба байгалийн нөөцийн менежментийн мэргэжилтэн Чанда Гурунг, хөдөө аж ахуйн сургалтын чиглэлээр суралцаж төгссөн боловч хөдөө аж ахуй, таримал ургамлын үржүүлгийн чиглэлээр ажиллаж буй Навраж Гурунг орсон
2. Нагаланд, Энэтхэг: Эдийн засгийн хөгжлөөр дамжуулан хүмүүсийн чадавхийг бэхжүүлэх Нагаландийн төсөл. Уг төслийн нийгэм жендэрийн дүн шинжилгээний баг нь хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийг сонирхон судалдаг нийгмийн ухааны судлаач Чозулье Кики, мөн хөдөө аж ахуйн чиглэлээр ажилладаг байгалийн ухааны судлаач Венгота Накро нараас бүрдэж байв.
3. Балба: Биологийн төрөл зүйлийн хамгаалал, хөгжлийн төлөө орон нутгийн санаачлага гэдэг төрийн бус байгууллага. Тус багт Дипа Сингх, хөдөө аж ахуйн сургалтын мэргэжилтэн Анил Сүбэди, хөдөөгийн хөгжлийн мэргэжилтэн Питамбер Шреста нар орж ажилласан.
4. Хятад: Хятадын Шинжлэх ухааны академийн Хөдөө аж ахуйн бодлогын төв. Тус төвийн нийгмийн ба жендэрийн судалгааны багт нийгмийн ухааны судлаач хоёр хүн орж ажилласан. Энэ бол хөдөөгийн хөгжлийг судалдаг Ючин Сон, хөдөө аж ахуйн эдийн засагч Линшү Жан нар юм.
5. Вьетнам: Хью хөдөө аж ахуй, ойн аж ахуйн их сургууль. Тус сургуулийн нийгэм жендэрийн дүн шинжилгээний багийг ой, хөдөө аж ахуйн мэргэжилтэн Хоанг Ти Сен, мал аж ахуйн мэргэжилтэн Ле Ван Ан нар төлөөлж ажиллав. Энэ хоёр судлаач хоёулаа хөдөөгийн хөгжлийн асуудлыг сонирхон

ажилладаг.

6. Монгол: Байгаль орчны яам болон Зохистой хөгжлийн жендэр төв. Нийгэм жендэрийн дүн шинжилгээний багт хэд хэдэн байгууллагын судлаач орсон. Хижабагийн Ыханбай, Энхбатын Булган нар Байгаль орчны яаманд, Цэрэндоржийн Одгэрэл бол Зохистой хөгжлийн жендэр төвд ажилладаг, харин Баатарын Наранчимэг Монгол Улсын Их сургуульд суралцдаг.

Ихэнх төсөл нийгэм жендэрийн дүн шинжилгээг харгалзан үзээгүй хэмээн шүүмжлэгддэг бөгөөд уг шинжилгээг маш сайн, бараг төгс хийсэн төслийг л үнэлж үзэх тал бий. Харин энэхүү төслийн хувьд бид суралцана гэдэг нь давтагдан үргэлжлэх үйл явц гэсэн байр сууринаас хандав. Бүс нутгийг дамнан хэрэгжсэн уг төсөл нь суралцах явцад хийсэн алхмуудыг дэмжиж, урамшуулж ирсэн. Энэхүү номонд орсон жишээнүүд нь бодит амьдралаас авсан, бодит амьдралд тохиолдсон бэрхшээл, боломж, амжилт, алдааг харуулсан жишээнүүд бөгөөд Азийн улс орнуудын соёл заншлын өөр өөр орчин нөхцөлд тохируулан хэд хэдэн өөр арга ашигласан гэдгийг эдгээр жишээнээс харж болно.


Эдгээр судалгаа нь чадавхийг бэхжүүлэх талаар юу хийгдсэнийг дурдаад зогсохгүй чухам яаж хийгдсэнийг, одоо юу хийж байгааг танилцуулж, нийгэм жендэрийн дүн шинжилгээг нэгтгэн авч үзэхэд эерэг болон сөрөг ямар хүчин зүйл үйлчилж байгааг харуулах болно. Түүнчлэн чадавхи бэхжүүлэх энэхүү ажиллагаанд ямар дэмжлэг үзүүлбэл илүү үр дүнтэй вэ гэдгийг асуух болно.

Жишээлсэн судалгааны арга барил нь зургаан үндсэн асуулт дээр тулгуурласан. Үйл ажиллагаанд чиглэсэн арга барил гэх мэт онол, арга зүйн шинжтэй бүрдэл хэсгийн зэрэгцээ семинар, орон нутагт очиж ажиллах гэх мэт давтан явагдах үйл явц, түүнчлэн хэд хэдэн бүтээлийг агуулж байна. Эдгээр 6 судалгааны хүрээнд судалгааны үйл явц яаж явагдвал зохих (Зураг 1.1) талаар нэгдмэл нэг онол боловсруулсан (Паттон 1997). Төлөвлөлтийн үед тэдгээр хоорондоо уялдаатай үе шатыг багууд нэвт харж сэтгэхэд уг бүдүүвч тус болсон бөгөөд харин судалгааны төгсгөлд амьдрал дээр чухам

яаж явагдсаныг эргэцүүлэн бодоход нэг хэрэглүүр болж өгсөн билээ.

Эдгээр зургаан жишээ нь тухайн орон нутагтаа анхдагч гэж хэлж болох арга хэмжээ болсон тул жендэрийн мэргэжилтнүүдийн удирдлаган дор хийгддэг зарим ажлуудтай хольж ойлгож болохгүй. Эдгээр жишээг хамтад нь авч үзвэл маш олон төрлийн стратеги, арга барил, арга зүй ашиглагдсан болно. Зарим жишээ нь “эмэгтэйчүүд ба хөгжил” хандлага, түүний шинж чанарыг агуулж байхад зарим нь эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн асуудлыг гол болгохгүй “жендэр ба хөгжил” гэдэг хандлагад илүү нийцэх арга барилыг ашиглажээ (Коннели нар. 2000:140-148; Ратгебер 1994). Мөн зарим жишээ нь дээрх хоёр хандлагын аль алийг нь агуулж, үндсэндээ “эмэгтэйчүүд ба хөгжил” хандлагаас “жендэр ба хөгжил” хандлага руу шилжих замаар хэрэгжсэн (Хүснэгт 1.1-д аль аль хандлагын гол шинж чанарыг харуулав). Хоорондоо яг адил жишээ гэж байхгүй. Бид төгсгөлийн бүлэгт эдгээр хандлага, тэдгээрийн шинж чанарын тухай эргэн авч үзэх болно.

Зураг 1.1 Үйл ажиллагааны онол



Хүснэгт 1.1.

“Эмэгтэйчүүд ба хөгжил” болон “Жендэр ба хөгжил” хандлагын үндсэн шинж чанарууд

Шинж чанар	Эмэгтэйчүүд ба хөгжил	Жендэр ба хөгжил
Голлон анхаарч буй зүйл	Эмэгтэйчүүд, тэднийг хөгжлийн үйл ажиллагаанаас орхигдуулж байгаа байдал	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох нийгмийн нөлөөлөл дор бүрдэн тогтсон харилцаа, эмэгтэйчүүд захирагдах байр суурь эзэлж байгаа байдал
Асуудал юунд оршиж байгаа талаарх үзэл бодол	Эмэгтэйчүүдийг орхигдуулж байгаа байдал	Эрх мэдлийн тэгш биш харилцаа
Зорилго	Эмэгтэйчүүдийг оролцуулж, хөгжлийг илүү үр дүнтэй болгох	Тэгш, тогтвортой хөгжил, зохистой оролцоо, шийдвэр гаргалт
Шийдэл	Эмэгтэйчүүдийг хөгжлийн үйл явцад бүрэн оролцуулах	Өөрөө өөртөө эзэн болох, нийгмийн өөрчлөлт
Гол стратеги	Эмэгтэйчүүдийн төсөл, эмэгтэйчүүдийн бүтээмж, орлогыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн өрх гэрээ авч явах чадавхийг дээшлүүлэх	Жендэрийн болон бусад тэгш биш байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр хөгжлийн үйл явцыг онолын хувьд өөрчлөн тодорхойлох, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн практик хэрэгцээг тодорхойлж, шийдвэрлэх, эмэгтэйчүүдийн стратегийн сонирхлыг харгалзан үзэх, ядуу болон гадуурхагдсан бүлгийн хүмүүсийн стратегийн сонирхлыг харгалзан үзэх

Эх сурвалж: Коннели нараас авав. (2000:141)

Тайлбар. Зарим зохиогчид гурав дахь хандлага буюу “эмэгтэйчүүд, байгаль орчин, хөгжил” (Лич нар, 1995) гэсэн хандлагыг тусад нь авч үздэг. Энэхүү хандлагын хувьд эмэгтэйчүүдийг байгаль орчинтой харьцаж буй байдалд нь үндэслэн байгалийн нөөцийн гол хэрэглэгч, менежер гэж үздэг. Зургаан судалгааны аль нь ч энэхүү хандлагыг авч хэрэглээгүй тул бид энэ талаар дэлгэрэнгүй өгүүлээгүй болно.

Багуудын харилцан тохирсон үндсэн зургаан асуултыг дурдъя. Үүнд:

1. Байгалийн нөөцийн менежмент дэх нийгэм жендэрийн дүн шинжилгээ гэдэг нь өөр өөр оролцогч талуудад ямар утгаар ойлгогдож байна вэ?

жендэрийн дүн шинжилгээг тусгахтай холбоотой есөн чухал асуудал түгээмэл тохиолдож байгаа нь харагдсан билээ. Үндсэн зургаан асуултанд зарим талаар хариу өгч буй эдгээр есөн элемент нь оролцогч талуудын талаар дүн шинжилгээ хийх; жендэрийн үүрэг, түүний тодорхойлолт болон тайлбар; олон талын хамтын ажиллагаа, түүнийг эхлүүлж, урамшуулан дэмжих; чадавхийг бүрдүүлэх олон төрлийн стратеги; чадавхийг бэхжүүлэх боломж олгохгүй байх, туршлагаа дээд шатанд болон бусад салбар руу тархаан түгээх; үр нөлөөний дүн шинжилгээ хийх (зохих арга зүй, хэрэглүүр), тогтвортой байдал (экологийн болон нийгэм-эдийн засгийн); системтэй баримтжуулалт зэрэг юм.

Аль ч нөхцөл байдалд эдгээр есөн асуудал бүгд биш гэхэд ихэнх нь өөр хоорондоо уялдаатай илэрдэг. Тухайлбал, оролцогч талуудын хамтын ажиллагааг эхлүүлэхийн тулд оролцогч талуудын дүн шинжилгээг зохих ёсоор хийсэн байх шаардлагатай. Ядуу эмэгтэйчүүд чадавхийг бэхжүүлэх стратегийг хэрэгжүүлэхийн тулд хөдөлмөрийн хуваарь; газар, ус, үр тариа, мал зэргийн нөөцийг ашиглах боломж; зээл, сургалт зэрэг үйлчилгээнд хамрагдаж буй байдал; эмэгтэйчүүдийн зохион байгуулалт зэрэг тухайн соёл заншилд оршин буй жендэрийн үүргийг ойлгосон байх шаардлагатай. Эдгээр есөн асуудлын дөрвийг (жендэрийн үүрэг, түүний тодорхойлолт болон тайлбар; чадавхийг бэхжүүлэх олон төрлийн стратеги; үр нөлөөний дүн шинжилгээ) ярилцлагын явцад цаашид гүнзгийрүүлэн авч үзэх хэрэгтэй гэсэн санал гарсны үндсэн дээр сонгон авсан юм. Энэ нь судалгаа өнөөг хүртэл ямар үр дүнд хүрээд байгаа, түүний чанар, ач холбогдлыг сайжруулахын тулд ямар ажил хийх хэрэгтэй байгаа вэ гэдгээс үүдэн гарсан шийдвэр байв.

Номын Бүтэц

Энэхүү удиртгал бүлгийн дараа тус номын гол цөм болох зургаан жишээлсэн судалгааг танилцуулна. Жишээнүүд ерөнхий нэг бүтцээр бичигдсэн бөгөөд жишээ тус бүрийн эхэнд тухайн судалгааны удиртгал нөхцөл байдлыг дурьдсан болно. Дараа

Хүснэгт 1.2.
Зургаан судалгааны онцлог шинжүүд

Жишээлсэн судалгаа	Голлон анхаарсан асуудал	Арга	Шийдвэрлэвэл зохих гол асуудлууд
Сикким/ Баруун Бенгал	Цагаан гааны үйлдвэрлэл болон өвчлөлийн менежментэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэж буй үүрэг	Цагаан гааны үйлдвэрлэлийн жендэрийн дүн шинжилгээ	Соёл заншлын асуудал, шилжих хөдөлгөөн, үндэстэн ясны болон анги давхаргын зөрчилдөөн
Нагаланд	Маркетинг ба эмэгтэйчүүдийн оролцоо	Үйлдвэрлэгч-хэрэглэгчийн гинжин харилцааны жендэрийн дүн шинжилгээ	Эдийн засгийн өөрчлөлт, хүн амын өсөлтийн үзүүлж буй дарамт, орон нутгийн улс төрийн байдал
Балба	Үрийн үйлдвэрлэл, маркетингэд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн гүйцэтгэж буй үүрэг	Үрийн үйлдвэрлэлийн жендэрийн дүн шинжилгээ: оролцоонд тулгуурласан хөдөөгийн үнэлгээ, үр үйлдвэрлэгчдийн бүлгийг үндэслэн байгуулах	Албан шугамаар хийгдэж буй судалгаа орон нутгийн хэрэгцээг тусгаж чадахгүй байгаа байдал, шинэ бодлого
Хятад	Хөдөө аж ахуйд эмэгтэйчүүд голдуу ажиллаж буй үзэгдэл, албан ёсны судалгааны тогтолцоо нь хөдөөгийн амьдралаас тасархай байгаа байдал	Оролцоонд суурилсан ургамлын үржүүлэг, нийгмийн “оролцон тоглогчдын” судалгаа, эмэгтэйчүүдийн бүлэг	Макро-эдийн засгийн хурдацтай өөрчлөлт, төр ба үндэсний цөөнхийн асуудал, шинэ бодлого
Вьетнам	Хөдөөгийн хөгжил дэх эмэгтэйчүүдийн үүрэг	Эмэгтэйчүүдийн хэрэгцээ, сонирхлын шинжилгээ, оролцоонд тулгуурласан хөдөөгийн үнэлгээ, сонирхлын бүлгүүдийн үүсгэл	Соёл заншлын асуудлууд, макроэдийн засгийн өөрчлөлт, төр ба үндэсний цөөнхийн асуудал, шинэ бодлого
Монгол	Мал аж ахуйн менежментэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг	Эмэгтэйчүүдийн хэрэгцээ, сонирхлын судалгаа, оролцоонд суурилсан хөдөөгийн үнэлгээ, сонирхлын бүлгүүдийн үүсгэл	Соёл заншлын асуудлууд, шинэ бодлого, хууль

Эх сурвалж: Жишээлсэн судалгааны төслөөс

Хүснэгт 1.3.

Зургаан жишээлсэн судалгаанд хэрэглэсэн арга зүй, хэрэглүүр, ур чадвар

Жишээлсэн судалгаа	Арга зүй, хэрэглүүр, ур чадвар
Сикким/ Баруун Бенгал	Судалгааны төсөл бичих ур чадвар (зорилго нь тодорхой, судалгааны асуулт нь оновчтой байх); орон нутгаас судалгааны туслах ажилтан авч ажиллуулах (эмэгтэй, эрэгтэй хүмүүс); оролцоонд тулгуурласан хөдөөгийн үнэлгээний хэрэглүүр, түүхэн нөхцөл байдлын дүн шинжилгээ, харилцааны ур чадвар; бусад төсөлтэй туршлагаа хуваалцах
Нагаланд	Асуулга, ярилцлага, фокус бүлэг, оролцоонд суурилсан хөдөөгийн үнэлгээ зэрэг хэрэглүүр; оролцон ажиглалт; хэлэлцээ хийх ур чадвар; сурталчилгаа хийх ур чадвар
Хятад	Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ хийх үйл ажиллагааны төлөвлөгөө; үйл ажиллагаанд чиглэсэн хамтарсан судалгаа (тухайлбал, оролцоонд суурилсан ургамлын үржүүлэг); эмэгтэйчүүдийн бүлгийг бэхжүүлэх; фермийн аж ахуй эрхлэгчдийн (эмэгтэй) хоорондын, судлаач болон хөдөө аж ахуйн сургалтын мэргэжилтнүүдийн хоорондын холбоог сайжруулах; бодлогын дүн шинжилгээ болон туршилт; оролцоонд тулгуурласан хяналт-шинжилгээ ба үнэлгээ; бусад төсөлтэй туршлагаа хуваалцах
Балба	Өмнө гарсан ном материалтай танилцах; оролцоонд суурилсан хөдөөгийн үнэлгээний хэрэглүүр; засгийн газартай хамтран ажиллах
Вьетнам	Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ хийх үйл ажиллагааны төлөвлөгөө; хамтарсан судалгаа; хөдөө аж ахуйтнуудын сонирхлын бүлгийг бий болгох; оролцоонд суурилсан хөдөөгийн үнэлгээний хэрэглүүр; оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ ба үнэлгээ; хөдөө аж ахуйн сургалтын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах; сургалт явуулах ур чадвар
Монгол	Өмнө гарсан ном материалтай танилцах; оролцоонд суурилсан хөдөөгийн үнэлгээний хэрэглүүр; чанарын судалгааны аргууд; оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ ба үнэлгээ; зохион байгуулах ур чадвар; дэм өгөх ур чадвар; сургалт явуулах ур чадвар; бусад төслүүдтэй туршлагаа солилцох
Бүх судалгаа	Үйл явц, үр дүнг нарийвчлан баримтжуулах

Эх сурвалж: Жишээлсэн судалгааны төслөөс

Тухайн орон нутгийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх, судалгааны онцлог асуултанд хариулах зорилгоор судалгааны баг бүр онцлог арга зүй, хэрэглүүр боловсруулсан. Тэдгээрийг нэгтгээд үзэхэд арга зүй маш баялаг бөгөөд олон төрөл бүхий цуглуулга болж

чадсан билээ (Хүснэгт 1.3).

Түүнээс гадна мэдлэг, туршлагаа байнга хуваалцаж байх талаар харилцан тохирсон. Сүлжээ болж ажиллахад чиглэсэн зарим арга хэмжээ, тухайлбал, нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент төслийн хүрээнд байгуулсан вебэд тулгуурласан Виртуаль төв, хэрэгжүүлж буй төслүүд дээр харилцан зочилж очих, 2003 онд хоёр дахь семинарыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг тодорхойлсон юм (тайлангийн бүрэн эхийг <http://www.cbnrmasia.org> хаягнаас харна уу). Ингээд семинараас олж мэдсэн зүйл дээрээ тулгуурлан судлаачид маань эргээд ажилдаа идэвхийлэн орцгоосон билээ.

Судалгааны талбар дээр хийгдсэн ажлыг дүгнэн шинжилж, харьцуулж үзэх нь: Хоёр дахь семинар

Хоёр дахь семинар 2003 оны 10 дугаар сард Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо болсон. SARS өвчин дэлгэрснээс шалтгаалан орон нутгийн судалгааны ажил, аялал хэдэн сараар хойшлогдон анх төлөвлөж байснаас хожуу болсон билээ. Бээжингийн семинартай адил төстэй арга барилаар зохион байгуулагдсан уг семинарт оролцооны аргыг голчлон баримталж, нэгдсэн болон бүлгийн ажлын үеэр хувь хүн бүр оролцон, санал бодлоо илэрхийлэх боломжоор хангаж өгсөн. Семинарыг судлаачид хариуцан удирдаж явуулсан бөгөөд нийт дараахь дөрвөн хэсэгт хуваагдаж байв. Үүнд: жишээлсэн судалгааг танилцуулах (судалгааны бүс нутагт хийгдсэн ажлын тайлангийн төслийг үзүүлэн, зураг, видео (Монголын баг) ашиглан танилцуулах), эргээд оролцогчдын санал сэтгэгдлийг сонсох; түгээмэл тохиолдож буй асуудлыг тогтоох; жишээлсэн судалгаа/жишээг цаасан дээр буулган бичих; төлөвлөлт зэрэг болно.

Түгээмэл Тохиолдож Буй Асуудлууд

Судалгааны багуудын бэлтгэсэн жишээлсэн судалгааг эргэн уншиж, хамгийн их анхаарал татсан, орхигдсон эсвэл дутуу дурьдагдсан зүйлийг нэгтгэх явцад байгалийн нөөцийн менежментэд нийгэм

2. Нийгэм жендэрийн дүн шинжилгээг хийхийн тулд оролцогч талуудад ямар үндсэн чадавхи шаардагдаж байна вэ?
3. Эдгээр чадавхийг хэрхэн хөгжүүлж, бэхжүүлж байна вэ? (сүлжээ холбоо, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх замаар гэх мэт)
4. Эерэг ямар хүчин зүйл байна вэ? Сөрөг ямар хүчин зүйл байна вэ?
5. Янз бүрийн түвшний оролцогч талуудын хувьд өнөөг хүртэл олсон ямар амжилт байна вэ?
6. Нийгэм жендэрийн дүн шинжилгээ, нийгмийн болон жендэрийн тэгш эрхийг сайжруулахад өөр юу хийж болох вэ?

“Суралцах Судалгаа” Явагдсан Үе Шатууд

Нийтлэг асуудлуудыг тодорхойлох нь: Эхний семинар

2002 оны 5 дугаар сарын 8-12-нд судалгааны зургаан багийн гишүүд Бээжинд цугларсан бөгөөд өмнө нь хийж байсан боловч одоо хийгдэж байгаа судалгааны ажил, туршлагаа бие биедээ танилцуулж, нийгэм жендэрийн дүн шинжилгээний талаарх ойлголтоо хуваалцах, энэ талаар хийж буй ажлаа сайжруулахын тулд тодорхой төлөвлөгөө боловсруулах зорилго тавьсан. Нийгэм жендэрийн дүн шинжилгээг төсөл, хөтөлбөр, байгууллагуудад нэгтгэн тусгахад гарч буй хүндрэл, хаанаас эхэлж болох вэ зэргийг тодорхойлсон. Баг тус бүр нийгэм жендэрийн дүн шинжилгээний тодорхой аль нэг асуултад (ихэвчлэн одоо явагдаж буй судалгааны ажлынхаа хүрээнд) хариулах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан. Нийгмийн ба жендэрийн холбогдолтой асуудал тухайн орчин нөхцлөөсөө хамаарах нь дамжиггүй боловч ерөнхийдөө төслүүдэд нийгмийн болон жендэрийн ямар асуудал тулгардаг талаар нэгдсэн ойлголтод хүрсэн. Зургаан судалгааны гол онцлогийг Хүснэгт 1.2-т тоймлон харуулав.

нь тухайн нийгмийн ба жендэрийн асуудлын учир шалтгаан, судалгааны зорилт, судалгааны асуултыг товч тайлбарлана. Жишээлсэн судалгааны гол хэсэг нь тухайн судалгааны асуултанд хариулахын тулд судалгааны бүс нутаг хийгдсэн ажлын үр дүн юм. Тус номын бүлэг Өмнөд Азиас эхлэн Зүүн-Өмнөд Ази, дараа нь Зүүн-Хойд Азийн судалгааг хамрах болно. Үүнд:

- 2 дугаар бүлэг: Цагаан гааны үйлдвэрлэл, зах зээлд нийлүүлэх явцын нийгмийн болон жендэрийн шинж байдал: Энэтхэгийн Сикким дэх Рай, Лепча, Брахмин-Чхетри, түүнчлэн Баруун Бенгалын Калимпоны жишээн дээр тулгуурласан судалгаа (Чанда Гурунг, Навраж Гурунг).
- 3 дугаар бүлэг: Хүнсний ногоо худалддаг эмэгтэйчүүдийн зах зээлтэй холбогдох байдлыг сайжруулах: Энэтхэгийн Нагаландийн Кохимагийн жишээнд тулгуурласан судалгаа (Венгота Накро, Чозулье Кики).
- 4 дүгээр бүлэг: Газар тариаланчдын маркетингийн мэдлэгийг дээшлүүлэх, орон нутгийн үрийн системийг бэхжүүлэх: Балбын Бара мужийн агро-биологийн төрөл зүйлийн хадгалалт, хэрэглээг сайжруулах зорилго бүхий үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа (Дипа Сингх, Анил Сүбэди, Питамбер Шреста).
- 5 дугаар бүлэг: Фермийн аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхийг бий болгох, орон нутгийн үрийн системийг сайжруулах: Хятадын Гунши мужид хийгдсэн үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа (Ючин Сон, Линшү Жан, Ронни Вернойн хамт).
- 6 дугаар бүлэг: Өөрчлөлт хийгдэх боломж олгох: Вьетнамын Хью дэх өндөрлөг газар амьдардаг бүлгийн эмэгтэйчүүд, ядуучуудын нийгмийн капиталыг бэхжүүлэх судалгаа (Хоанг Ти Сен, Ли Ван Ан).
- 7 дугаар бүлэг: Малчин эмэгтэйчүүд ярьж байна: Монголд бэлчээр болон байгалийн нөөцийн хамтын менежментийг тэгш оролцоотой хэрэгжүүлэх (Х.Ыханбай, Ц.Одгэрэл, Э.Булган, Б.Наранчимэг).

Жишээлсэн судалгаануудын дараа судалгааны багуудад түгээмэл тохиолдсон асуудал, бэрхшээлийг харьцуулан дүн шинжилгээ хийв. Эмпирик судалгааны үр дүнд тулгуурласан энэхүү дүн шинжилгээг хоорондоо уялдаатай хоёр бүлэгт өгүүлсэн болно. 8 дугаар бүлэгт 1, 5, 6 дахь үндсэн асуултанд (өмнө дурьдсан) хариулсан бөгөөд нийгмийн болон жендэрийн холбогдолтой асуудлыг голлон авч үзсэн. Тус бүлэгт тухайн менежментийн практикт нөлөөлж буй гол хүчин зүйлийг харьцуулан авч үзэхийн зэрэгцээ тэгш эрх болон байгаль орчны тогтвортой байдлын хувьд шинээр үүсэн бий болж буй зарим асуудлыг харьцуулж үзлээ. Түүнчлэн судалгааны бүсүүд дээр байгалийн нөөцийн менежментэд нийгмийн болон жендэрийн харилцаа хэрхэн өөр өөрөөр, мөн адил төстэй байдлаар нөлөөлж байгааг харуулах болно. Тус бүлэгт жишээнүүдийг дүгнэн шинжлэхдээ дүрслэн үзүүлэх шинж чанартайгаас эхлэн өөрчлөгч судалгаа хүртэл үргэлжилсэн шугамын дагуу авч үзсэн бөгөөд “эмэгтэйчүүд ба хөгжил”, “жендэр ба хөгжил” хандлагатай холбон харууллаа. Зургаан судалгаа тус бүрдээ энэхүү үргэлжилсэн шугамын аль нэг элементийг агуулж байгаа билээ.

Харин 9 дүгээр бүлэгт 2, 3, 4 дэх үндсэн асуултад хариулсан бөгөөд судалгаа ба хөгжлийн үйл ажиллагаанд нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг тусгах үйл явцад голлон анхаарав. Чадавхи бэхжүүлэх асуудлын тухайд судалгааны үйл явцад ямар амжилтанд хүрч, ямар бэрхшээл тулгарсныг энэ бүлэгт нэгтгэн дүгнэсэн болно. Судалгааны эцэст мэдээж сүүлчийн, мөн төгс биш боловч урам зориг өгөхүйц үр дүнд хүрч чадсан. Ихэнх жишээний хувьд судалгаа үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд өөр шинэ асуудал ч үүсэн гарч байна. Тус бүлгийн төгсгөлд шийдвэрлэвэл зохих зарим томоохон асуудлыг тодорхойлон; байгууллагын өөрчлөлт, нийгэм жендэрийн дүн шинжилгээг судалгааны үндсэн үйл явцад нэгтгэн тусгах; үргэлжлэн оршсоор буй тэгш бус байдал болон эмэгтэйчүүдийн чадавхийг бэхжүүлэх; оролцооны чанарыг дээшлүүлэх; макро хүчин зүйлийн нөлөөллийг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг авч үзэв. Төгсгөлийн хоёр бүлэгт микро эсвэл макро аль ч өнцгөөс харсан байгалийн нөөцийн менежментийн асуудал

бол нийгмийн ба жендерийн хувьд саармаг биш шүү гэдгийг онцлон тэмдэглэхийг зорилоо. Үүний зэрэгцээ өдөр тутмын менежментийн практикийг бүрдүүлж буй үйл явц бол хэзээ ч аль нэг талыг зөвхөн хамардаггүй гэдгийг жишээлсэн судалгаанууд харуулж байгаа билээ. Энэ бол судалгааны нэгэн чухал бодит үр дүн байв.

Тайлбар 1. Үйлдвэрлэл, нөхөн үйлдвэрлэл гэдэг нь өрх гэр, хамаатны холбоо зэрэг нийгмийн суурь нэгж амьдралаа залгуулах, нэгжийнхээ амьдрах баталгааг хангахын тулд ашиглаж буй үйл ажиллагаа, стратегийг хэлнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Agarwal, B. (2001). Participatory Exclusions, Community Forestry, and Gender: An Analysis for South Asia and a Conceptual Framework. *World Development* 29 (10): 1623-48.
- Connell, P., T. Murray, L. M. MeConnell and J. L. Parbat (2000). Feminism and Development: Theoretical Perspectives. In J. L. Parbat, M. P. Connolly and V. E. Bantilan, eds. *Theoretical Perspectives on Gender and Development*, pp. 51-159. Ottawa: International Development Research Centre.
- Connell, A. (2000). Making a Difference? Gender and Participatory Development. IDS discussion paper 378. Institute of Development Studies, Sussex.
- Farnworth, C. R. and J. Jiggins (2003). Participatory Plant Breeding and Gender Analysis. РРВ monograph no. 4, Participatory Research Gender Analysis Program, Cali.
- Howard, P., ed. (2003). *Women and Plants: Gender Relations in Biodiversity Management and Conservation*. London: Zed Books.
- Kabeer, N. (1997). *Reversed Realities: Gender Hierarchies in Development Thought*. London and New York: Verso.
- (2003). *Gender Mainstreaming in Poverty Eradication and the Millennium Development Goals: A Handbook for Policy-makers and Other Stakeholders*. London: Commonwealth Secretariat, Ottawa.

- International Development Research Centre; Hull: Canadian International Development Agency.
- Leach, M., S. Joeekes and C. Green (1995). Editorial: Gender Relations and Environmental Change. *IDS Bulletin*, 26(1): 1-8.
- Patton, M.Q. (1997). *Utilization-focused Evaluation: The New Century Text*. Thousand Oaks: Sage Publications.
- Rathgeber, E.M. (1994). WID, WAD, GAD: Tendances de la Recherche et de la Pratique Dans le Champ du Developpement (WID, WAD, GAD: Research Trends in Gender and Development). In H. Dagenais and D. Piché, eds, *Femmes, Feminisme et Developpement* (Women, Feminism and Development), pp. 77-97. Montreal and Kingston: McGill-Queen's University Press.
- Vernooy, R. and L. Fajber (2004). Making Gender and Social Analysis Work for Natural Resource Management Research: An Umbrella Program for Building Researcher Capacity. In *Gender Mainstreaming in Action: Successful Innovations from Asia and the Pacific*, pp. 208-23. Washington: InterAction's Commission on the Advancement of Women and Silang; Cavite: International Institute of Rural Reconstruction.

2

ЦАГААН ГААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ ЯВЦ ДАХЬ НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН БАЙДАЛ

*Энэтхэгийн Баруун Бенгаль дахь Сикким болон
Калимпоны Рай, Лепча, Брахмин-Чхетри нарын
жишээ*



Зураг авсан: НАВРАЖ ГУРУНГ

ЧАНДА ГУРУНГ БОЛОН НАВРАЖ ГУРУНГ

Судалгааны Бүс

Сикким нь зүүн Гималайн (газар нутгийн хэмжээ: 7,299 км²; Өндөр: далайн түвшнээс 300-8580 метр) доторх уул нуруун дунд орших Энэтхэг улсын нэгэн жижигхэн муж улс юм. Калимпон (газар нутгийн хэмжээ: 1,056.5 км²) нь 1706 оноос өмнө Сиккимийн нэг хэсэг байсан ба одоо Зүүн Бенгал мужийн¹ Даржеелин дүүргийн (газар нутгийн хэмжээ: 3,281,87 км²; өндөр: далайн түвшнээс 300-3,000 метр) дөрвөн дэд дүүргийн нэг нь юм. Дээрх хоёр муж нь зэрэгцэн оршдог бөгөөд зүүн Гималайн хөдөө аж ахуйн-уур амьсгалын бүсэд харьяалагддаг. Энэ бүс нутгийн уур амьсгал нь харилцан адилгүй бөгөөд зүүн-хойд хэсэгт агаарын температур нь хүйтэн ба альфийн нурууны уур амьсгалтай, харин өмнөд хэсэгт дулаан орны уур амьсгалтай байдаг. Хур тунадасны дундаж хэмжээ нь жилд 2,000-4,000 мм байдаг.

Тус бүс нутаг нь гурван үндсэн угсаатны бүлгээс бүрддэг бөгөөд эдгээр нь Бхотиачууд (16-17-р зуунд Түвд болон Бутан улсаас Сикким мужид ирсэн цагаачдын үр сад), Лепчачууд (Сикким мужийн уугуул иргэд), Балбууд (18-19-р зуунд Балба улсаас ирсэн цагаачид) юм. Үүнээс гадна бизнесменүүд, худалдаачид, үйлчилгээ эрхлэгчид, ажилчид зэрэг Сиккимд ирсэн бусад үндэстэнээс бүрдэнэ.

Газар тариалан нь тус бүс нутгийн хамгийн гол салбар бөгөөд нийт хүн амын 80 хувь нь хөдөө аж ахуйн салбараас амьжиргаагаа залгуулдаг. Хүн амын өсөлт өндөр байгаатай холбоотойгоор нэг хүнд ногдох газрын хэмжээ огцом буурч байгаа учраас газар тариалан эрхлэгчдийн ихэнх нь жижиг бизнес эрхэлж байна. Тус

Зураг 2.1
Сикким мужийн судалгааны нэгжүүдийн байршил



Эх үүсвэр: Перри-Кастенадагийн номын сангийн газрын зургийн цуглуулга

бүс нутгийн уур амьсгал, улирлын онцлог нь цагаан гаа, халуун өвс, төмс, цэцэрлэгийн ургамал зэрэг өндөр үнэтэй ургамал, ногоог тариалахад тохиромжтой. Ерөнхийдөө, цагаан будаа, улаан буудай, жүржийг нам газар тариалдаг бөгөөд эрдэнэ шиш, төмс, цагаан гаа, халуун өвс зэргийг өндөр уулархаг газар тариалдаг байна. Цаг уурын тааламжтай нөхцлөөс хамааран хүмүүс худалдааны зориулалтаар цэцэг тариалах нь элбэг байдаг.

Өөрийн хэл, уламжлалт соёл бүхий олон янзын үндэстэн ястан энэ бүс нутагт оршин суудаг. Гэвч удаан хугацаанд хамт байсан учраас эдгээр ихэнх үндэстэн ястан бие биедээ уусаж, харьцангуй нэгдмэл болсон. Улмаар, адилхан шүтлэг, дадал хэвшилтэй болсон төдийгүй янз бүрийн хэлний нэр томъёог түгээмэл ашиглах болсон. Нэгдмэл байдал үүссэнийг илтгэх томоохон жишээ гэхэд оршин суугчид гэр орноосоо бусад бүх газар бараг бүгд балба хэлээр ярьдаг болжээ. Судалгааны бүсийн хүн ам зүйн талаарх мэдээллийг Хүснэгт 2.1-д харуулав.

Хүснэгт 2.1
Судалгааны 2 мужийн хүн ам зүйн мэдээллийг үндэсний мэдээлэлтэй харьцуулсан нь, 2001 он

	Калимпон	Сикким	Үндэсний хэмжээнд
Нийт хүн ам	225,143	540,493	1,025,251,059
Эрэгтэй хүн ам	115,521	288,217	530,422,415
Эмэгтэй хүн ам	109,622	252,276	494,828,644
Хот суурин газрын хүн ам	42,980	60,005	284,995,688
Хөдөө орон нутгийн хүн ам	182,163	480,488	740,255,371
Хүн амын нягтрал	413/км ²	76/км ²	324/км ²

Эх үүсвэр: Сиккимийн засгийн газар (1993); Держеслин дүүрэг, Калимпон, Зүүн Бенгалын Засгийн газар, Дэд-дүүргийн алба, Соёл мэдээллийн хэлтэс (албаны эх сурвалжаас).

Ястан Угсаатны Бүлэг

Лепча

Лепчачууд нь Сикким ба Калимпоны уугуул иргэд бөгөөд зүүн Гималайгаас бусад нутагт тэднийг бараг мэддэггүй. Тэдний гарал үүслийн талаар хэд хэдэн таамаглал байдаг бөгөөд тэдгээрээс

дурьдвал, зарим судлаачид Түвд улсаас гаралтай гэж үздэг бол (Пинн 1986), харин зарим нь Зүүн Балбын Кирайтчуудтай үндэс угсаа нэгтэй гэж үздэг (Фоннин 1986). Гэхдээ энэ талаарх батлагдсан онол, бодит мэдээлэл байдаггүй. Лепчагийн үүсэл гарлын тухайд ямар нэг газраас цагаачилж ирсэн гэсэн түүх эсвэл уламжлалын тухай дурьдаагүй байдаг ч тэд өөрсдийгөө Канченжунга уулын бурхан оргил, түүнийг хүрээлэн буй сав хөндий нутгаас гаралтай гэж үздэг бөгөөд өөрсдийгөө Бүхнийг бүтээгч эхийн хайрт хөвгүүд буюу *мутанчи ронгкан* гэж нэрлэдэг.

Лепчачуудад хамгийн их нөлөөлсөн үндэстэн нь тухайн бүсэд оршин суудаг хоёр том үндэстэн болох Сикким мужийг 300 орчим жил эзлэн захирсан *Түвд үндэстэн* болон 18, 19-р зууны эцсээр Сикким, Даржеелин дүүргүүдэд цагаачлан ирсэн *Балба* үндэстэн юм. Түвдүүд эрх барьж байсан тул их хүчтэй байсан бөгөөд харин олон тооны цагаач Балбачууд нь нийгмийн амьдралд нь маш их нөлөөлсөн. Үүнээс гадна, Английн колони байсан Даржеелин дүүргээс ирсэн христос шашныг дэлгэрүүлэгчид мөн нөлөөлжээ.

Рэй

Рэйчүүд нь угсаа зүйн хувьд онцлог боловч Түвд-Бирм овог аймагт харьяалагддаг янз бүрийн хүмүүсээс бүрдсэн бүлэг юм. Рейчүүд нь бие махбод, хэл яриагаараа мөн зарим талаар соёлын хувьд Ассамын уулархаг нутаг болон Гималайн дэд мужийн зүүн хэсэгт тархсан Түвд-Бирмчүүдтэй төстэй. Рейчүүд зүүн Балбад (Лимбуаны газар нутагт) ирэх үедээ өмнөд хиндүчүүдийн санскритжуулах гэсэн оролдлого, мөн хойд хэсгийн буддистуудын шашин шүтлэгээс хараат бус байж, өөрийн үндэсний онцлог шинж чанараа хадгалж үлдэж чаджээ (Чемжон 1966). Гэвч 18-р зууны дундуур нэгдсэн Балба улс байгуулах үед буюу 1787 онд Балба улсын Горхачууд Лимбуан нутаг дахь рей болон лимбус үндэстнийг (Баснет 1974) эзлэн авсаны дараа рэйчүүд Балба улсын харьяанд оржээ. Амьдралын уламжлалт хэв маягт нь тулгарсан багагүй бэрхшээлээс үүдэн тэдний шашин шүтлэг, нийгэм соёл, амьдралын хэв маяг нь их хэмжээгээр өөрчлөгдсөн. 19-р зууны эхээр рейчүүд цайны

цэцэрлэгт ажиллах, эзгүй газарт суурьшихаар Сикким, Даржеелин рүү дүрвэн ирж, ойг цэвэрлэж, орлогын эх үүсвэр олохоор эрэлхийлж эхэлсэн. Тухайн үед рэйчүүд нь “балбачууд” болон хувирч, өөрсдийн уламжлал, үндэстэн ястныхаа онцлог шинж чанарын ихэнхийг алдаж, хиндичүүдтэй их адил болсон байна.

Брахмин-Чхетри

Эдгээр хоёр бүлэг нь Энэтхэг-Ари бүлгийн Хас угсаатанд харьяалагддаг. Түүхийг нь сөхвөл, чхетричүүд нь Горхогийн хаант улсын эрх баригчид байсан бөгөөд брахминчүүд нь Чхетри хааны (Субба 1992) харьяанд байсан каст (анги, давхаргыг хэлдэг)-уудын нэг юм. Хоёр бүлэг хоёулаа хиндичүүд бөгөөд Балба улсын дээд кастад ордог байв. 19-р зууны эхэн үед Энэтхэг-Балба болон Балба-Сикким хоорондын дайны дараа тэд Сикким, Даржеелин муж руу дүрвэж эхэлсэн. Ялангуяа Балба ба Британийн колони Энэтхэг улс хооронд 1817 онд Титалигийн хэлэлцээр байгуулсаны дараа тэд Даржеелинд үзэгдэж эхэлсэн бөгөөд тэр үед Британчууд тэднийг цэрэгт татаж, зэлүүд атар газар ажиллах ажилчид, тариачид болгон суурьшуулж эхэлсэн. Британичууд Сиккимийг дайнд ялсаны дараахь жилээс эхлэн буюу 1861 онд Сиккимд нүүж суурьшсан. (Хэдийгээр Британичууд Сиккимчуудыг ялсан боловч газар нутгийг нь нэгтгэж аваагүй тул Сикким хараат муж болсон [Рао 1978]). Британичүүд тэднийг “дайны үе дэх цэрэг байснаас энх тайвны үе дэх тариачин байсан нь хоёр дахин илүү” гэдгийг ойлгосон учраас Сикким рүү дүрвэж, эзгүй газар суурьшихыг нь дэмжсэн (Баснет 1974:42). Брахминчүүд удалгүй тэднийг дагаж, энэ бүс нутагт суурьшсан бөгөөд Чхетри болон такурчүүд тэднийг санваартан болгохоор авчирсан.

ЦАГААН ГААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛТ, ХУДАЛДААНЫ ЯВЦ ДАХЬ НИЙГЭМ ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн ба жендэрийн харилцаа нь нийгэм, соёлын болон түүхэн нөхцөл байдлаас хамаарсан олон хүчин зүйлсийн үр дүнд

үүсдэг. Нийгмийн ба жендэрийн систем нь шашин шүтлэг, угсаатны тодорхойлолттой холбоотой боловч нийгмийн гадаад хүчин зүйлсийн хүчтэй нөлөөнд байдаг. Иймээс нийгмийн, ялангуяа жендэрийн харилцаа нь уламжлалт нийгэмд шинэ харилцаа үүсэх, өөрчлөлт гарах бүрт байнга шинэчлэгдэн, хувирч байдаг (Гурунг 1999). Судалгаанд хамрагдсан гурван угсаатны бүлэг доторх болон тэдгээрийн хоорондын нийгмийн ба жендэрийн харилцааг ойлгох, дүн шинжилгээ хийхийн тулд тус бүс нутаг, түүний оршин суугчдын түүхийг судлах нь чухал байв. Бидний судалгаанаас нэлээд өөрчлөлт бүхий, нарийн төвөгтэй дүр зураг харагдаж байна.

Аль ч нийгэмд жендэрийн төлөөлөл харилцан адилгүй, өөрөөр хэлбэл нэг хэвийн бус, хоорондоо зөрчилдсөн байдаг. Аливаа эмэгтэй хүний амьдрал, үйл ажиллагаа нь тэрээр жендэрийн үзэл баримтлалыг хэрхэн хүлээн зөвшөөрч, тэвчиж, эсэргүүцэж, үл тоомсорлож буйг нь илтгэдэг. Үүнээс гадна эмэгтэй, эрэгтэй хүмүүс тухайн нөхцөл байдлаас хамаарч амьдралынхаа янз бүрийн мөчлөгт болон төрөл бүрийн үйл ажиллагаанд ялгаатай ханддаг. Иймд, тухайн эмэгтэй, эрэгтэй хүний үйл ажиллагаа болон практикаас нь өөрчлөлтийн өргөн хүрээтэй хүчин зүйлс нь хувь хүний амьдралаар дамжин орон нутгийн түвшинд хэрхэн нөлөөлж буйг харж болно. Гэвч ихэвчлэн эрчүүдийн төсөөллөөр төгс сайханд тооцогдох нөхцлийг бүрдүүлэгч нийгмийн нэг хэвийн захиалгыг нийгмийн хэтэрхий хийсвэр ойлголтоор авч үзэх үед хувь хүн бүрийн сонголт, гаргаж буй үйлдлийн ач холбогдлыг ихэвчлэн үл ойшоодог (Ваткинс 1996).

Судалгааны бүсийн ихэнх тариачдын хувьд цагаан гаа нь худалдах зориулалттай цорын ганц биш юмаа гэхэд үндсэн тариалан юм. Хэдийгээр халуун өвс ба цай нь худалдах зориулалттай чухал тариалан боловч тэднийг худалдааны зориулалтаар тариалахын тулд илүү тусгайлсан нөхцлөөр хангах хэрэгтэйгээс гадна харьцангуй том талбай шаардлагатай болдог. Дээрх хоёр бүтээгдэхүүнийг ялангуяа цайг хэрэглэгчдэд хүргэхээс өмнө боловсруулах шаардлагатай. Үүний эсрэгээр, цагаан гааг эдийн засгийн хувьд хэмнэлттэйгээр жижиг талбайд, ямар ч төрлийн орчинд тариалж болно. Ийм ч

учраас жижиг тариаланчид цагаан гааг тариалж боловсруулахгүйгээр худалдах эсвэл өөрсдийн хэрэгцээнд ашиглах боломжтой. Цагаан гааг жил бүр, үндэстэй үрийг (орч.тайлбар: хөрсөн доогуур ургадаг үндэс шиг хэлбэртэй ургамал) хагас жил тутамд хураадаг бөгөөд үүнээс үндсэн үндэстэй үрийг ургалтын циклийн дунд үед, харин шинэ үндэстэй үрийг бүрэн ургаж дууссаны дараа хураадаг. Тариачдын хувьд цагаан гаа их чухал тул түүний үйлдвэрлэлийн эргэлт дэх хяналт, шийдвэр гаргалт онцгой ач холбогдолтой.

Худалдаажуулалтай² уялдан томоохон өөрчлөлтүүд гарч байна. Рейчүүд цагаан гааны гол тариалагчид бөгөөд лепчачууд шашны ёслолд зориулан цагаан гааг тариалдаг байв. Хоёр үндэстэн хоёулаа үйлдвэрлэлийн уламжлалт аргыг ашигладаг байсан. Харин халуун өвсний үйлдвэрлэл чухал бизнест тооцогдох болсон тул бусад үндэстэнүүд, ялангуяа балба, хиндү, брахмин-чхетри нар халуун өвсний үйлдвэрлэл эрхэлж эхэлсэн. Эдгээр үндэстэн өөрийн гэсэн шүтлэг, практик, технологи, тариалангийн арга техниктэй байсан бөгөөд тэдний үйлдвэрлэлийн практик нь лепча, рей нарт аажмаар нөлөөлж эхэлсэн. Үүнтэй зэрэгцээд цагаан гааны зах зээлийн үнэ цэнэ нэлээд өссөн. Цагааг гааг тариалахад уламжлалт бус аргуудыг түлхүү ашиглах болсон бөгөөд шинэ техникүүдийг практикт нэвтрүүлсэн. Мөн цагаан гаатай холбоотой шийдвэр гаргах, хяналт тавих, тариалах үйл явцад жендэрийн үүрэг өөрчлөгдсөн.

Эдгээр өөрчлөлт нь хэд хэдэн томоохон өөрчлөлт гарахад хүргэсэн. Сүүлийн 15-20 жилд газар тариалантай холбоотой өвчлөлийн улмаас ургацын өгөөжийн харьцаа нь 1 “үр” үндэстэй үр нь 8-10 үндэстэй үр болж ургадаг байсан бол энэ харьцаа нь дөнгөж 1:2-3 болж өөрчлөгдсөн. Ихэнх тариаланчид цагаан гааг тариалахаа больсон бөгөөд үлдсэн хэсэг нь орлого олох өөр тариалангийн бүтээгдэхүүн байхгүй учраас амьжиргаагаа залгуулах төдий хэмжээнд халуун өвсний тариалалт эрхэлж байна. Үүнтэй холбоотойгоор орлого болон амьжиргааны түвшин буурсан.

Цагаан гааг худалдаалах үнэ өсөж эхэлмэгц брахмин-чхетри нар өөрсдийн илүү боловсронгуй арга, шинэ технологийг ашиглан цагаан гааны тариалалтыг түлхүү эрхлэх болсон бөгөөд рей,

лепча нар цагаан гааны уламжлалт хяналт, эрх мэдлээ алдсан. Үндэстэн хоорондын нийгмийн харилцаа өөрчлөгдсөн. Балба улсаас цагаачилж ирсэн брахмин-чхетри нар бусад хоёр бүлэгтэй харьцуулахад хөдөө аж ахуйн талаар арвин туршлагатай учраас илүү сайн үйлдвэрлэгч гэж дүгнэгдэх болжээ. Тэд нийгмийн харилцаа сайтай, шинэ мэдээлэл олж авах боломж ихтэй, хөдөө аж ахуйн шинэ технологитой байсан тул газар өмчлөлийн хувьд рей, лепча нараас түрүүлж, нийгмийн бүтцийн хувьд давамгайллагч бүлэг болж чадсан. Рей, лепча нар тэдний практик болон шашин шүтлэгийг бага зэрэг өөрчлөн өөрсдийн практикт аажмаар нэвтрүүлж эхэлсэн.

Брахмин-чхетри нар цагаан гааны тариалалтыг давамгайлах болсоноор цагаан гааны үйлдвэрлэл, хяналтанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг огцом буурсан. Жишээлбэл: эмэгтэй хүнийг “ариун бус” гэж үздэг хиндү шүтлэгээс болоод тэднийг газар тариалангийн талбай руу орох, тэр байтугай тарианд хүрэхийг ч хориглодог. Хиндичүүд гэрийн “гадуурх”, “доторх” ажилд гүйцэтгэх жендэрийн үүргийг хатуу тогтоосон нь үүн дээр нэрмээс болсон. Тэд мөнгөтэй холбоотой ямар ч ажлыг гэрийн “гадуурх” ажил гэж үздэг бөгөөд иймээс эрчүүдийн хариуцах ажил гэж тооцдог. Иймд цагаан гаа нь худалдах зориулалттай гол тариалан учраас эрчүүдийн хяналтанд бүрэн оржээ.

Нэлээд хэдэн төсөл, судалгааны багууд цагаан гаатай холбоотой өвчнөөс ангижрах гарц хайж байна. Ийм төрлийн өвчний талаарх тариаланчдын төсөөлөл, мэдлэг, уламжлалт практикийн талаар санал асуулга явуулсан. Эдгээр судалгаа, санал асуулгыг үндэслэн шинэ туршлага боловсруулсан. Гэхдээ энэ судалгаа, туршилтын ажил нь зөвхөн эрэгтэй хүнийг чухалчилсан сул талтай бөгөөд нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээг огт хамруулаагүй.

Судалгааны Зорилтууд Ба Судалгааны Асуултууд

Энэ судалгаа нь цагаан гааны үйлдвэрлэл, худалдаа, өвчнийг бууруулах менежментийн нийгмийн ба жендэрийн онцлогт нь голчлон анхаарчээ. Судалгаа нь олон хүний хувьд ач холбогдолтой.

Нэгдүгээрт, судлаачдад - нийгмийн ба жендэрийн өөрчлөлтийг ойлгох, ахуй амьдрал болон цагаан гааны хувьд нийгмийн янз бүрийн бүлгүүд ямар давуу болон сул талтай байгааг тодорхойлоход нь тусална. Хоёрдугаарт, судалгааны төвийн ажилтан, хөгжлийн ажилтнуудад - нийгмийн ба жендэрийн өөрчлөлтийг ойлгох, ингэснээр практикт хэрхэн нөлөөлдөгийг нь тогтоох бөгөөд тариаланчид илүү таатай хүлээж авах арга хэрэгслийг бий болгоход нь туслаж чадна. Гуравдугаарт буюу эцэст нь, тариаланчдад – өөрсдийн арга, практикийг хянаж үзэх, өвчнөөс үүдэлтэй бэрхшээлүүдийг шийдэх шийдлийг өөрсдөө олоход нь тусална.

Мөн энэ судалгаа нь цагаан гааны үйлдвэрлэлийн менежмент, хяналтын үйл явцад эмэгтэйчүүдийг оролцуулах стратегийг боловсруулах зорилготой. Эмэгтэйчүүдийн практик ашиг сонирхлыг дэмжих ийм төрлийн стратегиуд нь тэдний ахуй амьдралд эерэг өөрчлөлт гарахад түлхэц болно гэж бид найдсан юм. Тус бүс нутгийн эмзэг бүлэг (эмэгтэйчүүд, ядуучууд, доод кастынхан)-ийнхэнд орлого авчирдаг цагаан гааны үйлдвэрлэлд хяналт тавих үйл явцад оролцоход нь саад болж буй болон боломж олгож буй хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон юм.

Судалгааны ажлыг дараах асуултын дагуу явуулсан юм. үүнд:

1. Гурван үндэстний бүлгийн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд нь цагаан гааг тариалах, худалдахад ямар үүрэг, хариуцлага хүлээх вэ?
2. Эдгээр гурван бүлгийн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд нь үндсэн нөөц (газар, хөдөлмөр, мэдлэг, капитал)-тэй холбоотой шийдвэрийг хэрхэн гаргадаг вэ?
3. Нийгмийн ба жендэрийн харилцаанд болон нийгэмд гарсан ерөнхий өөрчлөлт нь цагаан гааны үйлдвэрлэл г.м чухал үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтанд хэрхэн нөлөөлдөг вэ?

Судалгааны Бүс

Бид өөрсдийн судалгааг Зүүн Гималайн сүлжээ (ЗГС)-ний

зохицуулагч бөгөөд тус бүс нутгийг сайн мэддэг хүнтэй хийсэн ярилцлагаар эхэлсэн. Энэ нь рей, лепча, брхамин-чхетри хүмүүсийн хувьд цагаан гаа ямар ач холбогдолтой тухай яриа руу хөтөлсөн.

Цагаан гааны түүхэн мэдээлэл

Рэй. Рейчүүд цагаан гааг шашны бүх төрлийн ёслолд ашигладаг байсан тул чухал ач холбогдолтой гэж үздэг. Цагаан гаа зах зээлд борлуулагддаг болохоос өмнө ч гэсэн рейчүүд гэрийнхээ ойролцоо жижиг талбайд тариалдаг байсан. Тариаланчид олон төрлийн заншил, практикийг мөрддөг байснаас хамгийн чухал нь цагаан гааны талбайд гэр бүлийн гишүүн бус хүмүүс болон бүх төрлийн амьтдыг оруулахыг хориглодог байв. Үнэн хэрэгтээ, зарим гэр бүлийн зөвхөн нэг гишүүн буюу ихэвчлэн өрхийн тэргүүн нь л талбайд орох эрхтэй байжээ. Цагаан гааны талбайд ариун сахиус оршдог бөгөөд талбайд орж ирсэн гадны хүмүүс түүний хорлолд өртөж, улмаар түүний хөл нь догolon болох, хавдах (орч.тайлбар: dewa буюу лусын хорлол) зэрэг өвчин тусдаг гэж тэд итгэдэг байв. Цагаан гааны ургацыг хураахдаа гэр бүлүүд шашны зан үйл буюу *наяа ко нүжа* (орч.тайлбар: шинэ ургацын мөргөл)-г гүйцэтгэн шинэ ургацын дээжийг бурхан болон ариун сахиуст өргөдөг. Энэхүү зан үйлийг гүйцэтгэсний дараа л цагаан гааг гэртээ авчирч, хүнсэндээ ашиглах боломжтой байв.

Лепча. Лепчачууд цагаан гааг шашны бүх төрлийн ёслолд ашиглахаас гадна өвчинг анагаах³ зорилгоор ашигладаг байсан тул энэхүү ургамлыг хүндэтгэж, бусад тариалангийн бүтээгдэхүүнээс нэн тэргүүнд тавьдаг байв. Өөр айлаас цагаан гаа авч, шашны зан үйлд ашиглахыг хориглодог байсан тул бүх лепча айл түүнийг тарьдаг байсан. Иймээс Лепча, бхотиачуудын хувьд цагаан гаа харьцангуй ач холбогдолтой хэвээр үлдсэн. Рейчүүдийн нэгэн адил, лепчачууд шинэ цагаан гааг ашиглах, идэх, гэртээ авчрахаас өмнө шашны зан үйл гүйцэтгэдэг. Энэ зан үйлийг гүйцэтгэхдээ Тийста голын ариун сүнснийг дууддаг бөгөөд түүхий тутрага, улаан тахиа, нутгийн дарс, бага хэмжээний цагаан гааг тахилд өргөдөг. Тахил өргөж, шашны дуулал дуулагдсаны дараа ариун сүнснийг эх газарт нь буцааж залдаг. Хэрэв энэ зан үйлийг гүйцэтгэхгүй бол гэр бүлийн гишүүд өвдөх,

мал амьтан үхэх, газар тариалангийн ургац муу байх зэрэг гай тотгор тухайн гэр бүлд учрах болно гэж итгэдэг байв.

Брахмин-чхетри: Эдгээр хүмүүс нь энэ бүс нутагт 19-р зууны үед суурьшсан бөгөөд цагаан гааг худалдаа, бизнесийн хувьд ач холбогдолтой болсон цагаас эхлэн тариалах болсон. Цагаан гаа нь тэдний хувьд шашны болон соёлын хувьд ач холбогдолтой биш учраас худалдах ургацын хэмжээгээ нэмэгдүүлэхийн тулд шинэ технологи, аргыг практикт нэвтрүүлсэн. Энэ нь дээрх хоёр үндэстэнг бодоход газар тариалангийн цоо шинэ практикийг нэвтрүүлэхэд хүргэжээ.

Төслийн зорилтот газрын сонголт

Бид тухайн газар нутагт цагаан гаа чухалд тооцогддог бөгөөд рей, лепча эсвэл брахамин-чхетри гурван үндэстний аль нэг нь давамгайлж буй газруудыг хайж байв. Мөн хэтэрхий тархай бутархай бус, мөн тариачид нь төслийн ажилд оролцох сонирхолтой тийм газрыг хайж байсан. Эдгээр шалгуурыг үндэслэн төслийн баг хөдөө аж ахуйн хэлтэс, судалгааны төвүүд, сүүний хоршоодын холбооны хөгжлийн ажилтнуудтай зөвлөлдсөний эцэст боломжтой гэж үзсэн газруудын жагсаалтыг гаргасан. 7 тосгоныг сонгож, очиж үзсэн. Эцэст нь, тосгон нэг бүрийн талаарх цуглуулсан мэдээллийг үндэслэн Калимпон хотын хоёр тосгон, Сиккимийн нэг тосгоныг сонгосон.

Харка-Сангсэй. Энэ тосгон нь Калимпон дэд дүүргийн 1-р хорооны Сангсэй панчаят (орч.тайлбар: засаг захиргааны нэгж)-д харьяалагддаг. Энэ тосгоны нийт хүн амын 75 хувийг рейчүүд эзэлдэг (Хүснэгт 2.2). 10-15 орчим тооны тариачид өөрийн эзэмшлийн газаргүй. Хамгийн ойр орших хот нь Калимпон бөгөөд 8-10 км зайтай. Тосгоны тариачдын нэгний өгүүлсэнээр Харка-Сангсэй өмнө нь бхотиячуудад харьяалагдаж байсан бөгөөд тэнд мал сүргээ бэлчээрлүүлдэг байжээ. Ийм тариачин гэр бүл дэх зарим рейчүүд өөрсдийн малыг бэлчээрлүүлэхээр бас авчирсан байна. 4 үеийн өмнөх рейчүүд газар худалдан авч, тэндээ суурьшжээ. Олон рейчүүд аажмаар нэмэгдэн ирснээр энэ тосгон нь рейчүүдийн

харьцангуй том тосгон болсон.

1968 онд болсон газар хөдлөлтийн үеэр ихэнх газар нь устаж үгүй болсон бөгөөд дөнгөж 30 хувьд нь газар тариалан эрхлэх боломжтой үлджээ. Хүмүүс газар тариалан эрхлэх боломжгүй газар нь тэжээлийн зориулалттай мод, бут тарьж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор энд мал аж ахуй эрхлэлт сайжирсан.

Хүснэгт 2.2
Сонгогдсон тосгонуудын өрх айлын тоо, үндэстнүүдийн эзлэх хувь хэмжээ

Судалгааны газар	Тосгон	Өрх айлын тоо	Олонх болж буй үндэстний эзлэх хувь хэмжээ	
			Рэй (90)	Бусад өрх айл
Калимпон	Харка-Сангсэй	120	Рэй (90)	Чхетри, Прадхан, Таман, Мангар
	Наси	83	Лепча (53)	Таман, Прадхан, Чхетри
Калимпон	Пешо	117	Лепча (45)	Тусгай кастууд* (14 эсвэл 15) Лимбу эсвэл Субба
	Ташидин	40	Лепча (23)	Брахмин, Прадхан
Сикким	Тав Пандам (Карнифан, Бүрүн, Сажон)	500	Брахмин-чхетри (400)	Бхотияа (30) Рей (30), Бисвакарма (Хиндүгийн доод каст) (7), Таман (10)

Тайлбар: *Энэтхэг улсын үндсэн хуульд хиндү ястны дотроос нийгмийн хувьд хоцрогдож байгаа кастуудыг үндсэн хуулийн хуваарьт жагсааж, тэдгээрийг тусгай кастууд гэж нэрлэжээ. Тэдгээр каст нь хиндү кастаас доогуурт тооцогддог.

Гол тариалан нь цагаан гаа, халуун өвс, цэцэг, бут, хүнсний ногоо, эрдэнэ шиш юм. Тосгоныхон будаа ургуулахыг оролдсон боловч газар нь чийг хадгалдаггүй тул амжилт олоогүй. Бүх өрх айл газар тариалангаас амьжиргаагаа залгуулдаг боловч тэдний тариалангийн хэмжээ бага юм. Бүх тариачид болон өрх айл худалдах зориулалттай цорын ганц бөгөөд үндсэн тариалан болох цагаан гааг тариалдаг.

Наси, Пешо, Ташидин. Эдгээр гурван тосгон нь Калимпон хотын

орчимд нэг нэгэнтэйгээ зэрэгцэн оршдог (Хүснэгт 2.2). Хамгийн ойр орших хот нь Калимпон бөгөөд ойролцоогоор 8-10 км зайтай. Тухайн хот орчмын бусад тосгоны нэгэн адил ихэнх хүмүүс нь газар тариалангаас амьдралаа залгуулдаг жижиг тариаланчид юм. Үндсэн тариалан нь будаа, эрдэнэ шиш боловч тэд бөөрөнхий чинжүү, цагаан гаа, өргөст хэмх, улаан лооль, бусад хүнсний ногоог тариалдаг. Оршин суугчдын ярьсанаар 15 жилийн өмнө нийт газар тариалангийн талбайн 40-45 хувьд цагаан гааг тариалдаг байсан боловч одоо 5 хувиас бага талбайд л тариалж байна. Өнөө үед ихэнх тариачид цагаан гааг зөвхөн гэр бүлийн хэрэгцээнд зориулан тарьж байна. Цагаан гааны тариалалтын хэмжээ огцом буурсан нь өвчинтэй холбоотой.

Төв Пандам. Төв Пандам нь Сиккимийн зүүн дүүрэг дэх грам панчат (орч.тайлбар: засаг захиргааны хамгийн жижиг нэгж) юм. Энэ газар нь зургаан хороотой боловч Карнифан, Бүрүн, Сажон гурвыг л судалгаанд зориулан сонгосон. Эдгээр хороонд ойролцоогоор 500 өрх айл амьдардаг бөгөөд үүнээс 400 нь брахмин-чхетричүүд (Хүснэгт 2.2) юм. Брахмин-чхетри, бхотияа, рей, бисвакарма нар сикким хүмүүс бөгөөд харин таманчууд ихэвчлэн Балба улсаас ирсэн хүмүүс юм. Тэд жилийн төлбөр төлж түрээсийн газар эзэмшин газар тариалан эрхэлдэг. Ойролцоогоор 300 брахмин-чхетри өрх айл болон бусад кастын бүх өрх айл буюу нийт 400 орчим өрх айл халуун өвс тариалдаг. Бусад гол тариалан нь эрдэнэ шиш, гич, хар будаа, сагаг, бут, хүнсний ногоо юм. Хамгийн ойр орших хот нь Рангпо бөгөөд 5 км орчим зайтай оршдог.

Өрх айлууд

Өрх айлууд, тариачдыг сонгохдоо эд хөрөнгө, өрхийн тэргүүн нь (өрх толгойлсон эмэгтэй, эрэгтэй, эхнэр нөхөр хоёулаа) залуу, шинийг санаачлагч байх, шашин шүтлэг, тухайн газрын өдрийн цагийн урт, аж ахуйн хэмжээ зэрэг шалгуурыг ашигласан. Гол мэдээлэгчидтэй ярилцсаны эцэст тухайн газар бүрээс өөр өөр ангилалд хамрагдах өрх айлуудын 15 тариачны жижиг бүлгийг сонгосон. Угсаатны тухай гүнзгий мэдлэг, төсөөлөл олж авахын тулд

судалгааны нэгж бүрээс нэг эмэгтэй, нэг эрэгтэй хүнийг талбарын ажилтнаар сонгож авсан бөгөөд өөрийн тосгон, нэгдлээс мэдээлэл цуглуулахад нь туслах зорилгоор үндэстэн ястны бүлгүүдийг сонгосон. Талбарын ажилтнуудыг харилцааны ур чадварын аргууд болон хагас-бүтэцжүүлсэн ярилцлага авахад суралцуулсан.

Арга хэрэгслүүд

Төслийн янз бүрийн үе шатанд төрөл бүрийн арга хэрэгсэл ашигласан. Мэдээллийг цуглуулахын тулд улирлын хуанли, үйл ажиллагааны танилцуулга, хагас-бүтэцжүүлсэн ярилцлага, бүлгийн хэлэлцүүлэг, гол мэдээлэгчид, газар дээрх ажиглалт зэрэг хөдөөгийн оролцооны үнэлгээ (ХОҮ)-ний төрөл бүрийн аргыг ашигласан. Бид хэд хэдэн ярилцлага хийснээс гадна хоёрдогч эх үүсвэр (ном, сэтгүүл, баримт бичиг, нийтлэл)-ээс авсан мэдээлэл нь түүхэн мэдлэг, мэдээлэл өгсөн. Тухайн газар нутаг дахь цагаан гаа тариалалт ач холбогдолтой болохоос өмнөх үед, цагаан гаа бизнесийн хувьд ач холбогдолтой болсон үед, цагаан гааны тариалалт өвчлөлд өртсөн тэр үед, брахминчууд тус бүсэд ирж суурьшихаас өмнөх үед, брахминчууд ирж суурьшсаны дараа бөгөөд цагаан гааг тариалж эхлэх үед болон өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл олж авахыг зорьсон. Мэдээллийн дүн шинжилгээг цагаан гааны тариалалт, өвчлөл, менежменттэй уялдуулан нийгмийн ба жендэрийн гүйцэтгэх үүрэгт голчлон анхаарч гүйцэтгэсэн. Бид үндсэн оролцогчид, эдийн засгийн харилцаа, зах зээл, институтчлалын уялдаа холбоо зэрэг хувьсах хүчин зүйлийг онцлон авч үзсэн.

ЦАГААН ГААНЫ ТАРИАЛАЛТ БА ХУДАЛДААЛАЛТ

Гурван тосгоны цагаан гааны тариалалтын түүх

Харка-Сангсэй. Рейчүүд энэ нутагт дөрвөн зууны туршид амьдарч байгаа бөгөөд бусад хүмүүс аажмаар ирж суурьшсан. Эрт дээр үед

тариачид цагаан гааг газар тариалангийн уламжлалт арга буюу нийт тариалангийн талбайг үхрийн аргалаар бордож, хөрсөнд нь шингээсний дараа эгнээ, давхарга үүсгэлгүйгээр тариалдаг байв. Газар тариалангийн талбайг мал болон тэжээвэр амьтдаас хамгаалахын тулд хашаагаар хамгаалдаг байсан. Харка-Сангсэйн тариаланчид *нангри* (цагаан гааны төрөл, дүрслэвэл “хумс буюу савар”-тай цагаан гаа) төрлийн цагаан гааг тариалдаг байв.

Хүмүүс 1965-66 оны үед цагаан гааг худалдаалах үнийн талаар Горубофан (Калимпаноос 65-70 км зайтай зүүн талд нь оршдог хот) хотын рэйчүүдээс мэдсэнийхээ дараа цагаан гааг их хэмжээгээр тариалдаг болсон. Тариаланчид *горубофани* (горубофан гэдэг үгнээс гаралтай) гэж нэрлэгддэг цагаан гааны үрийг Горубофаны тариаланчдаас авч эхэлсэн бөгөөд одоо энэ төрөл нь *нангри* төрлийн цагаан гааг бүрэн орлох болсон. Тариаланчид энэ төрлийг илүү том бөгөөд зах зээл дээр сайн үнээр борлогддог учир илүүд тооцдог. Тэд зургаан жилийн өмнөөс эхлэн цагаан гаа өвчилж эхэлсэнийг анзаарчээ.

Тариаланчдын үзэж байгаагаар цагаан гаа тариалдаг бусад газартай харьцуулахад Харка-Сангсэй давуу талтай байдаг гэж итгэдэг бөгөөд гол нь энэ нутаг сүүдэр газарт оршдог, илүү сэрүүхэн байдгаас цаг агаарын хувьд нэн тааламжтай. Гэвч үр болгон ашиглах үндэстэй үрийн тариалалтын хувьд энэ давуу тал нь таатай нөхцөл болж чаддаггүй. Орон нутгийн үр нь сайн чанарынх бус учраас тариаланчид хөрш тосгонуудаас жил бүр үр худалдаж авах шаардлагатай болдог.

“Санскрит”-жаад удаж буй рэйчүүд хиндүгийн заншил, практикийн заримыг нь дагаж мөрддөг. Жишээлбэл: сарын тэмдэг нь ирсэн эмэгтэйчүүд сар бүр 10-12 өдрийн туршид цагаан гааны тариалангийн талбайд орох хориотой байдаг нь энэ үедээ эмэгтэйчүүд хортой нян биедээ тээж байдгаас агаараар дамжин цагаан гаанд өвчин авчрах магадлалтай гэж үздэг. Мөн рэйчүүд билгийн тооллын хуанлийн дагуу сарнаас хамаарч 27 хоногт ойролцоогоор нэг удаа тохиолдож хоёр өдрөөс долоо хоногийн туршид үргэлжилдэг *саран*-ы үед тариалангийн талбайд ажиллахгүй

байх хиндү заншлыг дагадаг. Үүнээс гадна гэр бүлийн хэн нэг гишүүн нас барсан тохиолдолд гашуудалтай байх хугацаанаас хамаарч 13 хоногийн туршид тариалангийн талбайд ажиллах, орохыг хориглодог. Гэр бүлд шинэ гишүүн мэндэлсэн үед рейчүүд долоо хоногийн туршид цагаан гааны талбайд ажиллахыг хориглодог бөгөөд энэ үед гэр бүл ариун бус болсон гэж үздэг.

Пешо, Наси, Ташидин. Цагаан гааг их хэмжээгээр тариалахаас өмнө ашигладаг байсан цорын ганц бордоо нь үнс байсан бөгөөд түүгээр талбайг бүхэлд нь борддог байв. Эрчүүд нь газар хагалж, эмэгтэйчүүд нь тариагаа тарьдаг байв. Тэд тухайн жилийн тарианаасаа үндэстэй үрийг цуглуулж, дараа жил нь тариалахын тулд талбайд ухсан нүхэнд булж хадгалдаг. Лепчагийн настай тариачин нэгэн сонирхолтой баримтыг дурдсан нь дээр үед бусад үндэстнүүд цагаан гааны талбайд ариун сүнс оршиж байгаа гэдгээс айдаг байсан тул, рэй, лимбус нараас үр худалдаж авдаггүй байсан. Тэднээс үр худалдаж авбал *дева* (орч.тайлбар: лусын хорлол)-гийн өвчин авна гэж итгэдэг байсан ажээ.

Энэ нутагт цагаан гааг худалдах бизнес лепчачуудын дунд дөнгөж 1979-80-аад оны үед л эхэлсэн. Бусад тариаланчид ялангуяа Пешо тосгоны таманчууд цагаан гаа худалдаж, их хэмжээний орлого олж байгааг мэдмэгцээ Лепча тариаланчид цагаан гааг арилжааны зориулалтаар тариалах болсон. 80-аад оны эхэн үед лепча тариаланчдын 50 хувь нь цагаан гааг худалдах зориулалтаар тариалж эхэлсэн боловч настай гэр бүлүүд энэ жишгийг дагаагүй. Удалгүй өвчлөл эхэлсэн тул худалдах зориулалтаар тариалах нь огцом буурсан. Одоогийн байдлаар энэ нутгийн зөвхөн 10 хувь нь цагаан гааг худалдах зориулалтаар тариалж байна.

80-аад оны дунд үеэс өвчлөл огцом нэмэгдсэн. Зарим тариаланчдын үзэж байгаагаар цагаан гааг худалдах зориулалтаар тариалж эхлэх тэр үед хангалттай хэмжээний үр байгаагүй учраас өөр газраас үр авчирсан нь өвчлөлтийн гол шалтгааны нэг нь юм. Тэд гаднаас авчирсан үндэстэй үр нь өвчин авчирсан гэж үздэг. Тариаланчид тус нутагт ирдэг байсан лалын шашинтнуудаас

ч мөн үр худалдаж авдаг байв. Өвчний шалтгааны талаарх өөр таамгуудыг ч тариаланчид дэвшүүлж байна. Тариаланчид цагаан гааг их хэмжээгээр тариалах болсноос хойш ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд бордоог их хэмжээгээр ашиглаж эхэлсэн болохоор нэг шалтгааныг бордоотой холбож үздэг. Их хэмжээний тариалалт гэдэг нь өвчлөлтэй холбоотой бэрхшээлийг дагуулдаг. Хоёр дахь шалтгаан нь Дурпин нутгийн цэргийн баазын дэргэд орших саван, тос, шатахуун зэрэг химийн бодисонд бохирдсон гол тосгон руу урсаж ирдэгээс үүдэлтэй гэж үздэг. Гурав дахь шалтгаан нь ойг их хэмжээгээр огтолсон явдал юм. Дөрөв дэх шалтгаан нь тариалалт хоорондын хугацаа хэтэрхий богино байгаа бөгөөд дээр үед тариаланчид газрыг 5-7 жил тутамд өнжөөж байх ёстой гэж үздэг байсан.

Төв Пандам. 75-83 настай тариаланчдын батлан өгүүлсэнээр тус үндэстэн энэ нутагт бүтэн зууны туршид суурьшин амьдарч байгаа болно. Прадхан ястанд хамрагдах нэгэн гэр бүл прадханчуудыг ойг цэвэрлэн чөлөөлж, тэндээ суурьшиж амьдар гэж авчирсан. Энэ нутагт өмнө нь ой байсан. Настайчуудын санаж байгаагаар тухайн үед хүмүүс гэр бүлийн хэрэгцээндээ зориулан 2-3 кг цагаан гаа л тариалдаг байв. Цагаан гаа худалдах тухай хэний ч санаанд ордоггүй байв. Настай тариаланчдын дурсамжаас үзэхэд тэдний ээжүүд газар тариалангийн ажлыг хийдэг байв. Мөн *дхам* (лам) нар шашны зан үйл гүйцэтгэх зорилгоор байнга цагаан гаа гуйж авдаг байжээ.

60-аад оноос эхлэн цагаан гааг тосгонд их хэмжээгээр тариалах болсон. Ингэж эхэлсэн анхны айл нь Дадирамын гэр бүл байсан бөгөөд тэднийх хаа нэг газраас (тариаланчид хаанаас авсаныг нь мэдэхгүй эсвэл санахгүй байв) 80 кг цагаан гаа авчээ. Дадирам гуай бусад тосгон руу ойр ойрхон аялдаг байсан ба цагаан гааг их хэмжээгээр тариалж, худалддаг болохыг мэдэж авчээ. Тэр эхэндээ цагаан гааг гурван жил тутамд нэг удаа тариалж Силигурид борлуулдаг байв. Удалгүй бусад гэр бүлүүд цагаан гааг их хэмжээгээр тариалах болж орон нутгийн зах зээл дээр болон Рангпод борлуулах болжээ. Цагаан гааны худалдааны бизнес нь ойролцоогоор 20

жилийн өмнөөс өргөн хүрээнд тархсан. Ойролцоогоор 15 эсвэл 16 жилийн өмнөөс өвчлөл анх гарч эхэлсэн. Тариаланчид газар талхлагдалд орсноос үр шим нь буурсан, янз бүрийн газраас үр худалдаж авсан, уламжлалт практик, заншил, зан үйлийг хүмүүс дагаж мөрдөхөө больсон зэрэг нь өвчлөлийн шалтгаан болсон гэж үзэж байна.

Эртний хиндүчүүд шүтлэг, заншлаа даган нэлээд хэдэн зан үйлийг гүйцэтгэдэг байв. Эмэгтэй хүнийг ариун бус байх гэж үзэхээс гадна *саран*-ы үеэр талбайд ажиллах, ялангуяа тариа тарих, ургац хураахыг хориглодог байсан. Мөн “si” (жишээ нь: *ekadasi*) “mi” (жишээ нь: *saptami, austami, nauwami, dasami*) гэсэн төгсгөлтэй өдрүүдэд тариа тарих, ургац хураахыг хориглодог. Мөн шашны ёсын дагуу мягмар гаригт тариан талбайд ажиллахаас зайлсхийдэг. Гэр бүлд шинэ хүн мэндэлсэн эсвэл гэр бүлд үхэл хагацал тохиолдсон үед тариан талбайд ажилладаггүй. Мөн *тифее* буюу гэр бүлийн гишүүний нас барсан өдөр жил бүр тохиох бүрт энэ өдөр ажилладаггүй.

Үндэстэн ястан хоорондын нийгмийн харилцаа: Зарим үндсэн асуудал

Түүхэн замналаас нь харахад энэ бус нутаг, түүний оршин суугчдад булаан эзлэлт, дайн, арилжаа худалдаа, шилжиж ирэх, дүрвэж ирэх зэрэг түүхэн хөдөлгөөн болох үед ирсэн янз бүрийн хүмүүс их нөлөөлжээ. Тэдэнд Түвдийн буддизмын ламын соёл, хиндүгийн кастийн систем, христосчуудын ямар ч кастгүй, ижил тэгш байх харьцаа, Английн колончлол, нам газрын худалдаачид гэх мэт олон янзын хүмүүсийн нөлөө их байсан. Эдгээр гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл, тэдгээртэй харилцах харилцаа нь тэгш бус харьцаан дээр тулгуурлаж байсан. Нийгмийн давхарга, каст, эд хөрөнгө, шашин шүтлэг, хүйсээр ялгавлан гадуурхах үзэх нь хэвийн зүйл буюу стандарт мэт болсон.

Гурван үндэстний нийгмийн харилцаан дээр хийсэн судалгаа нь тэд бие биендээ хэрхэн нөлөөлсөнийг харуулж байна. Тус бүс

нутагт хамгийн түрүүнд шилжин ирж, суурьшсан бөгөөд цагаан гааг шашны хувьд ач холбогдолтой гэж үздэг рейчүүд нь лепчачуудтай хамгийн ойр дотно харилцаатай бөгөөд тэдний нөлөөнд их автдаг. Эдгээр хоёр бүлэг нь хоёулаа Түвд-Бурман үндэстэнд хамрагддаг бөгөөд адилхан уламжлал, зан заншил олон бий. Хоорондоо гэрлэх явдал их байсан нь тэдний харилцааг ойр дотно болгосон. Цагаан гаатай холбогдсон шашны адилхан ёс заншил баримталдагийн гол шалтгаан нь энэ юм. Настай лепча тариачдын өгүүлсэнээр тэд *наая ко пүжа* (орч.тайлбар: шинэ ургацын мөргөл) хийх шашны ёсыг Лимбү ястантай гэрлэсэн охидоосоо сурсан. Лимбү болон рей нар Кират бүлэгт хамрагддаг учраас шашны адилхан ёс заншлыг мөрддөг. Брахмин-чхетричүүд энэ бүс нутагт суурьшиж эхэлснээс хойш тэд рейчүүд, лепчачуудад нөлөөлж эхэлжээ. Настай лепча тариачдын ярьсанаар тэд цагаан гааг давхаргатайгаар тарих аргыг брхамин-чхетричүүдээс суржээ. Харин брхамин-чхетричүүд цагаан гааг тарих, газар дор булж хадгалах аргуудыг рейчүүд болон лепчачуудаас сурсан байна. Мөн тэд *наая ко пүжа* (орч.тайлбар: шинэ ургацын мөргөл) хийх шашны ёсыг мөрдөж эхэлсэн.

Цагаан гааг худалдаалах бизнес нь янз бүрийн үндэстэн, ястан хоорондын нийгмийг харилцааг ойртуулсан. Тариаланчид тариа тарих, үр солилцох, худалдах, худалдаж авах тухай мэдээлэл, санал бодлоо солилцож эхэлсэн. Зах зээлийн хүч нь зөвхөн эдгээр гурван үндэстэн хооронд төдийгүй мөн бусад үндэстний бүлэгтэй харилцах нийгмийн харилцааг гүнзгийрүүлсэн. Нам газрын худалдаачид нь зах зээлийн хүчийг төлөөлж байсан бөгөөд тэд цагаан гааг худалдан авч, зах зээлийн үнийг нь тогтоож байв. Олон тариаланчид лалын шашинт худалдаачдаас үр худалдаж авч эхэлсэн ба тариаланчид (ямар үндэстэн ястан байхаас үл хамааран) ба арилжаа худалдааг хянагчид гэсэн нийгмийн шинэ харилцаа бий болсон.

Гэхдээ хүмүүсийн төсөөлөл, үзэл бодолд үндэстэн ястнууд хоорондоо ялгаатай гэсэн бодол хэвээр үлджээ. Лепчачуудыг бусдаас дуу цөөтэй, нийтэч бус гэж үздэг бөгөөд харин брхамин-чхетричүүдийг илүү аж ахуйч, мундаг тариаланч, илүү их мэдлэгтэйд тооцдог. Рейчүүд эдгээр хоёр бүлгийн дундаж нь юм.

Өнөө үед эдгээр бүх үндэстэн хоорондын нийгмийн харилцаа нь идэвхтэй хэвээр байгаа бөгөөд бие биенээсээ харилцан суралцаж, тариалангийн арга, өвчнийг эмчлэх арга, үнэ, үр тариаг борлуулах газар, үр тарианы эх үүсвэрийн тухай мэдээлэл солилцдог хэвээр байгаа билээ. Гэвч ихэнх тохиолдолд тухайн үндэстний бүлэг дотор *parma* систем⁴ оршсоор байна.

Газар тариалангийн өнөөгийн арга техник

Цагаан гаа тариалах газрыг сонгохдоо ус тогтонги газраас зайлсхийдэг. Мөн нэг газар жил дараалан тариа тарих нь үр ашиг муутай гэж тариачид үздэг. Сонгосон талбайг цэвэрлэхийн тулд бүх ургамлыг нь шатааж, үнсийг нь бордоо болгон ашигладаг. Үүний дараа Наси, Пешо, Порбун, Ташидин, Төв Пандам зэрэг нутагт газрыг хагалж, ухаж, тэгшилдэг. Дахин хагалах ажлыг 15-18 өдрийн дараа хийдэг. Талбайг бууцаар (5-8 см гүнд) бордоод, бордоогоо газрын хөрсөнд шингээхийн тулд газраа дахин хагалдаг. Харка-Сангэй нутгийн газрыг хагалахад хэтэрхий эгц байдаг тул хүмүүс гараар хагалж, тэгшилдэг. 20-25 см өндөртэй дундаа усгүйжүүлсэн давхаргатайгаар газрыг бэлтгэдэг. Тариалахын өмнөхөн газрын гүнд хадгалсан цагаан гааны үндэстэй үрийг дахин ангилдаг. Том хэмжээтэй, гэрэлтсэн, янз бүрийн толбогүй, нахиалж ургаагүй, гэмтэлгүй эрүүл үндэстэй үрийг сонгодог. Үлдсэнийг нь зах дээр борлуулдаг.

Цагаан гааны сонгосон үндсийг 8 см хөрсөөр бүрхэгдсэн давхаргатайгаар 2-3-н долгиолсон эгнээгээр тарьдаг. Үндэс хоорондын зай нь 15 см байх хэрэгтэй. Зарим тариачид үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд нэг давхаргад 3-4 эгнээгээр тарих нь зүйтэй гэж үздэг. Тариалах явцдаа үндэстэй үр бүрийг 2-4-н мөчиртэй ургуулахын тулд хэдэн хэсэг болгож хуваадаг. Тариалсаны дараа 8-10 см зузаан хуурай навчаар давхарганд хучилт хийдэг. Зарим тариачид үхрийн саравчинд хэсэг өвсийг хэдэн өдөр байлгаж, үхрийн өтгөн, шингэн ялгадастай холилдуулж гаргаж авсан хучилтыг ашигладаг. Хучилт борооноос

үр тариаг хамгаалж, хог ургамал ургахаас сэргийлж, газрын хөрсийг зөөлөн, чийглэг байлгадаг тул тариа хурдан ургадаг. Эрдэнэ шиш нь цагаан гааг сүүдэрлэж ургадаг учраас ихэнх тариаланчид, ялангуяа төв пандамынхан эрдэнэ шишийг цуг тариалдаг. Эрдэнэ шишийг давхарга хооронд усгүйжүүлсэн нүхэн дотор тарьдаг. Тариаланчид «NLD» сайжруулсан сортын цагаан гаа нь илүү намхан ургадаг бөгөөд салхинд хийсэх магадлал багатайг нь бодолцож түүнийг илүүд үздэг.

Ойролцоогоор сарын дараа давхаргуудад хог ургамал дүүрдэг. Цагаан гааны нахиа нь хэтэрхий богино байдаг тул тэдэнд учирч болох хохирол их байдаг. Хог ургамлыг сугалж, давхаргаас гаргаж хаядаг. Цагаан гааны ургамал гурав дөрвөн навчтай болсоны дараа *мау* буюу эх үндсийг гаргаж авдаг бөгөөд энэ нь хэтэрхий богино бол авахгүй үлдээдэг. Үндсийг нь гэмтээж, өвчлүүлэхгүй тулд болгоомжтой байх ёстой. Үндсийг тэр дор нь газрын хөрсөнд булдаг. Сайн үнээр борлуулах боломжтой үед тариаланчид *мау-г* ойролцоох зах дээр худалдаачдад зардаг. Төв Пандамд зарим тариаланчид *мау-г* хоршоолол, хамтлагуудад зардаг. Борооны улиралд учирдаг санхүүгийн бэрхшээлийг давахад нь тусалдаг учраас энэ орлого чухал ач холбогдолтой. *Мау-г* гаргаж авсанаас 15 өдрийн дараа газрыг борддог.

Төв Пандамд тариаланчид үрийг хадгалдаг бөгөөд ингэхдээ ургац хураахаас 15-20 өдрийн өмнө эрүүл буюу хатаагүй ургамлыг үр болгохоор сонгож, түүнийгээ хурааж хуурай, сүүдэр газар хадгалдаг. Наси, Пешо, Порбун, Ташидингийн тариаланчид үр үндсийг бас хадгалдаг боловч тэд эхлээд бүх үндсийг хураагаад дараа нь эрүүл үндсийг сонгож, газар доорх нүхэнд хийн сүрлээр хучих юм уу эсвэл байшин, агуулахынхаа сэрүүн, хуурай газар хадгалдаг.

Харка-Сангсэйд дээр дурьдсанчлан үр үндсийг хурааж чаддаггүй. Хөрш тосгоноос худалдаж авсан үрээ байшин дотроо юмаар бүтээж хуурай, сэрүүн газар хадгалах юм уу эсвэл гадаа хуурай, сэрүүн газар хадгалдаг. Зах зээлийн үнээс хамаарч худалдах цагаан гаагаа хураадаг. Тариаланчид цагаан гааг зах руу авч гарах юм уу эсвэл худалдаачдад шууд борлуулдаг. Үр хадгалдаг тариаланчид нь үрийг

гэмтэж өвчлөхөөс болгоомжлон 2-3 жил тутамд үрээ шинэчилдэг.

Янз бүрийн тосгоны тариаланчид өвчнөөс сэргийлэх, эмчлэх талаар өөр өөр практикийг мөрддөг. Зарим лепча тариаланчид өвчилсөн ургамлын доод хэсгийг шавраас нь салгаж, цэвэрлэн үндсийг нь наранд хатаадаг. Ургамлын үндэсний муудаж гэмтсэн хэсгийг тасалж, үнс түрхдэг. Зарим тариаланчид гэмтсэн ургамлын үндсийг наранд хатааснаар өвчин нь цаашид тархахыг нар зогсоож чаддаг гэж итгэдэг. Тариаланчид ийм үндэс буюу үндэстэй үр нь үндэслэж, сайн ургадаг гэж үздэг. Зарим тариаланчид цагаан гааг уламжлалт аргыг ашиглан налуу газарт тариалдаг бөгөөд ингэснээр газар шороог бэлтгэх ажил бараг хийхгүй гэсэн үг. Тэд газрыг ухаж нүх гаргаад л үндсээ түүнд булдаг. Ихэнх тариаланчид улаан өнгийн хөрс нь өвчнийг хянахад тусалдаг гэж баталж байна. Нэгэн рей тариачин маш их өвчин тархсан цагаан гааны талбайдаа *bikphul (Glorusa)* тарьсан байна. Тэр хэлэхдээ тухайн жил цагаан гаа ямар ч өвчингүй, маш сайн ургасан. Гэхдээ түүний цагаан гааны талбайн хэмжээ бага учраас тэр үүнийгээ батлах, туршилтаа давтах боломжгүй байв. Нэгэн лепча гэр бүл хадтай, чулуурхаг хөрсөнд цагаан гаа тариалсан байна. Ийм газар тариалсан тариа нь ямар ч өвчингүй байсан.

Газар тариалангийн ажилд жендэрийн ба үндэстэн ястны үүрэг

1. Калимпоны судалгааны хоёр тосгоны бүх айлын өрхийн тэргүүн нь эмэгтэй ч бай эрэгтэй ч бай *тариа тариалах газраа* сонгодог. Хэрэв өрхийн тэргүүн эрэгтэй нь ямар нэг шалтгаанаар эзгүй байвал эхнэр нь өрхийн тэргүүнийг орлож, энэ ажлыг хариуцдаг. Төв Пандамд өрхийн тэргүүн эрэгтэй хүн л тариа тариалах газрыг сонгодог. Өрхийн тэргүүн эрэгтэй нь эзгүй үед гэр бүлийн эмэгтэйчүүд энэ ажлыг хариуцдаг.
2. Тариа тариалах газрыг бэлтгэх ажилд эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан оролцдог. Төв Пандам, Наси, Пешо, Порбун, Ташидин нутгуудад эрэгтэйчүүд нь газар ухаж, эмэгтэйчүүд нь газар хагалж, тэгшилдэг бол харин Харка-Сэнгсэйд

газар хагалдаггүй учраас талбайд нүх ухах, тэгшлэх ажилд эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан оролцдог. Харин *парма* систем мөрддөг гэр бүлүүд нь эрчүүд биеийн хүчний ажилд эмэгтэйчүүдээс илүү сайн гэж үздэг учраас ийм ажлыг зөвхөн эрчүүд нь хийдэг. Мөн ийм өрх айл туслах ажилтан хөлсөлж авах болбол эрэгтэй ажилчинг сонгодог.

3. *Тариа тариалах, ургац хураах* ажлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоёулаа хийдэг. Гэхдээ ихэвчлэн зөвхөн гэр бүлийн гишүүд энэ ажилд оролцдог. Үүний шалтгаан нь хөлсний ажилчин нь гэр бүлийн гишүүнтэй адилхан сэтгэлээр тариа тарьж чаддаггүй гэж үздэг.
4. *Бордох* ажлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан хийдэг.
5. *Хучилт хийх* ажлыг ихэвчлэн эрэгтэй хүн хийдэг бөгөөд шаардлагатай үед эмэгтэйчүүд тусалдаг.
6. *Хог ургамал түүх* ажлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан хийдэг боловч туслах ажилчин авах шаардлагатай бол эмэгтэй хүмүүсийг хөлсөлж авдаг. Эмэгтэй ажилчны цалин нь (25 энэтхэг рупи) эрэгтэй ажилчны цалингаас (40 энэтхэг рупи) бага байдаг.
7. *Мау буюу эх үндсийг гаргаж авах* ажлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан хийдэг. Гэхдээ үндсийг гэмтээхээс сэргийлж болгоомжтой, нямбай ажиллах шаардлагатай тул ихэвчлэн зөвхөн гэр бүлийн гишүүд энэ ажилд оролцдог. Тариаланчид ийм ажилд туслах ажилтан авахгүй байх нь дээр гэж үздэг.
8. *Газрын хөрсийг хучих* ажил нь хүч чадал шаардсан хүнд хэцүү ажил учраас үндсэндээ эрчүүд энэ ажлыг хийдэг.
9. *Ургац хураах* ажлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоёулаа хийдэг боловч ихэвчлэн зөвхөн гэр бүлийн гишүүд энэ ажилд оролцдог.
10. *Үр хадгалах* ажлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан хийдэг.
11. *Үр тариаг борлуулах* ажлыг өрх толгойлсон эмэгтэйчүүдээс бусад айлд эрчүүд нь хийдэг.
12. *Үр худалдаж авах* ажлыг эрэгтэй хүмүүс хийдэг. Гэхдээ өрх толгойлсон эмэгтэйчүүд эсвэл өрхийн тэргүүн нь эзгүй үед эхнэр нь энэ үүргийг хүлээдэг.

Газар тариалангийн янз бүрийн үе шатанд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг нь бүх үндэстний хувьд бараг адилхан байгаа нь дээрхээс нотлогдож байна. Ялгаатай зүйл нь яс үндэстэний онцлогоос бус харин тухайн өрх айлын нөхцөл байдлаас хамаарч байна. Гэхдээ өрхийн тэргүүн нь эрэгтэй хүн бол Брахмин-чхетри эмэгтэйчүүд тариа тарих газар сонгох, үр худалдаж авах ажилд лепча, рей эмэгтэйчүүдээс харьцангуй бага эрх мэдэлтэй. Төв Пандамын нэгэн настай тариачны өгүүлсэнээр “би эмэгтэйчүүдийг тариан талбай сонгох тал дээр туршлагатай гэж бодохгүй байна, иймээс ч энэ ажлыг би тэдэнд итгэж даалгаж чадахгүй” гэсэн.

Настай эрчүүдийн ярианаас өнгөрсөн буюу түүхэн мэдээлэл, мэдлэг, төсөөлөл олж авсан. Рей гэр бүлийн хувьд эрчүүд нь давамгайлах үүрэг гүйцэтгэдэг байсныг бид олж мэдсэн. Ихэнх гэр бүлийн хувьд өрхийн тэргүүн эрэгтэй нь бүрэн эрх мэдэлтэй бөгөөд тариан талбайд орох эрхтэй цорын ганц хүн нь байв. Лепча гэр бүлийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүн адил тэгш үүрэгтэй байсан байна. “Нэгэн настай тариачны тайлбарлан өгүүлсэнээр “эрчүүд нь газар хагалж, эмэгтэйчүүд нь үр булж, хөрсөөр хучдаг” байжээ. Эмэгтэйчүүд нь үр сонгох ажлыг хийдэг. Харин эрэгтэйчүүд нь шашны зан үйлийг гүйцэтгэж, эмэгтэйчүүд нь ямар нэгэн үүрэггүйгээр идэвхгүй оролцогчид болдог байна. Брхамин-Чхетри гэр бүлийн хувьд цагаанг гааг гэр бүлийн хэрэгцээнд зориулан бага хэмжээгээр тариалсан бол эмэгтэйчүүд нь тариалангийн ажлыг хариуцдаг. Харин газар тариаланг арилжааны зориулалтаар их хэмжээгээр тариалж эхэлмэгч эрчүүд нь энэ үүргийг гартаа авч эмэгтэйчүүд нь ердөө л “туслагчид” болжээ.

Уламжлалт болон өнөөгийн практикийн хооронд бусад ялгаа ч бас байна. Жишээлбэл: зарим Рей, Лепча гэр бүл цагаан гааны шинэ ургацыг хоол хүнсэнд хэрэглэх, ашиглахаас өмнө хийдэг шашны уламжлалт ёсоо гүйцэтгэхээ больсон байна. Энэхүү зан үйлийг гүйцэтгэж байгаа хэсэг нь товчхон үйлдэх буюу цагаан гааны дээжийг ариун сахиуст өргөөд л шашны зан үйлийг гүйцэтгэсэнд тооцдог болжээ. Рейчүүд гэр бүлд шинэ гишүүн мэндэлсэн үед тариан талбайд ажиллахгүй байх ёсыг халжээ. Үүнийг больсон

гол шалтгаан нь гэр бүлүүд тархмал байдлаар амьдрах болсноос шинэ хүн мэндэлсэн мэдээллийг тэр дор нь авах боломжгүй болсонд оршино. Мөн тариаланчид хэлэхдээ ажиллах хүч илүү их шаардлагатай ба цалин өндөр болсон өнөө үед энэ зан үйл практикт нийцэхгүй болсон. Рейчүүд мөн *саран*-ы ёслолыг гүйцэтгэхээ больсон бөгөөд энэ ёслол нь практикт нийцэхгүй, бодит бус гэж үздэг болжээ. Залуу үеийнхэн хэзээ *саран* тохиож буйг ч мэддэггүй. Брахмин-чхетри нар ч энэ зан үйлийг мөрдөхөө болисон. үүний нэгэн адил, мягмар гаригт ажиллахгүй байх эсвэл “si” ба “mi” гэсэн төгсгөлтэй өдрүүдэд ажиллахгүй байх заншлыг мөрдөхөө улам бүр больж байгаа бөгөөд гэр бүлийн гишүүн нь нас барсан тохиолдолд ажиллахгүй байх зарчмыг цөөхөн гэр бүл л мөрдөж байна. Харин эсрэгээрээ зарим Брахмин-чхетри гэр бүл цагаан гааны шинэ ургацыг хоол хүнсэнд, хэрэглэх, ашиглахаас өмнө хийдэг *наая ко нужа* (орч.тайлбар: шинэ ургацын мөргөл) шашны уламжлалт ёсыг гүйцэтгэдэг болж эхлээд байгаа нь ажиглагдсан.

ЖЕНДЭРИЙН ХАРИЛЦАА БА ҮНДЭСТЭН ЯСТАН

Бид жендэрийн харилцааны дараах дөрвөн асуудлыг авч үзсэн. Үүнд: хөдөө аж ахуйн ажилд эмэгтэй ба эрэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг; газар, ажиллах хүч, капиталыг олж авах боломжууд; түүнд нэвтрэхэд саад болж буй зүйлс; шийдвэр гаргалт ба хяналт; имиж ба өөрийгөө хүндлэх байдал зэрэг орно. Сүүлийн хоёр нь эмэгтэйчүүдийг төрөл бүрийн шашны үйл ажиллагаанд оролцох эсвэл нийгэмд байр суурь, эрх мэдэлтэй байхыг нь үгүйсгэсэн нийгэм-соёлын арга хэмжээнүүд болон эмэгтэй хүнийг зориуд доогуур үнэлдэг соёлын үзэл баримтлал, бэлэг тэмдэг, мэдэгдэл зэрэг асуудалд үндэслэсэн болно. Иймээс эмэгтэй хүний имиж, өөртөө итгэх байдал, тэдний итгэл үнэмшил нь жендэрийн үзэл баримтлал, төрөөс тогтоосон үүрэг, соёлын ёс заншил, хүлээлт, боловсрол, гадаад ертөнцтэй харилцах харилцаа, мөнгө олох чадвар, шийдвэр гаргалтанд гүйцэтгэх үүрэг, тэдний өөрсдийн бие даасан байдал, өөрсдийгөө тодорхойж буй байдал, хүч чадлаа мэдэрч буй байдалд нь нөлөөлдөг (Гурун 1999).

Эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг

Бид өмнө дурьдсанчлан эрэгтэй, эмэгтэй хүмүүс тариалангийн газрыг бэлтгэхээс эхлээд үр хадгалах хүртэлх бүх үйл явцад ерөнхийдөө адил тэгш ажил үүрэг гүйцэтгэдэг. Үүрэг нь жендэр эсвэл үндэстэн ястны онцлогоос хамааралгүй, харин тухайн гэр бүлийн нөхцлөөс хамаардаг. Тухайн гэр бүл эрэгтэй хүн олонтой бол эмэгтэйчүүд талбайн ажилд бараг оролцдоггүй бөгөөд тухайн гэр бүл цөөхөн эрэгтэй хүнтэй бол эмэгтэйчүүд эрчүүдтэйгээ мөр зэрэгцэн ажилладаг. Гэхдээ Брахмин-чхетри нарын дунд уламжлалт ёс заншил их хүчтэй байдаг бөгөөд брахмин-чхетри эмэгтэйчүүд цагаан гааны үйлдвэрлэлд рей, лепча эмэгтэйчүүд шиг идэвхтэй оролцдоггүй.

Ерөнхийдөө, эмэгтэй хүний ажлыг эрэгтэй хүнийхтэй харьцуулахад доогуур үнэлдэг. Эрчүүд, эмэгтэйчүүдийн аль нь ч гэсэн эмэгтэй хүнийг эрэгтэй хүний туслагч гэж үздэг бөгөөд тэдний үүрэх ачаа нь эрэгтэй хүнийхтэй харьцуулахад үндсэндээ хамаагүй хүнд байдаг. Эмэгтэйчүүд эрчүүдийн нэгэн адил талбайд ажиллахаас гадна гэрийн ажил, гэр бүлийнхнийгээ асарч санаа тавихад гол үүрэг гүйцэтгэдэг.

Боломж ба хязгаарлалт

Ерөнхийдөө цагаан гааны үйлдвэрлэлд шаардагдах бүх орц (үр тариа, газар, ажиллах хүч)-од эмэгтэйчүүд бүрэн нэвтэрч чаддаг. Бидний ярицлага авсан бүх өрх айлын эрэгтэй болон эмэгтэй гишүүд нь талбайд ажиллах, цагаан гааг хураах, сонгох, хадгалахад адил тэгш эрхтэйгээр оролцох боломжтой.

Гэвч эмэгтэй хүнд хязгаарлалт болсон нэгэн хүчин зүйл байдаг нь эмэгтэй хүн сарын тэмдгээ ирсэн үед “ариун бус болдог” гэсэн хиндү шашны үзэл юм. Сарын тэмдэг нь ирсэн рэй, брахмин-чхетри эмэгтэйчүүд тариан талбайд орох байтугай цагаан гааны үрэнд хүрэхийг ч 12 хоногийн туршид хориглодог.

Эмэгтэй хүн цагаан гаанаас олж буй орлогыг адилхан хүртэх

эрхтэй. Гэхдээ тухайн гэр бүлд ямар байр суурь (жишээлбэл: охин, эх, саяхан гэрлэсэн бэр, хадам ээж гэх мэт) эзэлдэгээс нь шууд хамаардаг. Ер нь эмэгтэй хүн настай байх тусмаа мөнгө хүртэх давуу эрхтэй байдаг. Мөнгө хүртэх эрх гэдэг нь эмэгтэйчүүд хүссэнийхээ зоргоор мөнгө үрэх бус, эхлээд гэр бүлийнхэнтэйгээ, ялангуяа нөхөртэйгээ зөвлөлдөж, зөвшилцөлд хүрэх ёстой. Нөгөө талаас, эрэгтэйчүүд нь өөрсдийн авсан мөнгөө гэр бүлийнхэнтэйгээ зөвлөлдөж, зөвшөөрөл авахгүйгээр юу дуртай зүйлдээ (архи уух, мөрийтэй тоглох, хүссэн зүйлээ худалдаж авах гэх мэт) үрдэг.

Эмэгтэй хүмүүсийн хувьд хамгийн том хязгаарлагдмал байдал нь хөдөө аж ахуйн ажлаас олж буй цалингийн хэмжээ юм. Эмэгтэй ажилчдын цалин нь эрэгтэй хүмүүсийнхтэй харьцуулахад доогуур байдаг. Энэ ялгаа нь эмэгтэй хүн биеийн хүчний ажилд эрчүүдээс муу гэж үздэгээс үүсэлтэй.

Зах зээл, худалдааг эрчүүдийн хариуцах ажил гэж ойлгодог. Эмэгтэйчүүдийг зах зээлийн талаар бага мэдлэгтэй гэж үздэг. Бидний судалсан бүх үндэстний хувьд энэ нь адилхан байсан боловч брахмин-чхетри үндэстэний хувьд илүү түгээмэл байсан. Гэхдээ энэ хандлага өөрчлөгдөж байна. Бүх үндэстний хувьд орчин үеийн залуу бүсгүйчүүд нь ээж, эмээ нартайгаа харьцуулахад худалдааны ажилд идэвхтэй оролцдог болсон. Илүү олон тооны эмэгтэйчүүд ганцаараа эсвэл гэр бүлийнхээ эрэгтэй гишүүний хамт эсвэл гэр бүлийнхэнтэйгээ хамтран худалдааны үйл ажиллагаанд оролцож байна. Энэ хандлага нь мөн л тухайн өрх айлын төрөл, хувь хүмүүсийн онцлогоос хамаарч ялгаатай байна.

Шийдвэр гаргалт ба хяналт

Эмэгтэй хүн шийдвэр гаргалтанд оролцох боломж, тэдний гүйцэтгэх үүрэг нь өрх айлуудын дунд болон үндэстэн ястаны хооронд өөр өөр байна. Шийдвэр гаргалт нь ярвигтай байдаг бөгөөд олон хүчин зүйлээс хамаардаг. Энэ үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоо нь зөвлөлгөө өгөхөөс эхлээд зарим тохиолдолд тухайн гэр бүлд цаашлаад хязгаарлагдмал хүрээний хувьд нийгэмд эзэлж буй

байр сууринаас нь хамаарч шийдвэрийг өөрөө гаргах хэмжээнд байна. Лепча, рэй гэр бүлүүдийн хувьд мэдлэг сайтай ээж нар болон том охид нь цагаан гааны үйлдвэрлэл явуулах тариан талбайг сонгоход адилхан эрхтэй оролцдог бол брахмин-чхетри эмэгтэйчүүд энэ үүрэгт бага оролцдог. Зөвхөн өрх толгойлсон эмэгтэйчүүд ийм шийдвэрийг дангаараа гаргах эрхтэй. Цагаан гаа худалдаж авах, худалдах шийдвэрийг үндсэндээ өрхийн тэргүүн эрэгтэй хүмүүс гаргадаг бөгөөд эмэгтэйчүүд зөвлөлгөө өгөх үүрэг хүлээдэг. Гэхдээ тухайн гэр бүлийн онцлог, эмэгтэй хүний гэр бүлд эзэлж буй байр суурь, оролцож буй хувь хүмүүсээс хамаарч ялгаатай байдаг. Хэдийгээр эмэгтэйчүүд шийдвэр гаргалтанд ерөнхийдөө бага үүрэгтэй боловч энэ асуудал дээр давуу эрхтэй биш ч гэсэн адил эрхтэй эмэгтэйчүүдийн цөөхөн жишээ байна.

Ер нь эмэгтэй хүн газар гэх мэтийн чухал хөрөнгийг хянах боломж багатай байдаг. Ихэнх тохиолдолд, хөвгүүд нь газрыг өвлөж авдаг бөгөөд энэ нь эмэгтэйчүүд санхүүгийн болон албан ёсны бусад байгууллагаас зээл авахад шаардагдах чухал барьцаа хөрөнгө болдог газаргүй хоцроход хүргэдэг. 1956 оны Хиндүгийн өв залгамжлах эрх зүйн актаар хөвгүүд болон охидод өв залгамжлах тэгш эрх олгосон боловч эрэгтэй хүнийг өрхийн тэргүүн, гэр бүлээ тэжээгч гэсэн үзэл өдийг хүртэл хэвээр байна. Эмэгтэйчүүдийн цалин нь эмэгтэй хүн эрэгтэй хүнээс бага ажил хийдэг гэсэн эрчүүдийн төсөөлөлд үндэслэн тогтоогддог тул эмэгтэйчүүд өөрсдийн хөдөлмөрөө үнэлэх, хянах эрх багатай байдаг. Эмэгтэйчүүд цагаан гааны орлогоос олсон мөнгийг хянах эрх нь тухайн гэр бүлд эзэлж буй байр сууринаас нь хамаардаг. Байр суурь нь өндөр байх тусмаа эмэгтэйчүүдийн мөнгөнд тавих хяналт ихэсдэг боловч хүссэн зүйлдээ зарцуулах бус харин нөхөр эсвэл гэр бүлийнхээ хүсэж буй зүйлд ихэвчлэн зарцуулдаг тул тэдний эрх мэдэл нь хэзээ ч бүрэн гүйцэд байж чаддаггүй.

Имиж ба өөртөө итгэх итгэл

Бидний судалгаанаас харахад рей, брахмин-чхетри нарын дунд

эмэгтэй хүнийг ил эсвэл далдуур доогуур үнэлдэг соёлын үзэл баримтлал, бэлэг тэмдэг, мэдэгдэл хүчтэй байдаг. Эмэгтэйчүүд хүүхэд төрүүлдэг учраас тэднийг ариун бус, цэвэр бус гэж үздэг байна. Эдгээр үндэстэн нь сарын тэмдэг нь ирсэн эмэгтэйчүүдийг тариан талбайд орохыг хориглодог. Мөн хүүхэд төрүүлсэнийхээ дараа эмэгтэй хүн доод тал нь 7 хоногийн туршид ариун бус байдаг гэж үздэгээс энэ хугацааны туршид тухайн гэр бүлийн аль ч гишүүнийг тариан талбайд ажиллахыг нь хориглодог. Эдгээр үндэстний хувьд эмэгтэй хүн бол доод төрөлтөн юм. Рейчүүд цагаан гаатай холбоотой шашны зан үйлийг эмэгтэй хүн гүйцэтгэхийг хориглодог нийгэм-соёлын заншлыг нь лепча, брахмин-чхетри, мөн бусад үндэстнүүд нар дууриаснаас энэ үзлийг улам бататгасан юм.

Эмэгтэй хүний имиж нь харьцангуй ялгаатай байна. Ерөнхийдөө, настай эмэгтэйчүүдтэй харьцуулахад залуу бүсгүйчүүд имиж сайтай байдаг. Залуу бүсгүйчүүд өөртөө илүү итгэлтэй байдаг нь тэд гадаад ертөнцөд гарч, илүү идэвхтэй байсантай холбоотой. Ихэнх залуу бүсгүйчүүд цагаан гааны худалдаанаас эхлээд бүх асуудал дээр эрэгтэй хүнтэй адилхан хэмжээний мэдлэгтэй гэж өөрсдийгөө үздэг. Настай эмэгтэйчүүд эрэгтэй хүний ноёлох эрхийг хүлээн зөвшөөрч, дэмжиж байдаг бол залуу бүсгүйчүүд өөрсдийнхөө эрхийг болон хүйсээр ялгаварлан гадуурхагдаж буйгаа сайн мэддэг. Тэдний өөртөө итгэх итгэл нь ямар үндэстэн бэ гэдгээс хамаарахгүйгээр гэр бүлийн онцлогоос хамаардаг. Ихэнх тохиолдолд тухайн гэр бүлийн түвшин, нөхцөл байдал нь эмэгтэй хүний имиж, өөртөө итгэх итгэлд ихээхэн нөлөөлдөг.

Товчхоноор хэлэхэд энэ бүс нутгийн жендэрийн харилцааны тухай манай судалгаа нь ойлгомжгүй олон зүйлээс бүрдсэн аалзны тор мэт бөгөөд зарим тохиолдолд нотолгоо баримтууд хоорондоо зөрүүтэй байна. Эмэгтэй хүнийг ялгаварлах үзэл бүх үндэстний дунд түгээмэл байгаа хэдий ч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцаа тэгш эрхтэй болж байгаа зүйлс ч ажиглагдаж байна. Жендэрийн харилцаа нь тухайн үндэстний бүх өрх айлын хувьд адилхан бишээс гадна үндэстэн ястан бүрийн хувьд өөр өөр байна. Тухайн эрэгтэй,

эмэгтэй хувь хүн, янз бүрийн нөхцөлд хэрхэн хандаж байгаагаас хамаарч ялгаатай байна. Рей, лепча, бхоти эмэгтэйчүүд илүү бие даасан, эрх чөлөөтэй, бизнесийн үйл ажиллагаанд оролцох, өөрсдийн үзэл бодлоо хамгаалах, гэр бүлийн болон нийгмийн чухал шийдвэрт оролцох бололцоотой байдаг. Үүний зэрэгцээ аль ч үндэстний залуу бүсгүйчүүд илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэж, ажилд оролцоод зогсохгүй шийдвэр гаргалт, худалдааны үйл ажиллагаанд оролцож байна. Эдгээр өөрчлөлт нь боловсролтой, орчин үеийн сэтгэлгээтэй, идэвхитэй байдал, гадаад ертөнц болон улс төрийн мэдлэг өндөртэй байгаагаас үүдэлтэй. Залуу бүсгүйчүүд настай эмэгтэйчүүдийг бодоход өөртөө илүү итгэлтэй, өөрийн гэсэн имиштэй, өөрийгөө хүндэлдэг нь анзаарагдаж байна.

ЗАРИМ ҮНДСЭН АСУУДАЛ БА БЭРХШЭЭЛ

Ирээдүйн цагаан гааны үйлдвэрлэл ба худалдаа нь боломж ба бэрхшээлээс хоёулангаас нь хамаарч байна. Бид эмэгтэйчүүд болон ядуу тариаланчдын өмнө учирч буй бэрхшээл, боломжийн заримыг нь дор тоймлон дурьдав.

Эмэгтэйчүүдийн өмнө учирч буй томоохон бэрхшээл нь газар эзэмших эрх бөгөөд ихэнх тохиолдолд өрхийн тэргүүн эрэгтэй нь газрын хууль ёсны өмчлөгч байдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн хувьд дараагийн нэг бэрхшээлийг үүсгэдэг ба газар нь зээлийн барьцаа болдог түгээмэл хөрөнгө учраас эмэгтэйчүүдийг банк, санхүүгийн байгууллагаас зээл авах боломжийг хязгаарладаг. Ихэнх эмэгтэйчүүд гэр бүлийн бүх ажлыг хийж, хүнс хоолоо бэлдэн, гэр бүлийнхнийгээ хооллож, мал сүргээ маллаж, эрчүүдийн хамт газар тариалангийн ажилд зүтгэдэг учраас хэтэрхий их ачаа үүрдэг. Иймд ихэнх эмэгтэйчүүд цагаан гааны худалдааны ажилд идэвхитэй оролцох цаг зав муутай байдаг. Үүнээс үүдээд энэ нь мөнгөн орлогыг хянах боломжийг нь хязгаарладаг. Нийгэм-соёлын жишгээс дүгнэхэд эмэгтэйчүүдийг ялангуяа худалдааны ажил, мөн гэрийн гадуурх бусад ажилд идэвхтэй оролцогч, “өөрийн

үзэл бодлоо илэрхийлэгч” байхыг хүлээн зөвшөөрдөггүй учраас тэд шийдвэр гаргах ба хяналт тавихад идэвхитэй үүрэг гүйцэтгэж чаддаггүй.

Боломжийн хувьд ярихад рэй, брахмин-чхетри (залуу) эмэгтэйчүүд шинэ зүйлд суралцсаар байна. Тэдний ихэнх нь өөртөө итгэлтэй бөгөөд өөрсдийгөө өндрөөр үнэлж чаддаг. Рей эмэгтэйчүүд сайн бизнесмэн болохоо харуулж чадсан бол брахмин-чхетри эмэгтэйчүүд улс төрд, ялангуяа тосгоныхоо түвшинд оролцох боломжтой болсон. Тэд өөрсдийнхөө эрхийн талаар илүү мэдлэгтэй болсон. Ихэнх залуу бүсгүйчүүд үндэсний болон улс төрийн түвшинд юу болж байгаа талаар мэдээлэл сайтай байна. Харка-Сангсэй дэх рей эмэгтэйчүүд хэлэхдээ цагаан гааны үнэ нь олон улсын зах зээл ба эрэлтээс хамаардаг бөгөөд ялангуяа Араб улсад цагаан гааны эрэлт өндөр байдаг гэсэн. Тэд Иракт болж буй дайн нь цагаан гааны үнэд сөргөөр нөлөөлөх байх гэж санаа зовж байгаагаа ч илэрхийлсэн.

Ядуу тариаланчид гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулж ногоо, тариа тарих шаардлагатай байдгаас хязгаарлагдмал жижигхэн газартаа хангалттай хэмжээний цагаан гаа тарьж чадахгүй байна. Мөн том газартай хүмүүстэй харьцуулахад тэд янз бүрийн туршилт хийх боломжгүй байдаг. Төв Пандамын ядуу тариаланчид нь ихэвчлэн Балба улсаас цагаачилж ирсэн учраас газрыг хууль ёсоор өмчлөх эрхгүй байдаг. Тэд тариалангийн газрыг түрээслэх эсвэл ургацаа хувааж авах гэрээгээр газар тариалан эрхэлдэг. Үүнээс гадна, тэдэнд мужийн засгийн газраас тариачдад олгодог олон янзын хөнгөлөлт, бусад бололцоог ашиглах боломж өгдөггүй. Ядуу тариаланчид өөрсдийн ажил хийж цалин авдаг баян тариаланчдаас тариалангийн арга, өвчнийг эмчлэх аргыг суралцдаг нь өөрсдөд нь тустай байдаг. Ирээдүйн үйл явцын судалгаанд тэднийг хэрхэн илүү сайн дэмжих арга зам дээр голчлон анхаарна.

ТАЙЛБАР ТЭМДЭГЛЭЛ

1. 1706 оноос өмнө Калимпон нь Сиккимийн харъяанд байсан боловч Сиккимийн зэргэлдээ орших Бутан улс Сиккимийн одоогийн Калимпоныг багтаадаг байсан зүүн хэсгийг эзэлсэний дараа зэргэлдээх хэсэг нь колоничлогдож, дараа нь бүрэн нэгдсэн юм (Сен 1989). Британий колони Энэтхэг улс 1864 оны Энэтхэг-Бутаны дайны дараа Калимпоныг 1865 онд өөртөө нэгтгэж, 1566 онд Даржеелин дүүргийн харъяанд оруулсан (О"Малли 1985; Сүбба 1992).
2. Калимпон нь тухайн бүс нутгийн цагаан гаа тариалдаг гол нутаг байсан боловч 1975 онд Сиккимийг Энэтхэгт нэгтгэсний дараа тус улсын цагаан гааны зах зээл Сиккимийн өмнө нээлттэй болсон. Үүнээс хойш энэ бүс бүхэлдээ (Калимпон, Сиккимийг оролцуулаад) Энэтхэгийн зах зээл дээр цагаан гааны томоохон нийлүүлэгчдийн (нийт үйлдвэрлэлийн 15 хувь) нэг нь болжээ.
3. Энэ үед домч буюу *жар фүк* нар өвчтөнийг үзэхдээ шашны дуу аялж толгойноос хөл хүртэлх бүх биед нь цагаан гаа хүргэдэг байв. Дараа нь домч цагаан гааг зажлаад түүнийгээ өвчтөний өвчтэй хэсэгт түрхдэг. Энэ зан үйлийг өглөө эрт домч, өвчтөн хоёр аль аль нь юм идэж эхлэхээс өмнө гүйцэтгэдэг байв.
4. *Parma* гэдэг нь нэг айл өрхийн гишүүн нь өөр айл өрхөд очиж ажил хийх эсвэл ажилд нь туслах зорилготой ажиллах хүчний солилцооны систем юм. Энэ солилцоог ээлжээр гүйцэтгэдэг.
5. Ханшийн хөрвүүлэлт (ойролцоогоор): 1 ам.доллар (USD) = 43.6 энэтхэг рупи (INR).

АШИГЛАСАН НОМ ХЭВЛЭЛ

- Чемжон, Л.С. (1996). *Кират хүмүүсийн түүх: Боть I ба II. Катманду*. Аафрай хэвлэл.
- Фоннин, А.Р. (1987). *Лепча: Миний устаж буй үндэстэн*. Шинэ Дели: Стерлинг хэвлэл.
- Сиккимийн Засгийн газар (1993). *Сикким: Статистикийн хураангуй, 1979-80-аас 1991-92*.
- Ганток: Сиккимийн Засгийн газар, Төлөвлөлтийн хэлтэс, Эдийн засаг, Статистикийн товчоо.
- Гурунг, Ж.Д., (1999). *Хиндү-Күли Гималайн эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонсох нь*. Катманду: Уулархаг бүсийн нэгдсэн хөгжлийн олон улсын төв.
- О"Малли, Л.С.С (1985 [1907]). *Бенгал дүүргийн сонин: Даржеелин (2 хэвлэл)*, Калкутта: Бенгалын захиргааны нэгдсэн хэвлэл; Дели: Лагос Хэвлэл.
- Пинн,Ф. (1986). *Хувь заяаны зам: Даржеелингийн захидлууд 1839*. Какутта: Оксфордын их сургуулийн хэвлэл.
- Рао, Рагхунандха (1978). *Сикким: Энэтхэгтэй нэгдсэн түүх*. Шинэ Дели: Космо хэвлэл.
- Сен, Жахар (1989). *Даржеелин: Тааламжтай ухралт*. Шинэ Дели: Индус хэвлэл.
- Субба, Танка Б. (1992). *Яс үндэстэн, төр ба хөгжил: Даржеелингийн Горхаландын хөдөлгөөний кэйс жишээ*. Шинэ Дели: Хар-Ананд хэвлэл.
- Ваткинс, Ж. (1996). *Зоригт эмэгтэйчүүд: Непал улсын Гималай дахь жендэр, шашин шүтлэг ба соёлын тодорхойлолт*. Нью-Йорк: Колумбийн их сургуулийн хэвлэл.

3

НОГОО ХУДАЛДАГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН УЯЛДАА ХОЛБООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Энэтхэгийн Нагаланд дахь Кохимагийн туршлага



ЗУРАГ АВСАН: NERED

ВЕНГОТА НАКРО БОЛОН ЧОЗУЛЬЕ КИКИ НАР


ГАЗАР ЗҮЙ БА АСУУДЛУУД

Энэтхэгийн дэд-тив нь Ази тивийн бусад улсаас олон уулсаар тусгаарлагддаг. Тус улс нь хүн амын нягтрал ихтэй, 1 тэрбум гаруй хүнтэй бөгөөд дэлхийн хүн амын бараг 1/6-г эзэлдэг. Энэ улс нь хоорондоо асар их ялгаатай олон төрлийн соёл, газар нутаг, түүхүүдийн нэгдэл юм. Зүүн-хойд Энэтхэг нь “эгч дүү долоо” хэмээн нэрлэгддэг 7 муж (Аруначал Парадеш, Ассам, Манжпур, Мегхалаяа, Мизорам, Нагаланд, Трипура)-аас бүрддэг. Тэд Энэтхэгийн бусад хэсэгтэй нарийнхан зурвас газраар холбогддог. Энэхүү салангид байдал нь орон нутгийн шинж чанар давамгайлсан онцлог соёл, амьдралын хэв маягийнх нь шалтгаан юм. Алслагдмал, нэвтрэхэд хэцүү байдал нь зүүн-хойд хэсгийн хүн амын нягтрал нь тус улсын хэмжээнд хамгийн сийрэгт ордог газруудын нэг болоход нөлөөлжээ. Аруначал Парадеш нь хамгийн сийрэг хүн амтай газар бөгөөд 1 км² газарт 13 хүн ноогддог. Олонх болдог тус нутгийн уугуул иргэд нь Монголжуу гаралтай бөгөөд ихэвчлэн Хятад, Түвд, Тайланд, Мианмар улсаас ирсэн хүмүүс байдаг. Нагаланд нь Түвд-Бирм гаралтай өмнө нь “анчид” байсан 17 ястаны бүлгийн оршин суугчидтай. Зүүн-хойд Энэтхэг нь олон төрлийн байгалийн баялагтай “халуун цэг” юм. Мөн энэ бүс нь Энэтхэг улс Бутан, Хятад, Мьянмар, Бангладеш улстай хил залгадаг эмзэг бүс юм.

Орчин үеийн үйлдвэрүүд дутагдалтай байдаг. Уламжлалт үйлдвэрүүд нь гар урлалд суурилсан. Уулархаг бүх мужид үндсэн үйлдвэрлэл нь гар нэхмэл бөгөөд үндсэн нэхмэлчид нь эмэгтэйчүүд

Зураг 3.1.

Судалгааны бүс дэх Нагаландын байршлыг харуулсан газрын зураг



байдаг. Ойгоос гуалин мод, сүрэл авдаг. Зүүн-хойд хэсгийн хөдөө аж ахуй нь будаа тариалагч тостон дахь суурьшмал аж ахуй ба уулархаг хэсэг дэх нүүдлийн тариалалт буюу нүүдлийн газар тариалан гэж хуваагддаг. Оршин суугчдын 70 гаруй хувь нь газар тариалангаас амьдралаа залгуулдаг бөгөөд үндсэн тариалан болох будаа, эрдэнэ шиш ургуулдаг. Энэ бүс нь дэлхийн хамгийн чийглэг газрын нэг бөгөөд ихэнх уулын хотын нэгэн адил мод их унаснаас ундны ус нэлээн дутагдалтай газар юм. Усан-цахилгаан эрчим хүч гаргаж авах

боломжтой боловч энэ нь одоогоор хөгжөөгүй байна.

Нагаланд нь 16,579 км² талбайтай бөгөөд зүүн талаараа Мианмартай хиллэдэг (Зураг 3.1-ийг үз). Далайн түвшнээс 200-3800 метр өндөрт байдгаас уур амьсгал нь дулаан орны уур амьсгалаас эхлээд өндөрлөг газрын уур амьсгал зэрэг янз бүр байдаг. Газар зүйн энэ онцлогоос үүдээд тариаланчид дулаан орны уур амьсгал, өндөрлөг газрын уур амьсгал тариаланг нэг газар нэгэн зэрэг амархан тариалах бололцоотой. Тэнд тариаланг химийн бордоо зэрэг гадны хүчин зүйлсийг хэрэглэхгүйгээр жамаар нь ургуулах бололцоотой.

1000 гаруй тосгонд 17-н үндсэн ястан оршин суудаг. Тосгонууд нь далайн түвшнээс 100 метр өндөрт байдаг бөгөөд зарим нэг тосгон нь 2000 метр зэрэг хэт өндөрт байна. Нагаланд нь чийглэг ойн хамгийн баруун захад оршиж, өөрийн олон төрлийн оршин суугчдын ялангуяа Диптерокарпасичуудын нутаг юм. Энэ нутаг нь олон төрлийн зэрлэг болон таримал ногоотой. Хөдөө аж ахуй нь дундаж болон нэлээд налуу газар ургадаг. Ангами, Чахес нар будааг нэлээд огцом газар тариалдаг. Ойролцоох хотын хүн ам өсч байгаатай холбогдуулан тосгоны түвшинд хүнсний ногоо тариалах эрэлт хэрэгцээ маш их байна. Эрэлт хэрэгцээ их байгаагаас гадна тариаланчид олон төрлийн хүнсний ногоог их хэмжээгээр тариалах мэдлэг, туршлага сайтай.

Газрын онцлог нь тариа тариалах, услахад бэрхшээлтэй байдаг тул Нагаландын нийт оршин суугчдын 70 гаруй хувь нь нүүдлийн тариалалт хийдэг. Жум хэмээх нүүдлийн тариалалтын систем нь нэг талбайд будааг 20-60 бусад төрлийн ногооны хамт тариалах боломжтой ба уулархаг газар амьдардаг тариаланчдад илүү тохиромжтой. Нүүдлийн тариалалт болон тариалангийн биотөрөлжүүлэлт хоёр хоорондоо их уялдаатай байдаг. Жишээлбэл: Дээр үед Висвема тосгонд 30 төрлийн хар будаа ургуулдаг байсан бол одоо нүүдлийн тариалалтын системээс газрын тариалалтанд шилжсэнээс үүдэн зарим төрөл нь орхигдсон. Ер нь аливаа газрыг 2-3 жил ашигласны дараа тухайн газрын хөрсийг нөхөн сэргээхийн тулд газар хүрэлцээтэй эсэхээс хамааран талбайг 5-20 жилийн

хугацаагаар өнжөөдөг.

Харамсалтай нь ой болон хөрсийн үр шим муудаж байгаа нь томоохон бэрхшээл болоод байна. Ой, экологийн хэлтсийн мэдэгдсэнээр нийт 8,629 км² ангилагдсан ойн 33 хувь буюу 2,843 км² нь 1996-97 оны хувьд талхлагдсан байна. Нийт ойт газрын 90 хувь нь хувийн өмчлөлийн (үүнд тосгоны өмчлөлийн газар хамрагдана) ба дөнгөж 10 хувь нь улсын эзэмшлийнх байна. Үүнээс гадна, хүн амын өсөлт, газрын хомсдол жилд 6.4 хувиар өсч байгаа нь уламжлалт хүнсний аюулгүй байдалд “заналхийлж” байна (Нагаландын Засгийн газар, 2001).

Эмэгтэйчүүд нь ойн баялгаас гэр бүлийн хэрэгцээнд зориулан түүдэг гол хүмүүс бөгөөд тэд зэрлэг ногоо (тосгоны нэгэн мэдээлэгчийн хэлснээр 50 гаруй төрлийн ногоо, жимс), гуалингаас гадна ойн бусад бүтээгдэхүүн, түлшний зориулалттай мод зэргийг түүдэг. Эдгээр баялгийн бууралт нь эмэгтэйчүүдэд шууд нөлөөлж байгаа бөгөөд тэдний ажлын ачааллыг ихэсгэж, хүндрүүлж байна. Мөн энэ нь байгалийн баялгаас амь зуулгаа олдог өрх айлын бүх хүмүүс хэрэгцээгээ хангахад нь шууд нөлөөлөхөөс гадна гэр бүлийн орлогын чухал эх үүсвэрээ алдахад хүргэж байна.

Нагаландын тогтвортой хөгжил нь биотөрөлжүүлэлтийг хадгалах, одоогийн газар болон ойн тогтвортой менежментийг хангах, ойн шинэ нөөц, баялгийг олох, хөдөө аж ахуйн системийг цаг үетэйгээ нийцүүлэн шинэчлэх ажлуудын тэнцвэрийг хадгалах хандлагад үндсэндээ тулгуурлаж байна. Хөдөө аж ахуйн газрыг үндсэн ойн газар руу өргөтгөх ажил сэтгэл зовоосон асуудал болсон хэвээр байна.

Судалгааны Зорилтууд, Асуулт Ба Аргууд

Энэ асуудлын хүрээнд, бид орон нутгийн хүнсний ногооны зах зээлийн боломжууд ба бэрхшээлтэй талуудын талаар илүү сайн ойлголттой болсоноор өөрсдийн орлого, үр ашгаа нэмэгдүүлэх сонирхолтой хүнсний ногооны худалдаачин эмэгтэйчүүдийг дэмжих

зорилго тавьсан. Судалгааны гол асуултуудыг дор тусгав. Үүнд:

1. Хүнсний ногооны үйлдвэрлэл, ургац хураалт ба борлуулатын үе шатанд хэн ямар ажлыг гүйцэтгэдэг вэ?
2. Хүнсний ногооны худалдаачин эмэгтэйчүүдийг нийгмийн янз бүрийн бүлэг, давхаргынхан юу гэж үздэг вэ?
3. Эмэгтэйчүүд хүнсний ногоо борлуулсанаар гэр бүлдээ болон нийгэмд ямар нөлөө үзүүлдэг вэ?
4. Хүнсний ногоо борлуулж буй эмэгтэйчүүдийн боломж, саад бэрхшээлүүд юу вэ?
5. Эмэгтэйчүүд бэрхшээлийг хэрхэн даван туулж, давуу талаа хэрхэн ашиглаж болох вэ?

Бид хүнсний ногооны худалдаачин эмэгтэйчүүдийн амьдралын талаар илүү ихийг мэдэж, энэ мэдлэгээ ийм ажил эрхэлдэг эсвэл ийм ажилтай холбоотой хүмүүстэй хуваалцахыг хүссэн ба бид эдгээр худалдаачид ашиг, орлогоо нэмэгдүүлэхийн тулд энэ мэдлэгийг ашиглана гэж найдсан. Бид судлаачид учраас эдгээр эмэгтэйчүүдийг дэмжих арга замыг эрж хайж, мөн техник тусалцааг үзүүлэхийг зорьсон. Мөн бид оролцогч бүх талуудын нийгэм жендэрийн дүн шинжилгээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, ялангуяа жендэрийн асуудалд илүү нухацтай хандуулахыг хүссэн. Энэ судалгаа нь Эдийн засгийн Хөгжлийн төслөөр дамжуулан Нагаланд Ардын Байгууллага (НАБЭЗХ)-ын төсөлд шууд хувь нэмэр оруулсан (Хайрцаг 3.1-ийг үз).

НАБЭЗХ-ийн Төслийн үйл ажиллагааны нэгж (ТүАН), хүнсний ногооны худалдаачин эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийнхэн, тосгоны зөвлөл, тосгоны хөгжлийн хороо, олон нийтийн төлөөлөгчид, Кохима Хотын Хороо, худалдааны танхим, Кохима дүүргийн хөдөө аж ахуйн ба цэцэрлэгжүүлэлтийн ажилтнуудтай хамтран төслийн жижиг баг судалгааг явуулсан.

НАБЭЭХ төсөл

НАБЭЭХ төсөл нь Энэтхэг-Канадын хүрээлэн буй орчны тэнхим ба Нагаландын Засгийн газраас хамтарсан санхүүжилт авдаг. Энэ төслийн зорилго нь Нагаландад ядуурлыг бууруулах, амьжиргааны эх үүсвэрийн сонголтуудыг нэмэгдүүлэхийн тулд олон нийтэд түшиглэсэн газрын болон байгалийн баялагийн тогтвортой менежментийн механизмээр хангах явдал юм. Үндсэн үйл ажиллагаа нь Нагаландын 8 дүүрэг дэх сонгогдсон 104 тосгонд тогтвортой зээлийн эргэлтийн сан байгуулах үйл ажиллагаа юм.

Төслийн баг буюу Төслийн үйл ажиллагааны нэгж (ТҮАН) нь Нагаландын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн комиссарын ажилтай төслийн ахлагч зэрэг 13 гишүүнээс бүрддэг. Бусад гишүүд нь мужийн засгийн газрын янз бүрийн хэлтсийн ажилтнууд юм. ТҮАН-ийн бүх гишүүн нь өөрсдийн эрхэлдэг үндсэн ажлын албан тушаалаас хамаарахгүйгээр тэгш эрхтэйгээр ажлаа гүйцэтгэж байна.

Бид хагас-бүтэцжүүлсэн ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгийн санал асуулга зэрэг олон төрлийн арга хэрэгслийг ашигласан. Бид хүнсний ногооны худалдаачин эмэгтэйчүүдийн амьдардаг тосгонууд, борлуулж буй хүнсний ногооны тоо хэмжээ, эх үүсвэр, хүнсний ногоо борлуулж буй арга замуудыг тодорхойлох зорилгоор Нагаландын нийслэл Кохима хотод системтэй түүвэр судалгааг хийсэн. Бид талбайн нэг ажилтанг энэ ажлыг хийлгэхээр хөлслөн авч ажиллуулсан. Бид тосгонуудын жагсаалтнаас очиход амархан, Кохимагаас хир хол зайд байдаг, төслийн судалгаанд гол мэдээлэгчээр ажиллах сонирхолтой байгаа эсэх гэсэн шалгуурыг үндэслэн дөрвөн тосгоны худалдаачдыг сонгосон. Тосгонуудын нэр, тэдгээр нь Кохима хотоос хир зайтайг дор дурьдав. Үүнд: Кхонома ба Цисе Баса (22 ба 18 км буюу дундаж хэмжээний зайтай), Мерема (12 км), Фек дүүргийн Фолами (107 км). Эдгээр тосгонуудад цаг агаарын ямар ч нөхцөлд очиж болох зам бий. Дээрх тосгон нь НАБЭЭХ төсөлд хамрагдаж байгаа учраас бид төсөлд оролцогчдын тайлагналын системийг бий болгосон.

Бид сонгосон тосгонуудад очиж, судалгааны зорилгыг тосгоны

захиргаанд танилцуулах, тэдний зөвшөөрлийг авахыг зорьсон. Эдгээр уулзалт ярилцлагын явцад төсөлд оролцох сонирхолтой хүнсний ногооны худалдаачин эмэгтэйчүүдийг тодорхойлсон болно. Худалдаачид өөртөө-туслах бүлэг байгуулахыг нь дэмжиж, зохих сургалтанд хамруулсан. Тосгон бүрээс бүлгийн нэг гишүүнийг “харилцах хүн”-ээр сонгож, тэр хүнтэй төслийн талбарын ажилтнууд байнгын харилцаатай байхаар болсон. Судалгааны болон харилцааны үндсэн аргуудын тухай сургалтанд эдгээр хүмүүсийг хамруулсан.

Бид хагас-бүтэцжүүлсэн ярилцлага хийж, Засгийн газрын ажилтнууд болон Кохима Хотын Хорооны гишүүдтэй албан бус уулзалт хийсэн. Мөн бид судалгааны үр дүнг урт хугацаанд ашиглах олон талын боломжийг судлахын тулд шийдвэр гаргах түвшинд Зөвлөх Хороо байгуулахыг дэмжсэн. Бид хөдөөгийн оролцооны үнэлгээний (ХОҮ)-ний дараах арга хэрэгслийг ашигласан. Үүнд:

1. Төрөл бүрийн хүнсний ногооны үнэ хэзээ хамгийн өндөр байдаг ба хэзээ хүнсний ногооны нийлүүлэлт зах зээл дээр илүүдэлтэй байдгийг ойлгоход бидэн туслах газар тариалангийн улирлын хуанли;
2. Гэр бүлийн орлогыг хэрхэн нэмэгдүүлэх, холбогдох бэрхшээлийг хэрхэн даван туулах тухайд үйлдвэрлэгчид, худалдаачид, олон нийтийн төсөөллийн талаарх ойлголт олж авахад туслах хагас-бүтэцжүүлсэн ярилцлага;
3. Худалдаж буй газар тариалангийн бүтээгдэхүүнүүд, гол бэрхшээлүүд, үйлдвэрлэлийн өртөг, ногоог ангилах, талбайг бордох, борлогдоогүй хүнсний ногоог дараагийн өдөр хүртэл хадгалах практик зэргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олж авахын тулд Мерема, Цеси Баса тосгонуудын 20 айл өрхийн дунд судалгаа явуулсан. Мөн сүүлийн гурван сарын турш хүнсний ногооны борлуулалтаас олсон орлогыг тодорхойлохын тулд нэмж 63 өрх айлаас судалгаа авсан.

Үүнээс гадна, мэдээлэл цуглуулах бусад арга хэлбэрийг батлах, төрөл бүрийн тариалангийн бүтээгдэхүүний маркетингийн тухай бүлгийн төсөөлөл, боломжууд, бэрхшээлтэй талуудын талаарх

олон нийтийн төсөөллийг олж авахын тулд бүлгийн хэлэлцүүлэг хийсэн. Хүнсний ногооны үйлдвэрлэл ба маркетингийн зөрүү, боломжийн талаар эрх бүхий хүмүүстэй ярилцсан. Цуглуусан мэдээллээ баталгаажуулах, бусад үйлдвэрлэгчдийн дууриан хуулбарлаж болох “хамгийн сайн практик”-ийг тодорхойлох, үйлдвэрлэл ба маркетингийг нэмэгдүүлэх стратегийг суралцах зорилгоор гол мэдээлэгчдээс ярилцлага авсан. Бид хүнсний ногооны үйлдвэрлэлийг (тариаланчдын гэрээс хир хол байдаг, тариалангийн талбайн хэмжээ, ургацын хэмжээ зэргийг хамруулан авч үзсэн) ажиглахын тулд хэсэгчилсэн ажиглалт хийсэн. Мөн бид ургац хураалт, ангилалт, сортлох, борлуулах үйл явцад шууд ажиглалт хийлээ.

Хүнсний ногооны худалдаачин ихэнх эмэгтэйчүүд нь Кохима тосгоных бөгөөд тосгоны уугуул иргэд юм. Бүлгийн хэлэлцүүлгийг амжилттай явуулахын тулд худалдаачдын айдас, итгэлгүй байдлыг багасгах зорилгоор орон нутгийн хүнтэй гэрээ байгуулсан нь үр дүнгээ өгсөн. Төслийн тайлан бэлтгэх нь төлөвлөснөөс богино хугацаанд хийгдсэн боловч худалдаачид бүрэн мэдээлэл өгөхөөс байнга зайлсхийж байв. Бидний бодлоор тэдний өгсөн мэдээллийг өөрсдийнх нь эсрэг ашиглана гэж тэд айж байсан. Бид хэдийгээр судалгаагаар олж илрүүлсэн зүйлсийн нууцлалыг хадгална гэж тэдэнд амласан боловч бүх зүйлийг баталгаажуулах боломжгүй байв. Судалгаанд оролцсон ихэнх тариаланчид ядуу байсан нь давуу талуудыг дутуу үнэлэх, бэрхшээлтэй талуудыг хэтрүүлэн үнэлэхэд хүргэсэн байж болзошгүй гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй. Мөн зарим оролцогчдын судалгаа (судлаачид)-наас хүлээж байсан бодит бус төсөөлөлтэй ч бид тулгарсан.

Хүнсний Ногооны Үйлдвэрлэлийн Аргууд

Тариаланчид гэр бүлийн хэрэгцээнд болон худалдахад зориулсан хүнсний ногооны зэрлэг ба таримал гэсэн хоёр төрлийн эх үүсвэртэй. Зэрлэг ногоог ой, модны нөөц, нүүдлийн тариалалтын талбай зэрэг газраас түүдэг. Ер нь ингэж түүхэд ямар нэгэн

хязгаарлалт тавигддаггүй боловч сүүлийн жилүүдэд хэт их түүж байгаагаас зарим тосгоны захиргаанаас ингэж түүхэд одооноос хориг тавьж эхлээд байна. Эмэгтэй худалдаачдын ярьж байгаагаар эдгээр хориг нь зарим ургамлын хувьд, ялангуяа балсамасие аймгийн ургамлын экологийн онцлогт тохирохгүй. Тэдний үзэж байгаагаар ийм төрлийн ургамлын нахиаг түүснээр олон салаа мөчир болон ургадаг тул илүү хурдан ургадаг. Байгаагаар нь орхичихвол тэд өндөр бут болон ургаад үхэх болно.

Эдгээр зэрлэг ургамлын ихэнх нь хэрэв гэрийн нөхцөлд тарих нөхцөл нь байгальд ургаж буй нөхцөлтэй нь адил байвал үрийг нь суулгах, мөчрийг нь тасалж усанд ургуулах аргуудыг ашиглан амархан ургачих боломжтой. Ийм газрууд нэлээд их бий. Балсамасие аймгийн ургамлын дотор түгээмэл байдаг хүнсний ногоо болох *гажо жотхо*-г гэрийн нөхцөлд тариалах туршилтыг цаашид хэрэгжүүлэх үйл явцын судалгаанд оруулж болох юм.

Судалгааны тосгон дахь тариаланчид нь дараах гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг хөдөө аж ахуйн системийг ашигладаг. Үүнд: хэсэгчлэн хуваасан талбайд, *нүүдлийн тариалалтын* талбайд, гэр бүлийн цэцэрлэгт тариалах. Тус бүр нь тухайн улиралд борлуулах хүнсний ногооны нийлүүлэлтэнд нэмэр болдог бөгөөд бүгд нийлээд Кохимгийн захыг шинэ хүнсний ногоогоор байнга хангахад хувь нэмрээ оруулдаг.

Хэсэгчлэн хуваасан талбайд тариалах

Энэ аргыг будаа тариалахад голчлон ашигладаг боловч сүүлийн жилүүдэд худалдах зориулалттай хүнсний ногоотой ээлжээр тариалах нь нэлээд түгээмэл болоод байна. Жишээлбэл: будааны ургамал цэцэглэж байх үед буюу 9-10 сард улаан лоолийн үрийг тариан талбайд цацдаг. Эдгээр үр нь тогтмол усанд хөвөөд байж байдаг ч ургац хураах цаг дөхөөд усны хэмжээ багасах үед эдгээр үр нь ургахад бэлэн, нэлээд дэвтсэн байдаг бөгөөд хөрсөнд шингэж өгдөг. 5 сарын сүүл гэхэд улаан лоолийн ургацыг хураахад бэлэн болдог бөгөөд 7 сар хүртэл зах дээр худалддаг. Ийм аргаар тариалсан улаан лооль нь нэрс шиг жижигхэн улаан лооль байдаг ба хэдийгээр

сайхан амттай, органикаар ургуулсан боловч богино хугацаанд мууддаг тул сайн үнэ хүрдэггүй. Ээлжээр тарьдаг бусад ургамалд хэсэгчилж хуваасан газруудад ургадаг будааны шош, хэсэгчлэн хуваасан талбайн хөвөөнд ургадаг гадил жимс, бринжал, чинжүү, бусад төрөлжсөн ногоо, жимс орно.

Энэ ажлын хүрээнд үйлдвэрлэгчид, худалдаачдын орлогыг нэмэгдүүлэхийн тулд амархан мууддаггүй хүнсний ногоо, жимс жимсгэний төрлүүдийг танилцуулах, мөн ногоо, жимс нь эмзэг зөөлхөн урчаас нэлээд хэсэг нь тээвэрлэлтийн үед мууддаг тул үүнээс хамгаалахын тулд баглаа боодлын техникийг танилцуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж болно.

Жум буюу нүүдлийн тариалалтын талбай

Дагалдах хүнсний ногоог нүүдлийн тариалалтын талбайд тариалдаг. Дээр үед гол хүнсний ногоо нь эрдэнэ шиш, үндэс, хар будаа ба бусад нь амуу тариа, будаа байв. Сүүлийн үед энэ хандлага нэлээд өөрчлөгдсөн бөгөөд амуу тарианы оронд худалдах зориулалттай хүнсний ногоо, том хэмжээтэй хулууны оронд өргөст хэмх, периллагийн оронд солонам зэргийг тариалах болжээ. үндсэндээ эдийн засгийн ашиг өгөөж багатай хүнсний ногооны оронд амархан мууддаггүй, бага хэмжээтэй, илүү үнэтэй ногоог тариалах болсон.

Гэрийн цэцэрлэг

Гэр бүлийн хэрэгцээнд болон худалдах зориулалттай ихэнх хүнсний ногоог гэрийнхээ хажууд эсвэл тосгоны захад тариалдаг. Тэдгээр ногоо нь гэрт хамгийн ойр учраас тэднийг хамгийн их арчилж, торддог. Эдгээр гэрийн цэцэрлэгт олон төрлийн мод, олон наст ургамал, мөлхөө ургамлууд, нэг наст ургамлуудыг хольж тарьдаг. Мон дүүргийн Танхай тосгонд 120 гаруй төрлийн хүнсний ногоо ургаж байгаа гэж бидэнд мэдээлсэн.

Кохимагийн Хүнсний Ногооны Зах

Кохима нь Нагаландын нийслэл хот бөгөөд 83,000 орчим хүн амтай. Үүнд Нага үндэстний бүх ястан мөн Энэтхэгийн зарим ястан багтдаг.

Эдгээр ястан үндэстний төрөл бүрийн бүлэг нь өдөр тутмын хоол хүнсэндээ төрөл бүрийн ногоо, мах хэрэглэдэг бөгөөд ихэнхийг нь Кохиماغийн зах дээрээс худалдаж авдаг.

Бид нийт худалдаачдын 90-95 хувь нь эмэгтэйчүүд байхыг ажигласан. Эмэгтэйчүүд хүнсний ногооны менежмент, тариалалт, ургац хураалт, боловсруулалтыг хариуцдаг боловч заримдаа хүнсний ногоог зах дээр хүргэж өгөх ажилд эрчүүд нь тусалдаг. Зарим ногоог бөөнөөр нь байнгын түнш бөөний худалдаачиддаа зардаг бөгөөд заримыг нь түр зуур хөлслөн авсан талбай дээр жижиглэнгээр борлуулдаг. Кохимад үйл ажиллагаа явуулж буй хүнсний ногооны маркетингийн дөрвөн төрлийн байгууллагыг хүснэгт 3.1-д харуулав. Худалдаанд гүйцэтгэж буй үүргээсээ хамааран эмэгтэйчүүд гэр бүлийн шийдвэр гаргалтын үйл явцад зохих хяналтыг тавьдаг. Орлогын ихэнхийг зайлшгүй хэрэгцээтэй бараа, бүтээгдэхүүнийг худалдан авахад зарцуулдаг.

Хүснэгт 3.1
Кохиماغийн хүнсний ногооны худалдааны байгууллагуудын тойм

Байгууллагийн төрөл	Үйлдвэр-лэгчдийн тоо	Бүлгийн тоо	Борлуулж буй хүнсний ногооны төрөл	Хүнсний ногооны эх үүсвэр	Үйлдвэр-лэгчид
Хүнсний ногооны Нага худалдаачид			59	Тосгонууд	
Үндсэн	136	5			Эмэгтэйчүүд
Гэрээт	207	12			Эмэгтэйчүүд
Бөөний худалдаачид	12		19	Димапур ба Нагаландын гаднах газрууд	Гэр бүл
Хүнсний ногооны жижиглэн худалдааны дэлгэрүүд	120	10	19	Димапур ба Нагаландын гаднах газрууд	Гэр бүл
Айлуудаар явж хүнсний ногоо худалдагчид	50	12	19	Димапур ба Нагаландын гаднах газрууд	Эрчүүд

Эх сурвалж: НАБЭЗХ-ийн төслийн талбарын ажил

Хүнсний ногооны Нага худалдаачид

Энэ бүлэг нь зах зээл дээр ноёлдог бөгөөд ойролцоогоор 340 худалдаачид 12 байршилд бүлэг болон ажилладаг бөгөөд тэд нийлээд 60 орчим төрлийн хүнсний ногоо борлуулдаг. Ихэнх ногоо нь органик гаралтай багөөд ойролцоох тосгонууд болон 100 гаруй км-ийн зайтай газраас ч ногоогоо авдаг. Эдгээр худалдаачдын ихэнх нь өөрсдөө үйлдвэрлэгчид байдаг. Тэднийг байнгын буюу түр хугацааны худалдаачид гэсэн хоёр дэд бүлэгт хувааж болно. Байнгын худалдаачид нь мужийн захиргаанаас барьсан дээгүүрээ дээвэртэй лангууг тогтмол түрээслэж суудаг. Хүнсний ногоо борлуулах нь тэдний мэргэжил юм. Тэд өглөө эрт түр хугацааны болон гэрээт худалдаачдаас ногоог бөөний үнээр худалдаж авдаг. Нөгөө талаас, түр хугацааны худалдаачид хааяа л энэ ажлыг хийдэг. Тэд гэрийн цэцэрлэг, тариан талбайгаас хураасан илүүдэл ногоогоо болон арилжааны зориулалтаар тусгайлан тарьсан ногоогоо зах дээр авчирдаг.

Худалдаачид зах хүртэлх зай, хүнсний ногооны хэмжээнээс хамааран ногоогоо нийтийн тээврийн автобусаар авчрах буюу эсвэл сагсанд хийн толгой дээрээ тавьж авчирдаг. Байнгын худалдаачид тариаланчдаас их хэмжээгээр ногоо худалдан авдаг боловч ихэнх тохиолдолд тариаланчид замын хажууд суун, өөрсдөө борлуулахыг илүүд үздэг. Байнгын болон түр хугацааны худалдаачдын дунд хайр-үзэн ядалт зэрэгцсэн харьцаа үүсдэг. Эхний төрлийн харилцаа нь тариаланчид өөрсдийн ногоог байнгын худалдаачдад зарах үед үүсдэг. Харин түр зуурын худалдаачид тэднээс худалдаж авсан ногоогоо илүү үнээр зарж, өндөр ашиг олж буй байнгын худалдаачдыг хараад өөрсдөө худалдан авагчдад ногоогоо шууд борлуулахаар шийддэг. Байнгын худалдаачид үүнээс болж худалдан авагчдаа булаацалдаж, өрсөлдөх шаардлагатай болдог тул ийм үйлдлийг өөрсдөд нь аюултай гэж үзээд Кохима Хотын Хорооноос тэднийг зайлуулахыг хүсдэг. Ихэвчлэн хоёр тал хоёулаа заргаа алддаг бөгөөд эцэст нь бие биенийгээ үзэн яддаг.

Бөөний худалдаачид

Бөөний худалдаачид ихэвчлэн Кохима, Димапур хотуудын хооронд байнга тээвэр хийдэг Димапур, Ассам хотуудын уулын бэл газраас ачааны машинаар авчирсан хүнсний ногоог худалддаг. Тэдний худалдаж буй ихэнх хүнсний ногоо нь амархан мууддаггүй төрлийнх байдаг. Тэд хүнсний ногоог их хэмжээгээр авчран, хүнсний ногооны жижиглэн худалдааны дэлгүүрүүд, айлаар явж борлуулдаг худалдаачдад нийлүүлдэг. Төмс, улаан лоолийн улирлын үед тэд эдгээр ногоог заримдаа Кохиماغийн ойролцоох тосгонуудаас худалдан авч жижиглэн худалдаачдад борлуулдаг. Ойролцоогоор 12 бөөний худалдаачид хүнсний ногооны жижиглэн худалдааны 120 дэлгүүр, айлаар явж борлуулдаг 50 орчим худалдаачдад ногоо худалддаг.

Хүнсний ногооны жижиглэн худалдааны дэлгүүрүүд

Кохима хот дахь 120 дэлгүүр нь 19 төрлийн хүнсний ногоог 10 газарт борлуулдаг. Эдгээр хүнсний ногооны ихэнхийг бөөний худалдаачдаас тогтмол худалдаж авдаг бол дэлгүүрт борлуулж буй хүнсний ногооны төрлийг олшруулахын тулд зарим ногоог бага хэмжээгээр түр зуурын худалдаачдаас худалдаж авдаг.

Айлаар явж борлуулдаг худалдаачид

Эдгээр худалдаачид хүнсний ногоог бөөний худалдаачдаас худалдаж авдаг бөгөөд айл бүрийн үүдэнд очиж ногоогоо борлуулдаг. Тэд 30-40 кг ногоог толгой дээрээ тавьж явах чадалтай байдаг.

Зах Зээлийн Зохицуулалт: Кохима Хотын Хорооноос Хэрэгжүүлсэн Арга Хэмжээнүүд

Түр зуурын худалдаачдыг хүнсний ногоогоо ашигтай зарахад нь туслах зорилгоор Кохима Хотын Хорооноос гурван газар талбай гарган, дэд бүтцээр хангасан бөгөөд худалдаачдыг энэ журмыг

мөрдөхийг шаарддаг. Замын хөдөлгөөний түгжрэлийг сааруулах, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс өөр өөр газраас ирсэн худалдаачдад зориулан тусад нь зах гаргаж өгсөн (Хүснэгт 3.2).

Хүнсний зах, Мао зах хоёрыг л бүрэн ашигладаг, өүлд министес хилл (Жэйл колони)-ийн захын хүчин чадлын зөвхөн талыг нь л ашигладаг, Кейзизи, ТСП гэйт захуудыг 7 хоногийн ажлын өдрүүдэд ашигладаг. Түр зуурын худалдаачид тус дэд бүтцийг ашигладаггүйн шалтгаан нь тэдний байгаа газар нь худалдан авагчид очдоггүй гэсэн энгийн, мэдээжийн тайлбартай. 5 жил орчмын өмнө хэдэн настай Маочуудын нээсэн Мао захаас үлгэр дууриал авч болно. Тус зах нь зөвхөн нэг үндэстний эрх ашигт зориулсан байсан учраас тухайн үндэстний бүх хүмүүс тэнд цуглан хүнсний ногоо борлуулах болсоноор тус зах нь хүмүүсийн очих дуртай газар болсон.

Кохима Хотын Хорооны гишүүд хүнсний ногооны эмэгтэй худалдаачдыг хэдийгээр өрөвддөг боловч хотоо эмх замбараатай байлгахад бас санаа тавьдаг. Тэд замын хажуугаар сууж ногоо зардаг орон нутгаас ирсэн эдгээр эмэгтэйчүүд байгаа бүх мөнгөөрөө тосгоноосоо ногоо худалдан авч, Кохимад зардаг гэдгийг мэднэ. Хорооны гишүүд журмаа мөрдөхийн тулд замын хажууд худалдаа хийгчдийг ч үе үе шалгаж, хөөдөг боловч энэ нь түр зуурын чанартай байдаг. Ийм худалдаачид хотын өөр хэсэгт очин бизнесээ урьдын ажил үргэлжлүүлдэг. Дэлгүүрийн эзэд, ялангуяа эх газраас ирсэн эзэд ийм худалдаачид дэлгүүр рүү нь орох замыг бөглөж суудаг учраас дургүй байдаг. Харин орон нутгийн дэлгүүрийн эзэд нага эмэгтэйчүүдийг илүү хүндэлдэг учраас өөрсдийн эрхээ хамгаалахаар тэмцэх магадлал бага байдаг.

Кохима Хотын Хорооноос түр зуурын худалдаачдад зориулан 7 хоногийн захуудыг янз бүрийн газар зохион байгуулдаг. Долоо хоногийн захуудын талаарх мэдээллийг хөрш тосгодод бүгдэд нь хүргэдэг. Гэхдээ орон нутгийн худалдаачдад энэ арга хэмжээ нь үр өгөөжтэй байгаа эсэх дээр хорооны зүгээс юу ч хийдэггүй. Бидний ажигласнаар ийм газруудыг ихэвчлэн эх газрын худалдаачид ашигладаг байна.

Хүснэгт 3.2

Кохима Хотын Хорооноос хүнсний ногоо худалдаачдад гаргаж өгсөн захууд

Хүнсний ногооны төрөл	Товлосон захууд	Худалдаачдын төрөл	Тайлбар
Фек дүүрэг Хойд I ба II-р Вокха Цеминю өмнөд Ангами	Кезеки сүү, сүүн бүтээгдэхүүний зах	Түр хугацааны	Татваргүй
Баруун Ангами Жалукие Чахро (Димапур)	Өүлд министэс хилл зах (жэйл колони)	Түр хугацааны ба зарим нь байнгын	Татваргүй буюу бага хэмжээний татвартай
Жалукие, Баруун Чахро (Димапур)	Кохима хотын ТСП гэйт зах	Түр хугацааны	Татваргүй
Жижиглэнгийн байнгын худалдаачид	Хүнсний зах	Байнгын	Хотын хорооны татвар
Шууд үйлдвэрлэгчид	Мао зах	Байнгын	Хувийн эзэмшлийн

Эх сурвалж: Кохима Хотын Хороо

Хэдийгээр эдгээр дөрвөн төрлийн худалдаачид хүнсний ногооны борлуулалтанд чухал үүрэгтэй боловч сонгосон дөрвөн тосгон болох Фолами, Мерема, Цисе баса, Хономагийн хүнсний ногооны нага худалдаачид (байнгын болон түр зуурын)-ын тухай мэдээллийг судалгаанд голчлон оруулсан.

ФОЛАМИ

Энэ тосгон нь Кохима хотоос зүүн-өмнөд хэсэгт 107 км зайтай Фек дүүрэгт оршдог бөгөөд оршин суугчид чухасанчууд байдаг. Ойролцоогоор 274 айлтай бөгөөд 1,250 хүн амтай. Тосгон доторх замуудыг жилийн бүх улиралд ашиглах боломжтой байдаг тул хамгийн ойр хот болох Фолами, Фицерогийн хооронд нийтийн тээврийн автобус явах боломжтой байдаг. Энэ тосгоны 34 эмэгтэй худалдаачин хөрш дөрвөн хот болох Фек, Чизами, Фүцери, Кохимад хүнсний ногоо тогтмол худалддаг. Эдгээр худалдаачдыг дараах ангилалд хувааж болно. Үүнд:

1. Өөрсдийнхөө талбай, цэцэрлэгт бүх ногоогоо тариалдаг

худалдаачид (15 худалдаачид). Эдгээр худалдаачид хотын хүнсний ногооны байнгын худалдаачдад ногоо худалддаг гол нийлүүлэгчид юм. Тэд ногоогоо өөрсдөө тариалж, их хэмжээгээр бөөнөөр нь худалддаг тул тэд боломжийн үнээр ногоогоо борлуулж, худалдаачин, үйлдвэрлэгч хоёр хоёулаа ашиг олох бололцоотой байдаг.

2. Ногооныхоо тал хэсгийг нь өөрсдөө тариалж, үлдсэн хэсгийг нь бусдаас худалдан авдаг (6 худалдаачид).
3. Бүх ногоогоо бусдаас худалдан авдаг худалдаачид (13 худалдаачид).

2003 оны 12 сар, 2004 оны 1 сарын үед хүнсний ногооны борлуулалтаас эмэгтэй худалдаачдын олсон мөнгөн орлого нь 110,000 INR (ам.доллар [USD] = 43.6 энэтхэг рупи [INR]). Тус тосгоны хувьд газар тариалангаас өөр орлого олох боломж, хийх ажил байхгүй тул энэ бол их мөнгө юм. Фолами тосгоны мөнгөн орлогын нэгэн томоохон эх үүсвэр нь төрийн албан хаагчдын, ихэвчлэн тосгоны сургуулийн багш нарын цалин юм.

Эерэг хүчин зүйлс

Сүүлийн жилүүдэд хүнсний ногооны худалдаачин эмэгтэйчүүдийн тоо өсөж байна. Тосгоны зөвлөлийн настай эрийн өгүүлсэнээр: “Тосгоны эд баялгийн хэмжээг тосгоноос худалдахаар авч явж байгаа хүнсний ногооны тоо хэмжээгээр үнэлж болно. Тоо хэмжээ нь их байх тусмаа тосгон илүү баян байна гэсэн үг”. Хүнсний ногоог тосгоноосоо өөр газар зарахад худалдаачдад нөлөөлдөг хэд хэдэн хүчин зүйлс байдаг. Хүүхдүүддээ боловсрол эзэмшүүлэх хүсэл, ахуйн нөхцөл болон амьжиргаагаа дээшлүүлэх зэрэг олон шалтгааны үүднээс хөдөөгийн тариаланчид орлого олох боломжийг эрж хайдаг. Хүнсний ногоо тарьж, худалдах нь богино хугацаанд орлого олох арга юм.

Энэ тосгоны хүнсний ногооны бүх худалдаачид өөрсдийн тарьсан ногоог бүгдийг нь зарж чаддаг гэж хэлсэн. Гэхдээ заримдаа зарим ногооны нийлүүлэлт зах зээл дээр илүүдэлтэй байх үед

ногоогоо хямдхан зарахаас өөр аргагүйд хүрдэг гэж тэд мөн хэлсэн.

Арилжааны зориулалтаар газар тариалангийн үйлдвэрлэл явуулах боломжийг тариачдад олгодог тааламжтай хүчин зүйлст ургах таатай нөхцөл, гэр бүлийн ба олон нийтийн дэмжлэг, зах орох тээврийн хэрэгслүүдийн хүрэлцээ, орлого болон бусад ашиг олж болох боломжууд багтана.

Хүнсний ногооны үйлдвэрлэлийн таатай нөхцлүүд. Арилжааны зориулалтаар тосгонд хэдэн төрлийн хүнсний ногоо, жимс тариалж байгааг тооцолохын тулд Фолами тосгоны эмэгтэй худалдаачдын бүлгийг цуглуулсан. Хүснэгт 3.3-аас 1, 2, 3-р саруудад хүнсний ногооны төрөл хамгийн цөөн, 6-аас 11 сар хүртэлх хугацаанд хамгийн олон төрлийнх байгааг харж болно. Энэ тосгоны арилжааны зориулалтаар тариалсан хүнсний ногоо, жимс жимсгэний төрлийн нийт тоо нь 50 орчим байна.

Хүснэгт 3.3
Фолами тосгоны эмэгтэй худалдаачдын сар бүр
борлуулж буй хүнсний ногооны төрлийн тоо

Сар	Зэрлэг ногооны тоо	Таримал ногооны тоо	Нийт ногооны тоо
1-р сар	8	6	14
2-р сар	8	6	14
3-р сар	8	6	14
4-р сар	11	14	25
5-р сар	11	14	24
6-р сар	11	19	30
7-р сар	11	22	33
8-р сар	11	22	33
9-р сар	11	28	39
10-р сар	11	30	41
11-р сар	11	27	38
12-р сар	11	19	30

Эх сурвалж: Фолами тосгоны эмэгтэй худалдаачидтай хийсэн бүлгийн хэлэлцүүлэг

Хамгийн түгээмэл 10-н зэрлэг ургамалд балсамасигийн гурван төрөл, зэрлэг перцийн навч, *Oenethe*-гийн хоёр төрөл, *Centella*

asiatica-ын хоёр төрөл орно. Эдгээрийн зарим (Балсамаси, зэрлэг перцийн навч)-ыг нь анхдагч ойгоос түүдэг бөгөөд ферн зэрэг бусдыг нь хоёрдогч ойгоос түүдэг. Зэрлэг ургамлыг, бүр хувийн эзэмшлийн газраас ч түүхэд ямар нэгэн хязгаарлалт байдаггүй, нөгөө талаас бусдын эзэмшлийн талбайгаас таримал жимс, хүнсний ногоог авч болохгүй бөгөөд гэхдээ талбай дээрээс нь түүж идэж болно.

Ихэнх зэрлэг хүнсний ногоо, ялангуяа хамгийн түгээмэл ногоонууд бүтэн жилийн туршид ургадаг (Хайрцаг 3.2-ыг үз). Зарим таримал хүнсний ногоо, ялангуяа бүхлээр нь идэж болдог ногоонууд нь бас жилийн туршид худалдагддаг.

Хайрцаг

3.2

Gajo-jotho: Тарималжуулж болох боломжтой зэрлэг ургамалууд

Зэрлэг ургамал дундаас балсамаси аймгийн гажо-жотхо төрлийг тарималжуулахад хамгийн тохиромжтой гэж үздэг. Учир нь:

- Энэ нь байгальд ургамадаг зэрлэг ургамал бөгөөд богино хугацааны дотор их хэмжээгээр түүж болдог.
- Энэ нь амархан мууддаггүй. Худалдаачид бидэнд хэлэхдээ энэ ногоог наранд удаан байлгавал өнгө нь шарладаг боловч үндсийг нь усанд дүрээд хонуулахад шинэ чанараа алддаггүй юм байна. Энэ ажлын хүрээнд хийж болох зүйл нь энэхүү ногоог байгальд ургах нөхцөлтэй нь ижил нөхцөлөөр хангаж гэрийн цэцэрлэгт тарьж болох юм. Худалдаачдын ажигласнаар булцууг хөрсөнд булахад нь үндэслэж эхэлдэг. Үүнийг тарималжуулах нь их амархан гэж тэд үзэж байна.

Худалдаачдын ярьсанаар эрчүүд, эмэгтэйчүүд зэрлэг ногоог цуг түүдэг. Худалдаачид зах дээр ирэх бүртээ 50-60 багц зэрлэг ногоо авчирдаг бөгөөд тэдний анзаарсанаар эдгээр ногооны хэмжээ буурахгүй байгаа юм байна.

Тариаланчид талбайн газрын онцлогийг харгалзан төрөл бүрийн ногоог өөр өөр өндөрт тарьдаг. Хэсэгчилсэн ажиглалтын явцад, бид байцаа, талбайн шош, төмсийг өндөрлөг газар тарьдаг бол цагаан гаа, сармис, чинжүү, шошийг нам газар тарьдаг. Ихэнх тариалангийн талбай тосгоны захад байдаг тул тосгоныхон нүүдлийн тариалалт төрлийн талбайтай байдаг.

Гэр бүл, олон нийтээс үзүүлж буй дэмжлэг. Худалдаачид зах явахынхаа урьд өдөр нь хүнсний ногоогоо хураадаг. Гэр бүлийн гишүүд хамтдаа ногоог ялгаж, ангилж, цэвэрлэдэг бөгөөд ингэснээр худалдаачин маргааш өглөө нь маш эрт автобусандаа суух боломжтой болдог. Гэр бүлийн гишүүд ногоог автобусны буудалд хүргэлцдэг.

Олон нийтийн зүгээс ч хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмждэг. Жишээлбэл: газар тариалангийн талбайд мал сүрэг оруулахгүй тулд олон нийт хамтран хашаажуулалтын систем нэвтрүүлдэг. Энэ систем нь өвлийн тариалалтын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд их тустай байдаг (хайрцаг 3.3-ыг үз).

Фоламагийн олон нийтийн төлөөлөгчид нь Кохима хотын байнгын оршин суугчид бөгөөд хүнсний ногооны эмэгтэй худалдаачдад хоноглох газар гаргаж өгөх замаар тэднийг дэмждэг. Иймд, худалдаачдын хувьд байр, хоол үнэгүй байдаг нь борлуулалтаас олсон бүх орлогоо гэртээ авчрах боломжийг олгодог. Эдгээр оршин суугчид худалдаачдад зөвлөлгөө, заавар өгч тусалдаг. Эмэгтэй худалдаачдыг гэртээ байхгүй үед нь эрчүүд нь гэрийн ажлыг хариуцдаг тул тэд гэртээ байхгүй үедээ ч гэр бүлийн эрчүүдийн тусламж, дэмжлэгийг мэдэрч байдаг.

Хайрцаг

3.3

Хашаажуулалт: идэвхигүй хөдөө аж ахуй руу хийх үсрэлт

Уламжлалт ёсоор 11-р сарын дундах долоо хоногоос эхлэн 2-р сарын сүүл хүртэл малыг сул тавин хаа дуртай газраа бэлчээрлүүлэхийг зөвшөөрдөг. Үүнээс үүдэн, тариаланчид өвлийн болон олон наст ургамлыг тариалах боломжгүйд хүрдэг. Худалдах зориулалттай тариалалтыг дэмжих зорилгоор тосгоны зөвлөлөөс бүх мал сүргийг тосгоны хил хязгаар доторх тогтоосон газарт бэлчээрлүүлж байх шийдвэрийг гаргасан. Энэ журмыг бичгээр батлаад зогсохгүй хүмүүсийн дунд хэвшүүлж чадсан. Хашаажуулалт нь их хэмжээний талбайд арилжааны зориулалтаар газар тариалан эрхлэх боломжийг олгосон тул нэмэгдсэн ургацын хэмжээнээс олон тариаланчид үр ашиг хүртэж байна. Мөн хүнсний ногооны эмэгтэй худалдаачдын тоо ч мэдэгдэхүйц өсчээ.

Тээврийн хэрэгслийн хурэлцээ. Фолами, Фуцери хотуудын хооронд хувийн автобус байнга явдаг бөгөөд өглөөний 5 цагт Фоламигаас хөдөлдөг. Автобусны жолоочийн хэлснээр Фуцери орох зорчигчид ихэвчлэн худалдаачид л байдаг. Хүнсний ногооны ургацын оргил үед автобусанд багтахгүй, өрсөлдөөн ихтэй байдгаас худалдаачдын хооронд хэрүүл маргаан гарах нь элбэг, автобус ихэвчлэн хэт олон зорчигчидтой байдаг. Худалдаачдын аялалын 7 хоногийн хуваарийг гаргах оролдлого хийгддэг ч худалдаачин бүр өөр өөрийн хуваарьтай байдгаас энэ асуудал түвэгтэй болдог.

Хүнсний ногооны худалдаанаас орлого, бусад ашиг олох боломжууд. Хотын хүн ам нь хүн амын өсөлт ба орон нутгаас хот суурин газар руу шилжих хөдөлгөөн ихэсч байгаагаас шинэ хүнсний ногооны эрэлт хэрэгцээ ихэссэн. үүнтэй уялдуулан тосгоны тариаланчид өөрсдийн тариалангийн бүтээгдэхүүнийг зах зээл дээр илүү өндөр үнэтэй зарагдах хүнсний ногоогоор сольж байна. Жишээлбэл: өмнө нь халуун өвсийг зөвхөн гэр бүлийн хэрэгцээнд зориулан тариалдаг байсан. өнөө үед халуун өвсний талбайг зарим хэсгийг нь худалдах зориулалтаар ногоо тариалахаар өргөтгөж байна (дэлгэрэнгүй мэдээллийг бүлэг 2-оос үзнэ үү). Гичний навч, байцаа, талбайн шошны үйлдвэрлэл ч нэмэгдэж байна.

Худалдаачдын зорилго нь өөрсдийн тариалсан ногооны борлуулалтаас орлого олох эсвэл жижиглэнгийн худалдаачдаас авсан ногооны борлуулалтаас ашиг олох юм. Эдгээр хоёр стратеги нь органикаар гаргаж авсан хүнсний ногооны өсөн нэмэгдэж буй эрэлттэй уялдан Кохима болон бусад зах дээр харьцангуй амжилттай байна (Хайрцаг 3.4-ийг үз).

Худалдаачид хэрхэн орлого олдогийг мэдэх зорилгоор бид түр хугацааны худалдаачдын зардал, орлогыг харуулсан эсрэг тэсрэг хоёр жижигхэн кэйс жишээн дээр ажилласан.

Хайрцал

3.4

Шавьжны довтолгоо: Худалдааны амжилт

Фоламгийн амжилттай яваа тариаланч, түүний гэр бүлийнхэн 20-н өөр төрлийн ногоо тарихын оронд 2 жилийн өмнөөс зөвхөн байцаа тариалж эхэлсэн байна. Байцаануудын навчийг шавьж идсэнийг эс тооцвол ёрөнхийдөө эрүүл, шинэ байв. Үүнээс үүдээд тэдний гэр бүлийнхэн байцаагаа зарахад хүндрэлтэй учрав. Тэд ачааны машин хөлслөн, байцаагаа дүүргийн төв, Фект авчрав. Энэ газарт байцаа нэлээн өндөр үнэтэй буюу “халуун төрт” шиг л зарагддаг байв. Тэр худалдаагаа амжилттай хийж чадсан шалтгаан нь шавьж идсэн навчис бөгөөд худалдан авагчдын нэгнийх нь өгүүдсэнээр энэ нь тухайн бүтээгдэхүүн органик гэдгийг баталж байсан гэсэн.

Тосгоны ихэнх тариаланчид олон төрлийн ногоог холимог байдлаар тариалдаг системтэй тул нэгж талбай дахь үйлдвэрлэлийг хэмжээг тодорхойлох тохирох аргыг олоход хэцүү байв. Тариаланчид нүүдлийн тариалалтын талбайд 60 гаруй төрлийн ногоог зэрэг тариалж болдог (Супон 1999). Судалгаанд хамрагдсан тосгодын нүүдлийн тариалалтын дундаж талбайд 20 орчим төрлийн ногоо ургаж байна. Ногооны төрөл бүрийн хувьд хөдөлмөрийн хөлс болон ургацын хэмжээг тусад нь тодорхойлж чадсангүй. Тариаланчид холимог тариалалтын циклийг мөрддөг бөгөөд ээлжээр тариалах, олон төрлийн тариалалт, байнгын тариалалт хийдэг. Бидний ашигласан хувилбарт арга нь түр хугацааны хоёр худалдаачдын хүнсний ногооны борлуулалтын орлого, зардлын тооцоог хийх байв.

Худалдаачин 1 (түр хугацааны, цөөхөн ногоотой) Энэ худалдаачин нь ногоогоо зарахаар сард нэг удаа Кохима хот руу явдаг. 2003 онд тэр эмэгтэй нялх хүүхэдтэй байсан учраас хоёр л удаа зах явж худалдаа хийсэн. Түүний нэг хамаатан нь Кохимад байдаг учраас тэндээ ямар нэг мөнгө төлөлгүйгээр оройдоо хоночих бололцоотой байдаг (тус хотод нийтийн байр гэж байдаггүй). Бүх ногоогоо зарахад 5 өдөр зарцуулдаг. Нэг удаагийн аяллын орлого, зардлыг хүснэгт 3.4-д үзүүлэв.

Хүснэгт 3.4

Худалдаачин 1-ийн Кохима зах руу явах аяллын орлого, зардал

Зүйл	Зардал	Орлого
Хүнсний ногоо		
Модны улаан лооль /худалдаж авсан/ (600 орчим)	170	550
Гадил жимс /худалдаж авсан/ 350 орчим)	100	350
Гадил жимс /өөрсдөө тариалсан/	120	250
Балсамасгийн төрлийнх /1 өдөр түүсэн/	70	370
Колосасиа / худалдаж авсан /	50	100
Халуун өвс / худалдаж авсан /	50	120
Хэсгийн дүн	560	1,740
Тээвэр ба холбогдох зардал		
Тосгоноос ойрхон автобусны буудал хүртэлх билет	40	
Автобусны буудал Кохима хүртэлх билет	100	
Ачааны хөлс	20	
Таксиний хөлс	50	
Аялалын явцад идсэн өдрийн хоол	50	
Буцах автобусны билет	100	
Хэсгийн дүн	360	
Бусад зардал		
Зэрлэг ногоо түүх 1 өдрийн цалин (эрэгтэй)	70	
Зэрлэг ногоо түүх 1 өдрийн цалин (эмэгтэй)	60	
Аялалын 2 өдрийн цалин (ирэх буцах)	120	
Ногоо зарах 2 өдрийн цалин	120	
Хэсгийн дүн	370	
Бүгд	1,290	1,740
АШИГ		450

Эх сурвалж: НАБЭЗХТ-ийн талбайн ажил

Хүснэгтэн дэх тоон үзүүлэлтээс харахад тус худалдаачин Кохимад хоног төөрүүлэх хамаатны айл нь байгаагүй бол ийм их хэмжээний ашиг олох боломжгүй юм байна. Үүнээс үүдээд уг худалдаачин ногоогоо Кохима хотын бөөний худалдаачинд зарсан нь илүү ашигтай байж болох юм гэсэн асуудал урган гарч байна. Ингэснээр тэрээр хөдөлмөрийн зардлаас нэг өдрийг хэмнэх боловч орлогынхоо 1/3-ыг алдах болдог тул худалдаачид өөрсдөө жижиглэнгийн худалдаа хийх нь дээр гэж үздэг.

Худалдаачин 2 (тур хугацааны, их ногоотой) Худалдаачин 1-тэй харьцуулахад энэ худалдаачин нэг тосгоных боловч илүү их ногоотой, хот руу явж ногоо зарснаар их хэмжээний ашиг олдог.

Энэ худалдаачин эмэгтэй 7 жил худалдаа хийж байгаа туршлагатай бөгөөд мэргэжлийн байх нь хамгийн их ашиг олох гол түлхүүр гэж үздэг. Тэр өөрийн цагийг олон зүйлд үрэхийн оронд тариалах бүтээгдэхүүнээ сонгоод, түндээ хөрөнгө оруулдаг (Хүснэгт 3.5).

Худалдаачин 1-тэй харьцуулахад туршлага, танил найз нөхдийн хүрээ, зөв хянуур сонголт, цөөн тооны зүйл дээр төвлөрч ажиллах нь илүү ашигтай байх шалтгаанууд болдог гэдгийг бид анзаарсан. Аялалд бэлтгэх, аялах, худалдаа хийх өдрүүд нь адилхан гэж үзэхэд илүү их хэмжээний бараатай байх нь илүү ашигтай байна. Худалдаачдын хэлснээр үйлдвэрлэгчид хүнсний ногоогоо тэдэнд зээлээр өгдөг тул тээврийн зардлаас өөр зүйлд бэлэн мөнгө зарцуулах шаардлагагүй байдаг. Мөн гадил жимс зарах нь бусад бүтээгдэхүүнийг зарахаас илүү ашигтай байдгийг бид бас мэдэж авсан.

Эмэгтэй худалдаачид өдөржингөө замын хажууд газар бохирон сууж, замын хөдөлгөөний түгжрэл, КХХ-ны шахалт дарамт, бороо, салхи, халуун болон бусад бэрхшээлийг тэсвэрлэдэг. Бид тэднээс ногоогоо бөөний худалдаачдад зараад, гэртээ харьж яагаад болдоггүй юм бэ гэж асуухад ингэж зарах нь хоёр талд хоёуланд нь ашигтай байдаг тул ерөнхийдөө энэ арга илүү дээр санагдаж байна гэсэн.

Хүснэгт 3.5
Худалдаачин 2-ын Кохима зах руу явах аяллын орлого, зардал

Зүйл	Зардал	Орлого
Хүнсний ногоо		
Гадил жимс	1.250	4.100
Модны улаан лооль	100	200
Голоссика	50	100
Хэсгийн дүн	1.400	4.400
Тээвэр ба холбогдох зардал		
Тээвэр	385	
5 өдрийн цалин (өдөрт 60 рупе)	300	
Хэсгийн дүн	685	
Бүгд	2,085	4,400
АШИГ		2.315

Эх сурвалж: НАБЭЗХТ-ийн талбайн ажил

Бидний олж мэдсэнээр худалдаачид ногоогоо бөөний худалдаачинд зарсанаас өөрсдөө зарах нь гурав дахин их ашиг олдог юм байна (Хүснэгт 3.6).

Хүснэгт 3.6
Фолами тосгоны худалдаачдын авсан ногоо, жимсний жижиглэнгийн болон бөөний нэгжийн үнэ (рупи)

Хүнсний ногоо	Өөрийн өртөг	Кохимад худалдах үнэ	
		Бөөний	Жижиглэнгийн
Гадил жимс (ширхэг)	0.25	0.50	1.00
Модны улаан лооль жимс (ширхэг)	0.25-0.33	0.33	0.80
Халуун өвчний навч (багц)	5.00	10.00	10.00
Колосас (багц)	4.10	6.70	10.00
Жимс (ширхэг)	0.17	0.33	0.66
(ширхэг)	1.00	2.00	3.30
Өргөст хэмх (ширхэг)	1.40	3.30	4.00
Орон нутгийн сармис (багц)	10.00	15.00	30.00
(багц)	5.00	10.00	10.00
Талбайн шош (кг)	10.00	12.50	20.00

Эх сурвалж: НАБЭЗХ-ийн төслийн талбайн ажил (Фоламагийн эмэгтэй худалдаачидтай хийсэн бүлгийн хэлэлцүүлэг)

Кохимад худалдаа хийснээр хүртэх материаллаг бус үр ашиг. Зарим худалдаачид Кохимад ногоогоо зарах үедээ тэндхийн сургууль, дээд сургуульд байгаа өөрсдийн хүүхдүүдтэйгээ уулзах боломжтой байдаг. Эцэг эх нь зах гарангаа хүүхдүүд дээрээ очиж, сургуулийн төлбөрийг нь төлдөг. 340 гаруй нага эмэгтэй худалдаачид Кохима руу бизнесийн ажлаар өдөр бүр явдаг. Эхэндээ таньдаггүй байсан хүмүүс яваандаа найзууд болж, бие биенээсээ үйлдвэрлэл, маркетингийн арга техник суралцдаг. Зарим улирлын чанартай түр хугацааны худалдаачид таньдаг бөөний худалдаачиндаа хүссэн цагтаа өөрийн ногоог боломжийн үнээр борлуулчихаад явах өгөх хэмжээний сайн найзууд болсон байдаг. Түр хугацааны шинэ худалдаачид бүгд л хүнсний ногоогоо өөрсдөө борлуулах явцдаа ангилах, сортлох, баглах, чанарыг нь шалгах урлагт суралцаж байдаг. Эмэгтэйчүүд Кохимад цагийг өнгөрүүлсэнээр бусад хотын бизнесийн талаар мэдлэгтэй болдог. Тэд Фуцерод байдаггүй хүнсний бараа, бусад зүйлийг хотын хаанаас хамгийн боломжийн үнээр авахыг ч мэддэг.

Саад болж буй хүчин зүйлс

Тээврийн хэрэгслийн хүрэлцээгүй байдал. Фолами, Фуцерогийн хооронд явдаг цорын ганц автобус нь найдвартай боловч ихэвчлэн хүрэлцээ муутай байдаг. Харин Фуцерод ногоогоо борлуулдаг худалдаачдын хэрэгцээг сайн хангадаг. Гэвч 10 гаруй худалдаачид Кохимад ногоогоо борлуулдаг тул тэд цаашаагаа 74 км газрыг олдсон тээврийн хэрэгсэлд дайгдан явах хэрэгтэй болдог. Кохимад ирсэнийхээ дараа бизнесээ хийдэг зах хүртлээ такси хөлсөлж ачаагаа зөөх шаардлагатай. Энэ бүх аялалд худалдаачид нэлээд хөлс төлдөг. 3, 4, 5 ба 12-р саруудын (бизнесийн оргил үе) мягмар, лахгва, пүрэв гаригуудад автобус пиг хүнтэй явдаг. Олон худалдаачины ногоо нь автобусанд суудал олж чадаагүйгээс нь болж муудаж байдаг.

Бөөний худалдаа хийхэд үйлдвэрлэлийн хэмжээ хангалтгүй байх. Дээр дурьдсан олон давуу тал, боломжууд байгаа хэдий ч тосгоныхон бөөний худалдаа хийхэд хүрэлцэхүйц хэмжээний хүнсний ногоо тариалах, худалдан авах боломжгүй байгаа бөгөөд эмэгтэй худалдаачдын бодлоор бөөний худалдаа нь илүү ашигтай юм. Энэ бэрхшээлийн цаана хэд хэдэн шалтгаан бий. Нэгдүгээрт, ихэнх худалдаачид гэртээ тариалсан хүнсний ногоо хамгийн сайн чанартай байдаг гэж итгэдэг. Амжилттай яваа цөөхөн худалдаачин л байцаа, талбайн шошийг өвлийн улиралд хэсэгчлэн хуваасан талбайд тариалах зэрэг бусад аргуудыг туршихыг оролдож байна. 11-р сард газар чийг ихтэйгээс хүнд байдаг тул ухааж хагалахад нэлээн чадал шаарддаг бөгөөд энэ үед ихэнх эрчүүд ажил ихтэй завгүй байдгаас хүн олддоггүй. Хоёрдугаарт, нэг газрыг жил бүр хагалж, тариалалт хийснээс газрын шим буурч, өвчлөл ихэсдэг бөгөөд тариаланчдад бордоо элбэг байдаггүйгээс гадна хөрсийг бордож сайжруулах талаар мэдлэг багатай байдаг. Гуравдугаарт, эмэгтэй худалдаачдын ярьснаар хэрэв эрчүүд нь ширэнгэн ойг цэвэрлэж, талбай гаргаж өгвөл газар тариалангийн талбайн хэмжээ нэмэгдэнэ. Тэдний үзэж байгаагаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь эрчүүдийн хариуцах ажил бөгөөд эрчүүд нь энэ үүргээ биелүүлэхгүй байна.

Худалдаачид хоорондын зарга, маргаан. өнөө үед олон худалдаачид байгаагаас өрсөлдөөн хүчтэй байна. Тосгоныхны ярьсанаар худалдаачдын тоо улирал бүрт нэмэгдсээр байна. Гол мэдээлэгчдийн мэдээлснээр тосгоны зарим хүмүүс худалдаачид илүү их ашиг олж байна гэж үйлдвэрлэгчдэд хэлдэг. Энэ цуу ярианаас болж нэлээд үйлдвэрлэгчид өөрсдөө ногоогоо зарахад хүрснээр зөрчил нэмэгдсэн. үүнээс үүдээд худалдаачид, үйлдвэрлэгчдийн хоорондын өрсөлдөөн нэмэгдэж, үйлдвэрлэгчид үнээ нэмж, худалдаачдын ашиг буурч байна.

Худалдааны зориулалттай зах, газруудтай холбоотой бэрхшээлүүд. КХХ өөр өөр чиглэлийн тосгоноос ирж буй худалдаачдад зориулан тусад нь худалдааны зах гаргаж өгсөн. КХХ-ны гишүүд худалдаачид энэ журмыг мөрдөж байгаа гэж үздэг хэдий ч түр хугацааны худалдаачид журмын талаар мэддэггүй эсвэл зориуд мөрддөггүй бөгөөд аль ашигтай газарт бизнесээ хийж байна. КХХ-ын гишүүд үе үе шалгалт хийж замын хажууд ногоо зарагсдын ногоог хураадаг. Кохима хотын хүн ам өсч байгаагаас худалдаачдад ногоо зарах талбай олох нь улам хэцүү болж байна. Тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэж байгаа нь ч нэлээн хүндрэлтэй бэрхшээл үүсгэж байна.

Хийх ажлын стратегиуд

Судалгааны явцад хүнсний ногооны худалдаачдын өмнө тулгараад байгаа асуудлын заримыг нь шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх үйл явцын стратегийг боловсруулаад байна. Замын хөдөлгөөний түгжрэлийг сааруулахын тулд бид тосгоны захиргааныхан, олон нийтийн төлөөлөгчидтэй хүнсний ногооны өнөөгийн үйлдвэрлэл болон хэтийн төлвийн тухай ярилцаж, энэ бэрхшээлийг шийдвэрлэх боломж байгаа эсэхийг хэлэлцсэн. Олон нийтийн үзэж байгаагаар тосгонд нийтийн тээврийн ачааны машинууд байвал энэ асуудлыг шийдвэрлэж болно гэж үзсэн. Амжилттай яваа нэгэн тариаланч-үйлдвэрлэгч энэ саналыг сонирхсон бөгөөд түүнд ачааны машин худалдаж авахын тулд банкнаас зээл авахад нь туслах олон талын

боломжийг нь бид судалж байна.

Хүнсний ногооны нийлүүлэлт хангалтгүй байгаа бэрхшээлийг шийдэхийн тулд бид тосгоны эрчүүд, эмэгтэйчүүдийн хамт сэдэвчилсэн нөөцийн газар зүйн байршлыг тодорхойлох дасгал ажилласан. Тэд ямар төрлийн хүнсний ногоог хаана тариалж болохыг тодорхойлсон газрын зураг гаргасан. Оролцогчид орон нутагт ургах бололцоотой ногооны төрлүүдийг тариалах талаар өндөр мэдлэгтэй байсан ба үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх боломжуудыг тодорхойлсон (практикт аль хэдийн нэвтрүүлсэн нэгэн жишээг хайрцаг 3.5-аас үзнэ үү). Амжилттай ажиллаж буй 4 тариачин гэр бүлийнхний туслалцаатайгаар бид хэсэгчлэн хуваасан талбайд хүнсний ногоо тариалах үзүүлэх сургалтын үед хэрэглэх хүнсний ногооны үр тарааж, мэргэжлийн ажилчдыг талбайд ажиллуулж сургалтаа хийсэн. Үүнээс олсон орлого нь тосгонд их хэмжээгээр нөлөөлнө гэж хүлээж байна.

Тариаланчид газрын хөрсийг сайн бордсон үед л суурьшмал газар тариалан эрхлэх бололцоотой гэдгийг мэддэг ч тэдэнд бордоо авах боломж байдаггүй. Энэ бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд бид Био-бордооны хэлтэстэй (Нагаландын засгийн газрын хөдөө аж ахуйн хэлтсийн харьяа) хэлэлцээр хийж эхэлсэн бөгөөд ингэснээр судалгааны баг шаардлагатай байгаа био-бордоог бага хэмжээгээр нийлүүлэх боломжтой болно гэж үзэж байна.

Эрэгтэйчүүдтэй хийсэн бүлгийн ярилцлага дээр 11-р сард өвлийн тариалалт хийхэд тэд илүү их анхаарал тавих шаардлагатай байгааг ойлгуулсан. Судлаачид энэ ярилцлагыг зохион байгуулсан бөгөөд эмэгтэй худалдаачдыг урьж, нэмэгдсэн үйлдвэрлэлээс хир ашиг олж болохыг нь яриулсан нь үр дүнтэй байв.

Бид Кохима хотын захуудын бэрхшээлийг анхаарах, туршлагаасаа суралцах, Мао захын зөвлөх хорооны амжилтаас суралцах зорилгоор зөвлөх хороо байгуулахыг дэмжсэн. Мөн бид хотод олон хоног дарааллан худалдаа хийж буй худалдаачдад зориулан шөнийн агуулах байгуулах ажилд туслалцаа үзүүлсэн (Хайрцаг 3.6).

Хайрцаг

3.6

Кохимад шөнийн агуулах бий болгох

Бүсүвэй гэгч нь Фолами тосгоных бөгөөд Кохами хотод амьдардаг. Тэр хүнсний ногооны эмэгтэй худалдаачдын нийгэмд оруулж буй хувь нэмрийг нь ойлгож, өөрийн бизнесийн барилгын нэг өрөөг борлогдоогүй хүнсний ногооны хадгалах агуулах болгохыг зөвшөөрсөн. Бид түүнд төлөвлөгөө хэрэгжүүлэхэд нь тусалсан.

МЕРАМА БА ЦИСЕ БАСА

Эдгээр хоёр тосгон нь Кохимагийн хойд зүгт байдаг ба Мерема нь Кохимагаас 12 км, Цисе баса нь 18 км зайтай оршдог. Эдгээр хоёр тосгоны худалдах зориулалттай хүнсний ногооны үйлдвэрлэл нь хоорондоо адилхан. Ихэнх хүнсний ногоог нүүдлийн тариалалтын талбай болон гэрийнхээ цэцэрлэгт тарьдаг (Хайрцаг 3.7-г үзнэ үү). Нүүдлийн тариалалтын систем нь өөрийн гэсэн онцлогтой бөгөөд ихэвчлэн будаа тариалдаг боловч мөн хүнсний ногоог арилжааны зориулалтаар 3-4 жилийн хугацаатайгаар тасралтгүй тариалдаг.

Хүнсний ногооны үйлдвэрлэлд гүйцэтгэх жендэрийн үүргийн өөрчлөлт

Бид гэрийн цэцэрлэгийн менежментэд чухал өөрчлөлт гарсаныг ажиглалаа. Уламжлалын дагуу эрэгтэйчүүд нь “гэрийн цэцэрлэгийг арчилж тордох нь бидний нэр хүндэд харш” гэж үздэг байсан. Энэ нь эмэгтэйчүүдийн хариуцдаг ажил байв. Гэхдээ энэ сэтгэлгээ өөрчлөгдөж байна. Гэрийн цэцэрлэгийг арчилж тордоход эрчүүдийн оруулж буй хувь нэмэр нь тухайн өрхийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг олон нийт хүлээн зөвшөөрсөн байна. Эрчүүд гэрийнхээ цэцэрлэгийг томсгож, гэрийн ажилд оролцож эхэлсэнээр эмэгтэйчүүд хүнсний ногоогоо худалдахад зарцуулах цаг ихтэй болоход нөлөөлжээ. Гэрээсээ хол байдаг цэцэрлэгээс гэр бүлийн эмэгтэйчүүд, эрчүүд хоёулаа толгой дээрээ сагс дүүрэн хүнсний ногоо өргөөд ирж байхыг харах нь тун түгээмэл болжээ. Нэгэн настай эр бидэнтэй хууч хөөрөхдөө

“эмэгтэйчүүд чадал муутай, тэд ургацаа их хэмжээгээр зөөж дийлэхгүй, иймээс би өөрөө ургацаа хурааж, эхнэрээсээ хоёр дахин их ургацыг гэртээ зөөж авчирдаг” гэж хэлсэн юм. Бас нэг эрэгтэй “ургац хураалтыг өглөө эрт эсвэл оройн цагаар хийвэл хамгийн үр дүнтэй байдаг, иймээс эхнэр маань энэ үед гэртээ үлдэж, гэрийн ажлаа хийж, харин би өөрөө ургацаа хураасан нь дээр” гэж хэлсэн.

Хийрцэг

3.7

Циса баса тосгоны түр хугацааны дундаж худалдаачны нөхцөл байдал

Кохима хотод доод тал нь 4 хонож худалдаагаа хийдэг Фоламгийн худалдаачидтай харьцуулахад Циса баса, Мерамагийн худалдаачид нэг өдөр хангалттай хэмжээний ачаа бэлтгээд, оройдоо гэртээ буцаж ирдэг. Зах зээлийн ердийн өдрийн зардлыг (рупеегээр) дор харуулав. Үүнд:
Тээвэр

Тосгоноос Кохима хүртэлх нийтийн автобусны билет 50

Зах хүртэлх хөлс	20
Өдрийн хоол, зууш	40
Баглаа боодол	10
Нэг өдрийн цалин	100
Нийт	200

Өдрийн дундаж цалин 330 рупее орчим бөгөөд 110 рупеегийн (өчүүхэн) ашиг олдог. Худалдаачид болон тосгоны настайчуудын ажигласнаар тариалж буй хүнсний ногооны тоо хэмжээ нь хэтэрхий бага учраас ногооны худалдаа нь ерөнхийдөө тийм ч ашигтай бизнес биш юм. Үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн үед ашигтай болж болох боловч мал сүргийг тариалангийн талбайд оруулахгүйн тулд хашаажуулалтын систем ашиглаж эхлэх үед л энэ нь боломжтой болно. Тэд туршлагагүй худалдаачдаас хүнсний ногоог бөөнөөр нь авдаг байнгын худалдаачдыг бусдын туршлагагүйг нь далимдуулахаа зогсоох хэрэгтэй гэж хэлсэн. Үүнээс гадна янз бүрийн хүнсний ногооны төрөл бүрийн үрийг худалдаачдад өгсөнөөр үйлдвэрлэл нь нэмэгдэнэ гэж тэд зөвлөсөн. Тариаланчид шинэ төрлийн ногоог туршихдаа их сайн. Жишээлбэл: нэг эмэгтэй худалдаачин хэлсэнээр Жожуа гэдэг нэртэй төрийн албан хаагчийн өгсөн төрөл бүрийн шошны үрийг тариалсан нь их амжилттай болжээ. Тэд энэ ногоог «Жошуа шош» гэж нэрлэжээ.

Гэрийн цэцэрлэгт гүйцэтгэж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийг ойлгохын тулд бид хоёр тосгоны 17 өрх айлын дунд судалгаа явуулсан. Эдгээр бүх айлын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хамтдаа тариалалтын бүх ажилд оролцдог болсон нь эрчүүдийн хандлагад томоохон өөрчлөлт гарсаныг илтгэж байна. өмнө нь эрчүүд ердөө

хашаа барих, ширэнгэн ойг цэвэрлэхэд л тусалдаг байв. Одоо тэд газар хагалж, тариа тарьж, хог ургамлыг түүж, ургац хурааж байна. Эрчүүдийн оролцохгүй байгаа цорын ганц ажил нь худалдаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүдийн ажил хэвээр үлджээ.

Гол боломжууд ба бэрхшээлтэй талууд

Фоламитай харьцуулахад эдгээр хоёр тосгон Кохимад илүү ойр оршдог тул байнгын автобус явдгаас гадна Нейшинэл хайвей-61 автобус түүгээр дамжин өнгөрдөг. Худалдаачид зах гарахынхаа өмнөх өдөр ногоогоо хураагаад худалдаагаа дууссаны дараа оройдоо гэртээ харих бололцоотой.

Хэдийгээр тээвэрлэлт асуудалгүй боловч тосгоныхонд үйлдвэрлэлтэй холбоотой бэрхшээл их байдаг. Тэдний хувьд зах зээл дээр эрэлт ихтэй хүнсний ногоо болох төмс, байцааг тариалах нь хэцүү байдаг учраас техникийн ноу-хау суралцах нь тэдэнд үр дүнтэй болно. Мөн худалдаачид газар тариалангийн үйлдвэрлэл нь янз бүрийн шавьж, өвчлөлд өртөмтгий тул энэ талын менежментийн үр чадвараа дээшлүүлэх хэрэгтэй байна гэдгээ онцлон хэлсэн.

Хамгийн том бэрхшээл нь чөлөөтэй бэлчээрлэж яваа мал сүрэг бөгөөд хашаа барих нь ялангуяа ядуу айл өрхийн хувьд маш өндөр өртөгтэй байдаг. Энэ нь гэрийн цэцэрлэг уг нь гэр бүлийн мөнгөн орлогын ихэнх хэсгийг биш юм аа гэхэд нэлээд хэсгийг оруулдаг хирнээ жижиг хэвээр байдгийг тодорхой тайлбарлаж байна. Цэцэрлэгийн дундаж талбай нь 30, 20 метрийн харьцаатай байдаг ба 80, 40 метрийн харьцаатай том талбайтай цэцэрлэгүүд ч бий. Мал сүргийн бэлчээрлэлтийг жилийн туршид хянаж, зохицуулах тухай тосгоны зөвлөлийн журам болон Нагаландын хууль зүйн Ассемблейгээс гаргасан “Мал сүрэг бэлчээрлүүлэх тухай” хууль эрх зүйн акт байдаг ч тосгоны малтай хүмүүс элит гаралтай, өөрсдийн хувийн цэцэрлэггүй байдгаас энэ журам, акт огт нөлөөлж чаддаггүй юм байна. Тэд засгийн газрын тогтоолууд, журамуудыг дагаж мөрдөхгүй хэвээр байна. Тосгоны эрх баригчид, тариаланчид хамтран сул яваа малыг алах, малчинд томоохон торгууль

ноогдуулах, нийтийн хашаа барих зэрэг хүчтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж үзжээ. Гэвч энэ нь тосгоны эрх баригчид, малчин, мал эзэмшигч иргэдийн хооронд зөрчил үүсгэхээс өөр үр дүнд хүргэсэнгүй. Одоогоор тохирсон шийдэл олоогүй байна.

Хүснэгт 3.7

Мерема, Цисе баса тосгонуудын зах зээлд борлогддог хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжууд

Асуудал	Зэрэглэлээр нь жагсаасан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх сонголтууд	
	Мерема	Цисе баса
Нийлүүлэлт хангалтгүйн бэрхшээл/ өндөр эрэлттэй уялдуулан үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх	Буурцаг, жүрж, чинжүү, нэрс, гадил	Пассифлора төрлийн жимс /гранидилла гэж мөн нэрлэдэг/ ба навч, буурцаг, гичний навч, модны улаан лооль
Хамгийн их хэмжээгээр үйлдвэрлэгдэж, борлуулагддаг	Хаш баклажан/, гадил, нэрс, жүрж, чинжүү, буурцаг, гичийн навч, нутгийн сармис, colocassia, chayote навч	Гадил, халуун өвс, буурцаг, пассифлора төрлийн жимс ба навч, хаш, чинжүү, colocassia, chayote навч, нэрс
Оргил улиралд “санаа зовоосон борлуулалт” буюу борлуулалт муутай байдаг	Хаш, нэрс, гичийн навч, улаан лооль, chayote жимс	Hibiscus, solonum
Нэгжийн үнэ нь хамгийн өндөр байдаг	Жүрж, чинжүү	Буурцаг, нэрс, өргөст хэмх, гадил, чинжүү, гичийн навч, шош, модны улаан лооль, улаан лооль, colocassia
Арилжааны зориулалтаар их хэмжээгээр тариалах сонирхолтой боловч ноу-хау дутагдалтай	Төмс, сонгино, байцаа, усан үзэм, пассифлора төрлийн жимс, талбайн шош, лууван	Төмс, хаан чинжүү, сонгино, байцаа, бөөрөнхий самар
Шавьж, өвчлөлт өртөмтгий ногоо	Байцаа, гичий навч, жүрж	Улаан лооль, байцаа, модны улаан лооль, халуун өвс, төмс, бөөрөнхий самар

Эх сурвалж: НАБЭЗХТ-ийн талбайн ажил

Хөндлөнгийн оролцооны сонголтууд

Хоёр тосгоны хэрэгцээ шаардлага, сонголтуудыг бид хүснэгт 3.7-д тодорхойлон харуулсан. Эдгээрийн ихэнх нь хоорондоо нягт уялдаатай. Үйлдвэрлэгчид, худалдаачид зах зээл дээр сайн зарагдах бололцоотой хүнсний ногоонуудын талаар мэдлэг сайтай байна. Тэд зах дээр зарим ногоо эрэлт ихтэй байгааг мэдэж буй ч цаг үетэйгээ хөл нийлүүлэн, эрэлтэд нийцүүлэн үйлдвэрлэлээ явуулах гэхээр ноу-хау мэдэхгүй байна.

Тариаланчдыг өөрсдийн органик үйлдвэрлэлийн аргаа хадгалахын зэрэгцээ эрэлт ихтэй хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд нь туслах зорилгоор бид судалгааны лабораторууд болон үйлдвэрлэгчидтэй ялангуяа шавьжнаас хамгаалах нэгдсэн систем, био-бордоо, био-аргалийн талаар хэлэлцэж эхлээд байна. Бид тус бүсийн бусад тариаланчдын бодит жишээнд тулгуурлан тариачид Висвема тосгоны төмсний тариалалт зэрэг “хамгийн сайн” буюу шинэ туршлагаас суралцахыг дэмжиж ажилласан.

КНОНОМА

Кнонома нь Кохимагаас баруун зүгт 22 км зайтай оршдог бөгөөд Ангами ястаны хүмүүс оршин суудаг. Тэнд 391 айл өрх амьдардаг ба нийт 2.180 орчим хүн амтай (Каринс 2004). Тосгонд очиход их хялбар бөгөөд Кохима руу өдөр бүр нийтийн автобус явдаг. 1981 онд Кохима руу анхны автобус явж эхэлсэн тэр цагаас Кнономад хүнсний ногооны худалдаа эхэлсэн. үүнээс өмнө цөөхөн тооны эмэгтэйчүүд айлд зочлох гэж хот руу явган алхаж очингоо гадилын навч зэрэг зэрлэг ногоог худалддаг байв. Нийтийн тээврийн хэрэгслийн ачаар хот руу явагсдын хөдөлгөөн эрс нэмэгдсэн. Тосгоныхон хот руу нийгмийн асуудлаар явахаас гадна хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн эсвэл ойгоос түүсэн бүтээгдэхүүн худалдах, гэр бүлдээ шаардлагатай зүйлс худалдан авах зэрэг эдийн засгийн шалтгаанаар хот ордог.

Өөрсдийн талбайд хүнсний ногоо тариалж, зах дээр худалддаг 25-н худалдаачин бий. Заримдаа тэд өөрсдөө худалдаагаа хийдэг

бөгөөд үнэ боломжийн үед бөөний худалдаачдад ногоогоо зардаг. Зах гарсан ердийн өдрүүдэд худалдаачин өдрийн зардалдаа 200 орчим рупи зарцуулдаг бөгөөд багахан ашиг олдог. Ихэнх худалдаачид хэрэв бөөний үнэ боломжийн байвал ногоогоо бөөний үнээр тосгон дотроо борлуулахыг хүсч байна гэж хэлсэн. Ярилцлаганд хамрагдсан бүх эмэгтэй худалдаачин хүнсний ногооны худалдааг ашигтай бизнес гэж үзэж байв. Энэ орлого нь хүүхдийнхээ сургуулийн төлбөрийг төлөх, хувцас худалдаж авах, гэр бүлд хэрэгцээт бусад зүйлс болох сүү, элсэн чихэр, мах, хэрэв ахиухан ургац авсан бол будаа худалдаж авахад нь нэмэр болдог. Арилжааны зориулалтаар бөөний худалдаа эрхлэх нь уялдааг нь хангаж зохицуулахгүй бол худалдаанд саад болно гэж тэд үзсэн. Бүх хүүхэд нь сургуульд явдгаас талбай дээр туслах хүн байхгүй (сургуулийн амралтаас бусад үед) тул ажиллах хүчин дутагдалтай байгааг ч тэд мөн дурьдсан.

Боломжит хөндлөнгийн оролцоо

Энэ нөхцлийг сайжруулж болох хэд хэдэн санааг бид худалдаачдаас сонссон. Түр хугацааны нэгэн худалдаачин КХХ-нынхон тогтсон захууд дээр худалдаа хийх журмаа хатуу мөрдүүлэх хэрэгтэй гэж зөвлөсөн. Тэр хэлэхдээ “өнөөдөр худалдаачны ногоог хураасан бол маргааш нь юу ч хийдэггүй. Иймд худалдаачид бага зэргийн эрсдэлтэй ч гэсэн замын хажууд нөгөө газраа маргааш нь ахиад л ирдэг. Худалдан авагчид ч гэсэн замын хажуугаас бус хүнсний зах дээрээс худалдан авалт хийж сурах хэрэгтэй” гэсэн. Бас нэг худалдаачин “Засгийн газар сайн чанарын үрээр хангаж, сайн үнээр зарагддаг улирлын бус чанартай хүнсний ногоог хэрхэн тариалах техникийн мэдлэг, ноу-хауг түгээх хэрэгтэй” гэж хэлж байсан.

Бид бага хэмжээний хураамж худалдаачдаас авдаг боломжийн захууд нээх нь зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн. Худалдаачдын бодлоор Нагаландын улсын тээврийн цогцолборын хуучин байшинд одоо гуталчид байгаа бөгөөд тэр газар хамгийн сайн байршилтай юм байна. Тэдний энэ саналыг бид захиргааныханд хэлэхэд хотын төвд байрлалтай ийм газарт хүнсний ногоо худалдах нь эрүүл ахуйн

үүднээс зохимжгүй гэж үзэж байна гэсэн хариу өгсөн. Энэ асуудлыг нэмж судлах шаардлагатай.

Тосгонд хүнсний ногооны бөөний төв буюу агуулах барьж, тэндээс ногоог өөртөө туслах бүлгүүд, хоршоодын тусламжтайгаар Кохима руу тээвэрлэж байх саналыг зөвлөмж болгосон.

Амжилттай яваа тариланчдын дунд сайн практикийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл солилцуулахын тулд туршлага солилцох аялалыг илүү олон зохион байгуулах нь бас нэг боломжит сонголт юм. Сайн ажиллаж буй тариаланчдыг Засгийн газрын хөгжлийн хэлтсээс тодорхойлж, мөнгөн болон бусад хэлбэрийн урамшуулал олгох бас нэг боломж юм.

Эмэгтэйчүүд өөрсдөө хүнсний ногоог ачиж, буулгахад бэрхшээлтэй байдаг тул эрчүүд хүнсний ногоо худалдвал ямар вэ гэж асуухад худалдаачдын нэг нь дараах хариултыг өгсөн юм.

Уламжлал ёсоор эрэгтэй, эмэгтэй хүмүүс тус тусын үүрэгтэй тул худалдааны ажил нь эрчүүдийн хийх ёстой зүйл биш. Үүний оронд ерхийн орлогоо нэмэгдүүлэх эсвэл гэр бүлийн хэрэгцээндээ зориулан эрчүүд сүрлээр, чулуугаар, модоор эдлэл хийсэн нь дээр. Тэдэнд бага хэмжээний (өчүүхэн орлого олох) орлого олохын тулд бүхэл өдөржингөө замын хажууд суух тэвчээр байхгүйгээс гадна тэд юу ч зарахгүй байх магадлалтай. Бүх ногоогоо худалдаж чадсан ч тэр мөнгөөрөө гэртээ юу худалдаж авах ёстойгоо эрчүүд сайн мэдэхгүй. Харин худалдах зориулалттай их хэмжээний ногоог Димапур зэрэг хол зах дээр худалддаг учраас түүнийг их хэмжээгээр худалдах ажлыг эрчүүд хийдэг. Эрчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад удаан хугацаагаар хол газар явах боломжтой байдаг. Мөн эрчүүд их хэмжээний хүнсний ногоог ачих, буулгах ажлыг эмэгтэйчүүдийг бодоход амархан хийчихдэг.

Дүгнэлт

Хүнсний ногооны төрөлжсөн үйлдвэрлэл, маркетингийн практикийн тухай манай судалгаанд оролцсон эмэгтэй худалдаачид хэд хэдэн боломж, давуу талыг дурьдсан байсан. Газрын хөрс, хур тунадасны хэмжээ, газар зүйн байршил, газрын түвшин зэрэг нь Нагаландын

тариаланчдад нэг талбай дээр олон ногоог харьцангуй амархан тариалах боломжийг олгодог. Тэд услалтын систем, бордоогүйгээр байгалийн нөхцөлд нь тариалах бололцоотой. Кохимад тэдний борлуулдаг хүнсний ногоо нь зэрлэг ба таримал гэсэн хоёр төрөл байдаг. Зэрлэг ногоог ихэвчлэн анхдагч ойгоос түүдэг бөгөөд таримал ногоог нүүдлийн тариалалтын талбай, хэсэгчлэн хуваасан талбай, гэрийн цэцэрлэг гэсэн гурван газарт тариалдаг. Олон төрлийн ногоог санал болгодог нь янз бүрийн хэрэглэгчдийн шаардлагад сайн нийцдэг. Ихэнх эмэгтэй худалдаачдыг гэр бүлийнхэн нь болон олон нийтийн зүгээс сайн дэмжиж, тусалдаг. Эмэгтэйчүүдийг эзгүй байхад нь эрчүүд нь гэрийн ажлаа хийдэг. Олон нийтийн зүгээс нийтийн хашаажуулалтын систем хэрэгжүүлж тэднийг дэмждэг. Хэдийгээр журам, зааврын (жишээлбэл: бөөнөөр нь шилжүүлэн нүүлгэх г.м) дагуу КХХ-ын ажилтнууд худалдаачид болон худалдааны үйл явцыг албан ёсоор зохицуулах эрх үүрэгтэй ч эдгээр шийдвэр гаргах эрх мэдэлтнүүд тэднийг өрөвдөж, ихэвчлэн зөөлөн ханддаг.

Гэхдээ арилжаа худалдаа нь бэрхшээл, саадгүй байж чаддаггүй. Түгээмэл бэрхшээлүүдэд хот суурин газраас ирсэн бөөний худалдаачдыг өөртөө татахуйц хэмжээний их үйлдвэрлэлтэй бус, түр хугацааны худалдаачид бөөний худалдаа хийхээр Кохима хот руу явах гэхээр хүнсний ногооны тоо хэмжээ нь хангалтгүй бус зэрэг орно. Мерема, Цисе басагийн хувьд мал сүрэг хаа сайгүй чөлөөтэй бэлчдэг, үйлдвэрлэгчид хашаа барих зардлыг төлөх чадваргүй зэрэг бэрхшээл байна. Эдгээр олон төрлийн бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд маркетингийн өөр сүлжээ олох хэрэгтэй учраас нэмэлт (судалгаа) хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна (Хайрцаг 3.8-ыг үзнэ үү).

Худалдаа хийх зах, бусад газруудтай холбоотой бэрхшээл бүх оролцогчдод тулгарч байна. КХХ-ноос хүнсний ногооны худалдаачдад зориулан дэд бүтцээр хангасан боловч худалдаачид түүнийг нь ашигладаггүй. Тэд өөрсдөдөө тухтай газар сууж, бизнесээ чөлөөтэй эрхлэхийг илүүд үздэгээс явган зочигчид, дэлгүүрийн эздэд саад болж замын хөдөлгөөнд бэрхшээл үүсгэж байна.

Худалдаачдад гаргаж өгсөн газарт нь нэг ч худалдан авагч ирдэггүй учраас ямар ч ашиггүй байна гэж худалдаачид өөрсдийгөө зөвтгөдөг. Энэ нь “тахиа ба өндөг”-ний үлгэртэй адил байна.

Хайрцаг

3.8

1. Маркетингийн өөр сүлжээ: Фуцеровгийн худалдаачид

Бүлэг эмэгтэйчүүд маркетингийн өөр арга хэрэглэхээр туршиж байгаа гэж тариаланчид бидэнд хэлмэгц бид очиж судалсан.

Хөрш тосгонуудын тариаланчид өөрсдийн хүнсний ногоог толгой дээрээ тавьж авчираад эдгээр эмэгтэйчүүд Фуцери дахь бөөний худалдааны төвд нь хүргэж өгдөг. Энэ бүлэг нь зөвхөн сонгосон хэдэн төрлийн ногоогоо ихэвчлэн сармис тариалдаг гэр бүлээс худалдаж авдаг. Эмэгтэйчүүд цуглуулсан хүнсний ногоогоо байнгын худалдан авагчдын стандартад нийцүүлэн баглаж боодог. Тэд ачааны машин хөлслөн Димапур явдаг.

Димапур явах замд нь тэдний байнгын худалдан авагчид Фифема, Медзифемад замын хажууд ногоогоо хүлээгээд сууж байдаг. Тэд ачааны машинаас буулгүйгээр боодолтой ногоогоо худалдан авагчиддаа чулуудан “тан нарын авсан ногоо 700 рупеэ болж байгаа шүү. Би маргааш ирээд мөнгөө авна” гэж хашгирдаг. Тэгээд тэд аялалаа цаашаа нь үргэлжлүүлдэг.

Димапур ирсэн өдөр нь тэднийг хүлээж байгаа худалдан авагчид алга байв. Та нар энэ ногоогоо одоо яах вэ гэж биднийг асуухад “бид нар өнөөдөр бизнес хийж чадахааргүй орой ирчихсэн байна, иймд ногоогоо агуулахад (тэдний түрээсэлж авсан агуулах) буулгана. Маргааш өглөө нийтийн автобус ирэхэд бүх ногоо зарагдана” гэж хариулсан. Маргааш өглөө нь агуулахад байсан бүх ногоо нь зарагдсан.

Бэрхшээлийг даван туулахын тулд бид орон нутгийн онцлогт нь тохирсон хөндлөнгийн оролцооны хэд хэдэн стратегиудыг боловсруулж байна. Мерема, Цисе басагийн хувьд өвлийн цагт мал сүрэг “чөлөөтэй бэлчээрлэх”-ийг нь хориглосон тосгоны шийдвэр болон “Мал сүрэг бэлчээрлүүлэх тухай» хууль эрх зүйн актыг хатуу мөрдүүлэхийг бид дэмжиж ажиллаж байна. Бид хүнсний ногоо борлуулах, худалдахын давуу тал, үр ашгуудыг Фоламид сурталчилж, хүмүүсийг идэвхжүүлэх ажил хийсэн. Мөн бид тосгон

болон хамгийн ойр хотын хооронд байнгын ачааны машин явуулах ажлыг олон нийт санаачлан хэрэгжүүлэхийг дэмжиж байгаа. Бид эрэлт хэрэгцээ өндөртэй боловч тариаланчдын бага мэддэг хүнсний ногоонуудыг хэрхэн тариалах тухай техникийн болон бусад материаллаг туслалцааг үзүүлсэн. Жишээлбэл: Мерема, Цисе баса тосгонуудын тариаланчид төмсийг органик аргаар тариалахыг хүсдэг ч менежментийн ур чадвар дутагддаг. Үүнтэй холбогдуулан шавьжнаас хамгаалах нэдсэн сургалт явуулбал үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх болно.

Кохима хот дахь мао оршин суугчдын санаачлагаар Маогийн зах цогцолбор бий болсон. Тэд мао худалдаачин эмэгтэйчүүд тосгоноос хүнсний ногоогл хот руу авчирдаг боловч амьжиргаагаа залгуулах гэж зүдэрч буйг нь ажигласан байна. Тэд өөрсдийн ажигласан зүйлээ Кохима хот дахь өөрсдийн хүмүүстэйгээ хэлэлцсэн бөгөөд дараа нь төвд байрлалтай нэгэн байшинг худалдан авчээ. Энэ зах нь мао худалдаачин эмэгтэйчүүдээр дүүрэн бөгөөд мао эмэгтэйчүүдийн бэрхшээлийг шийдэж өгчээ. Энэ амжилттай туршлагаас үлгэр жишээ авч бид хүнсний ногооны худалдааны газар байгуулах төлөвлөгөө боловсруулахын тулд хотын шийдвэр гаргачдаас бүрдсэн албан бус нийгэмлэг байгуулсан. Энэ чиглэлээр эхний алхам хийгдсэн боловч тодорхой үр дүнд хүрэхэд нэлээд хугацаа шаардлагатай байна.


АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Кэринс, М. (2004). Түлш ба бордоо: Газрын ашиглалтыг эрчимжүүлэхэд алдер-ын гүйцэтгэх үүрэг. 2004 оны 7 сарын 7-нд “Шилжиж буй тариалалт (нүүдлийн тариалалт): зүүн-хойд Энэтхэгийн бодлогын шаардлагууд”. (ICEMOD-той хамтран ЛИИД-Энэтхэг газраас дахин хэвлэсэн).
- Нагаландын засгийн газар (2001). *2001 оны Нагаландын статистикийн эмхэтгэл*. Кохимагийн Эдийн засаг, статистикийн хороо.
- Супон, К. (1999). Нагаландын шилжилтийн тариалалтын талаарх тариаланчдын мэдлэг. Нагаландын Мококчун хотын Хөдөө аж ахуйн судалгааны төвөөс ОУХСТ-д ирүүлсэн тайлан.

4

ФЕРМЕРҮҮДИЙН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ БА НУТГИЙН ҮРИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

*Балбын Бара дүцрэг дэх Агро-биологийн төрөл
зүйлийг ашиглах, хамгаалах үйл ажиллагааны
судалгаа*



Зураг авсан: ДИПА СИНГХ

ДИПА СИНГХ, АНИЛ СҮБЕДИ БОЛОН ПИТАМБЕР ШРИСТА НАР

ТОО БАРИМТ БОЛОН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Төсөлд хамрагдсан улс болон судалгааны бүсийн байршил

Балбын Вант Улс (Непал) бол уулархаг орон өмнө зүгт далайн түвшингээс 60 м-ийн өндөрт орших Энэтхэг-Гангийн тал газраас хойт зүгт далайн түвшингээс 8848 м-ийн өндөрт орших Эверест уулын оргил хүртэл тархдаг байна. Балбын нутаг дэвсгэр байгалийн 5 бүсэд хуваагддаг: Эдгээрт Гималайн нуруу (далайн түвшингээс 4000 м-ийн өндөр), өндөр уулархаг нутаг (2000-4000 м), дундад уулархаг нутаг (1500-2000 м), Сивалик угсраа уулс (300-1500 м), мөн улсын баруун хэсэгт тархсан Тераи хэмээх (300 м-ээс доош) Инд-Гангийн тал газар ордог. Тус улсын уур амьсгалыг өмнө зүгийн халуун буюу хойт зүгийн альпийн хүйтэн цаг агаар тодорхойлдог.

Балбын нийт хүн амын 81 орчим хувь нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж амьдардаг (CBS 1999). Хөдөө аж ахуй эрхэлж амьдралаа залгуулдаг хүмүүсийн хувьд эдлэн газрын талбай бага бөгөөд тэдгээр нь олон хэсэгт хуваагдсан байдаг. Нэг өрхөд гол төлөв 1 га-аас бага хэмжээний газар ноогддог ба нэг ам бүлд дунджаар 5-6 хүн амьдардаг байна. Хөдөө аж ахуйнуудын эдлэн газар нь ерөнхийдөө ашиг шим багатай буюу 1 га-аас 2 тн хүрэхгүй цагаан будаа хураадаг байна. Хөдөө аж ахуй хүнд хүчир ажилтай бөгөөд ажлын гол үүргийг эмэгтэйчүүд гүйцэтгэдэг. Дунджаар нийт газар тариалангийн ажлын 75 хүртэлх хувь нь эмэгтэйчүүдэд ноогддог байна (WFDD 2002).

Энэ бүлэгт судалгаа хийгдсэн Качорва тосгоны тухай өгүүлэх болно. Качорва бол Бара тойрогт оршдог жижиг тосгон юм (Зураг 4.1).

Зураг 4.1.
Судалгааны бүсийг харуулсан Балбын газрын зураг



Качорва тосгон халуун уур амьсгалтай Инд-Гангын тал газарт байрладаг. Энэ бүсийн жилийн дундаж хэм 24°C бөгөөд нэгдүгээр сар хамгийн хүйтэн, харин тавдугаар сард цаг агаар хамгийн халуун буюу 35°C хэм хүртэл халдаг байна. Качорва бол Тераи нутагт оршдог суурингуудын ердийн нэг жишээ мөн. Тосгоны овооролдсон байшингууд нь хөдөө аж ахуйн эдлэн газраар хүрээлэгдсэн байдаг. Качорва бол хуучин суурин бөгөөд онхол цонхолтой, хайргатай замаар явж хүрнэ. Гэвч энэ замыг цаг агаарын бэрхшээлтэй үед ашиглахад хэцүү болдог. Тосгонд нийт 914 айл өрх оршин суудаг бөгөөд тэдгээр нь угсаатны 5 бүлэгт хамрагддаг. Үүнд: нийгмийн дээдсийн давхарга болох Брахмин-Четри, Сах, Коири, Лалын шашинтнууд, мөн түүнчлэн нийгмийн доод давхарга буюу доод кастын хүмүүс (“үл хүрэгсэд”) багтана. Доод кастынхан нийгмийн хамгийн ашиггүй байр суурийг эзэлдэг бөгөөд улс төр, нийгэм эдийн засгийн хувьд төдийлөн чухал бус давхарга юм.

Качорвад дангаар, эсвэл хүчээ нэгтгэн амьдардаг айл өрхүүд оршин суудаг боловч дангаараа хөдөлмөрлөж амьдардаг айлууд нь зонхилох хувийг эзэлдэг байна. Качорвагийн хүн ам нь Энэтхэг-Арийн соёлтой бөгөөд эрэгтэйчүүд нь ноёрхож эмэгтэйчүүд нь элдэв хоригоор дарамтлуулж амьдардаг байна. Ихэнх эмэгтэйчүүд нь гол төлөв фермийн баян аж ахуйтай айлд зарцлагддаг. Качорвагийн оршин суугчид хөдөө аж ахуйд үе үе гүйцэтгэдэг ажлын үр дүнд олсон орлогын нийлбэрээс хамаарагддаг байна. Ихэнх нь газар тариалан эрхэлж жилд гол төлөв 3 удаа ургац хурааж хүнсээ бэлддэг байна.

Тосгоны иргэд болон төслийн хүрээнд судалгаа явуулах, түүнийг өргөтгөж дэлгэрүүлэх ажлын тогтолцоо хоорондын харилцан хамтран ажиллах явдал өндөр түвшинд хүрсэн. Үүний зэрэгцээ Энэтхэгийн хил залгаа нутгийнхантай технологи болон газар тариалантай холбоотой үйлдвэрлэлийн зардлын талаар харилцаа холбоо тогтоосон байна. Энэ бүгд нь Качорваг Балбын бусад олон нутагтай харшуулан зүйрлүүлэх буюу бусдаас ялгагдах байдалд хүргэсэн ажээ. Тариалангийн талбай гол төлөв усжуулсан болон бороонд норсон (хет) хөрстэй. Харин усжуулаагүй (бари) бхитха

хөрс зөвхөн цөөн тооны тосгонд ажиглагдсан. Качорва бол хөдөө аж ахуйн олон нэр төрлийн ургамлаар баян. Үүнд 18 нэр төрлийн үр тариа буюу 34 нэр төрлийн хүнсний ногоо, маш олон төрлийн халуун ногоо, үүнээс гадна 24 нэрийн цагаан будаа ургуулдаг байна.

“Ургацыг газар дээр нь хадгалах” төсөлтэй нэгтгэх

“Ургацыг газар дээр нь хадгалах” төсөлд хамрагдсан гурван нутгийн нэг нь Бара юм. Олон орон хамарсан энэ төслийг Олон улсын ургамлын генетикийн нөөцийн хүрээлэнгээс удирдаж дэлхийн 9 оронд хэрэгжүүлж ирсэн. Балбын газар тариалангийн судалгааны зөвлөл, Биотөрөлжилтийг судлах, хөгжүүлэх талаарх орон нутгийн санаачилгыг дэмжих байгууллага хамтран Бара, Каски, Жумла нутгийн хөдөө аж ахуйн хоршоод болон бүлгүүдтэй түншийн харьцаа тогтоож дээрх төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Бара бол тал газрын, Каски дундад доворхог газрын бөгөөд Жумла өндөр доворхог газрын бүсэд оршдог.

Төслийн нэгдүгээр шатыг Нидерландын хөгжлийн агентлаг боловсруулж 1997 оны 9-р сараас 2001 оны 12-р сарын хооронд хэрэгжүүлсэн. Уг төсөл нь дараахь 3 үндсэн зорилтыг хөдөө аж ахуйд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн. Үүнд: Ургацыг газар дээр нь хадгалах ажлын шинжлэх ухааны үндэслэлийг бэхжүүлэх; хадгалалтыг удирдан зохион байгуулах үндэсний бүтцийг бий болгох үүднээс шаардлагатай барилга, байгууламжийг барих; фермерийн аж ахуй эрхлэгчдийн ашгийн төлөө нутгийн ургамлын генетик нөөцийн үнэлгээг нэмэгдүүлэх зэрэг орно. Төслийг төлөвлөх болон хөдөө аж ахуйд хэрэгжүүлэх ажлын явцад нийгэм болон жендэрийн холбогдолтой эгзэгтэй асуудлуудыг харгалзан шийдвэрлэхэд ихээхэн хүч чармайлт гаргасан ажээ. Үнэлгээний ажил болон нутгийн хөдөө аж ахуйн олон нэр төрлийн ургамлыг тухайн хөдөө аж ахуйн орчинд дасгах, мөн холбогдох барилга, байгууламж барих, эрх бүхий хамтын нөхөрлөлүүд бий болгох, улмаар нутгийн хөдөө аж ахуйн ургамлын олон нэр төрлийг ургуулж заншуулах ажлыг газар тариаланг хөгжүүлэх үндсэн чиглэл болгох зэрэг төслийн

арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явцад тодорхой үр дүнд хүрсэн байна. Хугацааны хязгаарлагдмал байдлаас үүдэн зарим зүйлийг нарийвчлан тодорхойлох боломжгүйд хүрсэн. (Лавлах жагсаалтанд дурьдсан тайлантай танилцана уу- Гаучан 2000; Раначал 2000; Сүбеди нар.1999; Сүбеди нар 2001).

Төслийн хугацааны төгсгөлд хөдөө аж ахуйн нийгэмлэгүүдэд эхлүүлсэн олон арга хэмжээ үргэлжилсэн хэвээр байлаа. Шийдвэрлэгдээгүй асуудал болон шинээр үүдэн гарсан эрэлт хэрэгцээг хянаж тодорхойлсон билээ. Канадын Олон улсын хөгжлийн судалгааны төвийн дэмжлэгтэйгээр төслийн хоёрдугаар шатыг 2002 оны 9-р сараас эхлэн хоёр жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэхээр тогтсон. Нийгэм болон жендэрээр ялгаварлах асуудалтай холбоотой бидний судалгаа нь төслийн хоёрдугаар шатны нэгэн хэсэг мөн. Төслийг хэрэгжүүлэх явцад хөдөөний амьдралд нийгэм болон жендэрийн холбоотой асуудал ямар ач холбогдолтой болохыг илүү ойлгуулах, үүнээс гадна нутгийн үрийн аж ахуйн тогтолцоог боловсронгуй болгох сонирхолтой байгууллагуудыг бэхжүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Бидний судалгаа тодорхой арга хэмжээнд чиглэсэн бөгөөд гурван томоохон зорилтыг агуулсан билээ. Үүнд:

1. Янз бүрийн нийгэм эдийн засгийн давхарга мөн жендэрийн бүлэгт хамрагдсан фермерүүдийн үр боловсруулах үйлдвэрлэл, улмаар худалдаанд оролцох чадавхийг дээшлүүлэх, ингэснээр тэдний эдийн засгийн байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах
2. Нутгийн үрийн зах зээлийн тогтолцоо болон сүлжээг бэхжүүлэх
3. Газар тариаланг судлах, хөгжүүлэх үйлсэд нийгэм болон жендэрийн асуудлаарх хэтийн төлвийг үндсэн чиглэл болгон баримтлах, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах боломжийг олгох зэрэг болно.

Дээр дурьдсан асуудлууд өргөн хүрээтэй, анхаарал татсан бөгөөд цаашид энэ бүлэгт өнөөдрийг хүртэл хэрэгжиж дуусаагүй төслийн зарим ажилтай танилцуулна.

Байгалийн Нөөцийн Удирдлагын Үндсэн Асуудал

Балбын фермерүүд өрхийн янз бүрийн хэрэгцээг хангах үүднээс олон төрлийн ургамал тарьж, тэдгээрийг хадгалж ирсэн байна. Бүс нутгийн хөрсний олон төрөл өвөрмөц шинж тэмдэгтэй байдаг. Жишээ нь, Бхатхид дээд зэргийн цагаан будаа ургадаг. Энэ нь усанд автсан хөрсөнд ургуулсан орчин үеийн олон шинэ нэр төрлийн цагаан будаанаас хавьгүй сайн чанартай байдаг. Фермерүүдийн үзэж байгаагаар олон газар тухайн нутгийн хөрсний чанар гагцхүү ашиг шим муутай газар сонгоход хүргэдэг. Иймд Качорвагийн фермерүүд, ялангуяа нөөц бололцоо хомс ядуу айл өрхүүд хүнсний найдвартай хангамжийг баталгаажуулах үүднээс багагүй хүч, хөрөнгө зарцуулсан байна (Рана нар 2000). Будааны их хэмжээний ургацтай хөрсөнд эдийн засаг, нийгмийн ач холбогдол, үнэлгээг хэдийнээ тодорхойлсон байдаг. Тэдгээрийн эрэлт хэрэгцээ маш их. Үүний зэрэгцээ онцгой чанартай эдгээр газруудын шинж чанарын талаарх зах зээлийн мэдээлэл хомс байдаг. Энэ байдал зарим хөдөө аж ахуйн ургамлын үр болон буудайн, жишээ нь Лалка, Басмапи, Кария Камодын цагаан будааны нийлүүлэлтэд хязгаарлах нөлөө үзүүлдэг. Фермерүүд үйлдвэрийн техникийн талаарх ямар нэгэн мэдлэг, чадвараар гачигдаж байдгаас нутгийн үрийг чанартай бөгөөд өндөр өгөөжтэй ашиглаж чадахгүй байна (Гаучан 2000). Ер нь фермерүүд өөрсдийн ургуулсан үрийг жилээс жилд хадгалж ирсэн хэдий ч үрийг сонгон үржүүлэх болон хадгалан үлдээх аргыг боловсронгуй болгох боломж байгааг судалгаа харуулсан. Энэ нь бидний ажлын шийдвэрлэвэл зохих асуудлыг нэг болсон.

Балбад газрыг албан бус үрийн аж ахуйн сүлжээгээр дамжуулан солилцдог байна. Гэвч үрийн жижиг үйлдвэрлэгчид болон зах зээлийн элдэв суваг хоорондын хэврэг холбоо улам ихсэх шахалтанд эмзэглэж ирсэн. Фермерүүд өөрийн талбайгаас хураадаг олон нэр төрлийн ургацаас олох ашгаа нэмэгдүүлж чаддаггүй. Учир нь орчин үеийн олон шинэ нэр төрлийн ургацын дундаж хэмжээ өндөр бөгөөд илүү ашигтай үнээр борлуулах боломжтой тул фермерүүд хэрэглээнд нэгэнт нэвтэрч чадсан эдгээр шинэ нэр төрлийг сонгох

сонирхолтой ажээ. Иймд хөдөө аж ахуйн нөхөрлөлд чанартай үр үйлдвэрлэх, арилжаа наймаанд оролцох чадварыг дээшлүүлэх зорилгоор шаардлагатай байгууламж барих хэрэгцээтэй болсон. Үүний үр дүнд нутгийн үрийн хангамжийн тогтолцоо болон үрийн зах зээлийн сүлжээг хүчтэй болгоход бодитой нөлөө үзүүлнэ. Хоёрт, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хариу барих, мөн чанартай хөрсөнд ургуулсан үрийн үнэд судалгаа хийгдэнэ.

Фермерүүд ургамлын олон нэр төрлийг хадгалж үлдээх зорилгоор тэдгээрийг тариалж нөөцөлдөггүй хэдий ч олон нэр төрлийг хадгалж үлдээх ажил нийт нийгмийн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд фермерүүдийн зүгээс энэ ажилд тодорхой хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэх нь зүйн хэрэг юм. Энэ асуудлыг шийдвэрлэхэд бүтээгдэхүүнийг зах зээлээр дамжуулан нэр төрлийн сонголт хийх бололцоогоор хангах нь хамгийн бага зардалтай хөшүүрэг байж болох юм (Бруш 1991). Нутгийн үр тарианы борлуулалтыг дэмжих болон үрийн жижиг үйлдвэрлэгчидийг зах зээлтэй холбож өгөх явдал фермерүүдэд туслалцаа үзүүлэх нөлөө бүхий арга байж болно.

Нийгэм болон жендэрийн судалгааг байгалийн нөөцийн асуудалтай нэгтгэх

Нийгэм болон жендэрээр ялгаварлах байдлын судалгаа нь өрхийн аж ахуйн бүлгүүдийн янз бүрийн гишүүд болон бусад айл өрхийн зүгээс байгалийн нөөцийн удирдлагад ямар үүрэг гүйцэтгэдэг талаар ойлгоход тусалдаг. Хөдөө аж ахуйн олон төрөлт ургамлын удирдлага нь тарьж ургуулах, ажлыг удирдах чадвар, ургац хураах, боловсруулалт хийх, үр солилцох болон олж авах зэрэг үрийг хөгжүүлэх, түүнийг шинэ орчинд дасгах үйл явцад нөлөөлөх олон асуудлыг хөнддөг билээ (Жаврис 2000). Газар тариаланг удирдан зохион байгуулахад фермерүүд яаж шийдвэр гаргадаг тухай асуудал жендэрийн онцлогтой буюу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг ажил, хүлээсэн үүрэг тус тус ялгаатай байж үр дүнд нь өөр хоорондоо ялгаатай ажлын туршлага, мэдлэгтэй болдог байна (Адамо болон Хорвока 1998; Сүбеди нар 1999).

Балбын үрийн тогтолцоо олон төрлийн үйл ажиллагааг багтаадаг бөгөөд юмны учрыг олдог фермер ажил нэг бүрийг эрхэлдэг байна. Үүрэг, хариуцлагын хувиарилалт үе дамжин өвлөж ирсэн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн мэдлэг, ур чадвар дээр үндэслэдэг ажээ. Үрийн үйлдвэрлэл болон олон төрөлт ургамлын удирдлага бол нийгмийн ер бусийн үзэгдэл мөн.

Нөөцөнд хүрэх буюу түүнээс хүртэх боломж мөн мэдлэгийн түвшин нь нийгэмд янз бүрийн байр суурь эзэлдэг бүлгүүд хооронд ялгаа үүсгэдэг бөгөөд энэ нь нийгмийн болон жендэрийн харьцаанд тэгш бус байдлыг даамжруулдаг байна. Ер нь нөөц бололцоо багатай өрхийн аж ахуйнууд фермерээс фермерт сүлжээгээр дамжуулан нөөцөөр баталгаатай хангагдсан фермерийн генетикийн материалын (ур, бусад суулгах материал) чанарт итгэдэг байна. Сүлжээний үйл ажиллагаа өргөжин тэлж улмаар тосгоны хилийг даван хэрэгждэг байна (Сүбеди нар 2001). Фермерээс фермерт сүлжээ генетикийн материалыг тарьж дэлгэрүүлэх, мөн түүнчлэн холбогдох мэдлэгийг түгээхэд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Энэ маягийн тогтолцоонд (гол төлөв жижиг) нийгэмд дээгүүр байр суурь эзэлдэг хэдэн тооны хүмүүс үрийн нэр төрлийг хэрэглээнд нэвтрүүлэх бөгөөд нийлүүлэх ажлыг гүйцэтгэдэг. Бид тэд нарыг “гол фермерүүд” гэж нэрлэх болсон. Сүлжээн доторхи нийгмийн харилцааг ойлгон тунгаах явдал нь тэдгээрийн үйл ажиллагааг цаашид хүчтэй болгох, өргөтгөх, жишээлбэл, технологийг дэлгэрүүлэх ажлын үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэхэд анхны чухал алхам мөн. Цаашид энэ нь янз бүрийн давхаргын фермерүүд технологи эзэмшиж, ингэснээр түүнээс олох ашгаас богино хугацаанд хүртэхэд нөлөөлнө.

Бидний судалгаа дараахи өргөн хүрээтэй асуудалд анхаарал хандуулахыг зорьсон билээ. Үүнд: Газар тариалангийн судалгаа, түүний хөгжлийн нийгэм болон жендэрийн талаарх хэгийн төлвийг хянан үзэж өнөөгийн байдалд ямар дүгнэлт хийх вэ?, Нийгэм болон жендэрийн оролцоог газар тариалангийн судалгаа, хөгжлийн асуудалтай нэгтгэхэд шахалт үзүүлэх ямар хүчин зүйл байна вэ?, Бара дахь үрийн аж ахуйн тогтолцоотой холбоотой судалгааны дараахь онцгой асуудлууд гарч ирсэн: Нийгмийн болон жендэрийн янз бүрийн бүлгүүдийн үрийн үйлдвэрлэл болон худалдаанд гүйцэтгэж буй үүрэг, хүлээсэн хариуцлага ямар байна? Үрийн

урсгалын өнөөгийн механизм ямар байна вэ? Үрийн худалдааны тогтолцоо мөн сүлжээний өнөөгийн үйл ажиллагааг ямар аргаар хүчтэй болгох вэ? зэрэг болно.

Төслийг Орон Нутагт Хэрэгжүүлэх Ажлын Явц

Зохиолын тойм/Баримтын шинжилгээ

Судалгааны эхний шатанд хэвлэмэл материалын хоёр удаагийн тойм хийгдсэн. Үүний нэг нь үрийн үйлдвэрлэл болон худалдаанд хэрэгжүүлж буй өнөөгийн арга сэдвээр, (жишээ нь, Балбын Хөдөө аж ахуйн яамны үрийн асуудлыг зохицуулах бодлого мөн Балбын Үрийн удирдах газраас зохион байгуулдаг семинарын материал), мөн түүнчлэн газар тариаланг судлах, хөгжүүлэх үйлсэд нийгэм болон жендэрийн янз бүрийн бүлгүүдийг оролцуулах асуудлыг баримтлах үндсэн чиглэлээ болгох сэдэвтэй холбоотой бусад материал (жишээ нь, Балбын Газар тариалангийн судалгааны зөвлөлөөс явуулдаг бодлогын талаарх баримт бичгүүд, Хөдөө аж ахуйн яамны бодлого болон төлөвлөлтийн талаарх баримтууд, Балбын Засгийн газрын таван жилийн төлөвлөгөө) юм. Балбын Газар тариалангийн судалгааны зөвлөл судалгааны ажилд, Газар тариалан болон хоршоодын яам, Хөдөө аж ахуйн газар бодлого болон өргөжилтөнд баримтлах гол чиглэл болох нийгэм болон жендэрийн судалгааг хэрхэн хэрэгжүүлж байгаад онцгой анхаарал хандуулж ирсэн. Бид нийгэм болон жендэрийн харилцааны талаарх хэтийн төлвийг газар тариалангийн судалгаа, түүний хөгжлийн асуудалтай нэгтгэхэд саад учруулах хүчин зүйл болон боломжийг тодорхойлохыг хичээсэн билээ.

Засгийн газрын болон Засгийн газрын бус байгууллагатай хамтран ажиллах тухай

Холбогдох материалтай танилцсаны үндсэн дээр ажлын үндсэн

чиглэл болох нийгэм болон жендэрийн асуудлыг шийдвэрлэхэд хариуцлага хүлээх газар тариалангийн судалгаа болон хөгжлийн байгууллагуудыг тодорхойлсон болно. Балбын Газар тариалан, судалгааны зөвлөл, Газар тариалан болон хоршоодын яамны Эмэгтэйчүүд хөгжлийн төлөө газрын явуулын ажилтнуудтай хамтран цуврал цуглаан, ганцаарчилсан ярилцлага бөгөөд гол бүлгүүдийг оролцуулсан мэтгэлцээн хийх зэрэг арга хэмжээнүүдийг удирдан зохион байгуулсан. Жендэрийн гол хүмүүс бөгөөд Газар тариалан болон хоршоодын яамны жендэрийн ажлын бүлгийн гишүүд хооронд харилцаа тогтоосон болно.

Гол бүлгүүдтэй зохион байгуулсан мэтгэлцээн нь нийгэм болон жендэрийн холбогдолтой хэтийн төлвийг газар тариаланг судлах, хөгжүүлэх асуудалтай нэгтгэн шийдвэрлэх талаар өнгөрсөн хугацаанд гүйцэтгэсэн ажлын ололт амжилт болон төлөвлөгөөг баримтжуулах зорилгоор хийгдсэн. Биотөрөлжилтийг судлах, хөгжүүлэх талаарх орон нутгийн санаачлагыг дэмжих байгууллагын төслийн ажилтнуудын дунд “өрхөд” мэтгэлцээн зохион байгуулж хянан шийдвэрлэх асуудлын жагсаалтыг өнөөгийн ололт амжилтаас гадна элдэв шахалт болон бусад хүчин зүйлийг харгалзан боловсронгуй болгосон билээ.

Бидэнд Засгийн газрын ажилтнуудтай харилцан хамтран ажиллах бэрхшээлтэй байсан. Уулзалтын цаг тохирох хэцүү байв. Бидэнтэй ярилцлага хийсэн ихэнх ажилтнууд жендэрийн холбогдолтой асуудлаар тодорхой ойлголтгүй байснаас гадна бидний санал бодлыг үл хүлээн зөвшөөрөх эсвэл үгүйсгэсэн ямар нэгэн шинэлэг санал ч дэвшүүлэхгүй байв. Жендэрийн тухай ярилцлагыг эмэгтэйчүүдийн асуудал уруу удаа дараа чиглүүлэн өөрчилж, бидэнд сэдвээсээ буцах шахалт үзүүлж байв. Энэ талаар эрх бүхий дээгүүр албан тушаалтанд мэдэгдэж байсан боловч тэр болгон анхааралдаа авсангүй. Судалгааны бүлгийн гишүүдийн тоо хязгаарлагдмал байсан учир энэхүү байдлыг ерөнхийлөн дүгнэж чадахгүй байлаа. Гэвч хуримтлуулсан туршлагын үр дүнд бидэнд эргэлзээ төрж, газар дээрх бодит байдал буюу улс төрийн хүрээнийхний хоцрогдсон, сул ажиллагааны тухай тодорхой ойлголттой болсон. Нөгөөтэйгүүр,

анхаарал хандуулах гэсэн бидний эрмэлзэл бөгөөд нийгэм болон жендэрийн асуудлыг судалгааны хүрээнд багтаах оролдлогыг эрчимжүүлсэн болно.

Зах зээлийн түргэн үнэлгээ

Цагаан будааны үрийн худалдааны өнөөгийн тогтолцооны утга учрыг мэдэхийн тулд судалгааны олон янзын арга, хэрэгсэл ашигласан. Асуулгын хуудсыг боловсронгуй болгож зах зээлийн цуврал судалгааг удирдан зохион байгуулсан. Гол болон бусад фермерүүд оролцсон мэтгэлцээнийг удирдан явуулж дараа нь ажлын уулзалтын үеэр эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн мэдлэг, ажлын чадварыг баримтжуулсан болно. Зах зээлийн нарийвчилсан тоймыг янз бүрийн угсаатны бүлэг, нийгэм эдийн засгийн давхарга бөгөөд жендэрийг төлөөлсөн нийт 98 хүнийг оролцуулан хийсэн. Долоо хоног бүр нутгийн зах дээр (хаат базаар) ажиллаж үрийн хэлэлцээний хандлагыг шууд шинжлэн үзэх болоцоотой байв. Дурьдсан аргууд тустай бөгөөд тэдгээрийг хэрэглэсний үр дүнд фермер болон худалдаачин, тэдний сонирхол, эрмэлзэл, шийдвэрлэвэл зохих асуудал мөн ямар нэгэн албадлагатай холбоотой өдөр тутмын бодит байдлын учир утгыг тодорхойлж чадсан.

Үрийн сонгон үржүүлэх ажлын тухай өргөн олны дунд явуулсан сургалт

Сургалтын удирдамж болон цагаан будааны үрийн сонгон үржүүлэх ажлын тухай зурагт хуудсыг урьдчлан бэлдсэн байв. Сургалтыг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан. Эхний шатанд тариалалтын өмнөх ажлын тухай анхан шатны мэдлэгтэй болгох, улмаар үрийн сонгон үржүүлэх ажлын тухай сургалтыг хураагаагүй ургацтай талбайд явуулсан. Хоёр дахь шатанд чанарын хяналт, савлалт болон шошго, хаягаар хангах ажилд сургасан билээ. Цагаан будааны судалгаа, шинжилгээний үндэсний станци болон Орон нутгийн үрийн

лабораторийн ажилтнууд уригдаж хичээл заасныг тосгодын оршин суугчид өндрөөр үнэлсэн юм.

Оролцогчдын семинар

Газар тариалангийн янз бүрийн ажил эрхлэгчдэд зориулж тосгонд, тосгоны гадна семинар зохион байгуулсан. Семинарт үр үйлдвэрлэгчид, малын эмч нар, цагаан будааны үр борлуулагчид, буудай борлуулагчид оролцсон. Семинарын үеэр явагдаж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээсэн бөгөөд нутгийн цагаан будааны үрийн эрэлт хэрэгцээг үнэлж тодорхойлсон байна.

Төслийг газар дээр хэрэгжүүлэх явцад, ялангуяа Качорвад зарим нэг түгшүүртэй байдалтай тулгарч байсан. Дээр дурьдсанчлан Качорва бол тераи нутгийн жирийн тосгон. Тосгоны оршин суугчид Бхожпури аялгуугаар ярьдаг бөгөөд Хинди хэлээр ямар нэг хэмжээгээр ойлгодог. Иймд хэлний мэдлэг бол бидэнд тулгарч байсан бэрхшээлийн нэг нь байсан боловч харилцан ажиллах боломжтой байв. Соёлын бэрхшээл нь илүү их төвөгтэй асуудал болж байсан. Эмэгтэйчүүдээс ярилцлага авах маш хүндрэлтэй, учир нь тэдний хувьд “гадныхантай” харьцахыг хориглосон байдаг. Гэвч харилцан ойлголцох бөгөөд эмэгтэйчүүдийг тайван байлгаж ярилцлага авах үүднээс дахин уулзалт хийж байв. Үүний зэрэгцээ “гаднаас” эрэгтэйчүүд эмэгтэйчүүдэд ширүүн үг хэлж байсан. Энэ нөхцөлд жендэрийн талаарх асуудлыг дахин тайлбарлаж, улмаар асуултыг ойлгосон нөхцөлд ярилцлагаа үргэлжлүүлж байлаа.

НИЙГЭМ БА ЖЕНДЭРИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ БОЛОН ГАЗАР ТАРИАЛАНГИЙН СУДАЛГАА, ӨРГӨЖИЛТ, БОДЛОГО

Газар тариалангийн судалгааны үндсэн чиглэлд нийгэм болон жендэрийн асуудлыг тусгах

Балбын Хөдөө аж ахуйн судалгааны зөвлөл нь бие даасан эрх бүхий байгууллага бөгөөд газар тариалангийн судалгааны ажилд тэргүүлдэг

байна. Тус төвийн үндсэн зорилго нь улсын эдийн засгийн өсөлт буюу тогтвортой хөгжлийг хангах, мөн түүнчлэн ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах технологийг хөгжүүлэхэд оршдог. Энэхүү зорилгыг гагцхүү фермерүүдийн нийгэм эдийн засгийн хэрэгцээнд нийцсэн, нийгмийн янз бүрийн давхаргуудын сонирхолд тохирсон, тэдгээрийн амьдрал ахуйд бодит ашиг шимээ өгч чадахуйц технологийг хөгжүүлэх замаар биелүүлж чадна. Балбын газар тариалангийн газар үндсэн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс нийгэм эдийн засгийн судалгааг 1977 онд эхлүүлсэн билээ. Үүний зэрэгцээ, өнөөгийн байдлаар Хумалтаар тосгонд байдаг явуулын албаны ажилтнууд мөн зарим нэг орон нутгийн болон газар тариалангийн онцгой бүс дэх судалгааны нэгжүүд нийгэм болон жендэрийн асуудлаарх судалгааны ажлыг улсын хэмжээнд удирдан явуулж байна.

Балбын Вант Улсад нийгмийн судалгааны ажил хараахан эрчимтэй явагдаж чадахгүй байна. Ямарваа технологийг хөгжүүлэх болон нэвтрүүлэхийн өмнө нийгмийн нарийвчилсан судалгааг зайлшгүй явуулах шаардлагатай. Ийм бодит шаардлага байгааг Засгийн газрын ажилтнуудтай хийсэн уулзалтан дээр тодорхой жишээнүүд хэлэлцэж гаргасан дүгнэлт харуулсан билээ. Тухайлбал, Балбын газар тариалангийн судалгааны төвөөс зохион бүтээж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн цагаан будаа суулгадаг машин, мөн түүнчлэн тариалангийн өнжөөсөн газрын тогтолцоо нь зерэг болон сөрөг үр дагавар авчирсан билээ. Эдгээр технологийг нэвтрүүлсний үр дүнд нэг талаас фермерүүдийн нийт ажлын ачаалал багассан хэдий ч нөгөө талаас тодорхой мэргэжилгүй ажилчид, өөрөөр хэлбэл, хар ажилчдын хөдөлмөр эрхлэх боломжийг боогдуулсан.

Өөр нэг жишээг дурьдахад, хөдөө аж ахуйн гол нэр төрлийн ургамлыг эрлийзжүүлж хэрэглээнд өргөн нэвтрүүлж байна. Эрлийз сортын үр, ургамлыг байгаль орчин болон үйлдвэрлэлийн зардлын хамгийн тохиромжтой нөхцлийг шаарддаг технологийн дагуу үржүүлдэг учраас өртөг болон үнэ өндөр байдаг. Хөдөө аж ахуйн эрлийзжүүлсэн ургамлын ургацын гарц сайн боловч нийгмийн янз бүрийн давхаргын фермерүүдийн эдлэн тус бүрт тохирохгүй

байж болно. Бид энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс Балбын газар тариалангийн судалгааны зөвлөл болон Биологийн төрөл зүйлийг судлах, хөгжүүлэх талаарх орон нутгийнханы санаачилгыг дэмжих байгууллага төслийн багтай хамтарсан судалгааг эхлүүлсэн болно. Энэ ажлын хүрээнд зөвхөн байгалийн (борооны) усалгаатай хөрсөнд тохиромжтой улаан буудайн нэр төрлийг олж тодорхойлох судалгаа, шинжилгээ хийгдэнэ. Буудайн энэ сортыг ургуулахад бага хэмжээний ус шаардлагатай бөгөөд усжуулалтын тоноглол авах бололцоогүй фермерүүдэд тохиромжтой байдаг. Үндэсний судалгаа, шинжилгээний байгууллагуудаас дэвшүүлсэн нийгмийн ач холбогдол бүхий өөр нэгэн санаачилга бол нийт фермийн аж ахуйн хэмжээнд ургуулахад тохиромж муутай ургамлын цорын ганц загварыг дэвшүүлэхийн оронд олон янзын фермийн аж ахуйд зориулж хөдөө аж ахуйн хурдан ургадаг ургамлын туршилтын талбайнуудыг байгуулах ажил билээ. Судалгаа, шинжилгээний багц арга хэмжээг фермийн аж ахуйн түвшинд зохион байгуулж фермерүүдийг шууд татан оролцуулсан нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой ажил болсон. Бидний ажлын энэ хандлага ярихад хялбар боловч хэрэг дээрээ улам боловсронгуй болгох үүднээс олон зүйлд суралцаж, цаашид судлах шаардлагатай байна.

Балбын газар тариалангийн судалгааны зөвлөлийн 20 жилийн стратеги төлөвлөгөөнд судалгааны төвүүд цаашдын үйл ажиллагаандаа жендэрийн асуудалд анхаарал хандуулах тухай заасан байдаг. Үүнээс гадна энэхүү төлөвлөгөөнд хүмүүсийн хэрэгцээ, шинэ технологи эзэмших үзүүлэлтийг сайжруулахад онцгой анхаарахыг дурьдсан байна. Өнгөрсөн хугацаанд жендэрийн судалгаатай холбоотой зарим асуудлыг судалж, шийдвэрлэхэд чиглэгдсэн ажлыг явуулын албанаас зохион байгуулж хэрэгжүүлсэн. Харин тэд судалгааг өргөн хүрээнд биш, зөвхөн нийгмийн дунд давхаргын түвшинд хязгаарлаж хийсэн байна. Явуулын албаны ажилтнууд тухайн сууринд хамтарч ажиллаж буй иргэдийн хэрэгцээг судалж тодорхойлон фермийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан. Явуулын багийн зарим ажилд нутгийн хэд хэдэн эмэгтэй оролцсон билээ. Нутгийн эмэгтэйчүүдийн

тавьсан шаардлагад нийцүүлж зарим энгийн технологийг боловсронгуй болгосон. Жишээ нь, жимсний ургацын талбайг хогт болон бусад ургамлаас цэвэрлэх, жимсний ургацыг боловсруулах технологиудыг боловсронгуй болгосон байна. Үүнээс гадна Балбын газар тариалангийн судалгааны зөвлөлөөс зохион байгуулсан ажлын туршлага солилцох болон фермийн аж ахуйд шинэ техник турших арга хэмжээнд тариачин эмэгтэйчүүдийг татан оролцуулсан.

Тус зөвлөл судалгаа, шинжилгээтэй холбоотой санал асуулгын арга хэмжээг боловсронгуй болгох үүднээс жендэрийн оролцоо болоод эмэгтэйчүүдийн асуудлыг анхаарч ажилдаа тусгасаар ирсэн. Үүний зэрэгцээ хөдөө аж ахуйд шинээр нэвтрүүлсэн технологийн үр дүнд улсаас тэтгэлэг авдаг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн амьжиргаа хэрхэн өөрчлөгдсөн талаар судалгаа хийсэн байна. Жишээлбэл, нутгийн хүмүүст сүү худалдаалах боломжийг бий болгосон. Эрэгтэйчүүд сүүг эмэгтэйчүүдээс давуулан борлуулж байсан хэдий ч тэд сүүний борлуулалтаас олсон бэлэн мөнгөний орлогоо гол төлөв өөрийн хувийн хэрэгцээнд зарцуулсан байв. Судалгааны ажлын энэ хэсэг нь тусдаа хөтөлбөрийн дагуу хэрэгждэг ч Балбын хөдөө аж ахуйн судалгааны зөвлөлийн эрдэмтэд өөрсдийн ажлын нэг чухал сэдэв гэж үздэг.

Балбын газар тариалангийн судалгааны зөвлөл болон Биотөрөлжилтийг судлах, хөгжүүлэх талаарх орон нутгийн санаачилгыг дэмжих байгууллага нэгэн шинэ ажил санаачилж хамтран ажиллаж байна. Энэ арга хэмжээний зорилт нь фермийн ажилчдыг хөдөө аж ахуйн шинэ ургамал санаачлан үржүүлэх ажлыг дэмжиж туслахад оршино. Ялангуяа, ургамал ургуулах технологийг боловсронгуй болгох ажилд эмэгтэйчүүдээс дэвшүүлсэн санаачилгыг дэмжихэд онцгой анхаарал хандуулж байв. Тухайлбал, эрдэнэ шишийн шинэ сортыг танилцуулья. Гүлми тосгонд нэгэн эмэгтэй фермер Биотөрөлжилтийг судлах, хөгжүүлэх талаарх орон нутгийн санаачилгыг дэмжих байгууллагын тусламжтайгаар Ресунга хэмээх баг цэцэгтийн ангид харьяалагдах эрдэнэ шишийн шинэ төрлийг үржүүлсэн байна. Энэ шинэ сортын онцлог нь салхинд тэвчээртэй учраас ургац салхинд налах бэрхшээлтэй тулгарахгүй болсон. Маш

амжилттай үржүүлсэн энэ сорт өнөөгийн байдлаар улсын хэмжээнд газар тариалангийн салбарт хүлээн зөвшөөрөгдөх шатандаа байгааг, мөн газар тариаланг хөгжүүлэхэд фермерүүдийн оролцоо чухал ач холбогдолтой болохыг харуулсан тод жишээ билээ. Балбын хөдөө аж ахуйн судалгааны зөвлөлийн эрдэмтэд, Биотөрөлжилтийг судлах, хөгжүүлэх талаарх орон нутгийн санаачилгыг дэмжих байгууллага хамтран аливаа загварчилсан үйл ажиллагааг ямар аргаар амьдралд ойртуулан өөрчилж чаддаг болохыг харуулна гэдэгт найдаж байна. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй хамтран фермийн аж ахуйд ажиллах нь судалгааны багийн ажлын нэг арга билээ.

Нийгэм болон жендэрийн судалгааны газар тариаланг хөгжүүлэх ажилд эзлэх байр суурь

Балбын газар тариаланг хөгжүүлэх янз бүрийн тогтолцооны хүрээнд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх үүднээс зарим ажлыг зохион байгуулсан. Харин нийгмийн бусад хүчин зүйл болон хэтийн төлвийн асуудал орхигдсон хэвээр байгажээ. Газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх олон хөтөлбөрийг гол төлөв нийгэм эдийн засгийн, өөрөөр хэлбэл, баян, дунд болон ядуу давхаргыг түшиглэн хэрэгжүүлдэг. Нэгдлийн гишүүн бөгөөд нийгмийн давхарга бүрийн фермерүүдэд зориулж олон янзын хөтөлбөр боловсруулж амьдралд хэрэгжүүлдэг боловч хэрэг дээрээ шийдвэрлэх шаардлагатай эгзэгтэй асуудал байсаар байна. Фермерүүдийн бодит хэрэгцээнд нарийвчилсан судалгаа, үнэлгээ хийгдээгүй. Мөн түүнчлэн, хамгийн ядуу фермерүүд газар тариалангийн өргөжилтийн тогтолцооноос гадна орхигдож холбогдох арга хэмжээнд оролцдоггүй байна.

Балбад “жендэрийн” нэртэй олон арга хэмжээ эмэгтэйчүүдийн асуудалд төвлөрч хэрэгждэг. Нийгмийн янз бүрийн давхаргын жендэрийн хэтийн төлөвтэй холбоотой асуудлуудыг цэгцэлж нэг тогтолцоо бий болгохын оронд эмэгтэйчүүдийн дунд тусад нь олон арга хэмжээ хэрэгжүүлдэг байв. Газар тариаланг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцох эмэгтэй фермерүүдийн тоог тодорхой

хувь зааж газар тариалангийн өргөжилтийн ажлын таван жилийн төлөвлөгөөнд зайлшгүй биелүүлэх заалт болгон тусгадаг байна. Наймдугаар таван жилийн төлөвлөгөөнд (1992-1997 он) 25 хувь байсан бол есдүгээр таван жилийн төлөвлөгөөнд (1997-2002 он) 35 хувь хүртэл өссөн. Өнөөгийн байдлаар аравдугаар таван жилийн төлөвлөгөөнд (2002-2007 он) газар тариаланг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцох эмэгтэй фермерүүдийн тоог 40 хувь хүргэхээр тусгасан байна.

Эмэгтэйчүүдэд зориулж боловсруулсан олон тусгай хөтөлбөр байдаг. Эмэгтэй фермерүүдэд тохирох технологийг боловсронгуй болгох ажилд аль болох олон эмэгтэйг татан оролцуулахыг улс төрийнхний хүрээнд дэмждэг. Үүнд: хүнсний ногоо болон хүнсний консервлосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хортон шавьжтай тэмцэх нэгдсэн удирдлагад оролцох зэрэг ажлыг нэрлэж болно. Мужийн алба эмэгтэй фермерүүдийг түшиглэн өндөр орлого бүхий дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн. Үүнд: хүнсний ногооны үйлдвэрлэл, зөгийн аж ахуй болон газар тариалангийн бүтээгдэхүүний боловсруулалт мөн худалдаа зэрэг болно. Мужийн газар тариалангийн хөгжлийн албад зөвхөн эмэгтэй фермерүүдэд зориулж тусад нь сургалт удирдаж, зохион байгуулдаг бөгөөд бусад тогтмол арга хэмжээнд эмэгтэйчүүдийг татан оролцуулдаг. Мужийн хөдөө аж ахуйн хөгжлийн алба фермерүүдэд зориулж хээрийн сургалтыг санаачилж, оролцох тариаланчдыг тусгай шалгуураар сонгож, улмаар ургац хураалтын дараах ажил, усжуулалт болон хортон шавьжтай тэмцэх нэгдсэн удирдлагатай холбоотой арга хэмжээнд оролцуулдаг. Хортон шавьжтай тэмцэх нэгдсэн удирдлагын хичээлийг хөтлөх эмэгтэй зааварлагчдыг мөн адил шалгуураар сонгодог байна. Бхактапур тосгонд эмэгтэйчүүд төмс ургах явцыг удирдах туршилтыг гардан гүйцэтгэж байна.

Мужийн алба эмэгтэй фермерүүдийг ажлын биелэлт мөн газар тариаланд оруулсан хувь нэмрийг нь үндэслэн шагнаж урамшуулах арга хэмжээг зохион байгуулдаг. Хөдөө аж ахуй, нэгдлийн яам газар тариалангийн салбарт амжилт гаргасан эмэгтэйчүүдийг урамшуулдаг. Тухайлбал, Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан

Эмэгтэйчүүд хөгжлийн төлөө хэлтэс улсын таван бүс нутагт газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан эмэгтэй фермерүүдэд шагнал гардуулсан байна. Мөн Калимати тосгоны ногооны зах дээр лангуу нээн өгч худалдааны ажил эрхлэхэд тусалсан байна.

Зарим эмэгтэй фермерүүд бусад фермийн аж ахуйг бордоогоор хангаж байна. Эмэгтэйчүүдийн хөгжлийн төлөө хэлтэс эмэгтэйчүүдийг шийдвэрлэвэл зохих асуудлыг бүртгэх, тэдгээрийг судлан үзэх мөн тус хэлтсээс дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын жилийн хөтөлбөрийг төлөвлөх зэрэг ажилд оролцуулдаг. Гэхдээ энэ арга хэмжээ хараахан өргөн дэлгэрээгүй байгаа юм.

Үүний үр дүнд нийгэм, жендэрийн хэтийн төлвийг газар тариаланг судлах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх асуудалтай хамтатган шийдвэрлэх гарааг хийсэн гэж үздэг. Үүний зэрэгцээ, ажлын хэрэгжилтэнд саад учруулах зарим дарамт, шахалт хэвээр байна. Бодлого, түүний хэрэгжилт болон анхан шатны түвшинд байгаа хүчин зүйлүүд нийгэм болон жендэрийн чухал ач холбогдол бүхий асуудлыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Үзэл бодлын өөрчлөлт уг асуудлыг амьдралд хэрэгжүүлж бэхжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Салбарын төлөвлөлт, хөгжил, өргөжилтийн үйл ажиллагааг нийгэм болон жендэрийн асуудлын ач холбогдлыг үл харгалзан хэрэгжүүлсэний улмаас бодлогын чанартай олон арга хэмжээ үр ашиггүй хэрэгжихэд хүрсэн байна. Анхан шатны түвшинд байгаа хүчин зүйлүүд, тухайлбал нийгмийн харилцааны өнөөгийн хэв маяг, соёл нь эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийг судалгаа, хөгжлийн арга хэмжээнд таган оролцуулахад нөлөөлж байна. Жишээ нь, тал нутагт хуучныг баримталсан соёлын хэв маягтай, эмэгтэйчүүд нь гэрийн ажилд “хадаастай” байдаг бөгөөд гэрийнхээ орчноос холдох эрхгүй амьдардаг. Энэ байдал технологи дэлгэрүүлэх буюу гарах нөлөөг судлах ажилд саад учруулдаг.

Судалгааны ажилд оролцож буй бүх шатны ажилтнууд туйлын хэлбэр төдий ажилладаг бөгөөд олон ажилтан шинэ технологи хөгжүүлэх үйл ажиллагаанд нийгэм болон жендэрийн асуудлыг үл ойшоож орхигдуулдаг. Тэдний нийгэм болон жендэрийн гол санаа,

хэрэглэж буй арга, хэрэгслийн тухай ойлголт учир дутагдалтай тул энэ асуудлыг газар тариаланг судлах, хөгжүүлэхэд баримтлах үндсэн чиглэл болгоход гол саад тотгор болж байна. Мөн нийгэм болон жендэрийн асуудлын тухай тодорхой мэдлэггүй бөгөөд хөтөлбөрийг хянаж тодорхойлох, боловсруулах, улмаар хэрэгжүүлэхэд нийгэм болон жендэрийн судалгаа чухал ач холбогдолтой болохыг ойлгох чадваргүй байдлаас шалтгаалж үндсэн чиглэлийг бүтээмжтэй хэрэгжүүлэхэд саад хийж байна. Нийгэм болон жендэрийн судалгааг хөгжлийн судалгааны үйл ажиллагаатай нягт нэгтгэж, хэрэгжүүлж болдгийг Качорва болон Бара тосгонд хийсэн судалгааны жишээн дээр танилцуулья.

КАЧОРВАГИЙН ҮРИЙН АЖ АХУЙН ТОГТОЛЦООНД ХИЙСЭН НИЙГЭМ БОЛОН ЖЕНДЭРИЙН СУДАЛГАА

Нутгийн уламжлалт болон шинэ төрлийн үр

Качорвагийн фермерүүд нутгийн цэвэр болон шинээр үржүүлж гаргасан сортын цагаан будааг тариалж өөрсдийн хэрэгцээг хангадаг билээ. Нутгийн цэвэр сортын олон төрлийн цагаан будаа нийгэм, соёлын үнэ цэнэтэй бөгөөд зохих орчинд амархан дасах чадвартайгаас гадна нутгийн хүмүүс амтыг нь дээдэлдэг билээ. Янз бүрийн давхаргын фермерүүд нутгийн цагаан будааг өөрсдийн тодорхой хэрэгцээнд тохируулж сонгон ургуулдаг байна. Зарим төрлийн цагаан будааг, жишээ нь Сатхийг (Гамади цагаан будаа) баян, дунд болон ядуу фермерүүд бүгд тариалангийн жижиг талбайдаа ургуулдаг. Энэ төрлийг Балбын баруун хэсэгт оршдог тал нутгийнхан өргөн тэмдэглэдэг Чадх наадамд зориулж мөн тариалдаг ажээ. Лажхи, Басмати болон Кария Камод хэмээх нутгийн цагаан будааны төрлүүдийг Хир гэж нэрлэдэг бүтээгдэхүүн хийхэд зориулж ургуулдаг. Лалка Басмати болон Кария Камод зэрэг анхилуун үнэртэй цагаан будааг сайн чанартай учир дээдэлж тариалдаг байна. Харьцангуй шинэ сортын эдгээр цагаан будааг баян эсвэл дунд давхаргын фермерүүд ургуулдаг бөгөөд зөвхөн зочдыг дайлах мөн онцгой баяр наадмаар хэрэглэж заншсан байна. Харин

нутгийн цэвэр сортын зарим цагаан будааг, тухайлбал Бхатхи болон Нахи Сароог орчин тойрондоо амархан дасдаг онцлогтой учраас тариалдаг.

Баян фермерийн тариалангийн талбай том бөгөөд тариалах цагаан будааны сортын сонголт хийх боломж харьцангуй их байдаг. Бүх давхаргын фермерүүд уламжлалт сортын будаанаас илүү шинэ төрлийн цагаан будааг сонирхдог. Шинэ төрлийн цагаан будаа зах зээлийн олон давуу талтай: Өндөр ашиг шимтэй, амт сайтай бөгөөд түргэн борлогддог байна. Зарим баян фермер шинэ будааны ургацын салхинд налдаггүй чанарыг нь өндрөөр үнэлдэг.

Баян болон дунд давхаргын фермерүүд өөрсдийн аж ахуйд ажилчин хөлсөлж, тэдний хөдөлмөрийн хөлсийг Жая болон Сабитри цагаан будаагаар төлдөг. Шинэ сортын цагаан будаа сонгоход дэрсний чанар, газар тариалан буюу байгаль орчны нөхцөлд дасах чадвар, хүнсний боловсруулалтын чанарын үзүүлэлт, тээрэмдэх болон хальслах үзүүлэлт, тухайлбал бутарсан буудайн эзлэх хувийн жин зэрэг хүчин зүйл нөлөөлдөг.

Эмэгтэй фермерүүдийн хувьд эдгээр үзүүлэлтүүд чухал ач холбогдолтой байдаг бөгөөд тэд нарын аж ахуйн үйл ажиллагаатай нягт холбоотой. Үүний зэрэгцээ, нутгийн цэвэр сортын цагаан будаа шашны баяр ёслолын үеэр тодорхой үүрэг гүйцэтгэдэг учраас нийгэм эдийн засгийн бүх давхаргын фермерүүд тариалдаг. Нутгийн зарим сортын будаа нь дайлага, баяр ёслолын үеэр өргөн хэрэглэгддэг учраас баян бөгөөд дунд давхаргын фермерүүд мөн адил өндөр үнэлдэг (Зураг 4.2, 4.3).


Нутгийн болон шинэ сортын цагаан будааны цэвэр үрийн асуудал чухал болохыг фермерүүд сайн ойлгож байсан. Сайн чанарын ургацын асуудал цэвэр сортын үрийг дээдэлж, улмаар цаашид хадгалж үлдээх үйл ажиллаганы үндсэн шалтгаан билээ. Үүний зэрэгцээ, нутгийн үр жигд боловсордог, хортон шавьжаар бага халдварладаг, найлзуур түргэн ургадаг болон хэрэглэгч дээдэлдэг зэрэг хүчин зүйлийг дурьдаж болно. Холимог үрийн асуудал нутгийн үрийн үйлдвэрлэлд тулгардаг гол бэрхшээл бөгөөд ургацанд муугаар нөлөөлж чанарыг бууруулдаг.

Зураг 4.2.




Зураг 4.3.

Мужийн сортын цагаан будааг ургуулах болсон шалтгаан



Шинэ сортын үрийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд үр тарих болгонд шинэ үр худалдаж авах эсвэл шинэ үрийн бүтэн жилийн хэрэгцээгээ худалдаж авах шаардлагатай болдог. Үрийг эвцэлдүүлэх эсвэл механик аргаар эрлийзжүүлэх үйл ажиллагаа ихэнх фермерийн үзэж байгаагаар хамгийн их дэлгэрсэн хэцүү асуудал билээ. Харин үрийг орлуулах хэмжээ болон үрийг орлуулах шалтгаан нь нийгмийн анги, үрийн сорт, төрлөөс хамааран өөрчлөгддөг байна. Лалка Басмати болоод бусад анхилуун цагаан будаан дахь өөр ургамлын хольц ноцтой асуудал билээ. Эдгээр төрлийн цагаан будааг жил тутам орлуулдаг. Судалгаа явуулсан нутагт цагаан будааг жилд нэг удаа буюу зургаан жил тутам нэг удаа орлуулж байжээ. Үрийг орлуулах явдал баян фермерүүдийн дунд олонтоо тохиолддог. Харин нийгмийн дунд (31.3 хувь нь) болон ядуу (32.4 хувь нь) давхаргын фермерүүдийн аж ахуйд үрийг орлуулах явдлыг гурав гурван жилээр хэрэгжүүлэх явдал нийтлэг болжээ (Зураг 4.4).

Зураг 4.4.
Үрийг сэлгэх/орлуулах үе фермерүүдийн бүлгээр



Үрийн эх үүсвэр

Качорвад баян фермерүүд тосгон дотор эсвэл тосгоноос гадуур үрийн нөөцөөс хүртэх бололцоотой байдаг. Үрийн нөөцөөс хүртэх боломжгүй дунд давхрагын болон ядуу фермерүүдтэй харьцуулахад баян фермерүүд шинэ үрийг олонтаа худалдаж авдаг.

Орон нутагт хийсэн бидний судалгаа дараах зүйлийг илрүүлсэн. Нутгийн болон шинэ төрлийн үрийн худалдаанд үрийн албан бус тогтолцоо бий болж, улмаар давамгайлах болсон байна. Хэдийгээр нутгийн үрийн худалдаанд дийлэнх фермерүүд албан бус тогтолцооноос хамааралтай байдаг бол шинэ төрлийн үрийн хувьд зарим тохиолдолд сонголт хийх эсвэл орлуулах боломжтой байдаг. Нийгэм эдийн засгийн гурван бүлгийн ихэнх фермерүүд нутгийн цэвэр сорт болон шинэ төрлийн үрийг дараа жил тариалах зорилготойгоор хадгалдаг байна. Мөн түүнчлэн, хамаатнууд болон хөршүүд өөр хоорондоо будааны үр солилцох эсвэл агрономчоос үр худалдаж авах зэрэг аргаар нутгийн сортын үртэй болдог. Баян болон дунд давхаргын фермерүүд цагаан будааны үрийг тосгонд эсвэл тосгоноос гадуур худалдаж авахаас гадна Энэтхэгийн зах зээлээс худалдан авч нөөцлөх явдал түгээмэл болсон байна. Дунд давхаргын болон ядуу фермерүүд өөрсдийн хадгалсан бөгөөд нутгийнхантай солилцох замаар бий болгосон будааны үрийн нөөцөөс хамааралтай байдаг. Тэдэнд агрономчийн худалддаг үр үнэтэй байдгаас гадна үр борлуулах зарим цэгүүдэд хэрэгцээтэй үед болон цагт үр байдаггүй билээ. Үүний зэрэгцээ, ядуувтар фермерүүд үрийн нөөцтэй болох үүднээс өөрийн фермийн ажилчдыг үрээр солилцох арга хэрэглэдэг байна (Хүснэгт 4.1).

Дийлэнх фермерүүдийн үзэж байгаагаар өөрийн хүчээр бэлдэж нөөцөлсөн үр чанарын хувьд хамаатан эсвэл хөрш зэргэлдээ аж ахуйгаас авсан үрийн чанартай харьцуулахад хольцгүй буюу цэвэр байх магадлал өндөр байдаг. Фермерүүдийн олонтоо дурьдаж байснаар, цэвэр үрийн бусад найдвартай эх үүсвэр агрономчдын үрийн нөөц болон улсын фермд байдаг хэдий ч тэд нар зөвхөн шинэ сортын үр наймаалдаг ажээ.


Хүснэгт 4.1.
Үрийн нөөцийн эх үүсвэр, нийгмийн давхаргаар

Эх үүсвэр	Нутгийн сортын үр			Шинэ сортын үр		
	Баян	Дунд	Ядуу	Баян	Дунд	Ядуу
Өөрийн ургацыг хадгалсан нөөц	15	19	5	63	65	44
Төрөл садныхны ургацын нөөц	3	1	1	7	8	4
Хөрш аж ахуйнууд	5	2	4	8	1	4
Ажилчнаар үр солих	-	-	-	4	2	4
Өөрийн болон төрөл садныхны ургацын нөөц	1	-	-	1	-	-
Өөрийн ба хөршийн ургацын нөөц	-	-	-	-	1	-
Агрономчдын нөөц	-	-	-	10	8	5
Үрийн судалгааны үндэсний хөтөлбөр	-	-	-	5	2	1
Энэтхэгийн зах зээл	-	-	-	10	7	3

Балбын газар тариалангийн судалгааны зөвлөлөөс хэрэгжүүлж буй цагаан будааны судалгааны үндэсний хөтөлбөрийн хүрээнд шинэ сортын цагаан будааны бас нэгэн эх үүсвэрийг бий болгосон бөгөөд Качорва тосгон тус зөвлөлийн судалгааны албатай ойрхон байрладаг. Судалгаа, шинжилгээний материалыг үрийн янз бүрийн нөөцөөс тосгон дотор эсвэл тосгоноос гадуур олж авахад үрийг их хэмжээгээр нөөцөлсөн фермерүүд чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, эдгээр фермерүүд цагаан будааны шинэ сортыг турших болон үрийн цаашдын эргэлтийг дэмжихэд маш чухал үүрэг гүйцэтгэдэг (Сүбеди нар 2001).

Үрийн зах зээлийн нөгөө нэг эх үүсвэр нь долоо хоног бүр нээгддэг Хаат хэмээх зах билээ. Фермерүүд бусдаас урьтаж үрээ зарах зорилгоор гол төлөв нутгийн цэвэр сортын үр бага хэмжээгээр авчирдаг. Энэ байдал цагаан будаанаас илүү хүнсний ногооны хувьд нийтлэг үзэгдэл болсон байна. Үүний зэрэгцээ, үрийг тариалахын өмнө болон үрэлгээний үеэр нээгддэг Бийз Бхандар хэмээх түр ажиллагаатай дэлгүүрүүдээс худалдаж авдаг. Энэ ажлыг гол төлөв Энэтхэгээс үр болон бордоо тээвэрлэх чадалтай баян фермерүүд хийдэг. Зураг 4.5-д гол мэдээллийг дүрслэн харуулав.

Зураг 4.5.
 Качорва тосгоны үрийн худалдааны тогтолцоо



Эх үүсвэр: Фокус бүлгийн ярилцлага, 2003 он

Үр солилцооны хэлбэр

Судалгаа явуулж байгаа нутгийн фермерүүд будааны үрийг хоёр хэлбэрээр солилцдог. Нэгдүгээрт, үрийг үрээр хоёрдугаарт, үрийг буудайгаар. Энэхүү хоёр хэлбэрээр шууд солилцох нөхцөлд 1:1-ийн харьцааг баримталдаг. Харин төлбөр хийх хугацаа хэтэрч, улмаар, ургац хураалт өнгөрсөн ч төлөгдөхгүй байвал 1,5:1-ийн харьцаатай солилцдог байна. Ядуу фермер энэ өндөр харьцааг гол төлөв хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдаг. Учир нь солих илүүдэл үрийн нөөц тэдэнд байдаггүй бөгөөд тухайн оны ургац хураалтыг хүлээх болдог. Өөрөөр хэлбэл, ядуу фермерүүд өөрсдийн үрэнд илүү мөнгө төлж байна гэсэн үг. Баян фермер хангалттай хэмжээний хадгалсан буудайтай байдаг тул илүү ашиг олох боломжтой байдаг (Зураг 4.6).


Зураг 4.6.
Үрийн арилжааны харьцаа, нийгмийн давхаргаар



Үрийн чанарыг сайжруулах арга

Фермерүүд үрийн цэвэр байдлыг хадгалж хамгаалах үүднээс янз бүрийн арга эзэмшсэн байна. Эдгээр аргуудыг нутгийн болон шинэ төрлийн үрэнд хоёуланд нь хэрэглэдэг. Үрийн шигшилт ургац хураалт болон хадгалалтын үед хийгддэг бөгөөд шигшилт хийх явцыг таван хэсэгт хувааж болно (Зураг 4.7).

Зураг 4.7.
Үрийг шигшин сайжруулах арга



Ер нь ядуу фермер цагаан будааны ургацаа хураасны дараа тарианы юужинг (боолтыг) бусад ургамлаас цэвэрлэдэг. Мөн ургацыг тариалангийн талбайд хольцноос цэвэрлэх эсвэл их хэмжээний буудайнд үрийн шигшилт хийх зэрэг арга хэрэглэх нь нийтлэг байдаг. Гэвч үрийг сонгон сайжруулах, үржүүлэх явц үрийн шаардлагатай хэмжээ болон янз бүрийн сортын үрийн боловсруулалтын өртгөөс хамааралтай байдаг. Шашны үйлд ашигладаг олон төрлийн цагаан будаанд нарийн бөгөөд нямбай шигшилт хийдэг. Хэрэв бага хэмжээний үр хэрэгцээтэй бол фермер тариалангийн талбайгаас сайн чанарын цагаан будааны шүхэр сонгон хураах бололцоотой байдаг. Харин их хэмжээний үр шаардлагатай нөхцөлд буудайн боолтыг хольцноос цэвэрлэх арга хэрэглэдэг. Үүний гол учир нь үрийн шигшилтийг энэ аргаар хийхэд бага хөдөлмөр болон цаг зарцуулдаг байна.

Үрийг шигшин сайжруулах үйл ажиллагаа фермерүүдийн нийгэм, эдийн засгийн байдлаас шалтгаалан өөрчлөгддөг. Ядуу фермер тарианы боолтыг хольцноос цэвэрлэж үлдсэн үрийг хадгалах хялбар аргыг сонгодог ажээ. Баян фермер ажилчин хөлсөлж цагаан будааны шүхэр түүлгэх боломжтой байдаг. Сонирхолтой нь, ядуу фермерүүдийн ярьж байснаар тэд өөрсдийн ургацанд шигшилт хийхэд, төдийлөн их цаг зарцуулдаггүй, учир нь илүү чанартай үрийг баян фермерээс худалдан авах боломжтой байдаг.

Үрийн үйлдвэрлэл болон худалдааны салбар дахь жендэрийн үүрэг

Шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг янз бүрийн нийгэм эдийн засгийн бүлгүүдээр судалж үзсэн байна. Судалгаанаас үзэхэд, баян фермерүүдийн дунд үрийн сортыг сонгон үржүүлэх ажлыг ихэнх тохиолдолд эрэгтэйчүүд гүйцэтгэдэг. Харин дунд болон ядуу давхаргын фермерүүдийн дунд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хамтран холбогдох шийдвэрийг гаргадаг. Баян фермийн аж ахуйд шүхэр шигшиж сайжруулахад мөн л эрэгтэйчүүд давамгайл үүрэг гүйцэтгэдэг, дунд давхаргын болон ядуу фермерүүд эмэгтэйчүүдийг оролцуулан шийдвэрлэдэг

байна. Өөрөөр хэлбэл, ажлын онцгой улирлын үед эрэгтэйчүүдийн хүч хүрэлцэхгүй тохиолдолд эмэгтэйчүүдтэй хамтран талбайд ажилладаг. Ургац хураасны дараа тээрэмдэх буюу хадгалах ажлыг нийгэм эдийн засгийн бүх давхаргын эмэгтэйчүүд гүйцэтгэдэг. Зарим улиралд дунд болон ядуу давхаргын эрэгтэйчүүд ажил хийх зорилгоор олуулаа тосгоноос явах үед үрийг шигшин чанаржуулах ажилд эмэгтэйчүүд олноороо оролцож энэ салбарын жендэрийн байдалд өөрчлөлт гардаг (Хүснэгт 4.2).

Хүснэгт 4.2.
Үрийн үйлдвэрлэл дэх эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн оролцоо


Үйл ажиллагаа	Баян			Дунд			Ядуу		
	Эрэг- тэй	Эмэг- тэй	Хоёул	Эрэг- тэй	Эмэг- тэй	Хоёул	Эрэг- тэй	Эмэг- тэй	Хоёул
Сорт шигшин сонгох	18	2	12	13	0	20	11	4	17
Боловсруулах үйл ажиллагаа	24	1	7	21	0	12	12	5	17
Ургац хураах	25	1	6	18	1	14	5	6	21
Шүхэр ялгах сонгох	21	0	6	19	1	11	6	4	22
Ургац хураасны дараа шигшин сайжруулах	26	0	4	17	0	16	10	4	18
Ургац хураалтын дараахь үйл ажиллагаа	12	14	4	5	11	16	2	25	5
Хадгалалт (зоорины ажил)	3	12	5	0	25	6	2	24	2

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр ашиглалт

Баян фермийн аж ахуйд дунд болон ядуу давхаргын фермерүүдтэй харьцуулахад хөлсний ажилчин ажиллуулах явдал түгээмэл болсон байна. Качорва тосгонд уламжлалт соёл болон хуучныг баримталсан хэв журмын дагуу эмэгтэйчүүдэд гэрээс гадуур ажил хийхийг хориглодог бөгөөд түүнийг зөвхөн нийгэм эдийн засгийн “дээд” давхаргынхан хатуу дагадаг байна. Баян фермер ажилчин

хөлслөх бололцоотой бөгөөд гол төлөв ядуу фермерүүдийг хөлсөлж ажиллуулдаг (Зураг 4.8). Хамгийн ядуу айл өрхүүдийг ажиглаж байхад эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд ургац хураах буюу шүхэр шигшиж түүвэрлэх ажилд их ч, бага ч адил хэмжээний хөдөлмөр (үгүйдээ, ажилласан хүний тоогоор) зарцуулсан байдаг. Харин эмэгтэйчүүд ургац хураалтын дараах ажлын хариуцлагыг бараг бүрэн үүрдэг байна (Хүснэгт 4.2).

Зураг 4.8.
Үрийн үйлдвэрлэл дэх ажиллах хүч ашиглалт




Худалдаа

Зөвхөн баян фермерүүд үрийн хэлэлцээг явуулдаг. Нийгмийн энэ бүлэгт тариалах үрийн хэмжээг тодорхойлох шийдвэрийг эрэгтэйчүүд болон ямар нэгэн хэмжээгээр эмэгтэйчүүд гаргадаг. Харин үрийг хаана, ямар үнээр борлуулах шийдвэр гаргахад эрэгтэйчүүдийн санал их нөлөөлдөг байна. Үрийн арилжааны үеэр эрэгтэйчүүд үрийн хэлэлцээг тосгонд болон тосгоноос гадуур явуулж байв. Эмэгтэйчүүд зөвхөн өөрийн аж ахуйгаас зарагдах үрийн арилжаанд оролцож байсан (Зураг 4.9).

Зураг 4.9.

Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах болон худалдаанд оролцож уй байдал



Мэдлэгтэй болох ба ур чадвар эзэмших тухай

Үрийн үйлдвэрлэлийн техникийн талаарх мэдлэг, ур чадвар эзэмшсэн байдлыг нийгмийн давхарга, угсаатны бүлэг болон хүйсээр судлахад маш сайн дүгнэлт гарсан болно. Мэдлэг болон ажлын чадварт үеэс үед дамжуулан гол төлөв үзүүлэн таниулах аргаар сургадаг байсан. Гэр бүлийн гишүүд бие биенээсээ суралцахаас гадна фермерүүд хөршүүд болон төрөл садны хүмүүсийг ажиглах замаар суралцдаг.

Фермерийн чадварыг нэмэгдүүлэх болон нутгийн цагаан сортын цагаан будааны зах зээлийн өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх нь

Бидний цуглуулсан тоо баримт, бусад холбогдох материалыг судлахад дээд зэргийн чанартай үр үйлдвэрлэхэд шигшин чанаржуулах ердийн арга хангалтгүй байдгийг харуулсан. Ялангуяа, нутгийн цэвэр сорт болох Лалка Басмати болон Кария Камод цагаан

будааны хувьд илүү ажиглагдсан. Анхилуун үнэртэй нутгийн сортын будааны хувьд үрийн хольц болон үрийг эвцэлдүүлэх үйл ажиллагааны явцад тулгардаг хүнд бэрхшээл бол хогт хольцны асуудал байдаг. Анхилуун үнэртэй будааны үрийн бүтэц мөн хэлбэр түүнийг эвцэлдүүлэх аргаар чанаржуулахад илүү тохиромжтой болохыг харуулсан. Цаашид сайн чанарын үрийн үйлдвэрлэлийг дэмжих үүднээс шигшин сайжруулах үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай байна.

Тосгоны нэгдлийн гишүүдийн үрийг шигшин чанаржуулах арга болон үрийн худалдаа эрхлэх чадварыг нь дээшлүүлэх явдал бидний удирдан зохион байгуулах гол ажил байсан. Дараа нь бид сургалтын лавлах материалыг боловсронгуй болгон түүгээр дамжуулан үрийг шигшин сайжруулах ажлын шинжлэх ухааны үндэслэлийг энгийн хэлээр зургийн хамт тайлбарлаж өгсөн.

Үрийг шигшин сайжруулах сургалтанд нийгмийн янз бүрийн давхарга болон угсаатны бүлгийн эмэгтэй болон эрэгтэй фермерүүд хамрагдсан билээ. Сургалтыг хоёр шаттайгаар хэрэгжүүлсэн. Нэгдүгээрт, тоймлон танилцуулах хичээл, хоёрдугаарт үрийн шигшин чанаржуулах явцыг тариалангийн талбайд тайлбарлах ажил байв. Нэгдүгээр шатны сургалтыг цагаан будааны улирлыг угтаж зохион байгуулсан бөгөөд сургалтын явцад үрийг шигшин сайжруулах ажлын ач холбогдол, улмаар түүнтэй холбоотой үндсэн шаардлагатай танилцуулсан. Фермерүүд үрийн үйлдвэрлэлийн олон янзын шат дараалалтай танилцаж энэ талаар мэдлэгтэй болсон.

Эхний шатны сургалтын төгсгөлд сурсан зүйлээ өөрийн аж ахуйд шууд нэвтрүүлэх сонирхолтой фермерүүдийг тодорхойлсон билээ. Бид фермерүүдийг цагаан будааны нутгийн онцгой гурван сортыг маш ихээр сонирхож байгааг үндэслэн фермерүүдийн хэрэгцээг тодорхойлж үнэлгээ хийж өгсөн. Судалгаанд хамрагдсан бүс нутгийн тариачидын нэгдлийг түшиглэн эмэгтэй болон эрэгтэй фермерүүдийг нэгтгэсэн байгууллага болох Газар тариаланг хөгжүүлэх болон хамгаалах нийгэмлэг нь Биотөрөлжилтийг судлах, хөгжүүлэх талаарх орон нутгийн санаачилгыг дэмжих байгууллагын ажиллагсдын техникийн дэмжлэгтэйгээр энэ гурван төрлийн

будааны эх үүсвэр болох үрийг цуглуулж төвлөрүүлэх, түүний чанарт шинжилгээ хийх, үр нийлүүлэх ажлыг хэрэгжүүлсэн болно.

Дараа нь үрийг шигшиж сайжруулах тухай сургалтыг нам дор газрын цагаан будааны ургац хураалтыг урьтаж фермерүүдийн 3 бүлэгт зохион байгуулсан. Хоёрдахь шатны сургалт нь үрийг шигшиж чанаржуулах ажлыг тариалангийн талбайд тайлбарлах, ургац хураалтын дараах үйл ажиллагаа болон үрийн чанарт хяналт тавих аргуудад сургах зэрэг хэсгүүдээс бүрдсэн байсан. Фермерүүд үрийг шигшин сайжруулах арга сэдвээр тариалангийн талбайд дадлага хийсэн бөгөөд үр соёлолт буюу үрийн цэвэр байдлыг шинжлэн шалгах энгийн аргыг сурсан билээ.

Сургалтыг эмэгтэй фермерүүдийн бүлэг дараах байдлаар дүгнэсэн байна. Үүнд:

Үрийг шигшин сайжруулах тухай нийгэм болон жендэрийн судалгааны хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтын явцад бид сайн чанарын үрийг зөвхөн зах зээлд зориулахаас гадна өөрсдийн хэрэгцээг хангах үүднээс шигшин чанаржуулах мөн үйлдвэрлэх боломжтой болсон. Одоо бид бусдаас хараат байх хэрэггүй бөгөөд чанартай үр хайж тосгоноор явах шаардлагагүй болсон.

Газар тариалангийн хөгжил болон хамгаалалтын нийгэмлэгийн гишүүд дараах дүгнэлт хийсэн. Үүнд:


Бид олон жилийн турш үрийг дараа улирлын хэрэгцээнд зориулж шигшилт хийж хадгалдаг байсан. Харин бүр эхнээс нь зөв аргаар үрийг шигшин сайжруулах нөхцөлд үрийн чанарт үлэмж өөрчлөлт гаргана. Бид нийгэм болон жендэрийн судалгааны хүрээнд сайн чанартай үрийн нөөцөөр хангагдсан бөгөөд энэ нь бидэнд үрийг шигшин чанаржуулах явцад нухацтай, буурь суурьтай хандахад түлхэц өгсөн. Зах зээлтэй холбогдсоны ачаар фермерүүд нутгийн цэвэр сортын цагаан будаа тариалах урамтай болсон.

Зах зээлтэй холбогдох нь

Бид нутгийн сортын цагаан будааны зах зээлийг бэхжүүлэх ажилд хүчин чармайлт гаргасны үр дүнд худалдааны шинэ сүлжээний хөгжилд тодорхой нэмэр оруулсан билээ. Шинэ сүлжээ нь үрийн албан болон албан бус сүлжээг боловсронгуй бүтэц, уян хатан

зохион байгуулалтанд нэгтгэсэн бөгөөд цаашид эдгээр ойлголтууд байхгүй болно (Зураг 4.5 ба Зураг 4.10-г харьцуулан харна уу.).

Зураг 4.10. Үрийн худалдааны шинэ тогтолцоо



- ASC-Газар тариалангийн үйлчилгээний төв
- AQDCS-Газар тариалангийн хөгжил хамгаалалтын нийгэмлэг
- DADO-Дүүргийн газар тариалангийн хөгжлийн алба
- DOA-Газар тариалангийн хэлтэс
- NARC-Балбын хөдөө аж ахуйн судалгааны зөвлөл
- NRRP-Цагаан будааны судалгааны үндэсний хөтөлбөр

Сайн чанарын үрийн үйлдвэрлэл болон борлуулалтын зах зээл, худалдааны цэгүүд хооронд холбоо тогтоох зорилготойгоор агрономчид, Дүүргийн газар тариалангийн хөгжлийн алба, газар тариалангийн хангамж үйлчилгээний төвүүд болон цагаан будааны худалдааны орон нутгийн төвүүд, дэлгүүрүүдийн төлөөлөгчидтэй хамтран тосгоны хэмжээнд мөн ойролцоох газруудад уулзалт-семинар зохион байгуулсан билээ. Энэ үед үрийн тогтолцооны хувьцаа эзэмшигчдийг урьж оролцуулсан. Мөн зах зээлийн эрэлт

хэрэгцээний талаар цагаан будааны худалдааны орон нутгийн төвүүд, дэлгүүрүүд болон агрономчидын боловсруулсан саналыг хэлэлцэж баримтжуулсан болно.

Орон нутгийн үрийн нөөцийн удирдлагыг хариуцдаг Газар тариалангийн хөгжил, хамгаалалтын нийгэмлэг худалдааны шинэ сүлжээний үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг. Энэ байгууллага үрийн нийлүүлэлт, төвлөрүүлэлт болон чанарын хяналтыг зохион байгуулж хэрэгжүүлдэг юм. Чанарын хяналтын ажлыг Газар тариалангийн газрын харьяа Чанарын хяналтын албатай хамтран зохицуулж гүйцэтгэнэ. Худалдааны үйл ажиллагаа албан болон албан бус янз бүрийн сувгаар хэрэгждэг. Шинэ тогтолцоо, нэг талаас, газар тариалангийн хангамж үйлчилгээний төвүүд, агрономчид болон цагаан будааны судалгааны үндэсний хөтөлбөрийг өөртөө багтаасан үрийн албан сүлжээг, нөгөө талаас, үрийн нөөц ихтэй фермерүүд, үрийн үйлдвэрлэгчид болон долоо хоног бүрийн захуудыг хамарсан албан бус сүлжээг хооронд нь нэгтгэдэг.

Төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүднээс Газар тариалангийн хөгжил, хамгаалалтын нийгэмлэгт олгосон мөнгөн хөрөнгө үрийн үйлдвэрлэлийн хөтөлбөрийн тогтвортой хэрэгжилтийг баталгаажуулах зорилготойгоор сурталчилгаа явуулах бөгөөд долоо хоног бүр нээгддэг захууд дээр лангуу, бусад төхөөрөмж суурилуулах боломж олгосон. Качорва тосгоны фермерүүд эдгээр дэмжлэг болон үрийн амжилттай хэлэлцээг үндэслэн зах зээлийн өндөр үзүүдэлттэй 3 сортын үрийг үйлдвэрлэж эхэлсэн. Фермийн аж ахуйгаа сайжруулах боломж олгосонд фермерүүд урам зоригтой ажиллаж байгаа юм.

Дүгнэлт

Нийгэм болон жендэрийн асуудлыг газар тариаланг судлах, бодлого хэрэгжүүлэх болон газар тариалангийн үйл ажиллагааг өргөтгөж, дэлгэрүүлэх явцад харгалзан үзэхийн зэрэгцээ хамтатган шийдвэрлэх, ялангуяа, хүн амын дийлэнх хэсгийн амьжиргаа газар тариалангаас хамаардаг Балба улсын хувьд онцгой чухал билээ.

Бодлогын хэмжээнд болон хөгжлийн олон янзын төлөвлөгөөнд нийгэм болон жендэрийн асуудлыг дурьддаг эсвэл ямар нэгэн хэмжээгээр хэлэлцдэг хэдий ч амьдралд хэрэгжүүлэх үйл ажиллагаа учир дутагдалтай хэвээр байна. Бодлого боловсруулах болон түүнийг хэрэгжүүлэх хооронд бий болсон зөрүүг олон нийтийг нийгэм болон жендэрийн асуудлын амин чухал ач холбогдлыг ойлгож ухамсартай ханддаг болгох аргаар багасгаж чадна. Хэрэгжүүлж буй ажлын гол санааг бүх шатанд тодорхой болгох нь чухал байдаг. Хэрэгжүүлэх бодлого, олон төсөл болон хөтөлбөр эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд, баян эсвэл ядуу мөн янз бүрийн угсаатны бүлгүүдэд ямар нөлөө үзүүлж байгаад хяналт тавих, түүнд үнэлгээ өгөх ажлыг газар тариаланг судлах, хөгжүүлэх, үйл ажиллагааны турш хүчтэй болгон бэхжүүлэх шаардлагатай.

Бидний хийсэн судалгааны ажлын зорилго нь газар тариаланг хөгжүүлэх арга замыг дэмжих, өөрөөр хэлбэл, нийгэм болон жендэрийн судалгааг тодорхой нөхцөл байдал болон фермерүүдийн хувьд хамгийн чухал болох үрийн асуудалтай хамт шийдвэрлэхэд оршино. Судалгаагаар соёл болон нийгмийн бүтцээ дагаад хүмүүсийн үүрэг, хариуцлага тус бүр хатуу зааглагдсан байдаг нь ажиглагдсан билээ. Качорва тосгоны үрийн үйлдвэрлэлийн тогтолцоог судлахад нийгмийн бүх давхаргын болон угсаатны бүлгүүдийн гол төлөв эрэгтэйчүүд нь үрийг шигшин сайжруулах ажлыг гүйцэтгэдэг. Харин ядуучуудын бүлгийн цөөн тооны эмэгтэй энэ ажилд оролцдог байна. Магадгүй өмнөд Азид эмэгтэйчүүд үрийг шигшин чанаржуулах ажлыг хийдэг тухай ташаа ойлголт байж болох юм.

Өнөөгийн байдлаар үрийн саадгүй эргэлтийн хувьд албан болон албан бус сүлжээ зэрэг үйлчилж байх чухал байна. Албан ёсны сүлжээ хэрэглээнд хэдийнээ нэвтэрсэн үрийн эргэлтийг хангаж байна. Харин тосгонд үйл ажиллагаа явуулж буй албан бус сүлжээ нутгийн цэвэр болон шинэ сортын үрийн эргэлтэнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ганцаарчилсан үйл ажиллагаа эрхэлдэг фермерүүд тус сүлжээгээр дамжуулан генетикийн болон газар тариалангийн үйлдвэрлэлийн бусад материалын эргэлтийг хангадаг ба тэд нар

илүү хурдан баяжих магадлалтай байдаг.

Нутгийнхан фермийн аж ахуйн олон үйл ажиллагаа эрхэлдэг буюу ажлын аргыг боловсронгуй болгож ирсэн. Тэд үрийг чанаржуулах, үржүүлэх ажлыг олон зууны турш гүйцэтгэсэн бөгөөд асар их мэдлэг, туршлага хуримтлуусан билээ. Бид ажлын зарим аргыг боловсронгуй болгох үүднээс бүтээгдэхүүнд чанарын хяналт хийхэд тариачдын чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх болно. Тариалангийн талбайд чанарын хяналт хийх ажилтай холбогдуулан нэгдлийг түшиглэсэн байгууллагыг дэмжиж, цаашид энэ ажил үрийн үйлдвэрлэлийг тогтворжуулахад баталгаа болох билээ.

Нутгийн олон төрлийн биологийн нөөцийг хамгаалах үйлсэд нутгийн цэвэр сортыг хадгалж үлдээх ажил тодорхой хувь нэмэр оруулна. Нутгийн иргэдийн газар тариалангийн ажлын баян туршлага болон газар тариалангийн бодлого боловсруулах ажил хоорондын тасархай байдал, түүнийг багасгах тухай эргэлзээ хэвээр үлдсэн. Бидний ажил энэ асуудалд бага ч болов дэмжлэг үзүүлэхийг зорьж байгаа хэдий ч судлаачид, үйлдвэрлэгчид болоод бодлого боловсруулдаг хүмүүс ихээхэн хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Адамо, А. ба А. Хорвока (1998). Жендэр болон биотөрөлжилтийн судалгааг нэгтгэхэд баримтлах чиглэл: Биотөрөлжилтийн тухай хөтөл-бөрийг тогтвортой хэрэгжүүлэх. Оттава: Олон улсын хөгжлийн судалгааны төв
- Браш, С. (1991). Хөдөө аж ахуйн ургамалын протоплазмыг хамгаалж хадгалах үйл ажиллагаанд фермерүүдийг оролцуулах. Ургамал судлалын эдийн засгийн асуудлууд, 45: 153-61.
- Статистикийн төв товчоо (1999). Балбын статистикийн жилийн эмхэтгэл.
- Катманду: Үндэсний төлөвлөгөөний комисс, Эрхэмсэг хааны Засгийн газар
- Гаучан, Д. (2000). Нутгийн цэвэр сортын цагаан будааны олон төрлийн нөөцийн эдийн засгийн үнэлгээ: Бара мужийн экосистем, Тераи, Балба. В. Стапит, М. Упадхайа, А. Сүбеди, г.м., Газар тариалангийн олон янз биологийн нөөцийг фермийн аж ахуйд хамгаалж хадгалах шинжлэх ухааны үндэс: Балбын Даяар төсөлд оруулсан хувь нэмэр, 120-48. Кат-манду: Балбын хөдөө аж ахуйн судалгааны зөвлөл/ Биотөрөлжилтийг судлах, хөгжүүлэх тухай орон нутгийн санаачилгыг дэмжих байгууллага, Ром: Олон улсын ургамалын генетикийн нөөцийн хүрээлэн
- Жарвис, Д.И. (2000) Фермерүүдийн шийдвэр гаргах тухай болон генетикийн

олон янз нөөцийн асуудал: Шинэ төрлийг фермийн аж ахуйд нэвтрүүлэх үүднээс олон талын судалгааг хэрэгжүүлэх. С. Браш, Гене-тикийн асуудлыг тариалангийн талбайд шийдвэрлэх: Нэр төрлийг фермийн аж ахуйд хадгалах, 261-78.

- Рана, Р.Б., П.Чодхари, Д.Гочан, С.П.Хативада, Б.Р.Стапит, А.Сүбеди, М.П.Упадхаяа болон Д.И.Жарвис (2000). Хөдөө аж ахуйн ургамалыг «газар дээр нь» хадгалж үлдээх: Качорвагийн байгаль орчин, ургамал-ын олон янз төрөл болон нийгэм эдийн засгийн нөхцлийг шинжлэн үзсэн тухай тоо баримт, Бара, Балба.
- Сүбеди, А., Д.Гочан, Р.Рана, С.Н. Вайдя, П.Р. Тивари ба П. Чодхари (1999). Цагаан будааны үйлдвэрлэл болон үрийн удирдлагын талаар шийдвэр гаргах болон жэндэрийн гүйцэтгэх үүрэг: Балбын байгаль орчны нөхцөлд тохирсон газар тариалангийн туршлага. Б.Стапит, М.Упадхаяа ба А.Сүбеди г.м., Газар тариалангийн олон янз нөөцийг фермийн аж ахуйд хадгалах, хамгаалах шинжлэх ухааны үндэс: Даяар төсөлд Балбын оруулсан хувь нэмэр, 38-48.
- Сүбеди А., П.Чодхари, Б.Баняя, Р.Рана, Р.К.Тивари, Д.Рижал, Д. Жарвис ба Б.Стапит (2001). Хэн, ямар аргаар генетикийн нөөцийг хадгалж байна? Газар тариалангийн олон янз нөөцийн удирдлагын тухай бодлогын асуудал. Д.Гочан, Б.Р.Стапит ба Д.И.Жарвис, Фер-мийн аж ахуйд биотөрөлжилтийг хадгалж үлдээх: Балба улс Үндэсний бодлогын асуудлаарх зөвлөмжийн шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлох ажилд оролцсон тухай (Үндэсний бодлогын семинар), 24-26.
- Эмэгтэйчүүд хөгжлийн төлөө газар (2002). Жилийн тайлан. Катманду: Хөдөө аж ахуй болон хоршоодын яам, Эрхэмсэг хааны Засгийн газар.

5

ЭМЭГТЭЙ ФЕРМЕРҮҮДЭД ЭРХ ОЛГОХ БОЛОН НУТГИЙН ҮРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХҮЙ

Хятадын Гуанши мужид хийсэн судалгаа



ЗУРАГ АВСАН: РОННЫЙ ВЕРНОЙ

Ючин Сон, Линшү Зан, Ронный Верной

Өнөөгийн Нийгмийн Байдал Болон Шийдвэрлэх Асуудлууд

Хятад улс эдийн засгийн өөрчлөлтүүдтэй тулгарч байгаа бөгөөд үүнтэй зэрэгцэн нийгэм өөрчлөн байгуулагдаж үүнд эргэн тойрон байгаа орчин их нөлөө үзүүлж байна. Хятад улс саяхан Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэн нь өөрчлөлтийн энэ үед тохиосон чухал үйл явдал гэж үзэж байгаа бөгөөд энэ нь хөгжлийг түргэтгэх найдвар төрүүлсэн билээ. Улсын эдийн засгийг гадаадын хөрөнгө оруулалт, бизнесийн хүрээнийхэнд нээлттэй болгох, мөн түүнчлэн дэлхийн эдийн засагт нягт нэгдэж орох явдал нь Хятадын нийт хүн амын аж амьдралд гүнзгий нөлөө үзүүлж байгаа нь эргэлзээгүй. үүний зэрэгцээ, хүмүүсийн амьжиргаа тэдний хөдөлмөрлөж буй салбарын хөгжил, амьдарч буй нутаг мөн нас, хүйс зэрэг хүчин зүйлээс хамаарагддаг учир эдийн засгийн шинэчлэл хүн амын өөр өөр давхаргын хүмүүст янз бүрийн нийгэм эдийн засгийн нөлөө зайлшгүй үзүүлнэ гэдгийг бид төсөөлж байна. Эдгээр өөрчлөлтүүд хамгийн эмзэг бүлэг болох жижиг фермерүүд, ялангуяа эмэгтэй фермерүүдэд ямар нөлөө үзүүлж байгаа болон хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах ажил бодлогын ажилтнууд ба судлаачдын хувьд чухал ач холбогдолтой асуудал болж хувирсан байна.

Энэ бүлэгт бид тодорхой үйл ажиллагаанд чиглэгдсэн судалгааны төслийн ажлын үр дүнтэй танилцуулна. « Эмэгтэй фермерүүдэд эрх олгох болон нутгийн үрийн тогтолцоог бэхжүүлэх замаар үр тогтсон ургамлын үрийн үйлдвэрлэл болон худалдааны талаарх судалгаа» судалгааны ажлыг нийгэм болон жендэрийн судалгааны баг Гуанши мужид хэрэгжүүлсэн хийгээд энэ нь Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төвөөс (CCAP) удирдан зохион байгуулж буй судалгааны төслийн нэг хэсэг билээ. Томоохон төслийн хүрээнд бодлого боловсруулах буюу түүнийг амьралд хэрэгжүүлэх, улмаар гүйцэтгэсэн ажлын үр дүнд үндэслэн дүгнэлт хийж үнэлгээ өгөх замаар фермерүүдийн амьдрах аргыг боловсронгуй болгоход чиглэгдсэн болно. Энэ ажлын хүрээнд ядуу фермерүүдийг төслийн арга хэмжээнд, мөн түүнчлэн фермерүүдийн бүлгийг түшиглэсэн

байгалийн нөөцийн менежментэд оролцох бололцоогоор хангах үүднээс дэмжлэг үзүүлнэ.

Хөдөө аж ахуйн салбарын эмэгтэй ажилчдын тоо үлэмж нэмэгдэж байна

Хятад улсад хэрэгжүүлж байгаа төслийн явцад хүн амын хөдөөнөөс, ялангуяа ядуурлын түвшинтэй бүс нутгаас, төв суурин эсвэл хот уруу чиглэсэн нүүдэл нийтдээ өсөн нэмэгдэж ганцаараа эсвэл өрхөөрөө шилжих, мөн түүнчлэн фермийн аж ахуйн бус ажилд улам их хугацаа зарцуулж байгаа нь ажиглагдсан (Сон болон Жиггинс 2002, Сон болон Зан 2004, НҮБХХ 2003, Зуо болон Сон 2002). Эдгээр судалгаа нь эмэгтэйчүүдийн нүүдэл эрэгтэйчүүдийнхээс хүний тоо, хугацаа болон өсөн нэмэгдэж буй илүү цагийн ажил зэрэг үзүүлэлтээр хавьгүй доогуур байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, гэртээ ганцаар үлдсэн эмэгтэйчүүдийн тоо өсөн нэмэгдэж, улмаар хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрлөдөг болон өрхийн аж ахуй эрхэлдэг эмэгтэйчүүдийн тоо улам нэмэгдэж байна.

Эмэгтэйчүүд хүнсний үйлдвэрлэл буюу фермийн аж ахуйг удирдахад их үүрэг гүйцэтгэх болсон бөгөөд гэрийн ажил үүргээ зэрэгцүүлэн хийдэг хэвээр байна. Хөдөө аж ахуйн салбар орлогын чухал эх үүсвэр болсон өнөө үед эмэгтэйчүүдийн энэхүү ачаалал нь эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурьд ямар нөлөө үзүүлж байгааг шинжлэн үзэх нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой асуудал нэгэнт болсон. Хятадын хөдөө нутагт, гол төлөв ядуу бүс нутагт, хөдөө аж ахуйд ажилладаг эмэгтэйчүүдийн тоо сүүлийн арван жилийн дотор нэмэгдсэн нь илэрхий зүйл билээ. Ийм хандлага Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төвийн гурван ядуу муж болох Анхуй, Кингхай, Гуаншид орших 200 фермерийн өрхийн дунд санамсаргүй сонголтоор хийсэн түүвэр судалгаагаар ажиглагдсан (Зураг 5.1). Эдгээр мужид ам бүл, хүний тоо болон фермийн аж ахуйн бус ажилд зарцуулсан хугацаа ерөнхийдөө өссөн буюу мужаас гадагшаа чиглэсэн нүүдэл их байгааг гэрчилсэн болно. Жишээлбэл, 1997 онд нийт 84 өрхөөс шилжин суугчид хот уруу

ирсэн бөгөөд энэ тоо 1999 он гэхэд 101 хүрч, 2001 онд 174 өрх хүртэл огцом өсч, улмаар 2003 онд нийт 196 өрх болж өссөн.


Мөн түүнчлэн, судалгаагаар хүн амын хөдөлгөөн олон нийтийг хамарсан үзэгдэл болсныг 1997-2003 онуудаар хүйсээр шинжилж харуулав (Зураг 5.1). Дүн шинжилгээнээс харахад эмэгтэйчүүдийн нүүдэл хязгаарлагдмал байдаг буюу тухайн онуудад өсөлттэй байсан хэдий ч эрэгтэйчүүд тэй харьцуулахад харьцангуй бага тоо билээ.

Хүснэгт 5.1
Анхуй, Кингхай ба Гуанши муж дахь гадагшаа чиглэсэн шилжих хөдөлгөөн
(1997-2003)

	Өөрчлөлт				
	1997	1999	2001	2003	1997-2003
Өрхөөс шилжсэн гишүүдийн тоо	84	101	174	196	112
Шилжсэн хүний тоо дунджаар (өрхөөр)	1.26	1.32	1.38	1.48	0.22
Шилжсэн дундаж хугацаа (сар/жилээр)	9.8	10.1	11.2	11.5	1.7

Эх сурвалж: Хятадын Хөдөө аж ахуйн бодлогын төв, 2004 онд цуглуулсан мэдээлэл

Зураг 5.1
Анхуй, Кингхай ба Гуанши муж дахь гадагшаа чиглэсэн шилжих хөдөлгөөний өөрчлөлт, хүйсээр



Эх сурвалж: Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төв, 2004 онд цуглуулсан мэдээлэл

Хөдөө аж ахуйг орлогын эх үүсвэр болгохуй, хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдал

Хятадад хөдөөгийн шинэчлэлтийг 1978 онд эхлүүлснээс хойш хөдөөгийн эдийн засаг болон газар тариалан улам ихээр хувьчлагдаж орлогын эх үүсвэр болж байна. Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэх явдал Хятадын газар тариалангийн үйлдвэрлэл болон түүнийг орлогын эх үүсвэр болгох явц, улмаар өргөн утгаар нь хөдөөгийн эдийн засаг болон иргэдийн ажил эрхлэлтийн байдалд ихээхэн өөрчлөлт авчирах болно.

Эмэгтэйчүүдийн өнөөгийн нийгэм эдийн засгийн хүнд байдал болон олноороо хөдөө аж ахуйн салбарт гол ажиллах хүч болж байгааг зарим судлаачид анхааралдаа авч, улмаар тэдний үзэж байгаагаар Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болсноор Хятадын хөдөө аж ахуйн салбарт илүү олон эмэгтэйчүүд ажиллах бөгөөд олон эмэгтэй хөдөө аж ахуйн улам их өрсөлдөөнтэй болоод хүнд хүчир ажил уруу шилжих болно.

(Сон болон Зан 2004, НҮБХХ 2003)

Иймд хохирлыг нөхөн олгодог арга хэмжээ буюу нийгмийн хамгааллын бодлогыг авч хэрэгжүүлэхгүй буюу ямар ч зохицуулалтгүй байдал нь хөдөөгийн эмэгтэйчүүдийн эдийн засаг, нийгэм болон гэр бүлд улам хүндээр тусах болно. Энэ нь хөдөөгийн өрхийн, ялангуяа алслагдсан бөгөөд нөөц бололцоогоор ядуу нутагт амьдардаг буюу хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрлөж амьдралаа залгуулж, хөдөө аж ахуйд найдаж явдаг хүмүүсийн амжиргаа, сайн сайхан байдалд нөлөөлөх билээ (Сон болон Зан 2004, НҮБХХ 2003).

Нөгөөтэйгүүр, Хятадын эдийн засгийн өсөлт гүнзгий сэтгэгдэл төрүүлж байсан хэдий ч алслагдсан олон нутагт, ялангуяа улсын баруун хэсэгт, ядуурал тогтвортой хэвээр байна. Ойролцоогоор 30 сая хүн өнөөг хүртэл ядуурлын доод түвшинд амьдарсан хэвээр байна. Тэд гол төлөв тарчигхан амжиргаатай фермерүүд бөгөөд хөдөө аж ахуй, байгаль орчны ядуу нөөцтэй буюу эрсдэл ихтэй

баруун зүгийн нутгуудад амьдардаг. Эдгээр алслагдсан нутгуудад ядуу фермерүүдийн дийлэнх хэсгийг эмэгтэйчүүд болон өрх толгойлсон эмэгтэйчүүд төлөөлдөг аж. Эмэгтэй хүн тариачин, хүнс үйлдвэрлэгч, фермийн аж ахуйн орлогыг бий болгодог гол ажиллах хүч болсон хэдий ч уламжлалт үүргийн дагуу гэрийн ажлыг мөн давхар гүйцэтгэж байна.

Судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүдийг удирдах эсвэл засаг захиргааны ажилд бараг дэвшүүлдэггүй бөгөөд эмэгтэйчүүдийн онцгой эрэлт хэрэгцээ, сонирхол болон ажлын мэдлэг, туршлагыг эс тоомсорлох, улмаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжилд ашигладгүй байна (Сон болон Жиггинс 2003, НҮБХХ 2003, Зан and Лин 2002). Мөн түүнчлэн, эмэгтэйчүүд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд чухал үүрэг гүйцэтгэдэг боловч хөдөө аж ахуйн нөөцөөс хүртэх, зээл, зах зээлийн мэдээ, сургалт болон хөдөө аж ахуйн үйл ажиллагааг өргөжүүлэх зэрэг үйлчилгээний байгууллагатай харьцах бололцоогоор хязгаарлагдмал байв. Энэ байдал нь эмэгтэйчүүдийн амьдрах аргын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бөгөөд ар гэрийнхэн нь хүнд байдалд орно (Сон 2003, НҮБХХ 2003, Зан болон Лин 2002, Зу 2000).

Генетикийн төрөл зүйлийн сүйрэл болон хүнсний аюулгүй байдал

Хятадад хөдөө аж ахуйн ургамалын, ялангуяа хүнсний ургамалын генетикийн төрөл зүйлийн сүйрэл маш хүнд болоод хэцүү асуудал билээ. Жишээ нь, бид хөдөө аж ахуйн ургамалын судалгааг эрдэнэ шиш дээр төвлөрүүлсний учир нь хүнсний энэ ургамал маш их ач холбогдолтой буюу Хятадад хүнсний гурав дахь хамгийн чухал ургамал бөгөөд баруун өмнөд зүгийн нутгийн ядуучуудын ургуулдаг үндсэн ургамал юм. Хятадын Засгийн газар хүч чармайлт гаргаж хүнсний үндэсний аюулгүй байдлыг бий болгох, түүнийг хангах үүднээс гол төлөв улсын үрийн тогтолцоог түшиглэн хөдөө аж ахуйн ургамалын шинэ болоод орчин үеийн технологид үндэслэсэн төрөл зүйлийг дэлгэрүүлж эхэлсэн. Газар тариалангийн үндсэн гурван бүтээгдэхүүн болох цагаан будаа, улаан буудай болон эрдэнэ

шишийн шинэ хувилбарыг, гол төлөв эрлийз сортыг хөгжүүлэх, газар тариаланг хангах ажил улсын үрийн тогтолцоо дахь нэн түрүүнд хэрэгжүүлэх үндсэн бодлого болсон.

Өнөөгийн байдлаар эрлийз сортын эрдэнэ шишийг Хятадын нийт тариалангийн нутгийн 80 орчим хувьд нь ургуулж байгаа бөгөөд үүнд гол төлөв их бололцоотой зүүн хойт зүгийн нутаг болон хойт зүгийн тал газар ордог.

Зах зээлийн эдийн засгийг нэвтрүүлсний үр дүнд улам өсөн нэмэгдэх ашгийн төлөө үрийн үйлдвэрлэл хийгээд хангамжийн тогтолцоо бий болсон. Эрлийз сортыг үржүүлэх болон эрлийз сортын үрийн үйлдвэрлэлд урьд нь тохиолдож байгаагүй хөрөнгө оруулалт хийсэн байна.

Харин Гуаншид хийсэн судалгаагаар алслагдсан уулархаг нутгуудад үрийн нийлүүлэлтийн 80 гаруй хувийг фермерүүдийн хувийн үрийн сүлжээ гүйцэтгэдэг тухай дүгнэлт хийсэн бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь хөдөө аж ахуйн ургамалын олон төрлийг хадгалж, улмаар нийт фермерүүдийн хүсэл, сонирхол болон тогтвортой амжиргааг дэмжиж ирсэн билээ (Сон 1998).

Хятадад эрдэнэ шишийг үржүүлэхэд шаардлагатай генетикийн сан сүүлийн арван жилийн турш хорогдож ирсэн байна. Өнөөгийн байдлаар эрдэнэ шишийн үрэвчний уугуул сийвэнгийн (протоплазмын) үндэсний цуглуулганд ойролцоогоор 16000 дээж хадгалагдаж байгаа бөгөөд улсын эрдэнэ шишийн нийт тариалангийн талбайн 53 хувийг зонхилох 5 эрлийз хувилбар эзлэж байна (Зан нар. 2000). Гуанши мужид эрдэнэ шишийн уугуул сийвэнгийн цуглуулга ойролцоогоор 2700 дээжтэй буюу түүний 1700 гаруй нь их мужийн нутгийн сорт юм (Хуанг 2000). Гэвч генетикийн эдгээр төрөл зүйлийг үржлийн үйл ажиллагаанд ашиглахад маш хангалтгүй буюу тоо хэмжээний хувьд хязгаарлагдмал байдаг. Эрлийз сортыг үржүүлэхэд зөвхөн үндсэн гурван эвцэлдүүлэх аргыг хэрэглэдэг бөгөөд сүүлийн 20 жилийн дотор нийт 14 эрлийз хувилбарыг шинээр үржүүлсэн буюу эдгээр нь ижил төрлийн жинхэнэ буюу угийн эгнээг янз бүрийн зэрэгт хуваасан байна (Хуанг 2000, Сон 1998). Мөн баруун өмнөд

зүгийн бусад мужуудад шинэ сортын эрдэнэ шиш өргөн дэлгэрч байгаагийн үр дүнд фермерүүийн тариалангийн талбайд ургуулж буй нутгийн цэвэр сортын эрдэнэ шиш доройтож үгүй болж байна.

Газар тариалангийн бодлого болон хэрэгжилт

Хятадад бодлогын ажилтнууд биологийн төрөл зүйлийг хамгаалах, хадгалж лдээх асуудал болон салбарын тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах асуудал хоорондын уялдаа холбоог улам их ухамсарлан ойлгох болсон. Хүнсний аюулгүй байдалд хийсэн дүн шинжилгээний дагуу биологийн төрөл зүйлийн хохирол нь Хятад улсын хүнсний хангамжийн ирээдүйн аюулгүй байдлыг баталгаажуулах үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх асуудал билээ (Хуанг 2003)

Засгийн газрын үзэж байгаагаар ургац хураалтын хэмжээ хүн амын өсөлттэй зэрэгцэн нэмэгдэх нөхцөлд биологийн олон янз нөөцийг хамгаалан хадгалж үлдээх буюу тогтвортой зарцуулах шаардлага бий болсон.

Хятад улс дэлхийн хамгийн их хүн амтай орон бөгөөд нэг хүнд хамгийн бага хэмжээний тариалангийн газар ноогддог аж. Сонголт байхгүй энэ нөхцөлд хүнсний аюулгүй байдлыг өндөр түвшинд хангах чухал асуудлыг нэн түрүүнд шийдвэрлэх хэрэгтэй байна. Засгийн газар хөдөө аж ахуйн салбарт маш олон эмэгтэй хөдөлмөрлөж байгаа мөн ядуучуудын дунд хамгийн ядуу бүлгийг эмэгтэйчүүд бүрдүүлэх болсон хүнд байдлыг ямар нэгэн хэмжээгээр шийдвэрлэх үүднээс бага ч болтугай чармайлт гаргасан билээ. Засгийн газраас ядуурлыг бууруулах болон холбогдох бусад хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн боловч жендэрийн асуудлын хялбар бус, эгзэгтэй мөн чанар, улмаар биологийн төрөл зүйлийн менежмент, хүнсний аюулгүй байдал, ядуурлыг бууруулах, хөдөөгийн хөгжилд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж буй үүргийг нягтлан тунгааж нэгдсэн ойлголтонд хүрээгүй бөгөөд асуудлыг тууштай шийдвэрлэх үйл ажиллагааг өнөөг хүртэл эхлүүлээгүй байна.

Харин зарим байгууллагууд эдгээр асуудлыг хариуцаж илүү нарийн нягт аргаар хандаж эхний ээлжинд судалгааны төсөл хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. Нэгэн ийм төслийг Хятадын шинжлэх ухааны академийн харъяа хөдөө аж ахуйн салбарт бодлого хэрэгжүүлэх туршлагаар тэргүүлдэг Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төвөөс удирдан хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл үрийн улсын тогтолцоо болон фермийн аж ахуйнуудын үрийн сүлжээ хооронд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьсон бөгөөд хөдөө аж ахуйн ургамалын тогтвортой хөгжлийг эрчимжүүлэх болон ургамалын генетикийн санг удирдах ажлыг «газар дээр нь» эсвэл фермийн аж ахуйд нэвтрүүлж, мөн түүнчлэн эрдэнэ шиш үйлдвэрлэдэг ядуу фермерүүдэд шууд туслалцаа үзүүлэх болно.

Төслийн хүрээнд эмэгтэй болон эрэгтэй фермерүүдийн газар тариалангийн биологийн төрөл зүйлийн менежментийн чадавхийг дээшлүүлэх, иргэдийн амьдрах аргыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлнэ (ССАР 1999, 2003) Хөдөөгийн амьдралд эмэгтэйчүүд гол үүрэг гүйцэтгэдэг хэдий ч нийгэмд хамгийн доогуур байр эзэлдэг учраас бид жендэрийн асуудал болоод зах зээлийн нөхцөлд аж ахуй эрхлэх эрх олгох, эдийн засгийн чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарал хандуулах болно.

Нэгдсэн судалгааг дэмжих нь: Бидний одоо хийж буй судалгаа

Жендэрийн асуудал төсөл хэрэгжүүлэх явцад нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих гол асуудал байх ёстой. «Хятадад хөдөө аж ахуйн ургамалыг хөгжүүлэх болон биологийн төрөл зүйлийг нэмэгдүүлэх чадамжийг судлах: үрийн албан ёсны тогтолцоо болон фермийн аж ахуйн үрийн сүлжээ хоорондын холбоог хөхүүлэн дэмжих» төслийг Канадын Олон улсын хөгжлийн судалгааны төв болон Фордын сангийн санхүүгийн бөгөөд техникийн дэмжлэгтэйгээр 2000 оны 1-р сард Гуанши мужид хэрэгжүүлж эхэлсэн (Зураг 5.2) (ССАР 1999).

Зураг 5.2 Судалгаанд хамрагдсан Өмнөд Хятадын байршил



Эх сурвалж: Перри Кастанеда номын сангийн Газар зүйн цуглуулга

Төслийн ажилд хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлдэг иргэдийг, ялангуяа фермерүүдийг татан оролцуулж байна. Өөрөөр хэлбэл, олон салбар ухааныг хамарсан шинжилгээ, судалгааны хүчтэй баг байгуулж нийгмийн янз бүрийн давхаргын хүмүүсийг бүрэлдэхүүндээ оруулж хамтран ажиллаж байна.

Гол нь төслийг хэрэгжүүлэх орон нутгийн ажлын сүлжээг үүсгэн зохион байгуулсан бөгөөд үйл ажиллагааны бүх түвшинд итгэл хүлээсэн, урам зоригтой, тодорхой үүрэг бүхий болон хамтран ажиллах сонирхолтой фермерүүд, бусад ажилчид оролцож байна (Верной 2001,2003)

Төслийг янз бүрийн мэргэжил, ажлын туршлагатай олон байгууллага, нийгмийн олон бүлэгт хамрагддаг эмэгтэй фермерүүд, үржлийн ажилчид, судлаачид үндэсний болоод тосгоны түвшинд хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх судалгааг 5 тосгонд явуулахаар сонгосон (Зураг 5.2)

Хүснэгт 5.2
Таван судалгааны бүс нутгийн талаарх үндсэн мэдээлэл

Шинж чанар	Вентенг	Зичинг	Ниантан	Зюрон	Хюанжан
Байршил (далайн түвшнээс дээш)	52	660	460	580	620
Жилийн дундаж хур тунадас	1.860	1.734	1.800	1.820	1.860
Байгаль орчин	Уудам ой, доворхог	Хуурай, налуу, уулархаг	Хуурай налуу	Уудам газар	Хуурай, налуу, уулархаг
Эдийн засгийн байдал	Баян	Маш ядуу	Ядуу	Баян	Маш ядуу
Зах зээлээс алслагдсан байдал (км)	2	10	6	3	12
Хүн амын боловсролын дундаж түвшин (сургуулийн жилээр)	7	4	6	7	13
Нийт ажиллах хүч	2.839	1.500	450	2.200	1.560
Шилжигчдийн тоо	519	975	220	570	820
Эмэгтэй шилжигч	140	235	66	120	210
Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо	80	83	70	78	82
Нэг хүнд ногдох эдэлбэр газар (гаагаар)	1.62	0.94	0.8	0.79	0.95

Эх сурвалж: Сон (1998).

Бидний ажлыг Олон улсын эрдэнэ шиш болон улаан буудайг сайжруулах төвөөс (СИММУТ) Хятадын баруун өмнөд нутгийн ядуу фермерүүдийн байдал болон эрдэнэ шишийн үрэвчийн уугуул сийвэнгийн талаар хийсэн нөлөө бүхий судалгааны үр дүнд түшиглэн гүйцэтгэж байна. Албан ёсны үрийн тогтолцоо болон фермийн аж ахуйн үрийн сүлжээнд хэрэгжиж буй шинэ технологи хөгжүүлэх болоод нэвтрүүлэх явц мөн хэрэглээнд нэвтрүүлсэн үрэвчийн уугуул сийвэнгийн газар тариалангийн ажлын янз бүрийн түвшинд үзүүлж буй нөлөөг судлахад чиглэгдсэн.

Судалгааны явцад албан ёсны үрийн тогтолцоо болон фермийн аж ахуйн үрийн сүлжээнд зөрчилтэй үйл ажиллагаа болон хоорондын хагарал олонтаа ажиглагдсан бөгөөд үүний үр дүнд хэлбэр төдий үржүүлж гаргасан үрийн шинэ төрлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажил сулрах, улмаар үржлийн ажилд хэрэгцээтэй генетикийн сан улам хязгаарлагдмал болж фермийн аж ахуйн тариалангийн талбайд генетикийн олон янзын төрөл зүйл багасах мөн доройтоход хүрч байна (Сон 1998, 2003) Бидний тоо баримтаар үйлдвэрлэлд нэвтрүүлсэн үрийн нэр төрлийн тоо гурваас тав хүртэл хэлбэлзэх буюу энэ нь маш хангалтгүй хэмжээ билээ (Зураг 5.3)

Янз бүрийн орчинд амьдарч буй фермерүүдийн олон янзын хэрэгцээг хангах болон генетикийн олон янз сортыг фермийн аж ахуйд нэмэгдүүлэх зорилготойгоор эрдэнэ шишийг чанаржуулах ажилд тариачидыг татан оролцуулах, үрийг шигшин сайжруулах, мөн түүнчлэн генетикийн нөөцийн менежментийг хөгжүүлэх зэрэг үндсэн аргуудыг хэрэгжүүлсэн болно. Үүний зэрэгцээ, нийгмийн судалгааны хүрээнд үрийн албан ёсны тогтолцоо болон фермийн аж ахуйн үрийн сүлжээг тус бүр тодорхойлох, фермерүүдийн мэдлэг, туршлагатай танилцаж цаашид эдгээр мэдээнд үндэслэн фермерүүдийн орон нутгийн зохион байгуулалтыг хүчтэй болгох мөн фермерүүдэд боломж олгох үүднээс зохих арга, механизмыг судалж боловсруулах болно (Сон, Верной 2003; Верной 2003).

Хүснэгт 5.3

Судалгааны 5 бүс нутаг дахь эрдэнэ шишийн үйлдвэрлэлийн шинж чанар

Шинж чанар	Вентенг	Зичинг	Ниантан	Зюрон	Хюанжан
Ургацын дундаж хэмжээ (т/га)	2.8	1.37	1.5	2.4	1.42
Усалгаатай талбай (%)	60	0	5	20	0
Химийн бордоо хэрэглэдэг эдэлбэр газар (%)	80	15	60	80	15
(%) Химийн бордоо хэрэглэдэг өрхийн аж ахуй	100	31	80	98	35
Худалдан авсан үр (эрлийз) ашигладаг өрхийн тоо	85	0	15	70	5
Судалгаа эхлэхээс өмнө үйлдвэрлэлд ашиглаж байсан үрийн нэр төрөл	3	5	5	4	5
Эрлийз үрийн сорт тариалдаг талбай (%)	60	0	10	45	3
Худалдах зорилгоор эрдэнэшишийн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн тоо (%)	70	10	40	70	15

Эх сурвалж: Сон (1998)

Иргэдийг хүйсээр ялгаварлах асуудлыг судлах, дүн шинжилгээ хийх нь судалгааны чухал хэсэг байв. Бид жендэрийн холбогдолтой хэд хэдэн асуудлыг судалсан. Газар тариалангийн үйлдвэрлэлд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, эмэгтэйчүүд айл өрх, тариачидын хамтлаг мөн нийгмийн түвшинд шийдвэр гаргах эрхтэй эсэх, ямар нэгэн үйлчилгээнд хамрагдах (зээл авах, сургалтанд оролцох) буюу хөдөө аж ахуйн нөөцөөс хүртэх боломж, эмэгтэйчүүдийн хэрэгцээ, сонирхол, тэдний ажлын туршлагыг газар тариалангийн технологийг хөгжүүлэх, түүнийг нэвтрүүлэхэд ашиглах.

Нэгэн тосгонд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнг зураг 5.4 болон 5.5-т харуулсан болно. Тосгоны эмэгтэйчүүд ихэнх тохиолдолд тариачин, фермийн аж ахуйн зохицуулагч болон өрх толгойлогчийн үүргийг хослуулан гүйцэтгэх шаардлагатай болсон ч эрэгтэйчүүд гэрт эсвэл гэрээсээ яваад хотод амьдардаг хэрнээ шийдвэр гаргадаг давамгайл үүргээ хадгалсан хэвээр байна.

Хүснэгтээс үзэхэд Хятадад эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд хоорондын хөдөлмөрийн уламжлалт хувиарилалт «эрэгтэйчүүд газар хагалж, эмэгтэйчүүд даавуу нэхнэ» гэж хэлсэн үгстэй нийцэж байсан бол одоо «эмэгтэйчүүд газар хагалж, эрэгтэйчүүд аж

үйлдвэрт ажилладаг» болж өөрчлөгдөв. Гэвч уламжлалт үзэл суртал болон амьдралын хуучин хэв маяг хүмүүсийн зан үйл, оюун ухаанд гүн хоногшсон байна («эрэгтэйчүүд гадна ертөнцийг, эмэгтэйчүүд дотоод ертөнцийг удирдана»).

Хүснэгт 5.4
Өрхийн нөөц болон үйл ажиллагааны удирдлагын талаарх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үзэл хандлага

Нөөц/Үйл ажиллагаа	Эрэгтэйчүүдийн үзэл хандлага (%)			Эмэгтэйчүүдийн үзэл хандлага (%)			Зөрүүтэй байдал Эрэгтэй-Эмэгтэй (%)		
	Эр	Эм	Хамт	Эр	Эм	Хамт	Эр	Эм	Хамт
Хөрс бэлтгэл	25	0	75	20	0	80	5	0	-5
Хүнсэнд зориулах ургац	10	40	50	5	70	25	5	-30	25
Үрийн солилцоонд ашиглах ургац	30	20	50	25	45	30	5	-25	-20
Бог	65	10	25	45	30	25	20	-20	0
Гахай	0	82	18	15	65	20	-15	17	-2
Үрийн үйлдвэрлэл	0	80	20	0	90	10	0	-10	10
Ус тогтоох/цуглуулах	0	80	20	0	90	10	0	-10	10
Өдөр тутмын хэрэгцээт бараа худалдан авах	10	60	30	10	80	10	0	-20	20

Эх сурвалж: Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төв, 2001 онд хийсэн суурь судалгааны үр дүн. 5 тосгоны 20 эрэгтэй, 20 эмэгтэй нийт 40 оролцогчийг хамруулсан

Хүснэгт 5.5
Өрхийн нөөц болон үйл ажиллагааны удирдлагын талаар шийдвэр гаргах асуудлаарх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үзэл хандлага

Нөөц/Үйл ажиллагаа	Эрэгтэйчүүдийн үзэл хандлага (%)			Эмэгтэйчүүдийн үзэл хандлага (%)			Зөрүүтэй байдал Эрэгтэй-Эмэгтэй (%)		
	Эр	Эм	Хамт	Эр	Эм	Хамт	Эр	Эм	Хамт
Хөрс бэлтгэл	60	0	40	55	0	45	5	0	-5
Хүнсэнд зориулах ургац	20	30	50	55	20	25	35	10	25
Үрийн солилцоонд ашиглах ургац	40	25	35	35	35	30	5	-10	5
Бог	65	10	25	70	0	30	-5	10	-5
Гахай	40	50	10	35	55	10	5	-5	0
Үрийн үйлдвэрлэл	10	65	25	5	75	20	5	-10	5
Ус тогтоох/цуглуулах	60	20	20	65	15	20	-5	5	0
Өдөр тутмын хэрэгцээт бараа худалдан авах	20	70	10	10	85	5	10	-15	5

Эх сурвалж: Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төв, 2001 онд хийсэн суурь судалгааны үр дүн. 5 тосгоны 20 эрэгтэй, 20 эмэгтэй нийт 40 оролцогчийг хамруулсан

Эрэгтэйчүүд мөн эмэгтэйчүүд хөдөө аж ахуйн нөөцийн менежмент, фермийн аж ахуй болон гэр ахуйн ажилд хэрхэн оролцдог тухай тэдний үзэл хандлагыг хүснэгт 5.4т харьцуулан үзүүлсэн болно. Ер нь тосгоны эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд өөрсдийн ажил эрхлэлтийн тухай янз бүрийн ойлголт төсөөлэлтэй байдаг. Хэрэв тэд өөр хоорондоо тохиролцон ажилласан нөхцөлд хүснэгт дэх баганы үзүүлэлт бүгд 0-тэй тэнцэх байсан. Гэвч зөвхөн таван тохиолдолд үнэн хариулт гарсан байна. Нутгийнхан зарим үйл ажиллагааны ангиллыг хүйс болон ажлын онцлогийг харгалзан хийх аргын талаар санал нэг байсан. Жишээлбэл, эрэгтэй ба эмэгтэй тариачидын бодлоор хөрс бэлтгэлийн ажлыг зөвхөн эрэгтэйчүүд эсвэл хамтран гүйцэтгэх ажил хэмээн үздэг аж. Үрийн үйлдвэрлэл болон ус хураах ажлыг гол төлөв эмэгтэйчүүд хариуцах эсвэл хамтран хийх саналтай байв. Ер нь эмэгтэйчүүд өөрсдийгөө эрэгтэйчүүдээс илүү олон янзын ажил хийдэгт итгэлтэй байдаг. Тухайлбал, эмэгтэйчүүд нийт найман ажлын зургаад нь эрэгтэйчүүдийн бодож байснаас илүү их зардал гаргасан ажээ. (Хүснэгт 5.4ийн сүүлчээсээ 2 дахь багана). Эрэгтэйчүүдийн бодлоор зөвхөн гахай хариулах ажилд эмэгтэйчүүдийн бодож байснаас илүү олон эмэгтэй оролцдог байна. Энэ сацуу эрэгтэйчүүдийн үзэж байснаар нийт ажлын тал хувьд нь тэд илүү их зардал гаргасан Энэ нь эмэгтэйчүүдийнхээр өөрсдийн хийсэн ажлаас их байсан.

Эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн хооронд зарим үйл ажиллагааны талаар санал зөрөлдөж байв. Жишээлбэл, олон эрэгтэйчүүд хүнсний болон үр ашиг сайтай ургамалын үйлдвэрлэлийг гол төлөв эрэгтэй, эмэгтэйчүүд хамтран гүйцэтгэх ажил гэж үзэхийн сацуу дийлэнх эмэгтэйчүүд бидний хийх ажил гэж үзэж байв. Гэвч зарим ажлын хувьд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд санал нийлж байв. Эрэгтэйчүүдийн 75 хувь нь, эмэгтэйчүүдийн 80 хувь нь хөрс бэлтгэлийн ажлыг хамтран гүйцэтгэх, харин гахай хариулах, үр боловсруулах, ус хураах болон өдөр тутмын хэрэглээний барааг худалдаж авах зэрэг ажил эмэгтэйчүүдийн үүрэг байж болох талаар санаа нийлж байв.

Хөдөө аж ахуйн нөөцийн асуудлаар шийдвэр гаргах буюу

аж ахуйн үйл ажиллагааны менежментийн талаарх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн саналыг харьцуулан хүснэгт 5.5-т харуулсан болно. Ер нь шийдвэр гаргах эрхийн тухай ойлголтын хувьд ажил, үүргийн хувиарилалтын талаарх үзэл бодолтой харьцуулахад эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд бага зөрөлдөөнтэй байсан (Хүснэгт 5.4 болон 5.5-ын «зөрүү» баганы абсолют тоог харьцуул)

Хөрс бэлтгэх, бод мал хариулах болон ус хураах зэрэг ажилд гол төлөв эрэгтэйчүүд шийдвэр гаргана гэж аль аль нь санал нэгтэй үзэж байв. Мөн түүнчлэн, гахай хариулах, үр боловсруулах бөгөөд өдөр тутмын хэрэглээний барааг худалдан авах зэрэг ажилд эмэгтэйчүүд шийдвэр гаргана гэж эрэгтэй, эмэгтэй аль аль нь санал нийлж байв. Зарим ажилд эрэгтэйчүүд оролцдоггүй, харин холбогдох шийдвэрийг гаргадаг хэрнээ түүнийг хэрэгжүүлэх ажлаас хөндий байдаг тухай эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь ярьж байсан. Хүнсний ургамалын асуудлаар шийдвэр гаргах эрхийн тухай эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн үзэл бодол их зөрөлдөөнтэй байв. Эрэгтэйчүүдийн 50 хувь нь хамтран шийдвэр гаргах боломжийн тухай ярьж байсан хэдий ч эмэгтэйчүүдийн 55 хувь нь ер нь эрэгтэйчүүд шийдвэр гаргаж байсан гэж үзэж байлаа.

Бид төслийн гол утгыг тодорхойлохдоо тухайн нутгийн гол тариачид болон үр шигшин сайжруулах ажлын гол хүч болсон эмэгтэй фермерүүдийн хэрэгцээ болон сонирхолд онцгой анхаарал хандуулсан билээ. Төслийн хүрээнд үрийн сортыг сонгон чанаржуулах ажлын явцад жендэрийн судалгаа, хүмүүсийн санаа бодлыг харьцуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Эрэгтэй ба эмэгтэй фермерүүд гол төлөв хуурайшилтад тэсвэртэй сортын ургамал сонирхож байсан. Энэ нь ихэвчлэн байгалийн (борооны) усалгаатай, ядуу нутагт амьдардаг фермерүүдийн хувьд зонхилох асуудал билээ. Үүнээс гадна эмэгтэй фермерүүд чанарын бусад үзүүлэлтийг тодорхойлж, тэдгээрийг өндөр үнэлж байсан бөгөөд үүнд дараа жилийн хэрэгцээ хүртэлх хадгалалтыг даах чанартай үр үйлдвэрлэх, бордооны хэрэгцээ бага байхаас гадна хоолны технологид тохирох сайн чанар зэрэг үзүүлэлтийг нэрлэсэн (Зураг 5.6)

Хүснэгт 5.6

Гуанши мужийн тосгодын эрэгтэй болон эмэгтэй фермерүүд үрийн төрлийг шилж сонгох үзүүлэлтүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Сонголтын дивтамж	
	Эмэгтэй (n=20)	Эрэгтэй n=(20)
Хуурайшилгад тэсвэртэй	100	100
Ургац налдаггүй	90	83
Өндөр ургац	80	83
Дараа жилийн үр	80	50
Буудайн өнгө	70	50
Хоолны чанар	50	33
Ургацын хэлбэр /эгнээ хооронд суулгах	50	83
Борооны хэрэгцээ бага	40	33
Боловсрох хугацаа	40	33
Ургацын өндөр	30	33
Хохирлын хэмжээ	30	33
Өвчинд тэсвэртэй	20	33
Хорьтон шавьжид тэсвэртэй	20	33
Ургах хугацаа	10	50

Эх сурвалж: Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төв. 2001 онд төсөлд хамрагдсан тосгодоос цуглуулсан мэдээлэл. Хүн бүр нэгээс илүү үзүүдэлт сонгох эрхтэй байв.

Энэ судалгааны үр дүн нэг талаас эмэгтэй үйлдвэрлэгч, нөгөө талаас гэрийн эзэгтэйн онцгой сонирхол, тэдний хэрэгцээг тод харуулсан бөгөөд цаашид тэдгээрийг газар тариалангийн технологийг хөгжүүлэх үйл ажиллагаанд харгалзахыг дэмжинэ.

ЭМЭГТЭЙ ФЕРМЕРИЙГ БОЛОЦООГООР ХАНГАХ, НУТГИЙН ҮРИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ҮҮДНЭЭС НИЙГЭМ БОЛОН ЖЕНДЭРИЙН СУДАЛГААГ НЭГТГЭХҮЙ

Эмэгтэйчүүд хөдөө аж ахуйн салбарт зонхилох хандлагатай ялангуяа ядуу бүс нутагт хамгийн олон эмэгтэй хөдөлмөрлөдөг бөгөөд өрхийн орлого бага, мөн түүнчлэн эмэгтэй өрх толгойлогчтой өрхийн тоо харьцангуй их байдаг. Үүний зэрэгцээ, Хятадад олон

нийттэй холбоотой судалгаа, түүний дотроос хөдөө аж ахуйд техник технологи нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоог «эрэгтэйчүүдэд зориулж бий болгосон» гэж хэлж болохоор бөгөөд эдгээр ажлыг гол төлөв эрэгтэйчүүд гүйцэтгэдэг. Тэдний хувьд «фермер бол фермер» буюу нийгэм болон жендэрийн судалгаа хамаагүй зүйл билээ. Эдгээр хүмүүс урьд нь тосгоноос хот уруу явсан эрэгтэйчүүд бөгөөд фермийн аж ахуйн ажил эрхэлдэггүй хэрнээ амралтын үеэр хотоос тосгонд ирж технологийн сургалтанд оролцдог байна.

Эмэгтэй фермерүүд эсвэл бүлэг эмэгтэйчүүд төслийн судалгааны ажилтнуудын гол түншүүд билээ. Багийн чадавхийг дээшлүүлэх, эмэгтэй фермерүүдийг бололцоогоор хангах асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ жендэрийн асуудлаарх хэтийн төлөвийг төслийн явцад анхаарлын төвд байлган шийдвэрлэх үүднээс илүү хүч чармайлт гаргаж тодорхой ажилд чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай байгааг бид ойлгож байсан.

Эмэгтэйчүүд биологийн төрөл зүйлийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн ургамалыг хөгжүүлэх болон хөдөөгийн амьдралын аюулгүй байдлыг хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгаа нөхцөлд жендэрийн асуудал нь төслийн хувьд, мөн түүнчлэн Хятадын газар тариалан болон хөдөөг тогтвортой хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон байна.

Үйл ажиллагааны зорилго болон судалгааны сэдэв:

Төслийн хөтөлбөр

Тодорхой ажилд чиглэгдсэн ямар үйл ажиллагаа эмэгтэй фермерүүдийг ашигтай ажиллах бололцоогоор хангах вэ? Энэ асуулт төслийн хүрээнд хийгдэх судалгааны гол асуулт байсан. Төслийн багийн дотор болон эмэгтэй фермерүүдтэй хамтран тосгонд зохион байгуулсан мэтгэлцээний үр дүнг үндэслэн ил аргаар үр тогтдог ургамалын үрийн хэдэн сортыг үйлдвэрлэх бөгөөд худалдааны сүлжээг бий болгох ажлыг эмэгтэй фермерүүдийн уламжлалт мэдлэг, ажлын туршлагад үнэтэй хувь нэмэр оруулж буй эхний ээлжийн арга хэмжээ юм. Эмэгтэй фермерүүдийг зах

зэлийн тогтолцоонд татан оролцуулах замаар эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх эдийн засгийн болон улс төрийн боломж олгохыг зорьж байв. Тухайлбал, эмэгтэй фермерүүдийг үрийн худалдаанд татан оролцуулахад дэмжлэг үзүүлж бололцоогоор хангах, үрийн үйлдвэрлэл болон худалдааг өрнүүлэх ажилд оролцох эмэгтэй фермерүүдийн чадавхийг хөгжүүлэх бөгөөд орон нутгийн үрийн сүлжээг хүчтэй болгоход бидний ажил чиглэж байв. Судалгааны үндсэн асуултуудыг дурьдахад:

1. Нийгэм болон жендэрийн судалгааны болоод төслийн ажлын багууд эмэгтэй фермерийг хэрхэн болоцоогоор хангах ба фермийн аж ахуйн үрийн сүлжээг бэхжүүлж чадах вэ? Хэрэгжлэх зөв үйл ажиллагаа болон тохирох аргыг тодорхойлох.
2. Ямар дотоод ба гадаад хүчин зүйл эмэгтэй фермерийг бололцоогоор хангах бөгөөд нутгийн үрийн сүлжээг бэхжүүлэх явцад нөлөө үзүүлэх вэ?
3. Хэрэгжүүлсэн ажлын үр дүнг бодлого боловсруулах явцад харгалзах.

Оролцооны төлөвлөлт

Нэгдүгээрт, бид тариалангийн талбай болон тосгонд ажиллах үеэр Бээжинд болсон олон улсын нийгэм ба жендэрийн судалгааны тухай семинарын үр дүнгийн талаар эмэгтэй фермерүүд, төслийн ажлыг орон нутагт техник, технологийн үйлчилгээ үзүүлдэг нутгийн иргэд мөн үржлийн ажилчид оролцсон багтай хамтран мэтгэлцэж, санал бодлоо солилцсон билээ. Учир нь нийгэм болон жендэрийн судалгаатай холбогдуулан хийх ажлын төлөвлөгөөний тухай төслийг анх эмэгтэй фермерүүд дэвшүүлсэн бөгөөд төсөлд оролцож буй нийгмийн бусад төлөөлөгчид дэмжсэн болно. Иймд бид ажлын зорилго хийгээд хэрэгжүүлэх арга зам буюу үйл ажиллагааны тухай шууд хэлэлцэж эхэлсэн.

Бид төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэх хоёр тосгон сонгох талаар хэлэлцэж нутгийнхантай хамтран хөдөө аж ахуйн ургамал үржүүлэх

туршилт явагдаж байгаа Вентенг болон Ниантан тосгодыг сонгосон. Эдгээр хэлэлцүүлгийг үндэслэн ажлын төлөвлөгөөнд тодотгол хийж боловсронгуй болгов. Ажлын төлөвлөгөө хэлэлцэхийг хоёр тосгоны эмэгтэй фермерүүд, төслийн техник, технологийн үйлчилгээ, сургалт хариуцсан үржлийн ажилтнуудтай хамтран ажлын шинэчилсэн төлөвлөгөөг хэлэлцүүлэх семинарыг 2002 оны 7-р сарын эхээр зохион байгуулав.

Хамтарсан семинарын үеэр хэрэгжүүлэх ажлын хөтөлбөр болон багийн гишүүдийн дунд тодорхой даалгавар өгсөн болно. Эмэгтэй фермерүүд бүтээлч урам зоригтой байж төлөвлөгөө боловсруулах явцад идэвхтэй оролцож байв.

Эмэгтэйчүүд ил аргаар үр тогтсон ургамалын үрийн үйлдвэрлэл хийгээд худалдааг өргөжүүлэх арга хэмжээ нь эмэгтэйчүүдэд зах зээлийн нөхцөлд ажиллах бололцоо олгох эдийн засаг болон улс төрийн ач холбогдол бүхий чухал эхлэл байна гэж удаа дараа тэмдэглэж байв. Эмэгтэй фермерүүд энэ санаачилгын тэргүүн эгнээнд ажиллах бөгөөд ажлын төлөвлөгөөг боловсронгуй болгох талаар шинэлэг зүйлийг санал болгож байв. Тухайлбал, үрийн үйлдвэрлэл давамгайлдаг тосгонд эмэгтэйчүүд нийгмийн эсвэл техникийн шалтгааны улмаас бүлгээр ажилладаг онцлогийг үндэслэн дараах саналыг дэвшүүлэв. Хэрэглэгчийн олон янз хэрэгцээг хангах үүднээс ил аргаар үр тогтсон ургамалын үрийн хувьд ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 2 сортын ургамалын оронд 4 янзын сортыг анхны туршилтаар үйлдвэрлэх явдал. Мөн түүнчлэн, аль нэг тосгонд фермийн аж ахуйнуудын дунд үрийн яармаг худалдаа зохион байгуулах замаар нутгийн тариачид фермийн аж ахуйн болон улсын үрийн сүлжээний олон сортын нөөцөнд хүрэх боломжийг нээж өгөх бүтээлч санал дэвшүүлсэн.

Судалгааны талбар

Эрдэнэ шишийн хоёр дахь ургац хураалтын улирал 7 дугаар сард эхэлдэг учир төслийн баг ажлын төлөвлөгөөг хэлэлцэж баталсан семинарыг дуусмагц сонгосон хоёр тосгон уруу явсан. Эмэгтэй

фермерүүд, төсөлд оролцдог нутгийн иргэдийн бүлэг болон үржлийн ажилтнуудын тусламжтайгаар туршилтын тариалангийн талбай бэлдэж үрийн нэр төрлийг сонгосон билээ.

Үрийн төрлийн 4 хувилбар, өөрөөр хэлбэл, олон улсын эрдэнэ шиш болон улаан буудайг боловсронгуй болгох төвийн (СИММУТ) төвийн ажилтнуудын үржүүлсэн сорт 961, 963, мөн фермерүүд сайжруулсан

Түксено сорт ба шигшин чанаржуулсан Мексико 1 хэмээх шинэ сортын үрийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилготойгоор сонгож фермийн аж ахуйн тариалангийн талбайд 7 дугаар сард суулгасан билээ.

Гүанши мужийн эрдэнэ шишийн судалгааны хүрээлэн болон эрдэнэ шишийг үржүүлэх, чанаржуулах ажлын 20 жилийн туршлагатай бөгөөд төслийн ажлын багийн гишүүн болох нэгэн эмэгтэй фермер эдгээр сайн чанарын үрийг үрэлгээнд зориулж нийлүүлсэн билээ (дэлгэрэнгүйгээр Song 1998)

Үрийн үйлдвэрлэлийн сургалтыг туршлагатай эмэгтэй фермерүүд үржүүлэгчид, орон нутгийн ажилчид болон улсын холбогдох байгууллагуудын үржлийн ажилтнууд хамтран тариалангийн талбайд зохион байгуулсан болно.

Үрэлгээний улирлын дараа тариачидын зарим бүлэг үйлдвэрлэсэн үрийн борлуулалтын талаар мэтгэлцээн явуулсан байна. Эдгээр шинэ сортын үрийг тарьж дэлгэрүүлэх, худалдах болон хэрэглэгчдэд хүрэх гурван үндсэн суваг байгааг тогтоосон. Одоо үйлчлэж буй фермерээс фермерт бараа солилцооны сүлжээ, фермерүүд нутгийн үрийн худалдаанд нийлүүлдэг суваг мөн фермерээс мужийн гаднах зах зээл үрүү чиглэсэн худалдаа орно.

Одоо үйлчлэж буй фермерээс фермерт үр солилцооны сувгийг хэвээр хадгалж, харин үйл ажиллагаанд ажиглалт хийх болсон. Цаашид эдгээр сортын үрийг тарьж, улмаар дэлгэрүүлэх ажлын явцыг баримтжуулахаар шийдвэрлэв. 2003 оны эхээр фермерүүдийн дунд үрийн яармаг худалдаа зохион байгуулагдсан бөгөөд энэ үйл явдал Хятадын хувьд шинэлэг зүйл байснаас гадна эмэгтэй фермерүүдэд худалдаа эрхлэх, цаашид бэхжүүлэх болоод

фермерүүдийн өнөөгийн худалдааны үйл ажиллагааг албан ёсоор баталгаажуулах тохиромжтой арга болсон.

Эмэгтэйчүүдийн эрхэлдэг фермийн аж ахуйн бүтээгдэхүүний үнэлгээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл болон худалдааны ажил эрхлэх бололцоогоор хангах үүднээс эмэгтэй фермерүүдийг мужийн гаднах зах зээлтэй холбох зарим арга хэмжээг авсан байна. Жишээлбэл, Нинксия, Жиансү болон Гансү мужид зах зээлийн судалгааг эхлүүлсэн билээ. Хоёр мужийн тариачид өөрсдийн тариалангийн талбайд нутагшуулах зорилготойгоор зарим сортын үрийг Гүанши мужийн тариачдаас импортлосон байна.

Төслийн Үр Дүн

Эмэгтэйчүүдийн Зохион Байгуулах Үр Чадварыг Нэмэгдүүлэх

Эмэгтэй фермерүүд нийгэм болон жендэрийн судалгааны ажлын төлөвлөгөөг эхлүүлсэн бөгөөд гол төлөв эмэгтэй тариачдын бүлгүүд төсөлд хамрагдсан нутгийн ажилчидтай хамтран түүнийг хэрэгжүүлж ирсэн. Иргэдийн энэ холбоо фермерүүдийг хамт олноороо өөрсдийн санал бодол буюу эрэлт хэрэгцээг төслийн ажлыг өргөн дэлгэрүүлэх бөгөөд судалгааны ажлын албан ёсны тогтолцоо уруу чиглүүлэх боломжийг олгосон.

Хууль журмын дэмжлэг байхгүй нөхцөлд зарим эмэгтэй фермерүүд бие биенийгээ дэмжих, мэдээлэл, ажлын үр чадвар буюу туршлага солилцох, мөн түүнчлэн ажил хуваарилах, жижиг зээлийн асуудлыг хариуцах, улмаар зээл олгох ажлыг зохицуулдаг ажээ. Эмэгтэйчүүдийн далд бололцоо болон наймаа хийх чадвар нэмэгдсэн билээ.

Эмэгтэй фермерүүдийг нэгтгэсэн бүлгүүд шинэ сортын ургамалыг тариалангийн талбайд үржүүлэх туршилтанд үргэлжлүүлэн идэвхтэй оролцож байна. Эдгээр бүлгүүд хүрээлэн байгаа орчин болоод нийгэм, эдийн засгийн нөхцлийн нөлөөний улмаас ажлын зорилго болон чадварын хувьд өөр /хоорондоо

ялгаатай байдаг. Харин нутгийн эмэгтэйчүүд урам зоригтой бөгөөд шинэ үйлсэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Нийгэм болон жендэрийн судалгааны ажил эмэгтэй тариачдын байгуулсан бүлгүүдийн өөрийгөө удирдан зохион байгуулах чадварыг нэмэгдүүлсэн болно. Эмэгтэйчүүд аж ахуйн менежмент, үрийн үйлдвэрлэл буюу худалдааны сургалтанд идэвхтэй хамрагдсан бөгөөд үрийн зах зээлийн мэдээлэл авах боломж өсөн нэмэгдэж, улмаар үрийн албан ёсны худалдаанд шууд оролцох бололцоотой болж байна. Үүнээс гадна эдгээр эмэгтэйчүүд өрхийн болон тариачидын хамтлагийн хэмжээнд улам их эрч хүчтэй болж байна. Тэд үйлдвэрлэл болон орлого бүхий бусад үйл ажиллагааны явцад шууд оролцох болон шийдвэр гаргахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна.

Эмэгтэйчүүдийн Бүлэг Болон Үрийн үйлдвэрлэл Худалдаанд Техник Технологийн Үйлчилгээ Дамжуулах Тогтолцоо Хоорондын Сүлжээг Нутгийн Иргэдийн Түвшинд Бэхжүүлэхүй

Фермерүүдийн болон үндэсний холбогдох байгууллагуудын мэдлэг, туршлагыг харилцан солилцох, үрийн хоёр тогтолцоо хоорондын хамтарч ажиллах орон нутгийн сүлжээ болон анхан шатны түвшинд техник технологи нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулдаг тогтолцооны асуудал чухал юм. Үүнд хот, тосгоны техник технологийн станцууд болон тэдгээрийн харьяанд ажилладаг тосгоны фермерүүд багтдаг бөгөөд энэхүү сүлжээгээр дамжуулан газар тариалангийн үйл ажиллагааг технологиор хангах ажлыг хэрэгжүүлдэг.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжих үед улсын чанартай технологийн тогтолцооны үүрэг өөрчлөгдөж зөвхөн улсын байгууллага, аж ахуйн нэгжид үйлчилдэг байсан бол одоо фермерүүдэд мөн адил үйлчилж байна. Хот, тосгоны шинэ техник технологи дамжуулах станцууд маш хүнд нөхцөлд өөрөөр хэлбэл санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байна. Эдгээр станцууд албан ёсны буюу улсаас фермерүүдэд тулж

хүрдэг тусламжийн цорын ганц эх үүсвэр билээ. Станцид албаны шугамаар сургалтанд хамрагдаж бэлтгэгдсэн хүмүүс ажилладаг ба бараг бүгд хөдөө аж ахуйн хамтлагаас ирсэн нутгийн хүмүүс байдаг. Нутгийн эдгээр «шинжээчид» хөдөө аж ахуйн салбарыг сайтар мэддэг хийгээд үйл ажиллагаандаа фермерүүдийг татан оролцуулахад өөр газраас ирсэн мэргэжилтнийг бодвол их урам зоригтой ажилладаг.

Станцын ажилчид төслийн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх явцад, тухайлбал, хөдөө аж ахуйн ургамалыг фермийн тариалангийн талбайд үржүүлэх (РРВ) мөн үрийн сортыг шигшин сайжруулах (РВС) зэрэг туршилтыг тариачидтай хамтран зохион байгуулахад эмэгтэй фермерүүдтэй ажиллаж байна.

Төслийг хэрэгжүүлж буй 5 тосгонд эмэгтэй фермерүүд болон хот, тосгодын технологийн үйлчилгээ хариуцсан ажилтнуудын хоорондын сайн хамтын ажиллагааны суурь тавигдсан болно. Ийнхүү хамтын ажиллагааг фермерүүд өндөр үнэлсэн бөгөөд Хөдөө аж ахуйн яамтай хамтран ажиллах хүрээнд бодлогын чанартай шинэ туршилтыг боловсруулах ба хэрэгжүүлэх ажлын хууль журмын суурь болж байна. Туршилт бол улсын хэмжээнд одоо хэрэгжиж буй газар тариаланд үйлдвэрлэлийн шинэ ололтыг нэвтрүүлж шинэчлэх ажлын нэг хэсэг юм. Бидний үзэж байгаагаар шинэчилэлтийн явц өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн ажлын үр дүнд үндэслэх бөгөөд нийгэм болон жендэрийн судалгааны явцад бидний гаргасан чармайлтыг улам хүчтэй болгоно.

Нутгийн Уламжлалт Сортын Үр Ба Туршилтын Сортын Үрийн (РРВ) Үнэлгээг Нэмэгдүүлэх Болон Ил Аргаар Үр Тогтсон Ургамалын Үрийн Орон Нутгийн Үйлдвэрлэл, Худалдаанд Эмэгтэй ФермериЙг Татан Оролцуулах

Үйлдвэрлэлийн зорилготойгоор сонгосон 4 төрлийн үрээс баян ургац хураасан буюу, ялангуяа, тариалангийн талбайд туршилтаар үржүүлсэн үрийн сорт болон Мексико 1 сорт өндөр үзүүлэлттэй байв.

Энэ хоёр төрлийн үрийн ургацын хэмжээ ил замаар үр тогтсон ургамалын үрийн ургацаас 1520 хувиар илүү байв. Үүний зэрэгцээ фермерүүд, тухайлбал, эмэгтэй тариачид үрийн чанарыг тодорхойлдог бусад чухал үзүүлэлтийг харгалздаг байна. Тухайн сортын үрээс хураах ургац агаарын хуурайшилтанд тэсвэртэй, салхинд налдаггүй бөгөөд хоол хүнсний технологийн шаардлагад тохирох сайн чанартай зэрэг үзүүлэлтийг харгалзан дээдэлдэг байна.

961, 963 болон Такспено сортын үрийн хувьд сайн ургац өгдөгөөс гадна фермерүүдийн онцгой хэрэгцээ, хэрэглээний сонирхолд нийцдэг боловч бусад сортоос зарим үзүүлэлтээрээ ялгардаг аж. Үрийн эдгээр 4 сортыг одоо үйлчилж буй «фермерээс фермерт» үр солилцооны сүлжээгээр дамжуулан түгээсэн билээ. Үүнээс гадна тодорхой хэмжээний үрийг орон нутгийн зах зээл болох фермерүүдийн чөлөөт худалдаа болон фермерүүдэд зориулсан үрийн яармаг худалдаагаар дамжуулан нийлүүлсэн болно.

Мексико 1 сортын үр орон нутгийн зах зээлд өргөн дэлгэрч байна. Мөн түүнчлэн, 2003 онд энэ сортыг үндэсний хэмжээний туршилтанд оруулахаар нийт 18 мужид санал болгон дэвшүүлсэн. Эдгээр туршилтуудын үр дүнг нягтлан судалж байна.

Гуанши Мужийн Яармаг Худалдаа: Фермерийн Мэдлэг Болон Үрийн Солилцоог Бэхжүүлэх Шинэлэг Арга

Төслийн багийн зөвлөж байснаар үрийн яармаг худалдаа нь фермерүүдийг дэмжиж урамшуулах хийгээд тариачдад үрийн зах зээлд оролцох, улмаар эрдэнэ шиш ба хөдөө аж ахуйн бусад төрлийн ургамалын талаарх мэдлэгээ дээшлүүлэх бөгөөд орон нутгийн өнөөгийн үрийн худалдааны сүлжээ болон үр солилцооны тогтолцоог хамгийн тохиромжтой аргаар хуулиар зөвшөөрүүлж албан ёсны үйл ажиллагаатай болгох асуудлыг судлахад дэмжлэг болох билээ.

Ургац хураасны дараа фермерүүдэд зориулж үрийн анхны яармаг худалдааг Гуанши мужид зохион байгуулсан. Түүнийг чухал ач холбогдолтой үйл явдал гэж үзсэн байна (Хайрцаг 5.1)

Хайрцаг Түозай хотын үрийн яармаг худалдаа

5.1

Өнөөдөр Гүанкси мужийн Түозай хотын захын өдөр бөгөөд яармаг худалдааны нээлтийг хобогдуулан хүмүүсийн сэтгэл хөөрч байв. Энэ бол ердийн яармаг худалдаа биш, энэ бол газар тариалангийн олон янз биологийн нөөцийг танилцуулах яармаг худалдаа бөгөөд мужийн хэмжээнд (магадгүй Хятад улсад) анх удаа тохиолдож буй үйл явдал болсон.

Хотын төв гудамжинд нутгийн хэдэн зуун фермер бөөнөөрөө цугларч үзэсгэлэнд тавигдсан хөдөө аж ахуйн олон төрлийн ургамал болон үрийг танилцуулж буй үзүүлэнг судлаж байсан. Мөн түүнчлэн, яармаг худалдааг үзэж оролцохоор хот, тосгоны албаны хүмүүс, худалдаачид, сониуч хүүхдүүд, Бээжингээс ирсэн чухал хүмүүс болон орон нутгийн телевизийн баг дүрс бичлэг хийж байв.

Олон нийтэд зориулж хөдөө аж ахуйн маш олон төрлийн ургамалтай, тухайлбал, нийт 38 нэр төрлийн 107 хувилбартай танилцуулж байсан. Зарим нэр төрлийн хувьд, жишээлбэл, хар лавын эрдэнэ шиш, уулын сараана зэрэг тухайн бүс нутагт ховор бөгөөд хосгүй ургамалтай танилцуулж байв.

Үзэсгэлэн худалдаанд нийт 31 төрлийн эрдэнэ шиш, 17 төрлийн шош, 16 төрлийн хүнсний ногоо, 14 нэр төрлийн үр тариа болон 24 нэр төрлийн төмс, хүнсний ногоо тавигдсан байв. Үүний зэрэгцээ, уламжлалт өвс, ургамал, халуун ногоо болон эмийн ургамалыг санал болгож байсан. Эдгээр үзүүлэнгийн дийлэнх нь нутгийн цэвэр сортын ургамал юм.

Энэхүү далай баян үзүүлэнг ердийн захтай адил саравчнуудад байрлуулж саравч нэг бүрт тухайн сортыг тодорхойлсон үзүүлэлтүүд хийгээд бараа нэг бүрийн үүслийн тухай гаргацтай хэвлэсэн хуудсаар хангасан байв. Бүтээгдэхүүнээрээ бахархасан фермерүүд, зарим судлаачид буюу хөдөө аж ахуйн нөөцийн ажилчид өөрсдийн бүтээгдэхүүний тухай асуултанд хариулж, тайлбарлаж байсан.

Яармаг худалдаанд ирсэн хүмүүс өндөр сэтгэгдэлтэй байсан. «Ийм олон төрлийн ургамал энд үржүүлэх боломжтойг би мэддгүй байжээ» хэмээн нэг хүн ярьж байв. Настайвтар фермер үзэсгэлэнд тавьсан эрдэнэ шишийг шалгаж үзээд гайхсан байдалтай голтойгоо сэгсэрч: «Би эдгээр үрийг 1960аад оноос хойш үзээгүй юм байна» гэж хэлсэн. «Би урьд нь үзэж байгаагүй 7 сортын эрдэнэ шиш энд байна» гэж хамт яваа нөхөр нь хариулав.

Өдрийн турш үргэлжилсэн яармаг худалдааны үеэр фермерүүд, судлаачид мөн албаны хүмүүс олон хонь бодол, шинэ санаа буюу ажлын туршлагаас гадна мэдээж үр солилцож байсан. Үдээс хойш зохион байгуулах хороо яармаг худалдаанд тавигдсан олон янз төрлийн бүтээгдэхүүнийг үнэлсний үндсэн дээр хамгийн алдартай үзүүлэнгүүдэд шагнал олгов. Гүанкси мужид зохион байгуулсан газар тариалангийн олон янз биологийн нөөцийн анхны яармаг худалдааг нийт 2000 гаруй хүн үзсэн. Энэ бол асар их амжилт бөгөөд сүүлийн арга хэмжээ болохгүй нь зүйн хэрэг билээ (Verney and Song 2003).

Бодлогын Асуудал

Бид төслийн хүрээнд хэрэгжүүлж буй судалгааны тухай эргэцүүлэн бодож гол ололт амжилтаа нэгтгэж урьдчилсан дүгнэлт хийж байна. Нэгдүгээрт, нийгэм болон жендэрийн судалгаагаар фермерүүдийн уламжлалт мэдлэг болон бүтээгдэхүүний нөөцөнд, тухайлбал, нутгийн цэвэр сорт болон тариачдын бие даан боловсронгуй болгосон сортын ургамал буюу үрэнд үнэлэлт хийх явдал гол асуудал болохыг харуулсан.

Бидний иж бүрэн судалгаа эмэгтэй фермерүүдийн ашиг багатай аж ахуй мөн тэдний мэдлэг, ажлын туршлагыг хамтын ажиллагааны явцад сайшаан дэмжих, хамгаалж бэхжүүлж чадахыг харуулсан. Фермерүүд, судлаачид, хөдөө аж ахуйн нөөцийн (техникийн үйлчилгээ) ажилчид болон бодлого боловсруулагчид албан ёсоор зөвшөөрөгдсөн буюу тэгш эрхтэй нөхцөлд хамтран ажиллах шаардлагатай байна.

Төслийг хэрэгжүүлэх явцад тодорхой амжилтанд хүрсэн хэдий ч олон фермерийг татан оролцуулах, улмаар ашигтай хамтран ажиллахад илүү тохирох буюу дэмжлэг бүхий зах зээл, ёс журам болон хуулийн хөшүүрэг, бодлого шаардагдаж байна. Үүнтэй холбогдуулан, бага ашигтай үйл ажиллагаа болон үндсэн чиглэлээс хазайх явдлаас цаашид зайлсхийж ажиллах хэрэгтэй.

Хүйсээр ялгаварлах асуудалд мэдрэмжтэй бодлого зохицуулалт мөн хэрэгжүүлэлт болон менежментийн стратеги боловсруулахад нийгэм болон жендэрийн судалгаа чухал ач холбогдолтой байдаг. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн бүлгүүдийн үйл ажиллагааг ажиглахад фермерүүдийн зохион байгуулах, удирдах чадвар бөгөөд эрхийг нь хамгаалах асуудал чухал болохыг харуулж байв. Фермийн бүлэг болон хамтлагийг бэхжүүлэх явдал тариачдыг өөрсдийгөө удирдан зохион байгуулах чадалтай болгох анхны алхам болно.

Магадгүй, фермерүүдэд зориулж зохион байгуулсан үрийн яармаг худалдаа гагцхүү олон зүйл амласан үйл явдал төдий байж

болох юм. Гэвч яармаг худалдаа богино хугацаанд олны дунд нэртэй болохын сацуу тариачдийг сайшаан дэмжих, фермерүүд мэдлэг, туршлага мөн генетикийн төрөл зүйлийг харилцан солилцох боломж билээ. Яармаг худалдаагаар фермерийн мэдлэг мөн орон нутагт хэрэгжүүлдэг арга хэмжээнд эдийн засгийн, соёлын болон нийгмийн үнэлэлт өгөх буюу дэмжих замаар орон нутгийн үрийн тогтолцоо болон бусад сүлжээг бэхжүүлж чадна.

Эмэгтэй фермерүүд болон анхан шатны түвшинд хөдөө аж ахуйн үйл ажиллагааг техник технологиор дэмжих үйлчилгээ эрхэлдэг нутгийн иргэд хоорондын хамтын ажиллагааны явцад эмэгтэй тариачид хууль журмын дэмжлэг авах, улмаар эмэгтэйчүүдийг албан ёсоор зөвшөөрөгдсөн зах зээлийн тогтолцоотой холбож өгөх арга зам болно.

Бидний ажилд дэвшилт гарч байгаа боловч шийдвэрлэвэл зохих эгзэгтэй асуудалтай тулгарсан хэвээр байна. Мөн түүнчлэн, бодлогын чанартай зарим асуудал шинээр үүдэн гарч ирсэн. Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэх явдал эмэгтэй фермерүүдийн үрийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх санаачилгыг эсвэл хөхүүлэн дэмжих, эсвэл хавчин хязгаарлах нөлөө үзүүлэх нь тодорхойгүй байна.

Хөдөөгийн хөгжлийн бодлого, тухайлбал, хөдөө нутагт газар тариаланг техникжүүлж шинэчилэх асуудал хөдөөгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн санаа бодол, янз бүрийн хэрэгцээ, сонирхолд ямар нөлөө үзүүлэх мөн тэдгээрийг хэрхэн тооцож цаашдын бодлогод тусгах вэ?

Хөдөөгийн шинэ бодлогын хүрээнд эмэгтэйчүүдэд хамтын хүчээр шинэ боломж олгох уу, эсвэл хөдөө аж ахуйн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт болон ядуурлыг гүнзгийрүүлэх үү? Нийгэм болон жендэрийн судалгааг бодлогын чанартай дөрвөн асуудалтай нэгтгэж цаашид шийдвэрлэхийн тулд нэн түрүүнд өөрсдийн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон болно. Бид дээр дурьдсан зүйлүүдийг товч танилцуулав (ССАР 2003)

ФЕРМЕРҮҮД, ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, АМЬЖИРГААГ САЙЖРУУЛАХ ҮҮДНЭЭС ҮРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ЭРХЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Үрийн шинэ бодлого, хууль тогтоомж бүх төрлийн үр, тухайлбал, ил аргаар үр тогтсон олон янз ургамалын үрийн хувийн үйлдвэрлэл эрхлэх бололцоо өгч байна. Гэвч одоогийн байдлаар үрийн хувийн болон улсын том компаниуд зөвхөн эрлийз сортын үр үйлдвэрлэх, худалдаалах сонирхолтой байдаг. Эдгээр компаниудын үндсэн сонирхол нь мөнгө хийх бөгөөд генетикийн аргаар хувилгасан үрийн худалдаа зах зээлийг нэгэнт эзэлсэн байна. Өнөөдрийг хүртэл ядуу болон уулархаг нутагт амьдардаг фермерүүдэд туслахын тулд бага хүч чармайлт гаргаж байсан. Эдгээр фермерүүд нутгийн уламжлалт цэвэр сорт болон ил замаар үр тогтсон ургамалын үрийн чанарт итгэж дээдэлдэг байна.

Шийдвэрлэвэл зохих хоёр эгзэгтэй асуудал бий: а) жижиг аж ахуйтай фермерүүдийг (гол төлөв ил аргаар үр тогтсон болон тариачдын оролцоотойгоор үржүүлсэн сортоор) үрийн зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлж түлхэц өгөх, б) үрийн асуудлаарх шинэ бодлого, холбогдох хуулийн хэрэгжилтийг газар тариалангийн тухай бусад бодлого, хуультай зохицуулах, тухайлбал Дэлхийн худалдааны байгууллагын гишүүний хувьд улсын эдийн засагт гарах өөрчлөлтийг харгалзах зэрэг болно.

ШИНЭ СОРТЫН ҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХИЙН ТУЛД ҮРЖҮҮЛЭГЧИЙН АЖЛЫГ САЙШААН УРАМШУУЛАХ, НӨӨЦ БОЛОН АШГИЙН ХУВААРИЛАЛТЫН АСУУДЛЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ

Тариачдын оролцоотойгоор үржүүлсэн ургамалын шинэ сортууд олон хүний хүч чармайлт гаргасны үр дүн билээ. Фермерүүд, ургамал үржүүлэгчид, судлаачид, газар тариалангийн нөөцийн (техник технологийн) ажилтнууд мөн ханвилагчид болон улс төрчид, үүнтэй холбогдуулан олон асуулт үүсдэг, тухайлбал, шинэ сорт үржүүлж гаргахад хувь нэмэр оруулсан хүмүүсийг зөв сайшаан

урамшуулах (шинийг санаачилсан, мэдлэг, ур чадвар, зарцуулсан хугацаа, хөдөлмөр болон мөнгөн хөрөнгө гэх мэт), шинэ сортын үр мөн ургамалыг хуваарилах бөгөөд хэрэглэх бололцоотой байх, шинэ сортын үр, ургамалаас олох худалдааны болон худалдааны бус ашгийн шударга хувиарилалтын асуудал зэрэг юм.

Өнөөдөр ургамал үржүүлэгчийн эрхийн тухай бодлого мөн хууль үйлчилдэг, харин жижиг үйлдвэрлэгчдийн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль байхгүй. Зарим оронд санал дэвшүүлсний мөрөөр фермерүүдийн эрхийг хангах арга хэмжээ авдаг. Хятад улсад тариачдын үржүүлсэн олон янз ургамалын асуудлыг фермерүүдийг дэмжин урамшуулах, газар тариалангийн нөөцөөс хүртэх бололцоо болон ашиг хуваарилалттай уялдуулан шийдвэрлэхийн тулд шинэ бодлого хэрэгжүүлж хуульчлах шаардлага байна уу?

Аз болоход, Хятадын улс төрчид олон биологийн төрөл зүйлийн нөөцийг («газар дээр нь») хамгаалан хадгалж үлдээх болон хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил мөн ядуурлыг бууруулах арга хэмжээ хоорондын уялдаа холбоог сайтар ойлгодог болсон. Нутгийн уламжлалт цэвэр сортыг газар дээр нь (in situ) хадгалж үлдэх асуудал эрдэнэ шишийн генетикийн санг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хувьд шийдвэрлэх ач холбогдолтой гэдэгт итгэлтэй хандах болсон. Энэ нь найдвар төрүүлж байгаа хэдий ч шинэ хэтийн төлөвийг бодлого болгон хуулиар зохицуулах хэрэгтэй байна.

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЧИГЛЭЛ

Өнөөдрийн байдлаар Хятадын олон мужид, тухайлбал Гуаншид, газар тариалангийн үйл ажиллагааг техникжүүлэх үйлчилгээ «устсан» бөгөөд хөдөөгийн технологийн шинэчлэлтийг хариуцдаг өндөр албан тушаалтнууд цаг үеийн энэ баримтыг хүлээн зөвшөөрдөг билээ. Эрх бүхий албаны хүмүүс асуудлыг шийдвэрлэх арга хайж байна.

Бидний бодлоор хөдөө аж ахуйн үйл ажиллагааг техник технологийн ололтоох хангах үйлчилгээ нь зах зээлийн эрэлт

хэрэгцээгээр удирдуулж, улмаар ядуу фермерийн хэрэгцээнд мэдрэмжтэй хандах, фермерүүдийг мэдэллээр хангах бөгөөд нутгийн иргэдийн сонирхол мөн үзэл бодлыг засгийн газрын байгууллага, судалгааны ажил Өтухайлбал, ургамал үржил0 болон иргэдийн боловсролын асуудалтай холбох ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.

Шийдвэрлэвэл зохих хэцүү асуудал нь газар тариаланд тохиромжтой т-техникийн хангамж үйлчилгээний хөшүүргийг туршиж хөгжүүлэхэд оршино.

Төслийг хэрэгжүүлэх явцад анхан шатны үйлчилгээний ажилчид, судлаачид, үржүүлэгчид болон бодлогын ажилтнуудын үйл ажиллагааг хооронд нь уялдуулах аргаар тариачидтай хамтран газар тариалангийн үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах үйл ажиллагааны туршилт хийсэн. Цаашид эдгээр үйлчилгээний санхүү, орлого, зардал, ашиг, урамшуулал болон хууль журмын тогтолцоог бий болгох асуудлыг харгалзан хот, тосгон, мужийн түвшинд туршилт хийх шаардлагатай байна.

Тэмдэглэл

1. Энд өрхийн толгойлогч бол хэрэг дээрээ фермийн аж ахуй болон хөдөөгийн гэр ахуйн ажлыг удирдан зохион байгуулах хариуцлагыг үүрч хамгийн их цаг зарцуулдаг хүнийг хэлнэ. Бодит байдал дээр ихэнх өрхийг эмэгтэйчүүд толгойлж байгаа хэдий ч ихэнх тохиолдолд тэд нарын нөхрүүд өрхийн толгойлогчоор албан ёсоор бүртгэгдсэн хэвээр байдаг.

Эх Сурвалж

Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төв (1999). Хөдөө аж ахуйн ургамалыг хөгжүүлэх болон биологийн төрөл зүйлийг нэмэгдүүлэх бололцоог судлах: Хятадад үйлчилж буй үрийн албан болоод фермийн аж ахуйнуу-дын үрийн сүлжээ хоорондын холбоог бэхжүүлэх. Судалгааны төлөвлөгөө. Бээжин.
-(2003)Хөдөөний иргэдийн амжиргааг баталгаажуулах болон бодлогын өөрчлөлтүүд: Хятадын баруун өмнөд зүгийн Гуанши мужид: хамтлагийн!

- түвшинд хөдөө аж ахуйн ургамалыг хөгжүүлэх, байгалийн нөөцийн менежмент болон фермерт эрх олгож бололцоогоор хангах. Судалгааны төлөвлөгөө. Бээжин.
- Хуанг. Ж. (2003) Хүнсний аюулгүй байдлын асуудлыг дахин хэлэлцсэн тухай. Тайлан илтгэлийг хэлэлцүүлэхээр Засгийн газарт оруулсан тухай. Бээжин.
- Хуанг. К. (2000) Гуанши муж дахь эрлийз үрийн үржүүлэлтийг хөгжүүлэх тухай судалгаа болон түүний генетикийн сан буюу олон төрлийн дээж хоорондын холбоо. Гуаншийн хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний сэтгүүл. 36-39.
- Сон, Ю. (1998) «Шинэ» үр «хөгшин» Хятадад: Олон улсын эрдэнэ шиш болон улаан буудайг сайжруулах төвийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн Хятадын баруун өмнөд зүгийн нутагт эрдэнэ шиш ургуулах ажилд үзүүлэх нөлөө. Вейжнингений дээд сургууль болон судалгааны төв, Вейжнингсн.
- (2003) Албан тогтолцоо болон фермийн аж ахуйн сүлжээ: Хятадын баруун-өмнөд нутгийн эрдэнэ шишийн протоплазмд үзүүлэх нөлөө. С.Матур ба Д.Пачико. Хөдөө аж ахуйн судалгаа болон ядуурлыг бууруулах тухай зарим асуудал.173-89. Кали: Халуун бүсийн хөдөө аж ахуйн олон улсын төв.
- Сон, Ю. ба Ж.Жигинс (2002). Газар тариалангийн салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн тоо улам нэмэгдэж буй байдал. Хятадад эрдэнэ шишийг сайжруулах үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг татан оролцуулахуй.
- ЛЕЙСА 6-9.
- (2003). Эмэгтэйчүүд болон эрдэнэ шиш үржүүлэлт: Үрийн шинэ тогтолцоог баруун-өмнөд Хятадын алслагдсан нутагт хөгжүүлэх тухай. П.Л.Ховард, *Эмэгтэйчүүд болон тариалан: Биотөрөлжилтийн удирд-лага болон хадгалж хамгаалах үйл ажиллагааны жендэрийн харилцаа*. 273-88. Лондон, Нью-Йорк.
- Сон, Ю. ба Л.Зан (2004). Жендэрийн үнэлгээний тайлан: Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн үүрэг хариуцлагын Хятадын эмэгтэйчүүдэд үзүүлж буй нөлөө (1995-2003) болоод жендэрийн асуудлын үндсэн чиглэлийн гол утга. Тайлан. Бээжин.
- Сонг,И. ба Р.Верной (2003). Хятадын баруун өмнөд нутагт эрдэнэ шишийн үйлдвэрлэл болон тариачидын амжиргааг фермерүүдийн оролцоотойгоор сайжруулах. Газар тариалангийн судалгаа ба өргөжилтийн сүлжээ сэтгүүл, (7 сар):8.
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (2003). Хятад улс ДХБ-ад элсэх тухай дэлгэрэнгүй тайлан: Хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбар дахь эмэгтэйчүүдийн асуудал. Хамтарсан судалгааны тайлан. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Бүх Хятадын эмэгтэйчүүдийн холбоо, Үн-дэсний хөгжлийн болон шинэчлэлтийн комисс ба Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төв. Бээжин.
- Верной, Р. (2001). Ургац хураалт: Олон улсын хөгжлийн судалгааны төвөөс биологийн төрөл зүйлийн судалгаанд үзүүлэх дэмжлэг. Ажлын тайлан. Оттава.
- (2003).Ургамал үржүүлэлтийн ажилд тариачдыг оролцуулахуй. Оттава: Олон улсын хөгжлийн судалгааны төв. <http://www.idrc.ca/sccds>
- Верной, Р. ба Ю.Сонг (2003). Хятадад төрөлжилтийн үйл ажиллагааг тэмдэглэхүй. ЛЕЙСА,19(3): 36.
- Зан, Л. ба С.Лиү (2002) Газар эзэмшилтэй холбоотой жендэрийн болон шударга ёсны асуудал. Судалгааны материал. Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төв.

Бээжин.

- Зан Шихуанг, Пен Зебин ба Ли Чинхай (2000). Эрдэнэ шишийн олон төрөл ба протоплазмыг сайжруулах, хөгжүүлэхүй. Хятадын хөдөө аж ахуйн ухаан, 33: 34-39.
- Зү Линг (2000). Газар хувиарилалттай холбоотой жендэрийн болон шударга ёсны асуудал. Эдийн засгийн судалгаа, 9: 39-41.
- Зүо, Ж. ба Ю.Сон (2002). Эмэгтэйчүүдийн газар тариалангийн ажлын туршлага: Баруун-өмнөд Хятадын хоёр тосгонд хийсэн судалгаа. Бээжин: Кингхуагийн дээд сургууль (хятад хэл дээр)

6

ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

*Вьетнамын Хью мужийн уулархаг нутгийн
эмэгтэйчүүд болон ядуучуудын нийгмийн хөрөнгийг
бэхжүүлэх нь*



Зураг авсан: Ронный Верной

ХОАНГ ТИ СЕН, ЛИ ВАН АН

Бүс Нутаг Болон Шийдвэрлэх Асуудлууд

Газар тариалан Вьетнам улсын эдийн засгийн хамгийн чухал салбар хэвээр байна. Нийт хүн амын 70 гаруй хувь нь газар тариалан эрхэлж амьдралаа залгуулдаг бөгөөд цагаан будаа, кофе, каучук мөн газар тариалангийн бусад бүтээгдэхүүн экспортлож улсынхаа эдийн засагт хувь нэмэр оруулж байна. Дой мой хэмээх шинэчлэлтийн бодлогыг хэрэгжүүлж эхэлснээс хойш Вьетнамын эдийн засаг үлэмж өөрчлөгдсөн буюу жилийн дундаж өсөлт 1990-1997 оны хооронд 8 орчим хувьд хүрсэн байна.

1997 оны Азийн санхүүгийн хямрал нь тус улсын эдийн засагт ямар нэгэн хэмжээгээр нөлөөлсөн хэдий ч 1998 оноос хойш дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) жилд ойролцоогоор 6,5%-иар өсөж байна. Нэг хүнд ноогдох орлого 1994 онд 220 ам.доллар байсан бол 1997 онд 320 ам.долларт хүрч өнөөдрийн байдлаар 400 ам.доллар хүртэл өссөн билээ.

Макро эдийн засгийн түвшинд дэвшилт гарсан боловч ядуурал тогтвортой хэвээр буюу улс орныхоо хөгжилтэй холбоотой шийдвэрлэх асуудлууд хэвээр үлдсэн. Вьетнамд ойролцоогоор 80 сая хүн амьдардагаас 29,6 сая буюу 37% нь ядуурлын доод түвшнээс доогуур орлоготой бөгөөд ядуу бүлэгт тооцогддог байна. Вьетнамын хамгийн ядуу иргэд уулархаг нутагт амьдарч ажилладаг хөдөөгийн фермерүүд билээ. Үүний зэрэгцээ, хүн амын өсөлт, угсаатны цөөнх бүлгүүдийн олон янз уламжлалт соёлын үнэт зүйл буюу эдгээр бүлгүүд хоорондын харилцаанд үүсдэг хүндрэлүүд болон байгалийн нөөцийн доройтол зэрэг олон хүчин зүйл ядуу фермерүүдийн амьжиргааг тогтворжуулахад саад учруулдаг байна.

Вьетнамын нийт нутгийн бараг гуравны нэг нь уулархаг газар хийгээд энд 25 сая хүн амьдрахын зэрэгцээ улсын хэмжээнд нийт 54 угсаатны бүлэг байдгийн 50 нь мөн энд амьдарч байна.

Уулархаг нутгийн газар тариалан ашиг шим бага, ядуурал газар авсан бөгөөд шилжих хөдөлгөөны хэв маяг байнга өөрчлөгдөж байдаг бүтэц мөн Вьетнамд амьдардаг олон тооны үндэсний цөөнхтэй холбоотой эгзэгтэй асуудал зэрэг улсын ирээдүйн хөгжилд

сөргөөр нөлөөлж буй нийгэм болон хүрээлэн байгаа орчинтой холбоотой тулгамдсан асуудлын илэрхийлэл билээ.

Ядуурлыг бууруулах асуудлыг байгалийн нөөцийг хадгалах асуудалтай холбож шийдвэрлэх явдал уулархаг нутгийн хөгжлийн үндсэн асуудал болсон. Хөрс, ус, ой болоод бусад байгалийн нөөцийн тогтвортой удирдлага зөвхөн нутгийн хүмүүсийн хувьд бус, нийт улсын хэмжээнд гүн хямралд орсон. Туа Тиен Хью муж болон Вьетнамын төвийн нутгийн фермерүүдийн олон хамтлаг, тосгоны иргэдийн өмнө тулгарч буй хэцүү асуудлыг шийдвэрлэх зорилготойгоор Уулархаг нутгийн байгалийн нөөцийн нутгийн иргэдэд түшиглэсэн менежмент (CBUNRM) төслийг Хью мужийн дээд сургуульд Олон улсын хөгжлийн судалгааны төв (IDRC) болон Фордын сангийн дэмжлэгтэйгээр боловсруулсан байна. Төслийг Хьюгийн газар тариалан, ойн аж ахуйн дээд сургуулийн судалгааны баг бусад хамтрагч талууд хамт хэрэгжүүлж байна. Судалгааг Хонг Ха хамтлаг хэрэгжүүлэх сонголтыг нийгэм, эдийн засаг болоод тус нутгийн байгалийн нөөцийн өнөөгийн нөхцөл байдалд үндэслэсэн бөгөөд Хонг Ха дахь байдал Вьетнамын төвийн нутгийн олон хамтлагийн хувьд нийтлэг чанартай буюу уулархаг нутгийн бодит байдлыг харуулж чадна.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад бид ядуурал, бодлого ба байгалийн нөөцийн доройтол хоорондын холбоог улам сайн ойлгох, мөн түүнчлэн газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтолцоог боловсронгуй болгох, улмаар хүн, нийгэм ба байгалийн хөрөнгийг бий болгохыг зорьсон билээ. Жишээлбэл, ойн талаар баримтлах бодлогод гарч буй зарим өөрчлөлтүүдийг нутгийнхан дэмжиж байна. Орон нутгийн удирдлагууд, төслийн ажилтнууд болон тосгоны иргэдтэй уулзаж менежментийн асуудлаар хамтарсан тохиролцоонд хүрэх эсвэл гэрээ байгуулах боломжийн тухай хэлэлцсэн билээ. Төслийн ажлын нэгэн зорилго ядуучуудад үйлчилдэг бодлого боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Энэ ажилд дүүрэг, муж болон үндэсний хэмжээний бүх оролцогч талуудыг татан оролцуулах шаардлагатай байна. Уулархаг нутгийн байгалийн нөөцийн хамтлаг түшиглэсэн менежментийн (CBUNRM) төслийн

үндсэн зорилго уулархаг нутгийн фермерүүдийн хамтлагийн ядуу гишүүдийн амьжиргааны түвшнийг сайжруулах, фермерүүдийн янз бүрийн бүлгүүдийн болон хамтлагийн гишүүдийг оролцуулан хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ядуучуудын талаар бодлого болон хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд оршино.

Нутгийн иргэдэд түшиглэсэн бүс нутгийн онцлогт тохирох тогтвортой хөгжлийг бий болгох хүний чадавхийг хөгжүүлэх тогтолцоог бий болгох, хөгжүүлэх нь бидний ажлын цөм билээ.

Бид төслийн явцад харилцааны хэрэгсэлүүд болон оролцооны аргууд үүнд хөдөөгийн оролцоотой үнэлгээ, хяналт шинжилгээ, үнэлгээний аргууд ордог. Үүнээс гадна энэхүү үйл ажиллагаанд фермерүүдийн оролцоог бий болгож дээшлүүлэхэд анхаардаг. Бидний ажиглаж байгаагаар фермерүүд төслийн үйл ажиллагаанд улам идэвхтэй оролцож үүний үр дүнд шинэ арга барилд маш хурдан суралцаж байна. Фермерүүд судлаачдын итгэлийг хүлээхийн зэрэгцээ өгсөн санал зөвлөгөөг түргэн тусгаж авахын хамт өөрсдийн саналыг илүү нээлттэй, тодорхой илэрхийлж байв.

Уулархаг нутгийн үндэсний цөөнхийн дунд судалгааны ажлыг зарим фермерүүдтэй хамтран явуулах нь бусад фермерүүдийн сонирхолыг татдаг байна. Төслийн арга хэмжээг хэрэгжүүлэх явцад фермерүүд юу болж байгааг ажиглах бололцоотой учир тэд сайн ойлгож, санал бодлоо илэрхийлдэг байна. Энэ нь зөвхөн заавар, зөвлөгөө боловсруулж өгөхөөс илүү ашиг тустай байдаг. Оролцооны аргыг хэрэглэн фермерүүдийг төслийн үйл ажиллагаанд оролцуулах явдал эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг үүрэг болоод тэдний хэрэгцээнд анхаарал хандуулах бололцоог нээж өгдөг.

Эрэгтэйчүүд яриа дэлгэж байх хооронд эмэгтэйчүүд тариалангийн талбайд ихэнх ажлыг хийх тохиолдол олонтоо байдаг. Судалгааны үр дүнг тодорхойлж дүгнэлт хийхэд фермерүүдийг оролцуулах хэрэгтэй байдаг. Фермерүүдийн бүлгийн хурал, мөн түүнчлэн хөдөө аж ахуйд зохион байгуулдаг уулзалт фермерүүдэд өөртөө дүгнэлт хийх бололцоог өгдөг.

Бидний аргачлалын нэг гол тулгуур бол фермерүүдэд түшиглэсэн байр сууринаас хандах явдал. Энэ хандлага хамтлагийн

түвшинд хүний чадавхийг бий болгох боломжийг олгодог энэ нь фермер бүрт ашиг тустай бөгөөд олон хүн нутгийн удирдлагад итгэдэг болж байна. Чадалтай бөгөөд туршлагатай удирдагч үйл ажиллагаанд хамтлагийн гишүүдийн оролцоог бий болгоход хүчтэй нөлөөлдөг. Нийгмийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нөхцөлд хамтлагийн гишүүдийн уур амьсгал, улмаар судлаачид болон хамтлаг хоорондын харилцааг бэхжүүлдэг. Чадвартай удирдагч болон нэгдмэл зорилготой хамтлаг нь байгалийн нөөцийн асуудал эрхэлсэн засгийн газрын байгууллагатай хамтын менежментийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой урьдчилсан нөхцөл болдог.

Нийгэм, Жендэрийн Дүн Шинжилгээг Нутгийн Иргэдэд Түшиглэсэн Уулархаг Нутгийн Байгалийн Нөөцийн Менежментийн Судалгаанд Нэгтгэн Авч Үзэх Учир Шалтгаан

Дэлхийн олон оронд эмэгтэйчүүд мэдээлэл авах, сургалтанд хамрагдах болоод боловсрол эзэмших хязгаарлагдмал бололцоотой байдаг. Олон оронд энэ байдлыг шинжлэн үзэхэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд техник технологи нэвтрүүлэх үйлчилгээтэй холбоотой үйлчилгээний зөвхөн 5 хувийг эмэгтэйчүүд авдаг (FAO 1997). Меконг мөрний бэлчир хавийн фермерүүдийн үйл ажиллагааг шинжлэн үзэхэд нийт эмэгтэй ажилчдын 72 хувь нь хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрлөдөг бол 82 хувь нь өрхийн аж ахуйг хариуцан ажилладаг байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин доогуур байсан бөгөөд тусгай боловсролыг хангалттай хэмжээгээр авдаггүй байна (Луат нар 1992).

Нам дор газар амьдардаг эмэгтэйчүүдтэй харьцуулахад уулархаг нутгийн эмэгтэйчүүд мэдээлэл авах, техник, технологид суралцаж эзэмших бололцоо муутай байдаг. Энэ байдал олон зүйлээс шалтгаалдаг. Эмэг-тэйчүүд олон цагаар тариалангийн талбай болон гэртээ ажилладаг буюу тэдний боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс гол төлөв доогуур байдаг бөгөөд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн үүргийн талаарх уламжлалт ойлголт төсөөлөл нь эмэгтэйчүүдийг идэвхжүүлэх, улмаар гэрийн эсвэл хөдөө

аж ахуйгаас гадуурх үйл ажиллагаанд татан оролцуулахад саад учруулдаг байна.

Хонг Ха-д (Хоанг 2000) хийсэн судалгаагаар эмэгтэйчүүд гэрийн ажилд эрэгтэйчүүдээс 10 дахин их хугацаа зарцуулдаг болохыг харуулсан. Үүний зэрэгцээ эмэгтэйчүүд тариалангийн талбайд эрэгтэйчүүдээс илүү цаг ажилладаг хэдий ч шийдвэр гаргах түвшинд болон нөөцийн зарцуулалтыг хянахад бараг үүрэг гүйцэтгэдэггүй байна.

Засгийн газар болон хөдөөгийн хамтлагуудын боловсруулж хэрэгжүүлсэн хөгжлийн хөтөлбөрт нийгэм буюу жендэрийн хүчин зүйлүүд тусгагдаагүй болно. Уулархаг нутагт хэрэгжүүлсэн хөгжлийн олон хөтөлбөр дотроос зөвхөн цөөн тооны хөтөлбөрт эмэгтэйчүүдийн үүрэг болон хамтлагийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах чадавхид анхаарал хандуулсан байв. Ер нь хөгжлийн тухай шийдвэрүүдийг гол төлөв эрэгтэйчүүд гаргасан байдаг. Үүнтэй холбогдуулан эмэгтэйчүүд болон ядуучуудын чадавхийг бэхжүүлэх асуудлыг судалгааны төслийн хүрээнд хэрэгжүүлэх нэг гол зорилгоо болгов. Бидний үзсэнээр уулархаг нутгийн ядуу иргэдийн хөгжилд хувь нэмэр оруулах явдал тогтвортой хөгжлийн зонхилох хандлага мөн билээ.

Энэ бүлэгт дурьдсан нийгэм болон жендэрийн судалгааны (SAGA) зорилго нь судалгааны багийн чадавхийг бэхжүүлж, улмаар нийгэм болон жендэрийн судалгааг нутгийн иргэдэд түшиглэсэн уулархаг нутгийн байгалийн нөөцийн менежментийн төсөлтэй нэгтгэх, судлаачид болон хөгжлийн ажилтнуудыг фермерүүдтэй хамтран ажиллах явцад нийгэм ба жендэрийн судалгааны асуудалд мэдрэмжтэй хандаж байхыг сайшаах, мөн түүнчлэн эмэгтэйчүүд, ядуучуудад асуудлыг өөрсдөө шийдвэрлэхэд туслах, улмаар ядуурлыг бууруулах бөгөөд уулархаг нутгийн хамтлагийн тогтвортой хөгжилд нэмэр оруулахад оршино.

Бид дараах асуудлуудыг судлахаар тодорхойлов.

1. Судалгааны баг эмэгтэйчүүд, ядуучуудтай ажиллах хандлагыг яаж бэхжүүлж чадах вэ? Ядуучууд болон эмэгтэйчүүдийн чадавхийг ямар аргаар сайжруулах вэ?

2. Судлаачид болон орон нутгийн албаны хүмүүс ядуучууд болон эмэгтэйчүүдийн байдлын тухай мэдлэгээ дээшлүүлэх мөн байдлыг зөв тодорхойлох, төлөвлөгөө хийх, технологийн хөгжлийн ажлыг хамтлагийн хэмжээнд хэмжээнд зохион байгуулах чадавхийг эрчимтэй болгох бөгөөд газар тариалангийн өргөтгөлийн үйлчилгээг яаж боловсронгуй болгож чадах вэ?
3. Фермерүүдийн чадавхийг бэхжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээл юу вэ?
4. Тариачидын чадавхийг бэхжүүлснээр уулархаг нутгийн эмэгтэйчүүд болон ядуучуудын амьжиргаанд ямар нөлөө үзүүлэх вэ?

СУДАЛГААНЫ БҮС НУТАГ, СУДАЛГААНЫ БАГ БОЛОН ОРОН НУТГИЙН СУДАЛГАА

Судалгааны Бүс Нутаг

Төслийн ажлыг Вьетнамын Туа ТиенХью мужийн А Лүой тойргийн Хонг Ха болон Хүонг Нгүен хамтлагт хэрэгжүүлсэн. Хонг Ха болоод Хүонг Нгүен хамтлагууд А Лүой тойрогт байрладаг хамгийн ядуу 16 хамтлагийн хоёр нь бөгөөд улсын хэмжээнд ядуурлын үзүүлэлтээрээ ойролцоогоор 1200 хамгийн ядуу хамтлаг байгаагийн нэг нь болж байна. Хонг Ха-г судалгаа хийх анхны газар, Хүонг Нгүен бол судалгааны шинэ газар бөгөөд Хонг Ха-д зохион байгуулсан судалгааны үр дүнг янз бүрийн байгууллагатай, ялангуяа мужийн Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийн газартай (DARD) хамтран дүгнэж үнэлгээ өгөх бөгөөд тархаагдах болно.

Хоёр хамтлагийн нутгийн нийт талбай 47000 га. Газар нутгийн дийлэнх хэсгийг төр эзэмшиж, захирдаг. Хонг Ха-д хамтлагийн эдэлбэр газар болон хамтлагийн эргэн тойронд байгаа газрын дийлэнх хэсэг нь засгийн газрын агентлаг болох Бо голын цөөрмийн асуудал эрхэлсэн газраас хэрэгжүүлж буй «цөөрмийн хамгаалалт болон менежмент» үйл ажиллагаанд багтаж байна. Үнэн хэрэгтээ нутгийн иргэд газар тариалангийн зориулалтаар ашиглаж буй нийт

Зураг 6.1



Эх сурвалж: Вьетнамын судалгааны бүс

газрын зөвхөн 1 орчим хувийг боловсруулах хийгээд хянах эрхтэй аж. Газар тариалангийн газар нутгийн энэ хэмжээ маш бага бөгөөд гол төлөв, зөвхөн цагаан будаа, тэжээлийн ургамал ургуулдаг байна (Хүснэгт 6.1).

Хонг Ха болон Хуонг Нгуен нэгдлүүд Туа Тиен Хью мужийн уулархаг нутагт амьдардаг Ка Ти ба Та ой хэмээх үндэсний цөөнхийн бүлгийн төрөлх нутаг билээ (Хүснэгт 6.2).

Хүснэгт 6.1
Хонг Ха болон Хуонг Нгуений хамтлагуудын газар ашиглалт

Газар ашиглалт	Хонг Ха (га)	Хуонг Нгуен (га)
Нийт газар	14.100	32.590
Хөдөө аж ахуйн эдэлбэр газар	180	98
Нам дор газрын цагаан будаа	20	19
Уулархаг нутгийн будаа	50	27
Тэжээлийн ургамал	70	15
Хөдөө аж ахуйн бусад зориулалттай газар	40	37
Ой	11.000	18.914
Унаган ой	10.200	18.800
Тариалсан газар	765	114
Ашиглагдаагүй газар	2.950	13.419

Эх сурвалж: Уулархаг нутгийн нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент төслийн судалгааны мэдээлэл, 2002

Хүснэгт 6.2
Хонг Ха болон Хуонг Нгуений хамтлагуудын хүн ам

Хүн амын бүлэг	Хонг Ха	Хуонг Нгуен
Нийт хүн ам	1.266	1.050
Ка Ту	609	998
Та Ой (Пако болон Пахи бүлгүүдийг оролцуулан)	520	3
Кинх (нам дор газрын оршин суугчид)	137	49

Эх сурвалж: Уулархаг нутгийн нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент төслийн судалгааны мэдээлэл, 2002

Нутгийн хүмүүсийн амьжиргаа газар тариалангаас ихээхэн хамаардаг буюу ургуулсан бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг өрхийн хэрэглээнд зориулдаг. Газар тариаланд «хадах-шатаах» арга уламжлагдаж ирсэн боловч газар ховордохоос гадна Засгийн газраас дээрх аргыг хориглох бодлого хэрэгжүүлсний нөлөөнд хөдөө аж ахуйг эрхлэх «суурин» арга өргөн дэлгэрч байна. «Суурин» хөдөө аж ахуйд шилжихтэй холбогдуулан фермерүүд олон эгзэгтэй асуудалтай тулгарч байна.

Гол нь шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой техникийн мэдлэггүй, шинэ технологи эзэмших боломжоор хомс бөгөөд хөрс боловсруулалтын менежментийн мэдлэггүй зэрэг бэрхшээлийн улмаас газар тариалангийн үйлдвэрлэл ашиг шим багатай байдаг.

Анхаарал хандуулах чухал зүйл бол Хүонг Нгүен хамтлаг Засгийн газрын хөтөлбөрийн дагуу шинээр нүүж ирсэн тариачид тус хамтлагийн нутагт суурьшаад дөнгөж 10 жилийн нүүрийг үзэж байна. Урьд нь Хүонг Нгүен тосгоныхон алслагдсан буюу хүрч очиход нэн бэрхшээлтэй Вьетнам, Лаосын хилийн ойролцоох ойгоор маш баялаг уулын хөндийд амьдардаг байсан юм. Тариачидыг нүүлгэн шилжүүлэхдээ үр шимгүй императа хэмээх нуга буюу сул газарт нүүлгэн суурьшуулсан бөгөөд тус газрыг тариалангийн талбай болгон өөрчлөн засах шаардлагатай байсан бөгөөд энэ нь удаан үргэлжилсэн хүнд ажил байв. Фермерүүдийг шинэ газар амьдралаа эхлэхэд туслалцаа үзүүлж ажлын багаж хэрэгсэл, мөн түүнчлэн хүнсний бүтээгдэхүүнээр хангаж байв. Иймд дайны дараа төрсөн нутагтаа эргэж ирсэн Хонг Ха тосгоны иргэдээс ялгаатай нь Хүонг Нгүен хамтлагийнхан албадах аргаар шилжиж нутагласан байна. Хамтлагийн фермерүүдийн хөрөнгө чинээний байдлыг хүснэгт 6.3-т харуулсан болно.

Хүснэгт 6.3
Хамтлагийн өрхүүдийн хөрөнгө чинээний байдал

Нийгэм эдийн засгийн бүлгүүд	Хонг Ха	Хүонг Нгүен
Нийт өрхүүд	243	185
Баян	1	4
Дунд	123	21
Ядуу	30	65
Нэн ядуу	92	95

Эх сурвалж: Уулархаг нутгийн нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент төслийн судалгааны мэдээлэл, 2002

Тэмдэглэл: *Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас боловсруулсан үзүүлэлтүүдийн хүрээнд 15000 вьетнамын донг (VND) 1 ам доллар (USD)); Баячуудын сарын орлого 100000 дээш VND/хүн, дундаж амьдралтай өрхийн сарын орлого 80000-10000 VND/хүн, ядуучуудын сарын орлого 55000 VND/хүн, нэн ядуу өрхийн сарын орлого 55000 VND/хүн-ээс доош

Судалгааны багийг бүрдүүлэх болон орон нутгийн судалгаа

Төслийн хүрээнд нэн түрүүнд шийдвэрлэх асуудал нь фермерүүдийн хамтлагт судалгааны ажлыг хэрэгжүүлэх бөгөөд энэ зорилгоор нийгэм болон жендэрийн судалгааны баг байгуулсан болно. Багийн бүрэлдэхүүнд Хьюгийн хөдөө аж ахуй болон ойн аж ахуйн дээд сургуулийн мал аж ахуй, агрономи, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуй болоод усны аж ахуйн мэргэжлийн багш нар мөн эдийн засгийн дээд сургуулийн газар тариалангийн эдийн засгийн буюу бодлогын асуудлаар мэргэшсэн багш нар, шинжлэх ухааны дээд сургуулийн нийгэм судлалын сургалт хариуцсан багш нар уригдаж орсон билээ. Тус баг нь хөгжлийн хөтөлбөрийн ажилтнууд болон хамтлагийн удирдлагуудын хамт нийгэм, жендэрийн судалгааг нутгийн иргэдэд түшиглэсэн уулархаг нутгийн байгалийн нөөцийн менежмент төслийн үйл ажиллагаатай нэгтгэх судалгааны хүрээг боловсруулж нэвтрүүлсэн. Ялангуяа нэн ядуу фермерүүдийн байдлыг сайтар ойлгох, тэдэнтэй хамтран ажиллах үүднээс судалгааны гол асуудлыг нийгэм, жендэрийн судалгааг гүнзгийрүүлэхэд чиглүүлэн улам боловсронгуй болгосон билээ. Мөн түүнчлэн, бид хөгжлийн асуудал эрхэлсэн янз бүрийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагааг сайтар ойлгох, хамтран ажиллахыг эрмэлзэж ирсэн.

Эрэгтэй болон эмэгтэй фермерүүд мөн бусад оролцогч талуудыг судалгааны бүхий л явцад татан оролцуулах нь хүндрэлтэй байв. Учир нь хамтлагийн гишүүд «дээрээс доош» хандлагад илүүтэй дассан байна. Ер нь судлаачид судалгааны туршид санаачилгыг гартаа авч удирддаг, тухайлбал, шийдвэрлэх асуудлыг тодорхойлох, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх хийгээд гаргасан шийдвэрт үнцэлэлт дүгнэлт өгдөг байна. Харин фермерүүдийн оролцоо чамлахаар түвшинд байдаг эсвэл огт оролцдоггүй аж. Нутгийн иргэдийг төслийн ажилд идэвхтэй оролцуулахын тул оролцооны олон аргууд хэрэглэхийг тухайлбал тоон болон чанарын судалгааны аргуудыг хэрэглэхийг шаарддаг. Нутгийн иргэдэд суралцах бололцоо олгож тэвчээртэй хандах

шаардлагатай байдаг. Фермерүүдийн бодит хэрэгцээг хангах, мөн түүнчлэн тэдний өөрөө өөртөө итгэх итгэлийг дээшлүүлэх явдал фермерүүдийн чадавхийг бэхжүүлэх үндсэн нөхцөл билээ.

Нийгэм болон жендэрийн судалгааны онол, үзэл хандлагыг танилцуулах, мэтгэлцэх зорилготойгоор цуврал сургалт зохион байгуулав. Сургалтыг урд нь фермерүүдийг оролцуулан хэрэгжүүлж байсан оролцооны судалгааны ойлголт мэдлэг болон фермерүүдийн газар тариалангийн техник, хэрэгсэл эзэмших чадварын талаар хуримтлуулсан туршлага, мэдлэг дээр үндэслэн боловсруулсан болно.

Сургалтанд орон нутгийн удирдагчид, судлаачид болоод хөгжлийн асуудал эрхэлсэн ажилтнууд оролцсон. Фермерүүдийн хамтлагийн түвшинд хамтлагийн ахлагч, орон нутгийн байгууллагуудын дарга нар, тухайлбал эмэгтэйчүүдийн холбоо, фермерүүдийн эвлэл мөн тосгодын удирдагчид хүрэлцэн ирсэн байв. Үүнээс гадна нийгмийн ухаан, улс төр судлал болон жендэрийн шинжээчид уригдан ирж сургалтын ажилд дэмжлэг үзүүлсэн.

Нийгэм болон жендэрийн судалгааны арга зүйд оролцооны ажиглалт, хөдөөгийн оролцоотой үнэлгээ, асуулга болон оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээний аргууд багтдаг.

Фермерүүдийн хэрэгцээ бөгөөд чадвар янз бүр байдгаас эмэгтэйчүүд болон ядуу фермерүүдэд юу хэрэгтэй, юу хийж чаддагийг тодорхойлохын тулд хамтран ажилласан болно. Төслийн багийнхны дэмжлэгтэйгээр фермерүүд суралцах бүлгүүд байгуулан хөдөө аж ахуйг боловсронгуй болгох зорилготойгоор хамтлагийн гишүүдийн үйл ажиллагаа болон хүсэл, сонирхолын тухай мэдээлэл цуглуулдаг. Эдгээр бүлгүүд цагаан будаа, тэжээлийн ургамал мөн өрхийн ногооны талбайн ургац, загас ба гахайны аж ахуйн асуудлаар мэдээлэл солилцдог аж. Хамтлагт нэгдсэн фермерүүдийн хүсэл, сонирхол өргөн хүрээтэй байдаг тул тухайн фермерийн хувьд өөрийн бүтээгдэхүүн илүү өргөн хүрээтэй үйл ажиллагаатай хөдөө аж ахуйн тогтолцоонд нэвтрэн орох бололцоог нээж өгдөг. Өөрөөр хэлбэл, фермерүүдийн янз бүрийн хэрэгцээ,

сонирхол эрмэлзлийн дагуу янз бүрийн сонирхлын бүлгүүд байгуулагдсан болно.

Төслийн хүрээнд нийт өрхийн 15 хувийг хөдөөгийн оролцоотой үнэлгээний судалгаанд хамруулж янз бүрийн нийгмийн давхаргыг төлөөлсөн нийт 60 өрхийг ярилцлагын судалгаанд хамруулж өрхийн амьжиргааны талаар мэдээлэл цуглуулав. Мөн түүнчлэн, фермерүүдийн хамтлагийн ахлагч, эмэгтэйчүүдийн холбооны төлөөлөгчид, фермерүүдийн нийгэмлэгийн удирдагчид болон жижиг тосгоны удирдлагуудыг ганцаарчилсан ярилцлагад хамруулсан. Үүний зэрэгцээ судалгааны гол сэдэв, асуудлаар төслийн судалгаанд хамрагдаж буй өрхүүдийн дунд ганцаарчилсан ярилцлагын судалгааг явуулсан.

Судалгааг хэрэгжүүлэх явцад оролцооны хяналт шинжилгээ үнэлгээг ашиглан оролцооны үйл явц болон үр дүнгээ үнэлэх ажлыг фермерүүдтэй хамтран гүйцэтгэж ирсэн. Холбогдох тоо баримт, дүгнэлтийг бичиж тэмдэглэн оролцогч талуудтай санал хуваалцсан билээ.

Эмэгтэйчүүд болон ядуучуудыг технологи болон үйлдвэрлэлийн бусад зардлыг, тухайлбал, үйлдвэрлэлийн талаар мэдлэгээс хүртэх боломжийг хэмжих шалгууруудыг боловсруулсан. Судалгаанд хамрагдсан тосгонд судалгааны үр дүнг хэлэлцэх зорилгоор хэлэлцэх зорилготойгоор нутгийн иргэд, судлаачид, шинэ техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйлчилгээ, сургалт хариуцдаг ажилтнуудыг оролцуулан 2 удаагийн семинарыг зохион байгуулсан болно.

3. Уламжлалт Техник Технологийг Нэвтрүүлэх

Уулархаг нутгийн иргэдийн эрхэлж буй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлдэд шинжлэх ухааны ололт, техник технологийг нэвтрүүлэх арга хэрэгслүүд

Сургалт болон судалгааны шугамаар судалгааны бүс нутагт туршлага солилцох уулзалт, хөдөө аж ахуйд шинэ техник

технологи нэвтрүүлэх асуудлыг танилцуулах тухай орон нутгийн телевизийн хөтөлбөр нь уулархаг нутгийн хамтлагийн гишүүдийн хувьд мэдээлэл болон мэдлэг олж авах гол эх үүсвэр болдог. Сургалт болон судалгааны хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа мөн уулзалтын явцад орон нутгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, тухайлбал, мал аж ахуй, хөдөө аж ахуйн ургамалын үйлдвэрлэл болон ойн аж ахуйн техник, технологид анхаарлаа төвлөрүүлж байв. Зээлийн үйлчилгээний тухай, эрүүл мэнд болон боловсролын тухай хамгийн чухал мэдээллээр маш дутагддаг. Эмэгтэйчүүдийн холбоо гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээлэл түгээдэг байна. Сургалтанд хамрагдах боломж нийгмийн давхарга бүрт ялгаатай байда бөгөөд ядуучуудыг дунд болон баян чинээлэг өрхтэй харьцуулахад энэхүү боломж бололцоо нь илүү хязгаарлагдмал байна (Хүснэгт 6.4)

Эрэгтэйчүүд болоод эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаар эрэгтэй фермерүүд техникийн сургалтанд илүү анхаарал хандуулж байхад эмэгтэйчүүд гол төлөв бүтээгдэхүүний гарц ихтэй үйлдвэрлэлийг их сонирхож, ийм төрлийн сургалтанд илүү цаг зарцуулж байсан. Сургалтанд хамрагдах боломжийн хувьд айл өрхийн дунд мөн адил ялгаатай байдаг. Ядуу өрхөд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг бодвол, сургалтанд хамрагдах бололцоо муутай байдаг (Зураг 6.2) бөгөөд хэрэв эрэгтэйчүүд тосгоны хамтлагийн байранд эсвэл гэрээс зайдуу газар сургалтанд явдаг бол эмэгтэйчүүд нь ихэнх тохиолдолд тосгондоо хичээллэдэг байна. Үүнээс гадна, сургалтанд гол төлөв эрэгтэй фермерүүд оролцдог.


Хүснэгт 6.4

Хоёр хамтлагийн чинээлэг ангилалын өрхийн сургалтанд хамрагдалтын боломж

Нийгмийн бүлгүүд	Баян	Дунд	Ядуу
Ярилцлагад хамрагдсан өрхүүдийн тоо	10	19	34
Сургалтанд хамрагдсан өрхүүдийн тоо	7	19	22
Хувь	70	100	65

Эх сурвалж: Уулархаг нутгийн нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент төслийн судалгааны мэдээлэл, 2003

Зураг 6.2
Сургалтанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувь



Эх сурвалж: Уулархаг нутгийн нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент төслийн судалгааны мэдээлэл, 2003

Эмэгтэйчүүдээс авсан ярилцлагын үеэр эмэгтэй фермерүүд гэрийн ажлыг дангаараа үүрдэг байхад сургалт болон туршлага судлах үйл ажиллагаанд эрэгтэйчүүд оролцдог тухай ярьж байсан. Нутгийн удирдлага болон сургалт, туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулагчид энэ байдлыг өөрчлөхөд анхаарал хандуулахгүй байгаагаа эрэгтэйчүүд эмэгтэй фермерүүдээс илүү сайн сурдаг учир энэ нь эрэгтэйчүүдийг сургалтанд хамруулах гол шалтгаан болдог гэж тайлбарладаг аж.

Бидний хийсэн судалгаагаар нийт ядуу бүлгийн эмэгтэйчүүдийн 30 хувь нь, нийгмийн дунд давхаргын эмэгтэйчүүдийн 36 хувь нь сургалтанд хамрагдаж байна. Баян фермер эмэгтэйчүүдийн боловсролын түвшин илүү байдаг тул эрэгтэйчүүдтэй адил эрхтэйгээр сургалтанд хамрагддаг байна. Ялангуяа, эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулдаг сургалтанд оролцох боломж илүү байдаг.


Сургалтын уламжлалт арга

Фермерүүдийн өгүүлснээр сургалт нь тэдэнд чухал ач холбогдолтой байдаг. Учир нь хамтлагийн түвшинд үйлдвэрлэлийн тогтолцоо хөгжиж, тогтворгүй газар тариалангаас тогтвортой хөдөө аж ахуйд шилжиж байна. Фермерүүд сургалтанд оролцох их эрмэлзэлтэй байдаг ч нэг хэвийн сургалтаас олж авсан мэдлэг санаснаас бага байдаг гэж үзсэн. Хөдөөгийн оролцоотой сургалтын үеэр эмэгтэй, эрэгтэй фермерүүд өөр хоорондоо туршлага солилцох болон тэд бүтээгдэхүүн хийх аргын талаар тусгай сургалтанд хамрагдах сонирхолтой бөгөөд мөн фермерүүд болон судлаачид тариалангийн талбайд хамт ажиллах нөхцөлд их зүйлийг түргэн, хялбар сурах буюу туршлага хуримтлуулж чадах тухай ярьж байсан. Тосгоны иргэдэд зориулж зохион байгуулсан сургалт нь хөдөө аж ахуйн ургамалын хамгийн чухал олон нэр төрлийг урьдаас зааж өгдөг. Нөгөөтэйгүүр, засгийн газрын байгууллагуудаас хэрэгжүүлдэг сургалтын үеэр зөвхөн тодорхой тооны нэр төрлийн бүтээгдэхүүнийг тухайлбал, чихрийн нишингэ, каучук мөн өндөр ургац бүхий хөдөө аж ахуйн ургамалын үйлдвэрлэлийн тухай санал дэвшүүлж танилцуулдаг. Өөрөөр хэлбэл, энэ сургалтыг орон нутгийн бус хүмүүс санаачилж хэрэгжүүлсэн бөгөөд тодорхой барааны үйлдвэрлэлд чиглэгдсэн буюу засгийн газраас санаачилсан төслийг дэмжихэд зориулагдсан билээ. Иймд ярилцлага өгсөн нийт фермерүүдийн зөвхөн 34 хувь нь эдгээр бүтээгдэхүүний технологийг нэвтрүүлэх сонирхолтой байсан.

Нэг загварын сургалтын аргын дагуу лекцийг тариалангийн талбай болон фермерүүдийн гэрээс хол, хамтлагийн хурлын танхимд зохион байгуулдаг аж. Сургалтын хөтөлбөрийг гол төлөв хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд техник технологи нэвтрүүлэх ажил үйлчилгээг хариуцдаг ажилтнууд бэлддэг бөгөөд сургалтын материалыг ном, сурах бичгийг ашиглах буюу эсвэл судлаачид боловсруулдаг байна. Сургалт болон уулзалтыг засгийн газрын хөтөлбөрт заасан үзүүлэлтийг үндэслэн зохион байгуулдаг (Зураг 6.3) Бүлгийн гишүүдийн дунд эсвэл бүлгүүдийн хооронд мэтгэлцээн,

ярилцлага зохион байгуулдаг бөгөөд харин үзүүлэн таниулах аргыг маш хязгаарлагдмал хэрэглэдэг буюу нийт сургалтын зөвхөн 5 орчим хувь нь дүрс бичлэгийн хэрэгсэл ашигладаг эсвэл бүлгийн ярилцлага, мэтгэлцээн явуулдаг байна.

Зураг 6.3
Сургалтын сэдвүүдийн талаар шийдвэр гаргасан эх сурвалжууд



Эх сурвалж: Уулархаг нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент төслийн судалгааны мэдээлэл, 2003

Албаны хүмүүс болоод орон нутгийн удирдлагуудын үзэж байгаагаар хөдөөгийн нөхцөлд агуулгын хувьд нэг загварын буюу ердийн сургалт хамгийн тохиромжтой. Тэд фермерүүд сургалтаар заалгасан зүйлийг жишээлбэл цагаан будаа болон эрдэнэ шишийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлж чадна гэв. Харин фермерүүд ярилцлага өгөхдөө сургалтын хугацаа маш богино бөгөөд багш нар сургалтыг түргэн дуусгаад хот уруу буцах гэж яардаг байна. Үүний зэрэгцээ, хэлний бэрхшээл хийгээд багш нарын боловсролын түвшин доогуур байдгаас нутгийн иргэдэд хичээлийн сэдвийг ойлгоход бэрхшээлтэй байдаг гэжээ.

Орон нутгийн удирдлагууд ба хөдөө аж ахуйд техник технологийн үйлчилгээ, сургалтыг зохион байгуулдаг ажилтнуудын нийгэм болон жендэрийн асуудлаарх ойлголт төсөөлөл

Нутгийн иргэд болон хамтлагийн ахлагч нарын үзэж байгаагаар уламжлалт сургалт нь фермерүүдийн хамт технологийг боловсронгуй болгох явцад нийгэм болон жендэрийн мэдрэмжтэй байдлыг харгалздаггүй байна. Хөдөө аж ахуйд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх, шинж техник технологи нэвтрүүлэх үйлчилгээ эрхэлдэг хүмүүстэй хийсэн ярилцлагаар зохион байгуулсан арга хэмжээнүүд улсаас хэрэгжүүлж буй хөтөлбөрт үндэслэсэн бөгөөд нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцдэг тухай батлан хэлж байсан. Мөн түүнчлэн, нутгийн хүмүүсийн амьжиргаатай холбоотой эгзэгтэй асуудлуудыг ч судалсан байна. Хөдөө аж ахуйд технологи нэвтрүүлэх үйлчилгээ эрхэлдэг ажилтнуудын үзэж байгаагаар хүмүүсийн хүйс, нас болон эдийн засгийн байдал сургалтын үр ашигт нөлөөлдөг. Гэвч хэрэг дээрээ тэд таамаглал дээр үндэслэн ажилладаг буюу зөвхөн чинээлэг фермерүүд сургалтанд цаг зарцуулж сургалтын хүрээнд танилцуулсан технологийг аж ахуйдаа нэвтрүүлэх чадалтай гэж үздэг. Нутгийн иргэд ч энэ үзэл бодолд захирагддаг байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд технологи нэвтрүүлэх үйлчилгээ эрхлэгчид сургалт болон хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож буй нутгийн иргэдийн хүйс, нас болон эдийн засгийн байдлыг огт сонирхож байсангүй. Тэд өөрсдийн дээдэлдэг технологийг боловсронгуй болгох ажилд гол төлөв баян фермерүүдтэй хамтардаг байна.

Орон нутгийн удирдлагууд сургалтын үйл ажиллагаанд шууд оролцдоггүй ч технологи нэвтрүүлэх сургалт, үйлчилгээг зохион байгуулагчдад оролцох фермерүүдийг сонгох, сургалт явуулах анги танхимаар хангахад дэмжлэг үзүүлдэг. Бид хамтлагийн удирдах зөвлөл, эмэгтэйчүүдийн болон фермерүүдийн нийгэмлэгийн төлөөлөгчидтэй гүнзгийрүүлсэн болон ганцаарчилсан ярилцлага хийсэн. Ярилцлагад хамрагдсан нийт удирдлагууд зөвхөн тосгоны хамтлагийн өндөр боловсролтой буюу үйлдвэрийн туршлагатай албаны хүмүүс болон айл өрхийн гишүүд сургалтын сэдвийг ойлгох чадалтай гэжээ. Зарим удирдах хүмүүсийн үзэж байгаагаар эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү мэдлэгтэй учраас сургалт болон мэтгэлцээний үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийг

сонгож оролцуулахыг илүүд үздэг, улмаар сургалтанд хамрагдсан эрэгтэйчүүд тосгоны бусад фермерүүд мөн эхнэрүүдээ сургах ажээ.

Гэвч бидний хийсэн жендэрийн судалгаагаар ихэвчлэн эмэгтэйчүүд газар тариалан болон хөдөө аж ахуйн бусад ажлыг гүйцэтгэж эрэгтэйчүүдээс илүү цагаар хөдөлмөрлөдөг байна. Энэ бодит байдлыг сургалтын үйл ажиллагаа болон орон нутгийн хөдөө аж ахуйн салбарыг боловсронгуй болгон хөгжүүлэхэд үл хэрэгсдэг билээ.

Ер нь хийгээд Орон нутгийн удирдлагуудын болон хөдөө аж ахуйд техник технологи нэвтрүүлэх сургалт, үйлчилгээ эрхэлдэг ажилтнуудын нийгэм болон жендэрийн асуудалд мэдрэмжит байдал болон мэдлэг хязгаарлагдмал хэвээр байна. Иймд хүмүүсийн чадварыг нийгмийн бүх шатанд нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Эмэгтэйчүүд Ба Ядуучуудын Хүний Нөөц Болон Нийгмийн Чадавхийг Бэхжүүлэхүй

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь нутгийн иргэдэд түшиглэсэн уулархаг нутгийн байгалийн нөөцийн менежмент болон хөдөөний хүмүүсийн аж амьдралын нэг хэсэг билээ. Уулархаг нутгийн үйлдвэрлэлийн нэгдсэн тогтолцоо дахь байгалийн нөөцийн менежментийг, өөрөөр хэлбэл хувийн болон дундын эзэмшлийн байгалийн нөөцийн менежментийг боловсронгуй болгох шаардлагатай байна. Тухайлбал, байгалийн нөөцөөс хүртэх буюу эзэмших эрхийн асуудлыг шийдвэрлэх нь ядуурлыг бууруулах чухал ач холбогдолтой арга хэмжээ билээ. Байгалийн янз бүрийн нөөцийг эзэмших бололцоотой болсноор нутгийн хүмүүс болоод хамтлагууд хувийн амьдрал, аж ахуйн үйл ажиллагааг хянах, нийгэм эдийн засгийн байдлаа сайжруулах өргөн сонголттой болох, улмаар нутгийн иргэд нийгмийн амьдралд ач холбогдол бүхий үр өгөөжтэй оролцох болно. Жишээ болгон дурьдахад, зээлийн болон мөнгөн хадгаламжийн үйлчилгээ зэрэг санхүүгийн үйлчилгээнд хамрагдах, ой болон мод бэлтгэлээс бусад байгалийн нөөц, газар, мал зэрэг байгалийн нөөцөөс хүртэх, нийгмийн үйлчилгээний

хувьд фермерүүдийн хамтлагийн түвшинд эсвэл тогсоны нутгийн иргэдийн хооронд үр ашигтай харилцаа болон зохион байгуулалтыг бий болгох, хүний нөөцийг хөгжүүлэх үүнд төрөл бүрийн үйлчилгээ, зах зээл, эрүүл мэнд буюу нийгэм эдийн засгийн бусад бололцоог ашиглах үүднээс мэдлэг чадвараа дээшлүүлэх хэрэгтэй байна.

Уулархаг нутагт амьдардаг фермерүүдэд гол төлөв ийм бололцоо байдаггүй. Амьдралын ядуу байдал хүмүүсийг итгэл багатай болгодог бөгөөд тэдний боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон засгийн газрын бусад хөтөлбөрт хамрагдах боломжийг эрс багасгадаг байна.

Бидний хэрэгжүүлж буй төслийн хүрээнд нутгийн хүмүүстэй хамт ажиллаж тэдний бодит байдлыг ойлгох, орон нутгийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх бөгөөд тосгоны хамтлагийн түвшинд хүн нэг бүрийг хөгжүүлэх бололцоог бий болгоход чиглэгдсэн. Хамтлагийн удирдах зөвлөл, фермерүүдийн болон эмэгтэйчүүдийн холбоо нь тосгоны хамтлагийн түвшинд нийгмийн асуудал эрхэлдэг буюу олон нийтийн ашиг сонирхолыг төлөөлж байдаг. Эдгээр байгууллагууд болон фермерүүд, ядуучуудын хооронд олон жилийн өмнөөс харилцаа тогтсон аж.

төслийн шугмаар 3 байгууллагад дэмжлэг үзүүлж маш нягт хамтран ажилласан болно. Бид олон удаагийн уулзалтаар олон нийтийн 3 байгууллагын үүрэг, хариуцлага, ажлын чиглэл, мөн түүнчлэн сайн буюу сул талыг нь мэддэг болсон бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг цаашид бэхжүүлэх, эрх зүйн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн хөгжлийн төлөвлөгөөг хамтран боловсруулав.

Нийгэм болон жендэрийн сургалт

Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтыг эрэгтэй болон эмэгтэй фермерүүд маш өндөр үнэлсэн билээ. Нийгэм болон жендэрийн сургалтыг хамтлагийн ахлагч, олон нийтийн байгууллагын төлөөлөгч мөн тосгоны ахлагч нарт зориулж зохион байгуулсан. Сургалтанд оролцогсод эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн үүрэг, аж ахуйн үйл ажиллагааг хамтлаг болон өрх нэг бүрээр судалсан билээ. Холбогдох сургалтыг хөдөө аж ахуйд

техник технологи нэвтрүүлэх үйлчилгээний ажилтнууд, судлаачдын дунд явуулсан. Сургалтыг зохион байгуулахад нийгэм болон жендэрийн шинжээчидийг урьж оролцуулсан.

Фермерүүдийн дунд сонирхлын бүлэг байгуулж дэмжлэг үзүүлэх нь

Энэхүү үйл ажиллагааг фермерүүдийн бүлгийн дотор бүлгийн ярилцлага, оюун ухаанаа уралдуулан сэтгэх аргаар нутгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хэрэгцээ ба сонирхолыг тодорхойлох ажлаар хэрэгжүүлж эхлэв. Үүний дагуу ижил сонирхолтой фермерүүдийг урьж жижиг бүлэг бүрдүүлсэн бөгөөд өөрсдийн хэрэгцээ, ашиглаж болох боломжийг тодорхойлох, улмаар амьдралаа дээшлүүлэх аргыг боловсронгуй болгохыг хамтран шийдвэрлэхэд суралцсан билээ. Ижил сонирхолтой фермерүүдийг нэгтгэж дараах бүлгүүдийг бүрдүүлэв:

1. **Цагаан будааны үйлдвэрлэлийн бүлэг.** Олон эмэгтэй болон эрэгтэй фермерүүд хүнсний аюулгүй байдлыг бий болгохын тулд усархаг хөрсний цагаан будааны үйлдвэрлэлийг сонирхож байсан. Энэ ажил фермерүүдийн нэгдүгээрт шийдвэрлэх асуудал билээ. Тосгонд энэ чиглэлийн хоёр бүлэг байгуулсан.
2. **Загас үржүүлэлтийн бүлэг.** Цөөрөм эзэмшдэг бөгөөд хөрөнгө оруулалт хийх болон үйлдвэрлэлийн менежментийг боловсронгуй болгоход хөрөнгийн бололцоогүй 10 ядуу фермер нэгдэж бүлэг байгуулав.
3. **Гахай үржүүлэлтийн бүлэг.** Эмэгтэйчүүдийн байгуулсан энэ бүлэгт нийт 20 фермер нэгдсэн бол хоёр жилийн дотор гишүүний тоо 48 хүртэл нэмэгдэв.
4. **Хүнсний ногоо болон тэжээлийн ургамал үйлдвэрлэлийн бүлэг.** Олон ядуу фермер хөдөө аж ахуйн эдгээр ургамалыг үржүүлэхийг сонирхож, улмаар шинэ нэр төрлийн ургамалыг турших болон үйлдвэрлэлийн менежментийг, тухайлбал, ургац хураалтын дараах арчилгааг боловсронгуй

болгох зорилготойгоор нэг бүлэгт нэгдэн орсон болно.

5. **Өрхийн ногооны цэцэрлэг хөгжүүлэх бүлэг.** Энэ бүлэгт 17 фермер хамтран ажиллаж, улмаар олонд нэртэй болж одоогоор нийт 60 гишүүнтэй байна.

Цаашид бид сургалтын үр дүн болон цагаан будааны үйлдвэрлэл мөн гахайны үржлийн бүлгүүдтэй хамтарч ажилласан тухай танилцуулах болно. Вьетнамын олон нутагт фермерүүдийн хувьд цагаан будаа өргөн хэрэглээний хамгийн чухал бараа хэвээр байна. Эмэгтэй фермерүүд гахай үржүүлэх ажлыг бэлэн мөнгөний өндөр орлого оруулдаг гэж үздэг байна. Тэд их хэмжээний мөнгөөр гэрт нь хэн нэгэн өвдсөн үед эмнэлгийн тусламж авах эсвэл эм, мөн түүнчлэн сургуулийн ном, бусад хэрэгсэл худалдан авах бололцоотой болдог.

Тосгоны хүмүүс цөхөрсөн байдалд орсон нөхцөлд гол төлөв нийгмийн байгууллагад итгэж ханддаг боловч их хэмжээний мөнгөн орлого эмэгтэйчүүдийн хувьд онцгой чухал ач холбогдолтой байдаг.

Цагаан будааны үйлдвэрлэлийн бүлэг. Бүлэг бүрт эхэндээ нийт 15 фермер нэгдэж орсон. Бүлгүүдийн гишүүд урьд нь тулгарч байсан хэцүү асуудлуудын тухай хоорондоо санал солилцож ярилцсан бөгөөд шийдвэрлэж болох арга замыг сонгон тохиролцож байв. Төслийн багийнхан шинжлэх ухааны болон техникийн мэдлэгээ нутгийн фермерүүдийн туршлага, уламжлалт мэдлэгт нэмэр болгон эдгээр ярилцлагад дэмжлэг үзүүлж оролцсон.

Фермерүүдэд тулгардаг хүнд асуудлын нэг нь цагаан будааны тариалангаас бага хэмжээний ургац хураадагт байдаг. Бүлгийн гишүүд үүний шалтгааныг хэлэлцэж шийдвэрлэх аргын тухай ярилцсан. Сонгосон аргын үр дүнг тариалангийн талбайд туршиж шалгана. Жишээлбэл, 3 шинэ сортын цагаан будааг (ТН 30, Кханг Дан, Д 116) туршиж хянах, нутгийн уламжлалт сортын цагаан будааг шалгуур болгон сонгох, мөн түүнчлэн олон янз бордоо хэрэглэх, ургамалыг шилжүүлж суулгахад хэр хөдөлмөр зарцуулдаг эсэхийг болон хөрсөнд шууд суулгах аргуудыг тус бүр туршиж үзэх юм. 3-5 фермер цагаан будааны ургацын хэмжээг нэмэгдүүлэх гурван аргын

нэгийг туршиж үзэхийг дэмжсэн байна.

Бүлгийн бусад гишүүд тариалангийн ажлын явцад ажлын үр дүнд үнэлэлт хийх бөгөөд мэргэжлийн сургалтанд гурваас доошгүй удаа оролцсон, өөрөөр хэлбэл сургалтыг тариалалт болон шинэ сорт турших ажил, цагаан будаа ургаж боловсрох үе хийгээд ургац хураалтын үеэр зохион байгуулсан болно. Сургалтанд фермерүүд хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг тодорхойлох өөрсдийн шалгуурыг дэвшүүлсэн бөгөөд сайн үзүүлэлт харуулсан цагаан будааны сортыг тодорхойлсон байв. Үүний зэрэгцээ, ямар бордоог хичнээн хэмжээгээр хэрэглэх болон газар тариалангийн ямар техник ашиглах тухай санал дэвшүүлж байсан. Фермерүүд хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн талаар бүлгийн бусад гишүүдээс гадна үйлдвэрлэлийн бусад бүлгийн фермерүүд болон ямар нэгэн бүлэгт гишүүнчлэлгүй нутгийнхантай санал солилцож байсан. Сургалтын арга хэмжээг хамтлагийн фермерүүдэд зориулж өргөн хүрээтэй хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйд фермерүүдтэй хамтран өрнүүлсэн туршилтын үеэр сурсан зүйлдээ үндэслэн төслийн судлаачид фермерүүдэд өөрсдийн аж ахуйн бодит нөхцөлд үндэслэн асуудлыг шийдвэрлэх арга боловсруулахад дэмжлэг үзүүлж туслана. Бидний энэ загварын дагуу зарим фермерүүд шинэ технологи туршиж шалгадаг, нөгөө хэсэг нь ажлын үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг. Харин эдгээр фермерүүдээс тосгоны хамт олон их зүйлд суралцдаг болно.

Зарим фермерүүдийн тариалангийн ажилтай холбогдуулан хийсэн сонголт буюу гаргасан шийдвэрийг бусад олон фермерүүдээр хүлээн зөвшөөрүүлэхийн тулд энэ тухай хоорондоо хэлэлцэх бөгөөд үүнд судлаачидын зүгээс дэмжиж болно.

Мэдлэгтэй, туршлагатай фермерүүд шинэ технологи болон өөрийн аж ахуйд хийсэн судалгааны үр дүнг бусад фермерүүдэд танилцуулж туршлага солилцох нь фермерүүдийн хувьд чанартай сургалт болдог.

Гахай үржүүлэлтийн бүлэг. Тариалалтын газар дутагдалтайгаас тосгоныхон мал үржүүлэх аргаар орлогоо нэмэгдүүлэхийг

эрмэлздэг. Хэдэн жилийн өмнө зарим төслийн хүрээнд тосгоны хамтлагт үхэр үржүүлэхийг санал болгож дэмжлэг үзүүлсэн билээ. Гэвч энэ ажил сайн үүлдрийн үхэр худалдаж авах эсвэл үхэр хариулах малчин хөлслөх чадалтай их хэмжээний мөнгөтэй дунд болон баян фермерүүдийн аж ахуйд ашигтай тусламж болсон. Хонг Ха болон Хүонг Нгүен тосгоны ядуу фермерүүд гахай үржүүлэх ажлыг сонгосон буюу энэ нь өөрсдийн аж ахуйн нөхцөлд илүү тохиромжтой гэж үздэг. Гахайг фермийн аж ахуйд ургуулсан ургамалаар, жишээлбэл тэжээлийн ургамал, хүнсний ногоо болон өрхийн ногооны талбайд ургуулсан бусад ургамал эсвэл цуглуулсан хоолоор тэжээж болдог. Харин зарим фермерүүд урьд нь гахай малладаг байсан боловч ашиг шим бага байсан аж. Уулаарахга нутгийн нөхцөлд гахай үржүүлэх ажил олон бэрхшээлтэй тулгардаг. Үүнд: гахай муу нэртэй, гахайн аж ахуйд хөдөө аж ахуйн техник бага хэрэглэдэг, гахайд тохирох тэжээл дутагдалтай байдаг болон өвчлөмтгий зэргийг нэрлэж болно.

Олон фермерийн оролцоотойгоор гурван туршилтыг хэрэгжүүлсэн үүнд фермерүүдийн эрхэмлэдэг нутгийн үүлдрийн Монг Кай гахайг үржүүлэх, эрлийз үүлдрийн мал үржүүлэх, цаашид зах зээлд нийлүүлэх зорилготойгоор таргалуулах бөгөөд тэжээлийн ургамлын үндэсийг хураан хадгалж гахайн тэжээлд ашиглах. Тэжээлийн ургамал нь элбэг ургадаг ургамал билээ. Хью тосгоны хоёр фермерийг нэг сарын сургалтанд урьж мал эмнэлгийн суурь мэдлэгтэй болгосон. Тосгоны иргэдэд энэ сургалтын үргэлжлэл болгон судлаачид болон оюутнуудын тусламжтайгаар нэмэгдэл сургалт зохион байгуулсан билээ. Мал эмнэлгийн төвүүд вакцинжуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Бүлгийн бусад гишүүд нядалсан гахайг зуучлагч наймаачидад худалдах үнийн талаар мэдээлэл цуглуулахаар дүүргийн худалдааны төвүүд үрүү явсан. Фермерүүд илүү өндөр үнэ хүргэх үүднээс өөрсдийн гахайг хамтран худалдахаар шийдсэн.

Эдгээр туршилтууд нийгмийн хөрөнгийг байгуулах үйл ажиллагаанд тохирсон боловч туршилт бүр амжилтанд хүрсэнгүй. Нийт 10 фермерийг Монг Кай гахайгаар хангасан билээ. Дээд

сургууль хиймэл хээлтүүлэгийн үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр дүнд эхний жил гахайнууд сайн үржиж байсан боловч тосгонд эр гахай байхгүй тул удаах хээлтүүлэг боломжгүйд хүрсэн билээ. Үүний эцэст фермерүүд гахай маллаж үржүүлэхээс татгалзахаар шийдсэн байна. Одоо тосгоныхон гахай үржүүлэхийн оронд гол төлөв Хонг Ха тосгоны ойролцоо оршдог нам газрын Хүонг Ван хамтлагийн фермерүүдээс сайн чанарын торой худалдаж авдаг. Баян фермерүүд гахай үржүүлж бусдад торой худалдаалах тухай таамаглал тосгоны иргэдийн дунд байдаг.

Бүлгийн гишүүн болсон эмэгтэйчүүд болон ядуучууд улсын банк эсвэл хэрэгжиж буй хөгжлийн хөтөлбөрийн шугамаар зээл авах илүү бололцоотой байдаг. Бид фермерүүдийн хамтлаг болон өрхийн түвшинд зээлийн менежментийг бий болгох үүднээс бүлэг бүрт бичил эргэлтийн сан байгуулахыг санал болгон танилцуулсан. Бүлэг бүрийн ахлагч мөн зээлийн бүртгэгч нарт зээлийн менежментийн хичээл заасан болно.

Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай эвсэл холбоо байгуулах нь

Тосгоны удирдлагуудын менежментийн чадавхийг (тухайлбал, хэлэлцээ хийх чадвар) нэмэгдүүлэхэд нутгийн иргэд болон орон нутгийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой байдаг. Төслийн хүрээнд фермерүүд, эмэгтэйчүүд, хөдөө аж ахуйн техник технологийн үйлчилгээ үзүүлэх ажилтнууд болон хөгжлийн хөтөлбөрийн ажилтнуудад хамтлагийн байранд зохион байгуулсан уулзалтын үеэр нутгийн хүмүүс үг хэлж хөдөө аж ахуйн техник технологи нэвтрүүлэх алба болон хөгжлийн байгууллагуудаас дэмжлэг хүссэний хариуд эдгээр байгууллагуудын төлөөлөгчид ямар дэмжлэг үзүүлэх тухай мэдээлэл өгсөн. Энэ нь анхаарал хандуулах шаардлагатай бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хооронд ажлын давхардал гарах эсвэл зөрчил үүсэхээс зайлсхийхэд тус болдог. Нөгөөтэйгүүр, хүмүүс хүсэл сонирхолоо илэрхийлэх болон тосгоны хамтлагийн

үйл ажиллагааг илүү үр ашигтай зохион байгуулах тухай саналаа хуваалцах бололцоотой байдаг. Жишээ нь, хөдөө аж ахуйн хангамж, үйлчилгээний алба, дээд сургууль хоорондын эвсэл фермерүүдэд үр болон бордоог техник технологи нэвтрүүлэх үйлчилгээ эрхэлдэг төвөөрөө дамжуулан нийлүүлэх, мөн түүнчлэн технологийн тухай нэмэлт сургалтыг дээд сургууль хэрэгжүүлж болно. Мал болон ургамал үржүүлэх мужийн санаачилгын хүрээнд фермерүүд жимсний модны суулгацыг худалдаж авахыг санал болгодог бөгөөд техник технологи нэвтрүүлэх үйлчилгээ эрхэлдэг төв холбогдох судалгааг зохион байгуулдаг.

Хүний Нөөц Болон Нийгмийн Чадавхийг Бэхжүүлэх Үйл Ажиллагааны Эмэгтэйчүүд болон Ядуучуудад Үзүүлэх Нөлөө

Нийгмийн асуудлыг хөндсөн эдгээр үйл ажиллагаанууд ямар ялгаа бий болгож байна. Төслийн шугамаар өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж ирсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг үндэслэн анхны дүгнэлтээ гаргасан бөгөөд үр ашиг хүртэгчдийн тоо өсөн нэмэгдэж байна ()

Сонирхолын бүлгүүдэд хамрагдсан Эмэгтэйчүүдийн болон ядуу өрхүүдийн тоо

<u>Сонирхолын бүлгүүд</u>	<u>Анхны гишүүнчлэл</u>	<u>Одоогийн гишүүнчлэл</u>
Гахайн үржүүлэлт	20	48
Цагаан будааны үйлдвэрлэл (2 бүлэг)	Тус бүр 15	Бараг нийт өрхүүд
Загас үржүүлэг	10	37
Цэцэрлэгийн аж ахуй	17	60
Гар тэжээлийн үйлдвэрлэл	5	Бараг бүх өрхүүд

Эх сурвалж: Уулархаг нутгийн нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент төслийн судалгааны мэдээлэл, 2003

Үйлдвэрлэлийн бүлэгт хамрагдах фермерийн тоо нэмэгдсэн, учир нь бүлгийн үйл ажиллагааны явцад фермерүүд бие биенээсээ

олон зүйлийг сурах бололцоотой байдаг. Урьд нь гахай эсвэл загасны аж ахуй эрхэлж байгаагүй фермерүүд бүлгийн гишүүн болсноор сургалтанд хамрагдаж бусад фермерүүдээс суралцаж, цаашид мэдлэгээ өөрийн аж ахуйдаа нэвтрүүлж байна. Бидний ажиглалтаар олон эмэгтэй болон ядуу фермер техникийн сургалтанд оролцдог байсан. Хэрэв урьд нь эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд 1.5:1-ийн харьцаатай оролцдог байсан бол жилийн турш хүчин чармайлт гаргасны үр дүнд одоо эрэгтэйчүүдээс илүү олон эмэгтэй фермер техникийн сургалтанд хамрагдах болсон.

Өнгөрсөн хугацаанд сургалтанд оролцсон нийт фермерүүдийн зөвхөн 30 хувь нь баян фермерүүд байсан бөгөөд өөрийн аж ахуйд шинэ технологи нэвтрүүлсэн байна. 2003 оны байдлаар энэ тоо нийгмийн янз бүрийн бүлгүүдийн хувьд дунджаар 43 хувиар өссөн байв. Харин фермерүүдийн 14 хувь нь шинэ технологийг өөрсдийн аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх туршилтыг чадаагүй байна.

Хайрцаг

6.1

Хүмүүсийн дуу хоолой

Гахай үржүүлэх бүлэг байгуулснаас хойш эмэгтэйчүүд сургалтанд оролцсон бөгөөд бусад фермерүүдээс суралцах бололцоотой болсон. Тэдний үйлдвэрлэл тогтвортой өсөн нэмэгдсэн байна. (Хонг Ха нэгдлийн эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгч)

Бидэнд цагаан будаа тарих газар байхгүй бөгөөд орлогоо нэмэгдүүлэх бэрхшээлтэй байдаг. Харин гахай үржүүлэх бүлгийн гишүүн болсноор бид гахай, галуу үржүүлж орлоготой болсон. Энэ нь цагаан будааны орлогыг нөхөж байгаа. (Эмэгтэй фермер)

Би урьд нь гахай маллаж байгаагүй. Гэвч нутгийн тэжээлээр таргалуулж боломжийн тухай хичээл дээр заалгасны дараа үржүүлж эхэлсэн. Одоо би гахай үржүүлэлтээс маш сайн орлого авч байгаа бөгөөд энэ мөнгөөрөө шинэ байшин барьж байна. (Паринх тосгоны эмэгтэй фермер)

Цагаан будааны үйлдвэрлэлийн тухай хичээл заалгасны дараа ургацын дундаж хэмжээ 2000 онд 2тн/га байсан бол 2003 онд 4тн/га хүртэл өссөн. Олон эмэгтэй болон ядуу өрхүүд сургалтын талаар өндөр сэтгэгдэлтэй байна. Тэд одоо цагаан будааны ургац, гахай болон загасны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж сурсан. (Хуонг Нгүен нэгдлийн дэд дарга)

Эмэгтэйчүүд сургалт болон судалгаанд анхаарал хандуулдаг болж шинэ мэдлэгээ үйлдвэрлэлд үр ашигтай нэвтрүүлж байна. Эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орлого өсөн нэмэгдэж байна. Гэр бүлд эмэгтэйчүүдийн эзлэх байр өөрчлөгдөж байна. Хэрэв нөхрүүд нь гэрийн ажлыг анхаардаггүй байсан бол одоо эхнэрийн хамт хувааж хийдэг болж байна. (Эмэгтэйчүүдийн холбооны төлөөлөгч)

Фермерүүдийн хувьд тэд сургалтаар эсвэл тариалангийн талбайд шинэ технологи эзэмшихийг өндөр үнэлдэг боловч хэлний болон үйлдвэрлэлийн шинэ аргын туршилттай холбоотой бэрхшээлтэй олонтаа тулгарсан хэвээр байна.

Хурлыг тосгоны ойролцоо зохион байгуулснаар эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцож санаачилгатай ажил өрнүүлэхэд түлхэц болсон. Эмэгтэйчүүд хуралд оролцож чадаагүй нөхцөлд ажиглагчийн байрнаас оролцож, хожим уулзалт дээр сонссон болон харсан зүйлээ нөхөдтэйгээ хэлэлцдэг. Судлаачид болон хөдөө аж ахуйн техник технологийн үйлчилгээ эрхэлсэн ажилтнууд тосгоны хамтлагт орой үдэш болтол ажиллах, мөн түүнчлэн зарим үед фермийн ажилд оролцоход нилээд хугацаа зарцуулдаг байв. Төслийн багийн эмэгтэй судлаачид тосгон дахь нийгмийн харилцаа болон итгэл гүнэмшлийг судалсан нь үр бүтээлтэй ажил байсан. Өөрсдийн ажлыг идэвхжүүлэх тухай эмэгтэйчүүдийн санаа бодлыг Хайрцаг 6.1-т танилцуулав.

Орон нутгийн удирдагчид нийгэм болон жендэрийн тухай илүү мэдлэгтэй буюу тодорхой ойлголттой болсон. Сонирхолын дагуу үйлдвэрлэлийн бүлгүүдийг байгуулсны үр дүнд нутгийн удирдах хүмүүс янз бүрийн аж ахуйтай хамтлагийн фермерүүдийн ажлын онцлогийг илүү мэддэг болжээ. Үүний зэрэгцээ тэд хөгжлийн үйл ажиллагааг (төлөвлөлт, хэрэгжилт болоод үнэлэлт хийж дүгнэлт гаргах) дэмжиж ажиллах чадвараа дээшлүүлж чадсан.

Олон эмэгтэй болон нийгмийн ядуу бүлгийн хүмүүсийг хамтлагийн хөгжлийн хөтөлбөрт татан оролцуулсан тухайлбал зээлийн үйлчилгээ, үйлдвэрлэлийн бүлэг болон хөдөө аж ахуйн эдлэн газрын хувиарилалтанд хамрагдах болсон. Нэгэн нэгдлийн дарга хэлсэн үгэндээ:

«Урд нь орон нутгийн заншлын улмаас цөөн тооны эмэгтэй болон ядуучууд техникийн сургалтанд оролцдог байсан бол одоо тэд үйлдвэрлэлийн бүлгийн гишүүд болсон байна. Энэ нь тэднийг хөгжлийн үйл ажиллагаанд оролцох бололцоотой болгов».

Хөдөө аж ахуйд техник технологийн үйлчилгээ, тусламж

үзүүлдэг болон хөгжлийн хөтөлбөрийн ажилтнууд төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийн дагуу ажилласан бөгөөд одоо иргэдийн оролцоог судлах, улмаар нутгийнхныг өргөнөөр оролцуулах ажлыг зохион байгуулж байна. Хөдөө аж ахуйд техник технологийн үйлчилгээ, тусламж үзүүлдэг ажилтнууд тосгоны фермерүүдийн нийгэм болон жендэрийн байдалд илүү анхаарал хандуулж аль болох олон эмэгтэйчүүд болон ядуучуудтай хамтран тэдний байдлыг сайжруулахаар ажиллаж байна. Тэд фермерүүдийн боломж бололцоо, цаг, цугларах боломжтой газар ялангуяа эмэгтэйчүүдийн боломжид нийцүүлэн, сонгодог болсон.

Сургалт явуулах аргыг өөрчлөж лекц уншихаас гадна үзүүлэн таниулах арга болон тодорхой үйлдвэрлэлийг дагнасан бүлгүүдэд зориулж мал хариулах, үржүүлэх эсвэл тариалангийн талбайд сургалт явуулдаг. Үйл ажиллагааны шинэ хандлагын дагуу фермерүүд юугаар дутагдаж байгаад биш, харин юу хэрэгцээтэй байгаад үндэслэн ажилладаг. Нийт үйл ажиллагаанд оролцдог эмэгтэйчүүд болон ядуучуудын тоо өсөн нэмэгдсэн билээ. Бидний нийгэм болон жендэрийн судалгааг хэрэгжүүлэх чадвар болон иргэдийн дунд энэ талаар бүрэн ойлголттой болгох явдал фермерүүдийн оролцоог нэмэгдүүлэх гол хүчин зүйл болсон.

Баян фермерүүдийн бүлэг үйлдвэрлэл дээр хамгийн өндөр амжилт гаргадаг. Иймд судалгааны баг эмэгтэйчүүд болон ядуучуудын оролцоог чанаржуулах асуудалтай тулгарч байна. Энэ ажлыг хэрэгжүүлэхэд илүү их хугацаа болон хүчин чармайлт гаргах шаардлагатай билээ.

ШИНЭ ХАНДЛАГЫГ УРАМШУУЛАХ, ДҮГНЭЛТ ХИЙХ

Хамтлагийн ахлагч нар бидний ажлын хандлагыг бусад төслүүдээс ялгаатай байгааг тэмдэглэж байв. Ядуу фермерүүд болон эмэгтэйчүүдийн хүсэл, сонирхолыг харгалзан өөрсдийн мэдлэгээ сайжруулах, тэдэнд боломж олгох явдал хүмүүсийн итгэлийг төрүүлж, чадварыг дээшлүүлдэг. Урьд нь хөдөөгийн хөгжлийн хөтөлбөрийн «шинжээчид» (судлаачид болон хөдөө аж ахуйд техник

технологийн үйлчилгээ, тусламж үзүүлдэг ажилтнууд), тосгоны хамтлагийн удирдагчид, нутгийн бусад хүмүүсийн шинэ санаа, уламжлалт мэдлэг болон давуу чанарыг нь хэрэгсдэггүй байна. Вьетнамын олон янз уулархаг нутагт ядуурлыг бууруулахад нутгийн иргэдийг оролцуулах бөгөөд нутгийн онцгой нөхцөлд зохицох сургалтыг хэрэгжүүлснээр илүү үр ашигтай үр дүнд хүрдэг.

Бидний хийсэн судалгаагаар уулархаг нутгийн хамтлагт эрэгтэйчүүд болон баян фермерүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд болон ядуучууд мэдээлэл авах, үйлчилгээнд хамрагдах бололцоо муутай байдаг нь ажиглагдсан. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон гэрийн хөдөлмөр, уламжлалт заншил, хэв журам, мөн түүнчлэн нутгийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд, судлаачдын зүгээс нийгэм болон жендэрийн асуудалд хайхрамжгүй хандах явдал бий. Өөрчлөлтүүд нэг өдрийн дотор ирэхгүй нь мэдээж. Уулархаг нутгийн ядуучуудын амьжиргааг сайжруулах нь нэн түрүүнд шийдвэрлэх асуудал болсон.

Фермерүүд өөрсдийн аж ахуйн үйлдвэрлэлийг боловсронгуй болгох, орлого нэмэгдүүлэх талаар янз бүрийн сонирхолтой тул үүнд нутгийн хүмүүсийг, ялангуяа эмэгтэйчүүд болон ядуучуудыг татан оролцуулах нь онцгой нөлөө үзүүлдэг билээ.

Фермерүүд оновчтой шинэ технологийг бие биенээсээ сурч мөн судалж хэвшсэн бөгөөд хөдөө аж ахуй үйлдвэрлэлдн техник технологийн үйлчилгээ, тусламж үзүүлдэг төв нь нутгийнхныг татан оролцуулах замаар хамтран ажилладаг. Нутгийн хүмүүс, удирдлагууд, судлаачид болон хөгжлийн хөтөлбөрийн ажилтнууд сургалт явуулж мөн нутгийн иргэдтэй хамт ажиллаж, мэдээлэлтэй болох, улмаар нийгэм болон жендэрийн асуудлаар илүү мэдлэгтэй, сайн ухамсарлаж ойлгодог болж эмэгтэйчүүд, ядуучуудтай ажиллах асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг болдог. Орон нутгийн хөгжлийн үйл ажиллагаанд маш олон эмэгтэйчүүд, ядуучууд оролцдог болсон хэдий ч тэдний дуу хоолойг сонсдоггүй хэвээр байна.

Эмэгтэйчүүд болон ядуучуудын оролцоог чанаржуулах явдал урьдын адил судалгааны ажлын эгзэгтэй асуудал хэвээр үлдсэн. Энэ асуудлыг шийдвэрлэхэд тэдний үзэл бодлоо илэрхийлж чадах

орчин бий болгоход зохих чадвар, нийгмийн ажлын туршлага болоод дэмжлэг, туслалцааг үзүүлэх шаардлагатай байдаг. Мөн түүнчлэн энэ ажлыг хэрэгжүүлж буй хүмүүсийн хувьд бид мэдлэг, ойлголт төсөөлөл, хандлага, ухамсараа сайжруулах хэрэгтэй. Зөвхөн судалгааны багийн хувьд биш бөгөөд засгийн газрын болон засгийн газрын бус байгууллагаас их хугацаа болон хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

Хөгжлийн хөтөлбөрийн ажилтнууд, судлаачид нийгэм болон жендэрийн асуудалд мэдлэгтэй, ухамсартай хандаж сурах нь хөдөөгийн эмэгтэйчүүд болон ядуучуудын байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд ач холбогдолтой болох юм. Нөгөөтэйгүүр, ухамсар, мэдлэгээ дээшлүүлэх нь амар ажил биш. Үүнд нарийн нягт хяналт шинжилгээ, үнэлгээний хөшүүрэг шаардлагатай. Хөдөөгийн хөгжлийн үйл ажиллагаанд хүмүүсийн өргөн оролцоо болон иргэдэд бололцоо, эрх олгох ажлыг анхан шатны байгууллагаас засгийн газар хүртэл бүх түвшинд нэвтрүүлж хэвшүүлэх шаардлагатай байна.

Эмэгтэйчүүд болон ядуучуудын дунд тодорхой үйлдвэрлэлийн чиглэлээр бүлгүүд байгуулах бөгөөд менежментийн чадварыг нэмэгдүүлэх явдал уулархаг нутгийн хамтлагт хүний нөөц болон нийгмийн хөрөнгө (капитал) бий болгох оновчтой арга мөн билээ. Уулархаг нутгийн хамтлагийн гишүүдийн соёл, заншил мөн хэлний ижил төстэй байдлын ачаар тодорхой үйлдвэрлэлийн чиглэлээр бүлгүүд байгуулах бөгөөд энэ нь фермерүүдэд зөвхөн техникийн бус, менежментийн болон зах зээлийн мэдээллийн сэдвээр хамт суралцах тохиромжтой арга билээ.

Эдгээр бүлгүүдэд татан оролцуулж хурал, цуглаан болон тариалангийн талбай, аж ахуйд хамтран ажиллахад фермерүүдийн, ялангуяа эмэгтэйчүүд болон ядуучуудын итгэлийг нэмэгдүүлдэг байна. Энэ хэлбэрийн сургалтын чанар бүлгийн ахлагчийн мэдлэг, мэдээлэл болон туршлагад суралцах орчинг бий болгох чадвараас ихээхэн шалтгаалдаг байна. Эмэгтэйчүүдийн дунд үйлдвэрлэлийн сонирхолын дагуу бүлэг байгуулах нь эмэгтэйчүүдийг хамтарч ажиллах, бие биенээсээ суралцах оновчтой сайн арга болохыг нотолсон болно. Энэ явцад бүлгийн ажлыг дэмжиж туслахад орон

нутгийн эмэгтэйчүүдийн холбооны үүрэг чухал байдаг. Иймд эмэгтэйчүүдийн холбооны чадавхийг бэхжүүлэх явдал мөн адил чухал ач холбогдолтой байдаг.

Ядуучууд болон эмэгтэйчүүдийг чадавхтай болгоход хөдөөгийн хөгжилд оролцож буй нийгмийн бүх зүтгэлтнүүд (орон нутгийн засаг захиргаа, засгийн газар болон засгийн газрын бус байгууллагууд, судлаачид болон олон улсын дэмжигчид) урт хугацаанд хамтарсан хүчин чармайлтаар ажиллах шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖ

- Хүнс ба хөдөө аж ахуйн байгууллага (FAO) (1997). Жендер: тогтвортой байдал болон хүнсний аюулгүй байдлыг хангах нь FAO. Ром. <http://www.fao.org/sd/wpdirect/wpdoe001.htm>
- Хоанг Ти Сен (2000). Хонг Ха хамтлагийн газар тариалан болон ойн аж ахуйн үйлдвэрлэлд жендерийн үүрэг. Хьюгийн газар тариалан болон ойн аж ахуйн дээд сургууль, Нутгийн иргэдэд түшиглэсэн уулархаг нутгийн байгалийн нөөцийн менежмент төслийн тайлан. 2000. Ханой.
- Лүат, Н.В. ба Д.К.Сон (19920). Ме Конг мөрний бэлчир хавийн нутгийн хөдөө аж ахуйн тогтолцоог судалсан тайлан. Олон улсын цагаан будааны судалгааны хүрээлэн, Азийн цагаан будааны аж ахуйнуудын ажлын бүлгийн 23 дахь хуралдаан. Манил.

7

МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮД ЯРЬЖ БАЙНА

Монголд бэлчээр болон байгалийн нөөцийн хамтын менежментийг тэгш оролцоотой хэрэгжүүлэх нь



Зураг авсан: Ронный Верной

Х.ЫХАНБАЙ, Ц.ОДГЭРЭЛ, Э.БУЛГАН, Б.НАРАНЧИМЭГ

Улс Орон Болон Шийдвэрлэх Асуудал

Монгол бол эх газрын эрс тэс уур амьсгалтай орон юм. Төв Азид байрласан бөгөөд хойд талаараа Орос, урд талаараа Хятадтай хиллэдэг. Ойролцоогоор 1.56 сая хавтгай дөрвөлжин км нутагтай, 2.4 сая хүн амтай тул дэлхий дээрх хамгийн хүн ам сийрүү суурьшдаг орны тоонд багтдаг (0.6 хүн/км²). Нийт газар нутгийн ойролцоогоор 82 хувь нь бэлчээр бөгөөд 23.9 сая малтай (үүнээс 82.7 хувь нь ямаа, хонь, 17.3 хувь нь адуу, үхэр, тэмээ). 175,900 малчин өрхтэй (БОЯ 2002). Бэлчээр бол Монголын үндсэн сэргээгдэх байгалийн нөөц боловч эмзэг, талхагдахдаа амархан, талхагдсаны дараа сэргээгдэхдээ удаан билээ.

Тус улсын түүхэнд, түүнчлэн соёл уламжлалыг харвал, бэлчээр хэзээ ч хувийн өмчинд байсангүй. Бэлчээр хэдийд ч улсын өмч байсаар ирсэн бөгөөд малчид бүгдээрээ эсвэл амьжиргааны хэрэгцээг даган бий болсон хэсэг бүлгээрээ өмчилж байв. Зөвлөлтийн нөлөөнд байх үед (1921-1990), иргэд малаа өмчлөх эрхгүй байсан. Тэд улсын өмчийн бэлчээр дээр нийгмийн малыг хариулж, цалин авдаг байлаа. Энэ нь улирлаар солигдох бэлчээр болон улсын сангийн аж ахуй, нэгдлүүдийн баталсан бэлчээр ашиглалтын журмын дагуу хийгддэг байв. 1990-ээд оны эхээр Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжиж эхэлсэн бөгөөд ардчилал, төвлөрлийг сааруулах, хувьчлалыг дэмжсэн бодлого явуулах болсон билээ. 1992 оноос хойш явагдсан хувьчлалын үйл явцын үр дүнд одоо бүх мал хувийн өмч болоод байна; гэвч бэлчээр төрийн өмч хэвээр үлдсэн бөгөөд нийтээр эзэмшиж, ашиглаж байна. 1992-2000 оны хооронд малчин өрхийн тоо 2.5 дахин нэмэгдэж, малын тоо 17.5 хувиар өссөн. Үүний зэрэгцээ бэлчээрийн менежмент хийх эрх мэдэл, үүрэг хариуцлага орон нутгийн захиргаа, малчдад шилжсэн билээ.

Зарим эх сурвалжаас үзэхэд улс орны нийт бэлчээрийн 76 хувь нь бэлчээрийн талхагдал, цөлжилтөнд автаад байна. Эдгээр бэрхшээлийн цаад учир шалтгаан нь дэлхий ертөнцийн дулааралтай холбоотой уур амьсгалын өөрчлөлт, хувьчлалын дараа малын тоо

өссөн (1999 он хүртэл огцом өссөн), түүнчлэн усны эх, суурин газар, хадлангийн газар, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаагаа даган малаа хяналтгүй хэт бөөгнүүлэх болсонтой холбоотой гэж үздэг байна. Малчид зах зээл дээр өрсөлдөх арга болгон сүргийн хэмжээ, малын тоогоо өсгөх сонирхолтой байдаг гэдэг нь туршлагаас харагдаж байна. Бэлчээр бол нийтийн нөөц бөгөөд эдийн засгийн бусад хүчин зүйлтэй харьцуулахад бага өртөгтэй байдаг байна. Энэ нь 1992 онд нэгдэл задарснаас хойш олон хүнийг малтай болж, мал хариулахад нөлөөлжээ.

БЭРХШЭЭЛТЭЙ АСУУДАЛ

Бэлчээрийн талхагдал, түүнтэй холбоотой бусад бэрхшээлтэй асуудал нь экологийн даац, байгалийн бусад нөөцийн удирдлагад нөлөөлөх ноцтой асуудал юм. Нийгэм эдийн засгийн болон экологийн аль ч талаас нь авч үзэхэд үүссэн нөхцөл байдал сэтгэл зовохоор түвшинд хүрээд байна. Байгалийн нөөцийг хэтрүүлэн хэрэглэх нь эдгээр нөөцөөс хамааралтай малчин өрхийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Гэхдээ малчин өрх бүгд адил биш бөгөөд өрх дотор ч нийгмийн үйл хөдлөл харилцан адилгүй байна.

Монголын нүүдлийн мал аж ахуйн байгалийн нөөцийн менежментэд эмэгтэй, эрэгтэй хүмүүс аль аль нь чухал боловч ялгаатай үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч байгалийн нөөцийн нөөцийн ашиглалт, шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх явцад эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, оролцоо дутуу үнэлэгдэж байна. Олон тохиолдолд, судалгаа хийх, бодлого боловсруулахдаа эмэгтэйчүүдийн мэдлэг, чадавхийг «зүгээр» мартаж, эсвэл хайхралгүй орхигдуулж байна. Байгалийн нөөцийн менежмент дэх эмэгтэйчүүдийн оролцоог саяхнаас л арай нухацтай авч үздэг болж байна. Байгаль орчны менежмент, хадгалалтанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг нь анхаарлын төвд ирж, тэдний үйл ажиллагаа, оруулж буй хувь нэмрийг үнэлэх байдал нь аажим нэмэгдэж байна. Эмэгтэйчүүд хийж буй үйл ажиллагаандаа явцын дунд арай илүү

дэмжлэг авдаг болж байна.


Бэлчээрийн Хамтын Менежмент

Хамтын менежмент гэдэг нь (зохион байгуулалтанд орсон) малчид болон засгийн газрын байгууллага хамтран шийдвэр гаргах явц юм. Бэлчээрийн хамтын менежмент бол Монголын хувьд хамгийн сайн хувилбар гэж бид үзэж байна. Бэлчээр бол нийтийн эзэмшлийн нөөц бөгөөд мал хувийн өмч (малчдад бизнесийн зорилгоор амьжиргаагаа хөгжүүлэх боломж олгож байгаа) ч гэсэн зөвхөн хувь хүмүүст тулгуурласан менежмент нь бэлчээрийн даацтай авцалдахгүй байна. Хувь хүмүүст тулгуурласан менежмент нь нэг л нөөцөөс хамааралтай байгаа айл хөршийнхөө сонирхлыг харгалзахгүйд хүргэнэ. Малчид нутгийн ард олны өргөн оролцоо, орон нутгийн болон төв засгийн газрын дэмжлэггүйгээр мал аж ахуйн энэхүү тогтолцоог зохих ёсоор удирдаж чадахгүй. Бэлчээр төрийн өмчинд байгаа тул түүний хэрэглээг засгийн газраас зохицуулж өгөх шаардлагатай. Малчид, орон нутгийн захиргааны нөөцийг тогтвортой байдлаар удирдах чадавхи сул байгаа тул бусад сонирхогч тал, салбарын оролцоо хэрэгтэй байна.

Байгалийн нөөцийн менежментийн чадавхийг бэхжүүлэх, бэлчээрийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэхэд үндэсний түвшний хэд хэдэн бодлого, хууль нөлөөлж байна. Газрын тухай шинэ хуулинд (2002) малчдын бүлэг, нутаг усныхан орон нутгийн захиргааны зохих оролцоотойгоор бэлчээр ашиглах урт хугацааны гэрээ байгуулах асуудлыг тусгасан. Энэ гэрээ нь бэлчээрийг зохистой ашиглах, сэргээх, (талхлагдахаас) хамгаалах үүрэг, хариуцлагыг хамтран тодорхойлсон тохиолдолд л хүлээн зөвшөөрөгдөх билээ. Түүнчлэн Газрын тухай хууль болон бусад хууль эрх зүйн баримт бичигт хөрш сум, аймгийн хооронд гарсан отор нүүдэлтэй холбоотой маргааныг шийдэх үүрэг, эрхийг засаг даргад олгосон байдаг.

Канадын Олон улсын хөгжлийн судалгааны төвийн

7.1 Зураг
Судалгааны бүсийн байршил



дэмжлэгтэйгээр Байгаль орчны яам бусад яам, байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй «Нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн тогтвортой менежмент» (НЭБНТМ) төсөл нь судалгааны сонгон авсан талбаруудад хамтын менежментийн аргыг нэвтрүүлэх замаар мал, бэлчээр, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж байна. (Зураг 7.1) Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хүн амын тоо, зах зээлд хэр ойр зэргээрээ ялгаатай Монголын гурван том экосистемд оролцооны болон үйл ажиллагаанд чиглэсэн судалгааг судалгааны бүс нутагт нь явуулах замаар энэхүү тулгамдсан асуудлыг авч үзэж байгаа болно. (Ыханбай болон НЭБНТМ төслийн баг, 2004) Одоогийн байдлаар төсөлд 10 гаруй малчдын хамтлаг хамрагдаж байгаа бөгөөд бүлэг тус бүрт 13 - 32 малчин өрх багтаж байна.

Хамтлаг тус бүр нь гэр бүл, хэл, түүхэн, экосистемийн болон бусад шинж чанарын хувьд харьцангуй ойролцоо эдийн засгийн эсвэл нийгмийн нэгж юм. Судалгааны талбар бүр дээр бэлчээр, байгалийн нөөцийн менежментийн оролцогч бүх сонирхогч тал хамтын менежментийн үйл ажиллагаанд өргөнөөр оролцож байна. Хамтлаг, түүний гишүүдийн хооронд, хамтлаг болон нутгийн захиргааны хооронд байгуулсан хамтын менежментийн гэрээ нь албан болон албан бус уулзалт, ярилцлагууд дээр хэлэлцэн тохирсон сонирхогч бүх талын үүрэг, хариуцлагыг баримтжуулж тусгасан. Эхлээд Хөдөөгийн оролцоотой үнэлгээний уулзалт хийсэн нь хувь хүмүүс болоод бусад талууд бие биеэ илүү сайн ойлгоход тус болсон.

Сумын түвшинд хамтын менежментийн баг судалгааны талбар бүр дээр байгуулагдсан бөгөөд малчид, хамтлаг буюу нутгийн олон нийт, засаг дарга, ТББ, сургууль болон бусад байгууллагын төлөөлөл бүрэлдэхүүнд нь орсон. Төслийн судлаачид мөн уг багт орж байгаа болно.

Нутаг орон бүрт малчин болон хамтлаг, хамтлаг ба баг, сумын Засаг даргын хооронд Хамтын менежментийн гэрээ байгуулж байна. Энэхүү гэрээ нь цаг бүр шинэчлэгдэн менежментийн арга барилыг шинэчилж байна

Малчид амьжиргаанд нь шууд нөлөөлөх өөр бусад үйл ажиллагаан дээр хамтарч ажиллах сонирхолтой байгаа тохиолдолд л бэлчээрийн менежментийн чиглэлээр хамтран ажиллах магадлалтай. Тиймээс төслийн зүгээс амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн хэд хэдэн арга хэмжээнд дэмжлэг үзүүлж байна. Үүнд: сургалт (бэлчээрийн менежмент, байгалийн нөөцийн менежмент, ногоо тарих, түүхий эд боловсруулах, гар урлал, оёдол, ойжуулалт, малын тэжээл суулгах, оролцооны аргаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх), бүлэг хоорондын сүлжээ, туршлага солилцох ажиллагаа (судалгааны талбар хоорондын хуралд малчдыг оролцуулах, «аж ахуйгаас аж ахуйд» харилцан айлчлуулах), дэмжих үйлчилгээ (жигжиг зээл, олон нийтийн сан, олон нийтийн төсөл, сумын төв дээрх мэдээллийн сан, нутгийн олон нийтийн мөрдөх дүрэм боловсруулах болон нутгийн зөвлөл, мөн эмэгтэйчүүдийн бүлэг байгуулахад дэмжлэг үзүүлэх).

НИЙГЭМ БОЛОН ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭГ НЭГТГЭН АВЧ ҮЗЭХ НЬ

НЭБНТМ төсөл нь нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн арга барилыг баримталж байна. Энэ нь судалгааны ажил, орчлын бүхий л үе шатанд (дүн шинжилгээ, төлөвлөлт, шийдвэр гаргалт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ) нутгийн хүмүүс, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг оролцуулна гэсэн үг юм. Бэлчээр, байгалийн нөөцийн менежментийн бусад чиглэлээр эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн гүйцэтгэж буй үүрэг, хариуцлага, сонирхлын ялгааг илрүүлж, шинжлэхийн тулд нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг ашиглав. Өмнө дурдсанчлан, нүүдлийн мал аж ахуйд эмэгтэй, эрэгтэй хүмүүс чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч байгалийн нөөцийн хэрэглээ, шийдвэр гаргалт, хэрэгжилтийн явц дахь эмэгтэйчүүдийн оролцоог бүрэн

дүүрэн хүлээн зөвшөөрч, тэдний оруулж буй хувь нэмрийг зохих ёсоор үнэлэх хэрэгтэй байна. Эмэгтэйчүүдийн мэдлэг, чадварыг үл тоомсорлож буй тохиолдол олон байна.

Жендэрийн дүн шинжилгээ нь бэлчээрийн мал аж ахуй, хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон байгалийн нөөцийн бусад (ан агнуур, жимс түүх) чиглэлд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэж буй ялгаатай бөгөөд өөрчлөгдөн буй үүрэг, хариуцлага, сонирхлыг тодорхойлох боломж олгодог. Жендэрийн дүн шинжилгээ нь байгалийн нөөцийн менежментэд хүний хүчин зүйлийг онцлон авч үзэх, түүнчлэн малчин өрх, нутгийн олон нийтийн түвшинд эмэгтэйчүүдийн ойлголт, сонирхлыг бүрэн харгалзан үзэхгүй байгааг харуулахад тусалдаг. Энд зан заншил, уламжлал, шашин шүтлэг чухал үүрэг гүйцэтгэнэ. Монголд эмэгтэйчүүд айл гэрээ авч явах, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хоол ундаа хийх, наад захын хэрэглээний зүйлээ үйлдвэрлэх зэрэг олон үүрэг хариуцлага хүлээж байдаг; тиймээс ирээдүй үедээ зориулан өөрөө өөрийгөө тэтгэх тогтвортой хөгжлийг бий болгоход тэдний гүйцэтгэх үүрэг асар чухал юм. Тус тайлан нь эдгээр үзэл санаанд тулгуурласан бөгөөд эмэгтэйчүүдийн ойлголтыг (санаа, сонирхол, бодол) бэлчээрийн болон байгалийн бусад нөөцийн хамтын менежментийн гэрээнд хэрхэн тэгш тусгах вэ гэсэн асуудалд онцгой анхаарал тавьсан болно.

НИТБНМ-ийн арга барил нь үйл ажиллагаа, эерэг өөрчлөлт гаргахад мөн чиглэж байна. Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ талаас нь харвал энэ нь эмэгтэйчүүд сургалт, бусад үйл ажиллагаанд оролцох, шийдвэр гаргах үүргээ хэрэгжүүлэх, бататгахад нь дэмжлэг, онцгой анхаарал үзүүлэхийг хүсч байж болно гэсэн үг юм. Энэ нь биднийг нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээний судалгааны практик руу хөтөлж аваачиж байгаа юм.

Судалгааны Хамрах Хүрээ: Судалгааны Асуулт, Онол, Аргачлал

Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ хийх ажилд дараахь

үндсэн асуултыг удирдлага болгов. Үүнд:

1. Байгалийн нөөцийн менежментийн судалгааны хувьд нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ хийнэ гэдэг нь өөр өөр сонирхогч талуудын хувьд юу гэсэн үг вэ?
2. Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ хийхэд янз бүрийн сонирхогч талуудаас ямар үндсэн чадвар шаардагдах вэ?
3. Эерэг болон сөрөг ямар хүчин зүйл байна вэ?

Бидний үйл ажиллагаанд баримталсан онолд байгалийн нөөцийн менежмент дэх жендэрийн үүргийн тодруулах асуудал бөгөөд үүнд эмэгтэйчүүдийн бүлэг гэх мэт сонирхогч талуудын ойлголтыг оролцогч хамтлагийн түвшинд судлах явдал юм. Ялангуяа бидний анхаарал хандуулж судалсан нэг асуудал бол хамтын менежментэд оролцох хүсэл, хандлагын талаарх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ойлголтын ялгааг илрүүлсэн байна. Үр дүнд суурилсан судалгааны энэ шатанд хамтлагийн нийгэм эдийн засаг болон шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн бүлэгт дэмжлэг үзүүлэх асуудал бидний зорилго байсан. Мөн энэ судалгаагаар хамтын менежментийн гэрээний талаар шийдвэр гаргахад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эдэлж буй тэгш эрх, байр суурь, тэгш байдлыг тодорхойлсон байна. Мөнтүүнчлэн эмэгтэйчүүдийг үйл ажиллагаанд чиглэсэн оролцооны аргын сургалтанд хамруулахаар төлөвлөсөн. Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээний энэхүү судалгаа нь нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент, байгалийн нөөцийн менежментийн жендэрийн үүрэг, оролцооны талаар хийгдэж буй анхны судалгааны болон хөгжлийн үйл ажиллагаа юм.

Бидний судалгааны ажлын үр дүнд

1. Хамтын менежментийг хэрэгжүүлэхэд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, сумын түвшинд хамтын менежментийн багт эмэгтэйчүүдийг илүүтэй татан оролцуулах боломжийг хангасан байна.
2. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс өрхийн орлогод оруулж буй хувь нэмэр, ялгааг үнэлсэн байна
3. Эмэгтэйчүүдийг бүлгүүд хамтын менежментийн (бэлчээр

болон байгалийн бусад нөөц) гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх бүхий л үйл явцад өөрсдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг авч үзсэн байна.

4. Малчин өрхийн амьжиргаа янз бүр байхад нөлөөлж буй эерэг болон сөрөг хүчин зүйлийг тодорхойлж, хувилбар боловсруулж туршихад ашиглана.
5. Судалгааны гурван талбарын эмэгтэйчүүдийн бүлэг харилцан туршлага солилцсон байна.
6. Судалгааны явцад хамтлаг болон малчин өрхийн хооронд, хамтлаг болон багийн засаг дарга, хамтлаг болон сумын засаг даргын хооронд хамтын менежментийн гэрээ байгуулагдсан байх бөгөөд нийт оролцогч талын хүлээх үүрэг, хариуцлага өөрчлөгдсөнтэй холбоотой шинэчлэгдэж байна.
7. Эрэгтэй эмэгтэйчүүдийн гэр бүлийн орлогод туслалцаа үзүүлэх, дэмжих үйл ажиллагааг үнэлэх
8. Ядуу өрхөд илүү анхаарал хандуулах, эрэгтэйчүүд эмэгтэйчүүд хамтдаа жижиг зээл авч эмэгтэйчүүд удирдан зохион байгуулах

Бид нутгийн олон нийтийн түвшин, баг, сумын захиргааны ажилтнууд, ТББ болон хамтлагийн гишүүдийн түвшинд эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулахыг хичээсэн. Төслийн багийн гүйцэтгэх үүрэг нь үйл ажиллагаа явагдахад дэмжлэг үзүүлэх, дээр дурдсан сонирхогч талуудтай хамтран судалгаа хийх явдал юм. Төслийн баг төслийн үйл ажиллагаан дахь янз бүрийн оролцогч талуудын харилцааны талаар судалгаа хийсэн. Хамтлагийн төслийн үйл ажиллагаанд малчин гэр бүлийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, бүх хамтлагт хамтын менежментийн гэрээнд эмэгтэйчүүдийн ойлголт төсөөллийг тусгах болон эрэгтэй, эмэгтэй малчдын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгоход төслийн үйл ажиллагаагаа чиглүүлсэн. Үүнээс гадна, хамтын менежментийн гэрээний зүйл заалт, үүрэг хариуцлагыг сайжруулах, хэрэгжүүлэхэд хяналт шинжилгээ хийх, эрх үүрэг болон судалгааны гурван талбар дахь эмэгтэйчүүдийн бүлгүүдийн хоорондох туршлага солилцох уулзалт, аялалыг хийхээр төлөвлөсөн.

СУДАЛГААНЫ БҮС НУТАГТ АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Судалгааны бүс нутгууд

Монголын уудам газар нутаг нь газар зүйн хувьд өмнөөсөө хойш экологийн таван бүсэд хуваагддаг: цөл-тал хээр, тал хээр, уулархаг-тал хээр, тал хээр-ой, болон ойн бүс. Тус төсөл нь уулархаг тал хээр, тал болон тал хээр-ойн эко бүсэд төвлөрч байна. Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээний судалгаа нь эдгээр экосистемийг төлөөлсөн дараах гурван сум дээр (Монгол улсад 330 сум бий) хийгдсэн болно:

Архангай аймгийн Хотонт сум нь Хангайн тал хээр, тал хээр-ойн экосистем. Нэн даруй шийдэх асуудал: Тус сумын зарим нутагт малын тоо зун, хаврын улирлын бэлчээрийн даацаас 1.2-1.3 дахин илүү байна. Тус бүс нутагт хөршийн холбоо, нийгмийн амьдрал сайн, халх соёлын уламжлал хүчтэй байдаг, байгалийн нөөцийн хамтын менежментэд эмэгтэйчүүд идэвхтэй оролцдог, тайгархаг тал, ойн нөөц бүхий баялаг экосистемтэй.

Баян өлгий аймгийн Дэлүүн сум нь Монгол Алтайн ойн ба тал хээрийн экосистемд багтдаг. Нэн даруй шийдэх асуудал: 2002 оны байдлаар малын тоо бэлчээрийн даацнаас 20 хувь хэтрээд байв. Боломж нь нүүдлийн уламжлалт мал аж ахуй, казах үндэсний соёлын онцлог, бэлчээр хуваах хүчтэй систем, хамаатан саднаараа бэлчээр, байгалийн нөөцийг хамтран удирддаг байдал, гэрийн ажилд эмэгтэйчүүд давамгайл үүрэг гүйцэтгэдэг.

Төв аймгийн Лүн сум нь төв Монголын тал хээрийн эко системтэй. Нэн даруй шийдэх асуудал: Нийслэлд ойр тул нутгийн малчдын мал маш нягт бөөгнөсөн байдаг. Түүнээс гадна бусад бүсийн малчид Улаанбаатарын зах руу малтайгаа нүүх замдаа дайрдаг. Энэ давхар ачаалал нь зун, хавартаа бэлчээр талхагдах, цөлжилт эрчимжихэд хүргэдэг. Боломж нь бизнесийн сайхан боломж, улс орны бусад бүс, эко системийг төлөөлсөн ястан, үндэстний холимог, хөдөө аж ахуй, бусад бизнесийн чиглэлээр эмэгтэйчүүд сайн мэдлэгтэй.

Одоогоор судалгаанд нутгийн 10 хамтлаг оролцож байна; Судалгааны талбар бүрт 3-4 хамтлаг, хамтлаг тус бүртээ 13-29 өрхтэй байна. Эдгээр хамтлагийг нийгэм (хөршийн харилцаа), эдийн засаг (малчдын бүлэг), экологийн (нэг экосистемийн малчид) гэх мэт хэд хэдэн онцлог шинж чанарыг харгалзан үзсэний үндсэн дээр зохион байгуулсан болно. 2001 онд төсөл гурван хамтлагийн 87 өрхийн 198 малчинтай эхэлж байсан бол одоо судалгааны гурван талбар дээр нийт 1000 орчим малчин хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцож байна.

Аргачлал

Ерөнхий аргачлал нь Хөдөөгийн оролцоот үнэлгээний (ХОҮ) арга хэрэгсэл болон асуулгын судалгаа юм. ОХХҮ-ний арга хэрэгсэлд фокус бүлгийн хэлэлцүүлэг, судалгааны бүсэд хийх ярилцлага, өрхийн асуулгын судалгаа, аман түүх, улирлын диаграм, судалгааны талбар дахь ажиглалт багтсан. Бэлчээр, байгалийн нөөцийн менежмент дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар мэдээлэл цуглуулахад бүлгийн хэлэлцүүлэг, судалгааны бүсэд хийх ярилцлагыг ашигласан. Судалгааны үр дүнд тулгуурлан, сонирхогч гол талуудын (малчин ба хамтлагийн тэргүүн; хамтлаг ба орон нутгийн засаг дарга) дунд байгуулах хамтын менежментийн гэрээг шинэчилж, өөрчлөн боловсруулсан бөгөөд эмэгтэйчүүдийн санаа, бодлыг тусгалаа. Жендэрийн дүн шинжилгээ нь микро, мезо, макро түвшний хувьд, байгалийн нөөцийн менежмент, шийдвэр гаргах үйл явц дахь жендэрийн үүргийг тодорхойлов. Түүнчлэн макро түвшний судалгаа нь засгийн газрын бодлогод дүн шинжилгээ хийсэн болно. Эмэгтэйчүүдийн бүлгийн олон нийтийн бүлэг хоорондын харилцан туршлага солилцох явдлыг дэмжиж, судалгааны талбарууд дахь мэдээллийн сангийн төвөөр дамжуулан эмэгтэйчүүдийн бүлгийн сүлжээ бий болгоход дэм болсон. Судалгаанд олон нийтийн 9 хамтлагийн 200 малчин өрхийн нийт 461 эмэгтэй, эрэгтэй хүмүүсээс гадна хамтлагийн ахлагч, засаг дарга нар, сумын хамтын менежментийн багийн гишүүд, судлаачид оролцлоо.

Үр Дүн Болон Ярилцлага

Байгалийн Нөөцийн Менежмент Дэх Жендэрийн Үүрэг


Улс орны байгалийн нөөцийн менежментэд эмэгтэй, эрэгтэй хүмүүс аль аль нь чухал боловч ялгаатай үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч байгалийн нөөцийн нөөцийн ашиглалт, шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх явцад эмэгтэйчүүдийн гүйцэтгэх онцлог үүрэг, оролцоо дутуу үнэлэгдэж байна. Олон тохиолдолд, судалгаа хийх, бодлого боловсруулахдаа эмэгтэйчүүдийн мэдлэг, чадавхийг «зүгээр» мартаж, эсвэл хайхралгүй орхигдуулж байна.

Малчин өрхийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарь, хариуцлагыг судалгааныхаа үр дүнд тулгуурлан Зураг 7.2-т үзүүлэв. Бэлчээрийн мал аж ахуйд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хоол хийх, хувцас хунар, хүүхэд, гэр бүлийн бусад хүмүүсийг халамжлах гэх мэт бусад олон өөр ажил хийдэг гэдгийг судалгааны дүн харуулж байна. Уг тоо баримт нь малчин өрхийн хөдөлмөрийн уламжлалт хуваарьтай таарч байна.

Эрэгтэйчүүд бэлчээр сонгох, гэжээл бэлтгэх, мал хариулах, хуралд суух, бизнесийн удирдлага гэх мэт «гадаах» (гэрээс хол) чухал ажлын ихэнхийг хийж байна. Гэвч эрэгтэйчүүдийн ажлын ихэнх нь улирлын шинжтэй. Харин эмэгтэйчүүдийн ажил нь өдөр бүр болон жилийн турш үргэлжлэх шинж чанартай байна. Тэд сүү цагаан идээ боловсруулах, хүүхдээ асрах, гэрийн ажил хийх гэх мэт давтагдах чанартай ажлыг голдуу хийж байна. Өөрөөр хэлбэл, эмэгтэй хүний өдөр тутмын ажлын ачаалал нь эрэгтэй хүнийхээс илүү боловч ихэнхдээ хөлсгүй хөдөлмөр байна. Эмэгтэйчүүдийн ажлын ачаалал нь байгалийн нөөцийн менежментийн талаар олон нийтийн гаргах шийдвэрт оролцох бололцоог нь хааж байна. Үүнээс бид эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг буруулах замаар тэдний байгалийн нөөцийн менежментэд оролцох оролцоог нэмэгдүүлж болно гэсэн дүгнэлт хийж болох юм.

Зураг 7.2.

Мал ахуй, гэрийн ажилд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцож буй байдал (n=84)



Эх сурвалж: Ц.Одгэрэл, НЭБНТМ төслийн судлаач, «Судалгааны 3 талбар дахь малчин эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хуваарь» судалгааны тайлан, 2002.

Хүснэгт 7.1-т байгаль, түүний нөөцийг малчид хамгаалахад эрэгтэй, эмэгтэй хүмүүс чухам ямар үүрэг гүйцэтгэж байгааг тэдний ойлголтод тулгуурлан харуулав.

Хүснэгт 7.1

Бэлчээр болон байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд хамтлагийн эмэгтэй, эрэгтэй гишүүдийн оролцоо

Үзүүлэлтүүд	Оролцооны хувь (n=84)	
	Эмэгтэй	Эрэгтэй
Байгалийн нөөцийг хамгаалахад	68.3	31.7
Байгалийг нөхөн сэргээхэд	73.3	26.7
Байгалийг нөхөн сэргээх үр, ургамал түүхэд	100.0	0.0
Хүүхдэд экологийн сургалт олгоход	66.7	33.3

Эх сурвалж: Ц.Одгэрэл Микро, мезо, макро түвшин дэх жендэрийн үүрэг (2003)

Хамтлагийн гишүүдийн зүгээс эмэгтэйчүүд байгаль орчныг

цэвэрлэх, хүүхэддээ «Хүн, байгаль орчны» талаар мэдлэг, боловсрол олгох, тэдэнд байгалийн нөөцийг зүй зохистой ашиглаж, хамгаалах уламжлалт зан заншлыг зааж сургах замаар байгалийн нөөцийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байгааг хүснэгт (7.1) харуулж байна. Түүнчлэн уг хүснэгтээс эрэгтэйчүүд хуралд суух, хамтлагийн ахлагчтай өрхийнхөө өмнөөс тохироо хийх гэх мэтээр шийдвэр гаргалтанд илүү үүрэг гүйцэтгэдэг гэж ойлгох нь түгээмэл байгааг харж болно.

Монголчууд байгаль орчноо хадгалж хамгаалах удаан жилийн уламжлалтай. Эмэгтэйчүүд хүүхэддээ байгалийг хэрхэн хамгаалж, зүй зохистой ашиглахыг зааж сургадаг тул энэ уламжлалыг хадгалж үлдэхэд эмэгтэйчүүд чухал үүрэгтэй. Түүнчлэн бууриа цэвэрлэх, гол ус, булгаа хамгаалах ажлыг голдуу эмэгтэйчүүд хийдэг. Гэвч гэртээ их ажилтай завгүй байдаг тул бэлчээр, байгалийн нөөцийн менежментэд оролцоход хэцүү байдаг (Хамтлагийн гишүүн эмэгтэй)

ХАМТЫН МЕНЕЖМЕНТ НЭВТРҮҮЛСНЭЭС ХОЙШХИ ӨӨРЧЛӨЛТ

Хамтын менежментийг хэрэгжүүлэх эхний үед жендэрийн үүрэг, бэлчээрийн нөөцийн менежментэд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцооны талаар нэгдсэн ойлголт байгаагүй. Гэхдээ энэ байдал одоо өөрчлөгдсөн. Хамтын менежментэд оролцож буй малчид, бусад сонирхогч талууд хамтын менежментийн тогтвортой үргэлжлэх систем бий болгохын тулд шийдвэр гаргахдаа эмэгтэйчүүдийн сонирхол, үүрэг чухал гэдгийг ойлгодог болж байна. Түүний зэрэгцээ малчдын (эмэгтэй, эрэгтэй) бэлчээр, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах хамгаалах талын мэдлэг, уг мэдлэгээ амьдрал дээр хэрэглэх ур чадвар сайжирсан.

Хамтын менежментийг нэвтрүүлж эхэлснээс хойш малчид байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр хамтран ажиллах байдал нь дээрдсэн. Байгалийн нөөцийг хамгаалах, сэргээх мэдлэг, сонирхол нь нэмэгдсэн. Ялангуяа БНМ дэх эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, оролцоо нь манай сумын хамтлагуудын хувьд сайжирсан. Одоо хамтын

менежментийн гэрээ байгуулахад эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш оролцож байгаа. Шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл явцад эмэгтэйчүүд оролцох нь нэмэгдсэн, тухайлбал, Лүн сумын эмэгтэйчүүдийн бүлэг үр цацах замаар доройтсон өвөлжөө, хаваржааны бэлчээрээ сэргээх санаачлага гаргасан. (Эрэгтэй, Сумын засаг дарга)

Гэвч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарь өөрчлөгдөөгүй байна. Энэ нь цаг хугацаа шаардах зүйл юм. Гэхдээ зарим өөрчлөлт гарч байна: эмэгтэйчүүд хамтлагийн хуралд илүү идэвхтэй суух болсон бөгөөд өөрсдийгөө илэрхийлж эхэлж байна.

Эмэгтэйчүүдийн Бүлэг

Төслийн үйл ажиллагааны нэг хэсэг нь эмэгтэйчүүдийн бүлгийг байгуулах явдал байв. Хамтлаг дотроо эдгээр бүлэг нь байгалийн нөөцийн менежментийн талаар шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэхэд асар чухал нөлөөтэй юм. Түүнчлэн хамтын менежментийн ямар сайн дадлага байгаа, орон нутгийн мэдлэг, дадлага дээр тулгуурлан хамтын менежментэд гарч буй бэрхшээлийг хэрхэн давж болох тухай асуудлыг судлахад эдгээр бүлэг чухал ач холбогдолтой.

Эмэгтэйчүүдийн бүлэг нь хамтлагийн эмэгтэй гишүүдээс бүрдэнэ. Эмэгтэйчүүдийн бүлэг бүр хамтлагийн хурал дээр гишүүдийнхээ дундаас удирдагчаа сонгоно. Эмэгтэйчүүдийн бүлэг нь сард нэг удаа уулзаж, үйл ажиллагаагаа төлөвлөн, асуудлын авч хэлэлцэн, юу хийх талаар шийдвэр гаргана. Гэвч зарим бүлгийн хувьд, ялангуяа зарим эмэгтэй бие биеэсээ 50-100 км зайтай амьдардаг Дэлүүн, Лүн сум дахь судалгааны талбарын хувьд сар бүр уулзахад хэцүү байв. Тиймээс зарим бүлэг хоёр эсвэл гурван сард нэг удаа уулзаж байхаар шийдсэн.

Эмэгтэйчүүд байгалийн нөөцийн менежментэд маш тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Эмэгтэйчүүдийн бүлэг байгуулснаар тэд нэгдэж, санаа бодлоо хуваалцаж, хамтарсан шийдвэр гарган, бие биедээ тусалж байна. (Эмэгтэй хамтлагийн нарийн бичгийн дарга)

Эмэгтэйчүүдийн бүлэг нь эмэгтэйчүүдийн дунд дараахь үйл

ажиллагааг зохион байгуулдаг: эмэгтэйчүүдийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх (жишээ нь, гар урлал, эсгий хийх, ногоо тарих), бие биеэсээ суралцах (ур чадвараа хамтлагийн бусад гишүүдэд заах, бусдаасаа суралцах, тогтвортой амьжиргаа болон БНМ-ийн талаар эмэгтэйчүүдэд сургалт явуулах), хамтлаг хооронд болон судалгааны талбар хооронд туршлага солилцох (хамтлагийн бүтээгдэхүүний үзэсгэлэн, өөр судалгааны бүс нутагт суралцах аялал хийх; жишээ нь, Дэлүүн, Хотонт, Лүн сумын эмэгтэйчүүдийн бүлгийн Лүн суманд болсон хурал, Хотонт суманд болсон хамтын менежментийн гэрээг шинэчлэн сайжруулах уулзалт) хамтлагийн хамтын менежментийн хүчин чармайлтыг оролцооны аргаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Төслөөс судалгааны талбарууд дээр «Бэлчээрийн менежмент» сургалтыг явуулснаас хойш хамтлагууд бэлчээрийн менежмент хийж буй системээ сайжруулахын тулд бэлчээр сэлгэх төлөвлөгөө боловсруулсан. Цагааннуур, Аржаргалант хамтлагийн эмэгтэйчүүдийн бүлэг бэлчээр сэлгэх төлөвлөгөө зохиосон нь маш үр өгөөжтэй болсон байна (7.2 хүснэгтэд Аржаргалант хамтлагийн эмэгтэйчүүдийн бүлгийн боловсруулсан бэлчээр сэлгэх хуваарийг харуулав)

Манай хамтлагийн эмэгтэйчүүд бэлчээр сэлгэх төлөвлөгөө хийсэн. Өмнө нь эмэгтэйчүүд бэлчээрийн асуудалд хэзээ ч оролцож байгаагүй, гэхдээ тэдний бэлчээр сэлгэх төлөвлөгөө маш зөв, сайн хийгдсэн байсан. (Эрэгтэй, 42, хамтлагийн гишүүн)

Бүх хамтлагт эмэгтэйчүүдийн бүлэг байгуулсны үр дүнд одоо хамтлагийн шийдвэр гаргалтанд эмэгтэйчүүд илүүтэй оролцох болсон: тэд хамтлагийн хуралд оролцож, хурал дээр өөрсдийн санааг чөлөөтэй илэрхийлж, эмэгтэйчүүдийн бүлгийн үйл ажиллагааны талаар бусад гишүүддээ мэдээлж байна.

Хүснэгт 7.2
Аржаргалант хамтлагийн эмэгтэйчүүдийн бүлгийн зохиосон бэлчээр сэлгэх төлөвлөгөө

Юу	Хэзээ?	Хэн зохион байгуулах?
Зуны бэлчээрээс Цагааннуур голын эрэг рүү нүүх	6 сарын 20 – 8 сарын 20	Хамтлагийн ахлагч, эмэгтэйчүүдийн бүлэг
Зуслангаас хадгалсан зарим бэлчээрийг намар ашиглана	8 сарын 20 – 10 сарын 20	Хамтлагийн гишүүд
Их нуур руу оторт гарна	12 сарын 20 – 2 сарын 20	Хамтлагийн ахлагч, гишүүд
Өвөлжөөнд олон настын үр суулгах	5 сарын 1-нээс эхлэх	Эмэгтэйчүүдийн бүлэг, хамтлагийн гишүүд

Орлого Нэмэгдүүлэх Үйл Ажиллагаа

Малчдын орлогын цорын ганц эх үүсвэр нь мал аж ахуй. Гэвч бидний өмнө дурдсанчлан энэ эх үүсвэр нь улам бүр найдваргүй болж байна. Орлого нэмэгдүүлэх нэмэлт эх үүсвэр бий болгох нь малчин өрхийн амьжиргааг дээшлүүлж, экологийн асуудлыг (бэлчээрийн доройтол гэх мэт) шийдвэрлэхэд тус дөхөм болох тул маш чухал ач холбогдолтой.

Судалгааны талбарын байршил, зах зээлд хэр ойр, дэд бүтэц, соёл заншил, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг нь байгалийн нөөцийн хамтын менежментийн хэрэгжилтэнд маш их нөлөөлж байна. Тухайлбал, Дэлүүн суманд соёл заншил, уламжлал, хамаатан садны ойр харилцаа зэрэг нь хамтын менежментийн нэвтрүүлэхэд зэрэг хүчин зүйл болж өгсөн. Хотонт суманд бэлчээрийн хүрэлцээ муу (малчид өөр хоорондоо ойрхон амьдардаг) тул малчдын орлогын өөр эх үүсвэр олох сонирхол өндөр байв. Түүнчлэн зах зээлээс хол тул хамтран ажиллах хэрэгцээтэй байдаг байна. Гэтэл Лүн сум илүү бизнесийн чиглэлтэй бөгөөд тус тусдаа бизнес эрхлэх сонирхолтой байна. Ийм шинж чанартай байхад нөлөөлж буй хүчин зүйл нь зах зээлд хэр ойр, дэд бүтэц хэр хөгжсөн эсэх юм.

Хүснэгт 7.3-т малчин өрхийн орлогын дундаж бүтэц хэрхэн өөрчлөгдөж буйг харуулав.

2001 оноос өмнө малчин өрхийн орлогын дунджаар 48.6 хувь нь малын мах борлуулснаас, 15.2 хувь нь сүү, цагаан идээнээс, 22.9 хувь нь ноос, ноолуурнаас, 7.1 хувь нь арьс ширнээс, үлдсэн 6.2 хувь нь настай хүмүүсийн тэтгэвэр тэтгэмж зэрэг бусад эх үүсвэрээр бүрдэж байв. Одоо малчид ногоо тарих, гар урлал зэрэг шинэ, нэмэлт орлогын эх үүсвэртэй болсон. Тэд зөвхөн мал аж ахуйн орлоготой байх нь явцгүй боллоо гэдгийг ойлгодог болж байна. Сүүлийн хэдэн жил (2000, 2001, 2002) зуд болж, өвөлжилт хүндэрсэн нь үүнийг хурдан тусгаж ойлгоход нөлөөлсөн нь дамжиггүй. 2001 ба 2003 оныг харьцуулахад малчид одоо эсгий бүтээгдэхүүн (нийт орлогын 7.9 хувь), ногоо тарих (нийт орлогын 4.1 хувь) гэх мэт орлогын шинэ эх үүсвэртэй болоод байна. Энэ хувь ойрын жилүүдэд нэмэгдэнэ гэж найдаж байна.

Хүснэгт 7.3
Малчдын өрхийн орлогын бүтцийн өөрчлөлт 2001, 2003 оноор (n=36)

Орлогын эх үүсвэр	2001 оны орлого	2003 оны орлого
Мах	48.6	41.5
Ноос ноолуур	15.2	18.1
Сүү, цагаан идээ	22.9	17.1
Эсгий бүтээгдэхүүн	-	7.9
Арьс шир	7.1	6.1
Бусад (тэтгэвэр)	6.2	5.2
Хүнсний ногоо	-	4.1

Эх сурвалж: доктор Ц.Цэрэнбалжир, төслийн судлаач, «Хамтлагийн малчдын орлого, зарлагын судалгааны тайлан», 2004. Нийт 36 малчдыг хамруулав.

Малчин өрхөд нэмэлт орлого бий болгоход эмэгтэйчүүд гол үүрэг гүйцэтгэж байна. Хамтлагуудад орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох зорилгор төслөөс дараахь үйл ажиллагааг явуулав:

Малын арьс, хонины ноосоор гар урлалын зүйл хийх: Хамтлагийн

төлөөлөгчид хотод эсгий урлалын сургалтанд сууж, ноос боловсруулах төхөөрөмж төслөөс авсан. Хамтлагийн эмэгтэйчүүд өөрсдийн хэрэгцээнд болон худалдах зорилгоор эсгийгээр хувцас хунар, бусад гар урлалын зүйл хийж байна. Энэ үйл ажиллагааны үр дүнд малчин өрхийн орлого нэмэгдсэн. Түүнчлэн эмэгтэйчүүд «өөрийн» мөнгөтэй болж эхэлсэн нь тэдэнд БНМ-эд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих сан бий болгох боломж олгож байна. Эмэгтэйчүүд боловсруулсан сүү, цагаан идээ, хийсэн гар урлалын зүйл гэх мэт хөдөө аж ахуйн болон бусад бүтээгдэхүүнийг хийж худалдах гүн сонирхолтой байна. Тэдний хийсэн ажил нь үзэгдэж харагдахуйц, шууд мөнгөн хэлбэрийн ач тус (орлого) өгч эхэлсэн. Өөрөөр хэлбэл, өмнө нь хийдэг байсан хөлсгүй хөдөлмөр нь хөлстэй болж ирж байна.

Ногоо тарих: Судалгааны гурван талбарын хамтлагууд төмс, бусад хүнсний ногоо ургуулж байгаа нь өрхийн нэг нэмэлт орлого болж байна.

Эмэгтэйчүүдийн орлого нэмэгдүүлэх ажиллагааг дэмжих жижиг сан: Энэ жил төслөөс эмэгтэйчүүдийн жижиг хэмжээний орлого нэмэгдүүлэх төслийг санхүүжүүлсэн.

Хангайн уулархаг, ойт хээрийн экосистемд амьдарч буй малчид жимс, эмчилгээний зарим ургамал зэргийг өрхийн хэрэглээндээ түүж ашигладаг байв. Одоо тэд эдгээр нөөцийг хууль бус түүгчдээс хамгаалж, өөрсдөө зах зээлд нийлүүлэх зорилгоор цуглуулж эхлэв.

Би Дархан хотод эсгий урлалын сургалтанд суусан. Би шинэ төхөөрөмж ашиглан сайн чанарын эсгий бүтээгдэүүн, гар урлалын зүйл хийхийг сурсан. Энэ нь нэмэлт орлоготой болоход маш өгөөжтэй байсан гэж би бодож байна.(Эмэгтэй 29, малчин)

Энэ жил хамтлагийн сангаас эмэгтэйчүүдэд эсгий бүтээгдэхүүн, гар урлалын зүйл хийх, бусад үйл ажиллагаанд зориулан жижиг зээл олгож эхэлсэн. Үүний ачаар өрхийн орлого нэмэгдэж, эмэгтэйчүүд өөрийн мөнгөтэй болсон.(Эмэгтэй, 34, эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч)

Судалгааны баг одоогийн байдлаар эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг дэмжих санг (магадгүй, эргэлтийн сан байдлаар) хамтлагуудад байгуулах, хамтлагийн хийсэн сүү цагаан идээ, гар урлалын зүйлийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг системтэйгээр зохион байгуулах хувилбаруудыг судалж байна.

ХАМТЫН МЕНЕЖМЕНТ ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент нь хамтлагт болон засгийн газарт түшиглэсэн менежментийн арга хэмжээний хослолын хэлбэртэй байж болно. Хамтын менежмент гэдэг нь цэвэр улсын өмч болон цэвэр олон нийтийн өмчийн дэглэмийн дунд оршдог засаглалын зохицуулалт юм. Хамтын менежмент нь тэгш байхын тулд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг бүхий л үйл ажиллагаандаа шударга, эн тэнцүү оролцуулдаг байх шаардлагатай. Олон тохиолдолд, судалгаа хийх, бодлого боловсруулахдаа эмэгтэйчүүдийн мэдлэг, чадавхийг «зүгээр» мартаж, эсвэл хайхралгүй орхигдуулж байна.

НЭБНТМ-ийн төсөл нь жендэрийн үүрэгт онцгой анхаарал тавьж байна. Хамтын менежментийн талаарх эмэгтэйчүүдийн санаа бодлыг тодруулахын тулд бид 9 хамтлагийн 220 өрхийн 461 эмэгтэйгээс асуумж авсан. Түүнээс харахад хамтын менежментийн хамгийн чухал зорилгод эмэгтэйчүүд дараахь зүйлийг хамруулж авч үзсэн байна. Үүнд:

- Хамтран ажиллах, нийтлэг зорилготой байх
- Үйл ажиллагаагаа төлөвлөх, тодорхой зорилготой ажиллах
- БНМ-ийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх
- Бэлчээр болон байгалийн нөөцийн зүй зохистой хэрэглээ
- Маллагааны менежментийг сайжруулах, малын ашиг шимийг дээшлүүлэх
- Амьжиргааг дээшлүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх
- Малчин, бэлчээртэй холбоотой хууль, журмыг мэдэж авах

- Хамтын менежментийн үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, нэмэгдүүлэх

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүд хамтын менежментийн гэрээнд эмэгтэйчүүдийн санаа бодлыг хэрхэн тусгах талаар маш олон тооны (судалгааны нэг бүсэд 16, нөгөөд 36) санаа дэвшүүлсэн. Дэлүүн сумын Каратау, Бузаукөл хамтлагийн эмэгтэйчүүд эн тэргүүний зорилгоо «хамтын менежментийн үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, нэмэгдүүлэх» гэж томъёолсон байна. Түүний дараа «малын түүхий эдийг боловсруулж, эсгий болон бусад гар урлалын зүйл хийх замаар хамтлагийн орлогыг нэмэгдүүлэх» түүнчлэн «ногоо тарих гэх мэт хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулах замаар хамтлагийн нэмэлт орлогыг өсгөх» гэсэн зорилго орсон байна. Дөрөв, тав дахь зорилго нь «Бусад хамтлагтай туршлага солилцох, сонинг олдоцтой болгох замаар БНМ-ийн талаарх эмэгтэйчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх» «үр цацаж бэлчээрийн доройтлоос сэргийлэх, бэлчээрийн усалгааг сайжруулах, ойн шигүү хэсгээс мод зөөж тарих гэх мэтээр байгалийн нөөцийг нөхөн сэргээх ажиллагаа явуулах» гэсэн байв.

Ой-тал хээрийн экосистемд байдаг Аржаргалант хамтлагийн эмэгтэйчүүд «бэлчээр сэргээх, мод тарих» болон «ногоо тарих гэх мэт өөр эх үүсвэрээс орлогоо нэмэгдүүлэх замаар бэлчээрийн ачааллыг бууруулах» дараа нь, «хамтын менежментийг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулах» зэргийг тэргүүлэх ач холбогдолтой зорилгоо гэж үзсэн байна. Харин Аржаргалантаас нэг жилийн хойно байгуулагдсан Ихбулаг хамтлагийн эмэгтэйчүүд (мөн адил ой-тал хээрийн экологийн системд байдаг) «малын түүхий эдийг боловсруулж гар урлал хийх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэхийг» хамгийн чухал зорилт гэж тодорхойлжээ.

Бэлчээрийн менежментэд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлийн талаарх хамтлагийн эмэгтэйчүүдийн санаа бодлыг судалсан асуумжийн дүнг Зураг 5-д үзүүлэв. Хамтлагт ороогүй нутгийн иргэдтэй гарах маргаан нь эмэгтэйчүүдэд хамгийн том бэрхшээл болж байна.

ХАМТЫН МЕНЕЖМЕНТИЙН ГЭРЭЭНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОДОЛ, СОНИРХЛЫГ ТУСГАХ НЬ

Эмэгтэйчүүд байгалийн нөөцийн менежментийн талаар болон нутгийн ажил амьдралтай холбоотой хамтын шийдвэр гаргалтанд оролцох эрх, бололцоо нь хязгаарлагдмал байгаа ч тэдний дийлэнх нь байгалийн нөөцийн хамтын менежментийг дэмжиж байгаа бөгөөд *гагцхүү* хамтын менежмент нь тэднийг амьжиргааг сайжруулахтай уялдсан байх шаардлагатай гэж үзэж байна.

Ерөнхийдөө, хамтын менежментийн гэрээг хэрхэн сайжруулах тухай эмэгтэйчүүдийн гаргасан санаа нь хоёр хэсэгт хуваагдаж болохоор байна:

Эмэгтэйчүүдийн сонирхлыг төлөөлөх чиглэлээр

- Хамтлагийн ахлагч нь шийдвэр гаргахдаа эрэгтэй, эмэгтэй гишүүдээ татн оролцуулж байх, шийдвэр гаргахынхаа өмнө санаагаа бусадтай хуваалцаж, танилцуулж байх ёстой.
- БНМ-тэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахдаа эмэгтэйчүүдийг оролцуулах.
- Эсгий хийх, гар урлал хийх, сүү цагаан идээ боловсруулах, ногоо тарих зэрэг орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох ажилд эмэгтэйчүүдийн оролцох оролцоог дэмжих.

Хамтын менежментийн гэрээг сайжруулах талаар

- Хамтлагийн болон хамтлагийн биш малчдын дунд явуулах хамтын менежментийн үйл ажиллагааг сумын засаг дарга зохион байгуулж, идэвхжүүлж байх ёстой.
- Багийн засаг дарга нь улирал бүр нутгийн иргэдтэй уулзаж, тэдний санаа бодлыг засгийн газрын дээд шатны хүмүүст хүргэж, орон нутгийн засаг захиргааны бодлоготой илүү сайн уялдуулж байх ёстой.
- Хамтлагийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд хүргэх ажлыг хамтлагийн нягтлан бодох, сум, багийн засаг даргын туслалцаатайгаар хамтран зохион байгуулах шаардлагатай.
- Хамтлагийн ахлагч нар нь хамтлагийн ядуу өрхийн амьжиргааны талаар санаа тавьж, байгалийн нөөцийн

зохистой ашиглалат, хамгаалалт, нөхөн сэргээлттэй уялдуулан хамтлагийн гишүүдийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ авч байх ёстой.

- Тогтвортой менежментэд амжилт гаргаж буй хамтлагийн гишүүдийг урамшуулах шаардлагатай.
- Хамтлагийн гишүүн үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээг тодорхой болгох хэрэгтэй.
- Хамтлагийн гишүүд БНМ-ийн талаарх туршлагаа бие биетэйгээ хуваалцаж, хамтран ажиллаж, хамтлагийн үйл ажиллагаа, сургалтанд идэвхтэй оролцож байх хэрэгтэй.

Монголын бэлчээрийн мал аж ахуйд эмэгтэйчүүд гэрийн ажил хийж ирсэн уламжлалтай тул эмэгтэйчүүдийн гаргасан санааны нэлээд нь үүнтэй холбоотой байв. Энэ нь «Эсгий хийх, гар урлал хийх, сүү цагаан идээ боловсруулах, ногоо тарих зэрэг орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох ажилд эмэгтэйчүүдийн оролцох оролцоог дэмжих» эсвэл «БНМ-ийн талаар хүүхдэд зааж сургах эмэгтэйчүүдийн үүргийг сайжруулах» гэж дурдсанаас харагдаж байна. Эмэгтэйчүүдийн гаргасан хамгийн шинэлэг, чухал санаа бол «хамталгийн шийдвэр гаргалтанд оролцох, санаагаа хамтлагийн хурал дээр илэрхийлэх бололцоог эмэгтэйчүүдэд олгох», «эмэгтэйчүүдийн бүлгийг байгуулах шаардлагатай» гэсэн санаа байлаа.

Эмэгтэйчүүдийн бүлэг нь бэлчээртэй холбоотой асуудлаар хамтын менежментийн үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө байна гэж үзэж байна. дараахь байдлаар илэрхийлсэн байна.

Эерэг нөлөөнд гэрээ бол нутгийн иргэдийн хамтлаг бэлчээрийн зохистой хэрэглээ, байгаль нөөцийн менежментийг хэрэгжүүлэх нэг чухал арга зам, бэлчээрийн сайн менежмент хийснээр мал чийрэгжиж, эрүүлжинэ, бэлчээрийн доройтлоос гарах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хэрэглэгдэхгүй байгаа бэлчээр уст цэг байгуулах боломжууд байна хэмээн үзлээ.

Сөрөг нөлөө нь тухайн орчинд амьдарч буй хамтлагийн гишүүн биш иргэдтэй байнгын маргаан гардаг, өвөлжилт/цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалаад өөр нутгаас хүмүүс нүүж ирэхийг

нь хориглоход хүндрэлтэй, бэлчээр хүрэлцээгүйгээс улирлаар нүүх боломжгүй байдаг (Ялангуяа хангайн уулархаг-тал хээрийн экосистемд буй хамтлагийнхны хувьд), хамтлагийн гишүүд бие биеэсээ хол байдаг тул бэлчээрийн хамгаалалтанд бүх гишүүдийг хамруулахад хэцүү хэмээн үзлээ.

Мөн түүнчлэн эмэгтэйчүүд хамтлагийн шийдвэр гаргалтанд оролцоход гарах зарим сөрөг нөлөөг тодорхойлсон. Хамтлагийн гишүүд бие биеэсээ зайтай амьдардаг тул хурал хийхээр цуглахад цаг их ордог. Хуралд зарим гишүүн оролцоогүй, мэдээлэлгүй байдаг тул зарим шийдвэрийг бүрэн тохирч чаддаггүй, эсвэл хэрэгжүүлж чаддаггүй. Энэ асуудлаар эмэгтэйчүүдийн санал зөрөлдөөнтэй байна: зарим нь «хамтлагийн гишүүд идэвхтэй оролцсон, түүний үр дүнд хамтлаг амжилттай ажиллаж байна» гэж үзэж байхад зарим нь «хамтлагийн гишүүд идэвхтэй оролцохгүй байгаа хамтлагийн зарим үйл ажиллагаа сайн явагдахгүй байна» гэж үзжээ. Түүнчлэн зарим эмэгтэй «хамтлагийн гишүүдийн хоорондын зөрчил үйл ажиллагаа, гишүүнчлэлд сөргөөр нөлөөлж байна» гэжээ.

Дүгнэлт, Тулгамдаж Буй Асуудлууд, Бэрхшээлүүд

Өнөөг хүртэл хийгдсэн нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээний судалгааны хамгийн чухал үр дүн нь сонирхогч талууд байгалийн нөөцийн хамтын менежментэд жендэрийн тэгш эрхийн гүйцэтгэх үүргийг ойлгох байдал нь дээшилсэнд оршино. Түүний зэрэгцээ эмэгтэйчүүд БНМ-д оролцох боломж хязгаарлагдмал байгаа, БНМ-ийн талаар шийдвэр гаргахад эрэгтэйчүүдийн эрх мэдэл давамгайлж байгааг хүлээн зөвшөөрсөн. Уг судалгааны одоо гараад буй гол шууд үр дүн нь хамтлаг, орон нутгийн засаг даргын хооронд байгуулсан хамтын менежментийн гэрээг эргэн нягталж, өөрчилж байгаа явдал юм. Эдгээр гэрээ нь хамтлагийн эмэгтэйчүүдийн санаа, бодлыг тусгадаг боллоо. Тэд цаашид сонирхогч талын уулзалтанд эмэгтэйчүүдийг бүрэн оролцуулах хэрэгтэйг мөн тэмдэглэсэн.

Хамтлагууд дээр «эмэгтэйчүүдийн бүлгийг» байгуулсны үр дүнд

эмэгтэйчүүд хамтрах, бие биэсээ суралцах, туршлага солилцох, мэдлэг, мэдээллээ хуваалцах боломж сайжирсан. Түүнчлэн эмэгтэйчүүдийн бүлэг байгуулагдсанаар БНМ-д жендэрийн тэгш эрхийн хангахад дөхөм үзүүлснээс гадна байгалийн нөөцийн хамтын менежментэд эмэгтэйчүүдийг оролцуулах орчинг буй болгосон. Мөн байгалийн нөөцийг уламжлалт мэдлэг, зан заншлаар хамгаалахад эмэгтэйчүүдийг санаачлагыг хөхиүлэн дэмжиж байна.

Бэлчээр, байгалийн нөөцийн хамтын менежментийн гэрээг одоо эмэгтэйчүүдийн санаа бодлыг тусгах, жендэрийн тэгш эрхийг хангах зорилгоор өөрчилж байна. Эмэгтэйчүүд хамтын менежментэд гүйцэтгэх өөрсдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж эхлэхийн хамт тэд БНМ-ийн талаар хамтлагийн шийдвэр гаргалтанд илүү идэвхтэй, ухамсартайгаар оролцдог болж байна.

Төслөөс хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар сургалт явуулсны үр дүнд эмэгтэйчүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадвар сайжирсан бөгөөд сургалт, туршлага солилцох ажиллагааны үр дүнд эмэгтэйчүүдийн нэмэлт орлого олох мэдлэг, чадвар сайжирсан. Тэд түүний ашиг тусыг хүртэж эхэлж байна.

Гурван чухал асуудал үүсэн гарч байна. БНМ-эд эмэгтэйчүүдийг оролцуулахад нэлээд ахиц гарсан боловч бэлчээр, байгалийн нөөцийн менежментэд эрэгтэйчүүдийн эрх мэдэл давамгайлсан хэвээр байна. Тиймээс, БНМ-ийн талаарх шийдвэр гаргалтанд жендэрийн тэгш эрхийг хангах явдал анхаарах чухал асуудал хэвээр байна. Хоёрдугаарт, хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн уламжлалт хуваарь бараг өөрчлөгдөөгүй боловч зах зээлийн эдийн засагт шилжсэнээр эмэгтэйчүүдийн хөдөө аж ахуйн ажлын ачаалал нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь тэднийг хамтын менежментэд бүрэн дүүрэн оролцоход нь саад болж байна. Гуравдугаарт, БНМ-эд эмэгтэйчүүдийг оролцуулах асуудлыг зөвхөн бэлчээрийн менежментээр хязгаарлалгүй өргөн утгаар нь авч үзэх шаардлагатай байна.

Тулгамдаж буй шийдвэрлэх гол асуудал нь ойлголт нэмэгдүүлэх, өөрчлөлтийн хүчин чармайлтаа үргэлжүүлэх явдал юм. Үүнд хамтын менежментэд эмэгтэйчүүдийг оролцуулахыг үргэлжлүүлэн дэмжих,

улмаар эмэгтэйчүүдийн бүлгийн чадавхийг бэхжүүлэх, хамтлаг, судалгааны талбаруудын хоорондын туршлага солилцох тогтмол үргэлжүүлэх зэрэг багтаж байна.

Монгол эмэгтэй тогтвортой хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэг нь эргэлзээгүй билээ.

Чадавхи Бэхжүүлэх Үйл Явц Болон Сургамж

Судалгааны явцад судлаачдын баг нүүр тулж уулзах, семинар, Виртуаль (Олон улсын веб сайт) нөөцийн төв, Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээний имэйлийн жагсаалт зэргээр дамжуулан бусад түнштэй холбоо тогтоож, сүлжээнд орж чадсан. Энэ нь мэдээлэл солилцох, БНМ-ийн судалгааны практик аргачлалын талаарх мэдлэгээ хуваалцахад тус болсон. Багийн хувьд энэ бол БНМ-ийн чиглэлээр нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ хийх анхны тохиолдол байсан бөгөөд судлаачид үндсэн хөтөлбөрийн бусад оролцогчдоос, ялангуяа Суралцах судалгааны төслөөс их зүйлийг мэдэж авлаа.

БНМ-ийн бүх сонирхогч талууд Хөдөөгийн оролцоот үнэлгээ, төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний арга техникт суралцахын хамт тэдний оролцооны төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн чадавхи сайжирсан. Олон улсын хөгжлийн судалгааны төвөөс сургалт, туршлага солилцох, ном, сурах бичиг болон бусад унших материал хэлбэрээр үзүүлсэн дэмжлэг нь сурах үйл явцад их дөхөм боллоо.

Нутгийн иргэд болон засаг дарга нар илүү жендэрийн мэдрэмжтэй болж, тэдний БНМ-д эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүгийн талаарх ойлголт өөрчлөгдсөн. Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээнд тулгуурлан эмэгтэйчүүдийн бүлэг нь шийдвэр гаргах үйл явц, түүний дотор хамтын менежментийн гэрээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор НЭБНТМ-ийн хамтлаг дээр хийгдэх үйл ажиллагааны санаачлагчид болоод байна. Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил үүнд чухал үүрэг гүйцэтгэж байна. Бэлчээр, байгалийн нөөцийн менежментэд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг эргэцүүлэн бодсоны

үндсэн дээр хамтын менежментийн гэрээг тохируулан өөрчилсөн. Хамтын менежментийн үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцоо мэдэгдэхүйц нэмэгдсэн. Тэд илүү бүтээлч болж, малчин өрхөд орлогын шинэ эх үүсвэр бий болгох болон бусад үйл ажиллагаанд санаачлага гаргаж байна.

ТАЛАРХАЛ

Канадын Олон улсын хөгжлийн судалгааны төвийн доктор Ронный Верной, доктор Жон Грэм, доктор Хайн Малли, доктор Лиз Фажбер нарт судалгааны явцад үнэтэй зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж байсанд талархал илэрхийлэхийг хүсч байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. «Жендэр» НЭБНТМ-ийн санаачлага, Судлаачдад зориулсан унших материал, Ном 1, ОУХСТ, 1998 оны 12 сар, Канада, Оттава
2. Карен МакАлистер, Ронный Верной, «Үйл ажиллагаа ба эргэцүүлэл: Оролцооны судалгаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж» 1999 оны 9 сар, Канада, Оттава
3. Р.Верной, 2000. Хятад. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн хоёрдугаар семинарын материал
4. Жендэрийн тэгш байдлын үндэсний хөтөлбөр. 2002, Монгол Улсын засгийн газар
5. «Байгалийн нөөцийн менежментийн тухай нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ» эхний семинарын тайлан. 2001. Хятад
6. “Монголын эмэгтэйчүүд: Шилжилтийн үеийн ахицыг зураглахуй” НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сан, 2001
7. Х.Ыханбай нар «Монгол дахь нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн менежмент», БОЯ-ОУХСТ төслийн тайлан, 2002, 2003, Улаанбаатар, Монгол
8. Ц. Одгэрэл «Макро, мезо, макро түвшний байгалийн нөөцийн менежмент дэх жендэрийн үүрэг», 2003, НЭБНТМ

төсөл

9. Б. Наранчимэг «Байгалийн нөөцийн хамтын менежмент дэх эмэгтэйчүүдийн оролцоо», 2003, НЭБНТМ төсөл

8

НИЙТЛЭГ БОЛОН ЯЛГААТАЙ АСУУДЛУУД

Нөхцөл байдлыг танин мэдсэнээр нийгмийн өөрчлөлт хувирал хийхийг зорихуй



ЗУРАГ АВСАН: РОННЫЙ ВЕРНОЙ

РОННИ ВЕРНОЙ, ЛИНШУ ЖАН

Юу нь түгээмэл, юу нь онцлогтой байгааг харах зорилго бүхий зургаан жишээлсэн судалгааны үр дүнг дурдсан хоёр бүлэг дууслаа. Харин энэхүү бүлэгт бид нийгмийн ба жендэрийн харилцаа нь судалгаа явагдсан газрууд дахь байгалийн нөөцийн менежментэд хэрхэн нөлөөлж байгааг, байгалийн нөөцийн менежментийн арга хэмжээ нь эргээд нийгмийн ба жендэрийн харилцаанд хэрхэн нөлөөлж байгааг авч үзлээ. Бид тухайн орчинд менежментийн практикийг бүрдүүлж буй хүчин зүйлийг судлахын зэрэгцээ тэгш эрх болон байгаль орчны тогтвортой байдлын тухайд шинээр үүсэн бий болж буй зарим асуудлыг хөндлөө.

Судалгааны гол үр дүнг тоймлон хүргэх нэг арга зам нь дүрслэн үзүүлэхээс эхлээд өөрчлөн хувиргах хүртэл үргэлжлүүлж, 1 дүгээр бүлэгт дурдсан “эмэгтэйчүүд ба хөгжил”, “жендэр ба хөгжил” гэсэн хандлагын гол шинж чанартай холбон авч үзэх явдал юм. Энэхүү үргэлжилсэн шугам нь жендэрийн үүрэг болон жендэрт суурилсан тэгш биш байдлын талаарх ойлголтыг дээшлүүлэх ажлаас эхлээд жендэрийн болон нийгмийн судалгаа, дүн шинжилгээний талаарх мэдлэг, үр чадвараа дээшлүүлэх, хөдөө аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд, малчин эмэгтэйчүүдийн эдийн засаг, улс төрийн эрх мэдлийг дээшлүүлэх хүртэл өргөн хүрээг хамарна. Зургаан жишээлсэн судалгаа бүр энэхүү үргэлжилсэн шугамын зарим элементүүдийг, өөрөөр хэлбэл, “эмэгтэйчүүд ба хөгжил”, “жендэр ба хөгжил” хандлагын онцлог шинж чанарыг агуулна. Тийм ч учраас бодит амьдралын нөхцөл байдлаас харахад онолын хувьд давхцах зүйл цөөнгүй гарч байв. Түүнчлэн эдгээр судалгаанаас хэд хэдэн бэрхшээлтэй асуудал гарсан бөгөөд нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээг судалгаа, хөгжлийн асуудалд нэгтгэн авч үзэх, тэгш эрхт харилцаа тогтооход цаг хугацаа шаардагдах билээ.

Бид хаанаас эхэлсэн билээ гэдгээ цухас санахын ялдамд нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээг байгалийн нөөцийн менежментийн судалгаанд нэгтгэн авч үзэх нь яагаад чухал байдгийг дахин дурдъя. Үүнд:

1. Байгалийн нөөцийн нөөцийг ашиглах боломж, хэрэглээ, хяналтыг хэрэгжүүлж буй нийгмийн болон эрх мэдлийн

харилцааг илүү сайн ойлгож, таньж мэдэх. Энэ нь нийгмийн оролцогч талууд, орон нутгийн нөхцөл байдал дахь ялгаа, тэгш биш байдлыг ойлгож мэднэ гэсэн үг юм.

2. Технологи, бодлого, үйл ажиллагааны нийгмийн болон жендэрийн мөн чанарыг хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг үзүүлэх. Бодлого, технологи нь тодорхой үнэ цэнийг агуулж байдаг бөгөөд эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдэд харилцан адилгүй нөлөө үзүүлдэг.
3. Нийгмийн оролцогч талуудад (эмэгтэй, эрэгтэй хүмүүс) амьдралдаа өөрчлөлт хийх боломж гаргах, гадуурхагдсан, ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хэлэлцээ хийх, чадавхийг сайжруулах, улмаар тэдний чадавхийг бэхжиж, байгалийн нөөцийг ашигладаг, хяналт тавьдаг, үр шимийг нь хүртдэг болгох

Жишээлсэн Судалгааны Тойм

Аливаа түгээмэл болон онцлог зүйлийг эрэлхийлэхийн өмнө эдгээр жишээгээр дамжуулан судалсан үйл явцын гол шинж чанарыг товчхон дурдъя (Бүлэг 2-7).

Сикким/Баруун Бенгал, Энэтхэг

Сармисны үйлдвэрлэл, худалдаанд голлон анхаарсан Сикким/Баруун Бенгалын жишээлсэн судалгаа нь нийгмийн бодит байдал ихэвчлэн маш ярвигтай, зарим үед зөрчилтэй байдаг гэдгийг харуулж байна. Жендэрийн асуудлууд үндэстэн ястан, анги давхарга зэрэг нийгмийн бусад хувьсагчтай харилцан үйлчлэх бөгөөд өнөөгийн зүй тогтлыг тодорхойлогч томоохон хүчин зүйл нь түүх юм. Соёл, үндэсний онцлог, уламжлал (түүний дотор цээрлэдэг зүйл) зэрэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарь, хөдөлгөөнд нөлөөлдөг байна. Тус судалгаа нь өрхийн нийгэм-эдийн засгийн ялгаа их, нас, соёлын өөрчлөлтөөс үүдэн эмэгтэйчүүдийн

дунд шинэ ялгаа үүсч байна гэж үзжээ. Нийгмийн бүлгүүдийн хувьд, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдмал, зээл авах боломж тааруу зэрэг нь үйлдвэрлэлээ сайжруулах чадавхид нь сөргөөр нөлөөлдөг ажээ. Эрэгтэйчүүд л газар өмчлөх эрхтэй. Өрхийн мөнгөн орлого, зарлагад хяналт тавих боломж ихэнх эмэгтэйчүүдэд хязгаарлагдмал байна.

Ядуу хүмүүсийн газар өмчлөх боломж хязгаарлагдмал, тиймээс үйлдвэрлэлээ өргөжүүлэх боломж нь мөн л хязгаарлагдмал байдаг байна. Түүнчлэн газар өмчлөх боломж хязгаарлагдмал байдаг тул ядуу хүнд туршин үзэх боломж огт үгүй бөгөөд засгийн газрын дэмжлэг авахад ч бэрхшээлтэй байдаг. Непалаас гаралтай Сиккимийн үндэсний цөөнхийн хувьд засгийн газрын дэмжлэг болон судалгаанд ихэнхдээ хамрагдаж чаддаггүй байна.

Нагаланд, Энэтхэг

Нагаландийн жишээлсэн судалгаанаас бид хотжилт явагдаж, хүнсний хэрэглээний дадал өөрчлөгдөхийн хэрээр өөрийгөө л арай ядан тэтгэж байсан эдийн засаг хэрхэн зах зээлийн эдийн засаг болон хувирч, улмаар хүнсний ногооны хэрэгцээ огцом нэмэгдсэнийг харсан билээ.

Ойн бүтээгдэхүүнийг цуглуулдаг, хүнсний ногоог борлуулах гол хүмүүс нь эмэгтэйчүүд байдаг. Гэхдээ эмэгтэй борлуулагчид эдийн засгийн хувьд болон нийгмийн байдлын хувьд ялгаатай нөхцөлд байдаг. Зах зээлийн гинжин сүлжээ бүрэн хөгжөөгүй (тухайлбал, тээвэрлэлтийн сүлжээ хангалтгүй), мөн засгийн газрын чадавхи сул, үйлчилгээ тааруу тул эмэгтэй худалдагч нар олон бэрхшээлтэй тулгардаг. Зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлнэ гэдэг нь улс төр-нийгмийн гүн гүнзгий, ярвигтай үйл явц бөгөөд түүнд эмэгтэйчүүд саяхнаас л оролцож эхэлсэн билээ. Тус жишээлсэн судалгаанд эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэж, хувь нэмэр оруулж байгаа боловч Нагаландийн эмэгтэйчүүдийг эдийн засгийн агент, иргэн хэмээн бүрэн хүлээн зөвшөөрч, зохих ёсоор хүндэтгэхгүй байна.

Хэрэгцээ ихэссэн нь байгалийн нөөцөд ч нөлөөлж, нийгэм,

эдийн засагт гарсан өөрчлөлт ул мөрөө үлдээж байна. Хүнсний ногооны талбай хаагдаж, ойн нөөц шавхагдан хумигдсанаар зарим айл амьдрах аргагүйд хүрч байхад заримынх нь өмнө богино хугацаанд ч атугай өргөн боломж нээгдэж байна.

Балба (Непал)

Непалын эмэгтэйчүүд хөдөө аж ахуй, үрийн үйлдвэрлэлд маш чухал үүрэг гүйцэтгэдэг боловч зохих ёсоор үнэлэгддэггүй. Зохиогчдын үзэж байгаагаар Непалын засгийн газрын чиглэл, дэмжлэгээр явагдаж буй технологийн хөгжлийн үйл явц жендэрийн асуудлыг огт бодолцоогүй, баян хүмүүсийн эрх ашгийг илүүтэй анхаарсан шинжтэй байна. Харин сүүлийн үед нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээний учир холбогдлыг онол, үзэл баримтлалын түвшинд хүлээн зөвшөөрөх тал дээр зарим өөрчлөлт гарч байна. Гэхдээ ийнхүү хүлээн зөвшөөрч байгааг эргээд практик арга хэмжээ болгох, нийгэм, жендэрийн асуудлыг тусгасан, мэдээлэлтэй бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх нь томоохон зорилт хэвээр байна. Жендэрийг “эмэгтэйчүүд” хэмээн ойлгож, жендэрийн асуудлыг шийдвэрлэх арга зам нь “эмэгтэйчүүдийн” төсөл гэж үзэх тал байна. Жендэрийн асуудлыг анхаарсан судалгаа саланги явагдаж, түүнийг бусад асуудалтай хамтатган авч үзэх нь ховор байна.

Талбар дээрх судалгаанаас үзэхэд хөдөөгийн амьдралын дүр зургийг нийгмийн байдал, эд баялгийн шатлал голлон тодорхойлдог байна. Үрийн үйлдвэрлэлийг голлон судалсан тус жишээ нь ядуу, боловсролгүй хүмүүс уламжлалт болон орчин үеийн алинаас нь ч хүртэж тэр бүр чаддаггүй, үүнээс үүдэн амьжиргаа нь доройтдог болохыг үзүүлжээ. Албан болон албан бус үрийн системийг холбож өгөх нь нэг шийдэл бөгөөд төслийн оролцоотойгоор нөөцийг ашиглах боломж, орлогыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн биологийн төрөл зүйлийг хадгалах тал дээр тодорхой ахиц гарч байна.

Гуанши, Хятад

Хятадын хөдөө аж ахуйд эмэгтэйчүүд улам бүр их үүрэг

гүйцэтгэх болсон нь өнөөдөр тус улсын хөдөөгийн амьдралын хамгийн том өөрчлөлтийн нэг болоод байна. Түүнчлэн ядуу, баяны ялгаа (эрүүл мэнд, боловсрол зэрэг суурь үйлчилгээг ашиглах боломж бололцоо ч үүнд хамаатай) улам бүр нэмэгдэж байна. Засгийн газраас тодорхой бодлого баримталж байгаа ч үндэсний цөөнхүүд олон талаар орхигдон хоцорсон хэвээр байгаа ажээ. Тэдний тухайн орон нутагтай учир холбогдолтой мэдлэг, ур чадварыг нийгэм, судлаачид зохих ёсоор үнэлэхгүй байна. Биологийн төрөл зүйлийн хадгалалт, үр тариаг сайжруулахад фермийн аж ахуйтнуудын оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, үнэлэх систем алга. Үрийн зах зээл, түүний дотор нутгийн болон нутагшуулан сайжруулсан үрийн сортын зах зээл сайн хөгжөөгүй байна. Өрхийн хүнсний хангамжийн асуудал шийдэгдээгүй, ялангуяа даяаршил, чөлөөт зах зээл хүрээгээ тэлж байгаагаас үүдэн өндөрлөг газар, үндэсний цөөнхийн амьдардаг бүсэд хүнсний хангамжийн асуудал улам бэрхшээлтэй болж байна. Байгаль орчны асуудал газар авч, ноцтой болж ирэв. Нийгмийн болон жендэрийн асуудлын тухайд гэвэл хэдийгээр зарим өөрчлөлт гарч байгаа боловч засгийн газар, судалгааны байгууллагуудын ойлголт, мэдлэг, төлөвлөлт сул байгааг тус жишээлсэн судалгаа тэмдэглэжээ.

Дээр дурдсан өөрчлөлтийн нэгийг Хятадын судалгааны баг ашигласан бөгөөд тал бүрийн оролцогчид, тэдний хамтын хүчин чармайлтанд тулгуурлажээ. Үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа нь эмэгтэй аж ахуйтнуудын ноу-хау буюу яаж хийх тухай мэдлэгийг ургамал, үр тариа үржүүлэгчдийн туршлагатай холбох ажлыг газар дээр нь туршихад голлон анхаарсан. Уг туршилтанд бүтээмж, байгаль орчны тогтвортой байдал, хүмүүсийн чадавхи, чадавхийг бэхжүүлэх асуудлыг авч үзсэн. Түүнчлэн үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа нь хөдөөгийн амьдрал, амьжиргааг хөндсөн хэд хэдэн бодлогод нөлөөлөх, өөрчлөх зорилго тавьсан байна. Тэдгээр бодлогын асуудал нь хөдөө аж ахуйн сургалт, үрийн хадгалалт, оюуны өмч, хөдөө аж ахуйтны эрх зэргийг хамарсан байна.

Хью, Вьетнам

Хятад, Непалын жишээтэй гайхмаар адилхан нэг зүйл нь Вьетнамын эмэгтэйчүүд хөдөө аж ахуйд эрэгтэйчүүдээсээ илүү хувь нэмэр оруулдаг, гэвч тэдний ажлыг засгийн газраас хүлээн зөвшөөрөхгүй байгааг Вьетнамын судалгаа харуулсан явдал юм. Засгийн газрын ихэнх бодлого, хөтөлбөр жендэрийн мэдрэмжгүй, цаасан дээр жендэрийн талаар бичдэг байж болох ч практик амьдрал дээр жендэрийн асуудалд анхаарал тавихгүй байна. Тийм ч учраас эмэгтэйчүүд болон ядуу аж ахуйтнууд боловсрол, үйлчилгээ, мэдээллээс (тухайлбал, судалгааны дүн) тэгш хүртэж чадахгүй байгааг судалгааны талбараас цуглуулсан мэдээлэл дээрээ түшиглэн тэмдэглэжээ. Судалгааны багийнхны үзэж байгаагаар, (өндөрлөг газрын) аж ахуйтнууд засгийн газраас хэрэгжүүлж буй техник технологийн үйлчилгээ, боловсрол, сургалт зэргээс суралцаж чаддаггүй, энэ нь технологи эзэмших, амьжиргаагаа дээшлүүлэхэд нь сөргөөр нөлөөлдөг ажээ.

Хөдөөгийн хөгжлийн сургалтын дизайн, уг сургалтын явуулж байгаа байдал нь жендэрийн болон нийгмийн хувьсагчийг хэр зэрэг анхаарч байгааг уг судалгаанд баримтжуулан тусгаж, дүн шинжилгээ хийжээ. Хөдөө аж ахуй эрхлэгч олон хүмүүс (тэдний дотор эмэгтэйчүүд) хөдөө аж ахуйн шинэ технологи, практикийг сурахдаа эрэгтэйчүүд илүү сайн гэж хэлсэн бөгөөд орон нутгийн удирдлага, хөдөө аж ахуйн сургалтын ажилтнууд ч үүнтэй санал нэг байна. Түүнчлэн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдэд мэдлэгийг автомат тархаан хүргэдэг гэж тэд боддог байна (сургалтанд зөвхөн эрэгтэйчүүд хамрагдаж байгаа асуудалд тэд тайван хандаж байгаагийн нэг шалтгаан). Тус судалгаагаар энэхүү жендэрийн мэдрэмжгүй үзэл бодол, түүнээс уламжлан гарч буй үр дагаврыг шүүмжилсэн байна.

Хятадын нэгэн адил Вьетнамд макро-эдийн засгийн асар том өөрчлөлт явагдаж байна. Гэхдээ эдийн засгийн өсч байна гэдэг нь ядуурал буурч, тэгш байдал, байгаль орчны тогтвортой байдал сайжирч байна гэсэг үг биш. Харин ч хот хөдөө, өндөрлөг болон нам дор газар, үндэсний олонхи болон цөөнхийн хоорондын ялгаа улам

бүр нэмэгдэж байна. Оролцоонд тулгуурласан, үйл ажиллагаанд чиглэсэн судалгаагаар дамжуулан Вьетнамын судалгааны баг дээрх асуудлуудыг шийдэхэд ямар нэг ахиц гаргахыг эрмэлзэж байна. Тэд орон нутгийн сонирхлын бүлгүүдийн туршилт, санаачлагыг дэмжин, хөдөөгийн ядуу хүмүүс, эмэгтэйчүүдэд өөр төрлийн сургалт, үйлчилгээ хүргэж байна. Мөн бодлогын хэд хэдэн асуудалд анхаарал тавин ажиллаж байгаа ажээ.

Монгол

Монголд байгалийн нөөц, ялангуяа бэлчээрийн доройтол маш эрчимтэй явагдаж, малчны амьдралын уламжлалт хэв маягийг хадгалахад улам бүр бэрхшээлтэй болоод байна. Макро түвшинд авч үзвэл тус улсад маш хурдацтай өөрчлөлтүүд (либералчлал, хотжилт, ардчилсан алхмууд) хийгдэж байна. Гэхдээ хуучин ЗХУ давамгайлж байсан түүх, засгийн газрын дээрээс доош чиглэсэн хэвээр байгаа удирдлагын хэв маяг, байгаль орчны хүчин зүйлээс шалтгаалсан хязгаарлагдмал байдал, уламжлалт практик, итгэл үнэмшилд тулгуурласан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарь, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, шилжилт зэрэг нь амьжиргааны хэв маягийн сонголт, өөрчлөлт хийх боломжийг хязгаарлагдмал болгодог байна. Баян, ядуугийн ялгаа нэмэгдэж байна. Непал, Вьетнам, Хятад зэрэг хөдөө аж ахуйн эдийн засагтай улс орнуудын нэгэн адил байгалийн нөөцийн менежментэд малчин эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэдэг боловч засгийн газар ч, малчид ч үүнийг дутуу үнэлдэг байна. Шийдвэр гаргахад тэгш оролцож чаддаггүй, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрх мэдэл тэнцвэртэй биш байдаг. Орон нутгийн мэдлэг, практикийг ихэнхдээ үл тоомсорлон орхигдуулдаг.

Судалгааны багийн зүгээс судалгаа ба хөгжлийн асуудалд шинэ арга барил баримтлан, нийгмийн болон жендэрийн мэдрэмжтэй бодлого, хууль, оролцоонд түшиглэсэн хамтын менежментийн гэрээ, амьжиргааны шинэ хэв маягийг хэрэгжүүлэхийг эрмэлзэж байгаа юм. Тэд судалгааны талбар дээр янз бүрийн үйл ажиллагаа явуулж, малчид, засгийн газрын ажилтнууд, судлаачдад оролцоонд

түшиглэсэн хөдөөгийн үнэлгээ, нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ, оролцоонд тулгуурласан хяналт-шинжилгээ, үнэлгээ, үндэсний болон олон улсын сүлжээнд нэгдэх, үндэсний бодлого боловсруулах явцад оролцох, хуулийн төсөл боловсруулахад оролцох зэрэг чиглэлээр зорилтот бүлгийн сургалтууд зохион байгуулжээ. Үйл ажиллагаанд чиглэсэн судалгааны шинэлэг хоёр ажлыг дурдвал малчдын хамтлагийг төлөвшүүлэн бүрдүүлсэн, малчин, орон нутгийн засгийн газрын ажилтнууд болон иргэний нийгмийн гишүүдээс бүрдсэн бэлчээрийн хамтын удирдлагын багийг бий болгосон явдал юм.

Ойлголт, Мэдлэг Сайжирсан Байдал

Илүү сайн мэдлэгтэй болсон, орон нутгийн мэдлэгийг зохих ёсоор үнэлсэн, байгалийн нөөцийн менежмент дэх нийгмийн болон жендэрийн хүчин зүйлийн талаарх ойлголт дээшилсэн зэрэг нь эдгээр зургаан жишээлсэн судалгаанаас харагдсан гол үр дүн юм. Тэдгээр судалгаанд хөдөөгийн өрхүүд үр тариа (Непал), хүнсний ногоо (Нагаланд), сармис (Сикким/Баруун Бенгал), эрдэнэ шиш (Хятад), мал аж ахуйн үйлдвэрлэл, борлуулалтыг хэрхэн зохион байгуулж байгааг нарийвчлан үзүүлсэн. Түүнчлэн жендэрийн үүрэг нь хөдөлмөрийн хуваарь болон орлого бий болж, хуваарилагдаж буй, мөн зарим үед хуваарилагдахгүй байгаа үйл явцад хэрхэн нөлөөлж буйг баримтжуулан харуулж, дүн шинжилгээ хийжээ. Жендэрийн үүрэгт дүн шинжилгээ хийхдээ дараах зүйлийг харгалзан үзсэн болно. Үүнд:

1. Байгалийн нөөцийн менежментэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, тэдний орон нутаг болон түүнээс дээшхи түвшин дэх харилцааны талаарх үзэл бодол. Судалгааны багууд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн “дуу хоолойг” аль болох сонсохыг хичээсэн.
2. Арга, хэрэгсэл, түүнчлэн тэдгээрийг нөхцөл байдал болон соёлын хувьд зохистой байдлаар хэрхэн ашиглах, түүхэн өөрчлөлтийг хэрхэн харгалзан үзэх

3. Жендэрийн ялгаатай байдал. Яагаад ийм ялгаа оршиж байна вэ? Яагаад, яаж өөрчлөгдөж байна вэ? Өөрөөр хэлбэл, дүрслэн үзүүлэх зорилго бүхий судалгаа, баримтжуулалтаас тайлбарт судалгаа, тайлан руу хэрхэн шилжих вэ?
4. Судалгааны үйл явц дахь жендэрийн үзэл бодол, үүрэг. Энэ бол шинээр үүсэн бий болж буй маш чухал сэдэв юм. Энд дурдсан судалгаанууд нь энэхүү асуудалд гол анхаарлаа хандуулж хараахан чадаагүй боловч судалгааны багууд цаашид түүнийг судлах сонирхлоо илэрхийлээд байгаа билээ.

Сикким/Баруун Бенгалын судалгаанд цаг хугацааны туршид явагдсан өөрчлөлт болон өнөөдрийн төвөгтэй нөхцөл байдлыг сармисны үйлдвэрлэл, борлуулалт дахь үндэстэн ястны асуудал, жендэр, анги давхарга, насны асуудлын зангилаан дунд харуулсан. Үүрэг, хариуцлагын тухай зарим нэг ойлголт, түүнчлэн талбай, зах зээл зэрэг хөдөө хотын орон зайд нэвтрэх боломжийг зохицуулах дүрэм журмаас шалтгаалан эмэгтэйчүүдийн дийлэнх нь эрэгтэйчүүдийн эрхшээлд байгааг дурдсан байна. Гэхдээ зарим эмэгтэйчүүд, ялангуяа залуу эмэгтэйчүүд өөрчлөлт гарах боломжийг бий болгож байгаа билээ.

Монголд эрэгтэйчүүд бэлчээр сонгох, хадлан авах, малаа хариулах, хуралд суух, бизнесээ удирдах зэрэг гэрээс гадуурх чухал ажлыг нугалж өгдөг. Гэхдээ эрэгтэйчүүдийн хийдэг ажлын ихэнх нь улирлын чанартай байхад эмэгтэйчүүдийн хийдэг ажил өдөр, жилийн турш үргэлжилж байдаг. Тэд сүү боловсруулах, хүүхдээ асрах, гэрээ цэвэрлэх, арчлах гэх мэт байнга давтагдах гэрийн ажлыг амжуулж байдаг. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн нэг өдрийн ажлын ачаалал эрэгтэйчүүдийнхээс илүү боловч ихэвчлэн хөлсгүй хөдөлмөр байна. Эмэгтэйчүүд ажлын ачааллаас шалтгаалан байгалийн нөөцийн менежментийн талаарх нутгийн олон нийтийн шийдвэр гаргах үйл явцад оролцоход бэрхшээлтэй тулгардаг ажээ.

Дээрх бүхий л судалгаанаас либералчлал, хувьчлал, үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол) үнэ төлбөртэй болгох зэрэг макро-нийгмийн хүчин зүйлсийн үзүүлж буй ялгаатай нөлөөг харж

болохоор байна. Эдгээр хүчин зүйлс нь эрэгтэйчүүд гадагш цагаачлан гарах (Хятад, Непал) гэх мэт олон өөрчлөлтийг дагуулж, улмаар хөдөлмөрийн хуваарьт ч зарим өөрчлөлт илэрч байна. Ажлын ачаалал ч өөрчлөгдөж байна. Үүний үр дүнд эмэгтэйчүүд илүү их ажиллах болж, хөлсгүй хөдөлмөр нь ч нэмэгдэж байгааг баримт жишээнүүд харуулж байгаа юм. Хэдийгээр Монгол, Хятад, Вьетнам, Нагаланд зэрэг газарт зарим эмэгтэй орлогоо нэмэгдүүлэх шинэ арга зам нээн олж байгаа ч нийгмийн үйлдвэрлэлийн хөлсгүй үйл явцад эмэгтэйчүүд гол үүрэг гүйцэтгэдэг хэвээр байгааг аль ч судалгаанаас харж болохоор байгаа билээ.

Нагаландийн эмэгтэйчүүд бол зэрлэг ногоо, ойн дайвар бүтээгдэхүүн, түлшний мод, малын тэжээл зэрэг ойн нөөцийг түүж цуглуулан өрхийн хэрэгцээгээ хангадаг гол хүмүүс юм. Тэрхүү нөөц барагдан дуусч байгаа нь эмэгтэйчүүдэд шууд нөлөө үзүүлж, тэдний ажлын ачаалал ихсэхэд хүргэж байна. Ойн нөөц амьжиргаанд нэмэр болоод зогсохгүй өрхийн үндсэн орлогыг бүрдүүлдэг тул нөөц хомсдож байгаа нь хүмүүсийн амьдралд ч шууд нөлөөлж байна.

Хятадад фермийн ядуу аж ахуйтнуудын дунд эмэгтэйчүүд, *de facto* буюу бодит амьдрал дээр эмэгтэй нь тэргүүлэн авч яваа өрх харьцангуй өндөр хувийг эзэлж байгаа ажээ. Эмэгтэйчүүд гол тариалагч, хүнсний үйлдвэрлэгч болоод байгаа ч өрхийн уламжлалт үүргээ давхар гүйцэтгэдэг хэвээр байна. Түүнчлэн засгийн газар, захиргаанд эмэгтэйчүүд төлөөлөл дутмаг, тэдний гүйцэтгэж буй үүргийг хүлээн зөвшөөрдөггүй, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээ, сонирхол, туршлагыг үл хайхардаг байдал түгээмэл байна. Зээл авах, зах зээлийн мэдээлэл олж авах, сургалтанд хамрагдах зэрэг суурь үйлчилгээнд эмэгтэйчүүд хамрагдах нь хязгаарлагдмал байна.

Вьетнамд ч байдал дээрхтэй адил төстэй байна. Хьон талаарх судалгаанаас үзэхэд өндөрлөг газар амьдардаг эмэгтэйчүүд гэрийн ажилд эрэгтэйчүүдээс даруй 10 дахин их цаг зарцуулдаг бөгөөд тэдний талбай дээр ажиллах хугацаа ч эрэгтэйчүүдийнхээс илүү байна. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдэд шийдвэр гаргах, хөрөнгө нөөцөд хяналт тавих боломж бараг байдаггүй ажээ. Засгийн

газраас хэрэгжүүлж буй хөгжлийн хөтөлбөрүүдэд нийгмийн болон жендэрийн хүчин зүйлийг харгалзан үздэггүй. Хөгжлийн холбогдогдолтой ихэнх үйл ажиллагааны талаарх шийдвэрийг эрэгтэйчүүд л гаргадаг.

Сармисыг худалдаалдаг болсноор Сикким/Баруун Бенгалд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Брахмин-Чхетрийн ардууд үйлдвэрлэгч хүчин болохын хувьд Рай, Лепча нарыг зугуухан гүйцэн түрүүлж байна. Сармисны үйлдвэрлэлд зориулсан шинэ газрыг эзэмшин ашиглаж байгаа бөгөөд шинэ технологи нэвтрүүлж байгаа юм байна. Эдгээр өөрчлөлтийн улмаас тариалалт болон түүнтэй холбоотой гол шийдвэр гаргах, хяналт тавих явц дахь жендэрийн үүрэг өөрчлөгдөж байна. Сармис ургуулах, хэрэглээнд тавих хяналт зэрэгт эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг мэдэгдэхүйц суларчээ.

Монголын нүүдлийн бэлчээрийн аж ахуйн хувьд байгалийн нөөцийн менежментэд эмэгтэй, эрэгтэй хүмүүс өөр хоорондоо ялгаатай боловч адилхан чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ байгалийн нөөцийн хэрэглээ, шийдвэр гаргалт, хэрэгжүүлэлт зэрэгт эмэгтэйчүүдийн гүйцэтгэх онцлог үүрэг, оролцоог дутуу үнэлж иржээ. Судалгаа хийх, бодлого боловсруулахдаа эмэгтэйчүүдийн мэдлэг, чадварыг үл тоомсорлодог тохиолдол олон. Байгалийн нөөцийн менежмент дэх эмэгтэйчүүдийн оролцоог дөнгөж саяхнаас л харгалзан үзэх болжээ. Байгаль орчны менежмент, хадгалалтанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг анхаарлын төвд багтсан бөгөөд тэдний хөдөлмөр, хувь нэмрийг зохих ёсоор хүлээн зөвшөөрөх байдал нэмэгдэж байна. Улмаар эмэгтэйчүүдэд ирэх дэмжлэг ч аажимдаа нэмэгдэх хандлагатай байна.

Ургамал, ургамлын үржүүлгийн талаарх эмэгтэйчүүдийн мэдлэг, биологийн төрөл зүйлийг хадгалан хамгаалахад тэдний оруулж буй хувь нэмрийг хэд хэдэн судалгаанд тусгайлан тэмдэглэсэн байна. Хятад, Непалын судалгаа үүнийг дэлгэрэнгүй харуулсан бол Сикким/Баруун Бенгал, Нагалангийн судалгаанд тодорхой зарим хэсгийг дурджээ. Мөн жендэрийн асуудал анги давхаргын асуудалтай хэрхэн холбогдож байгааг судалгаанууд хөндсөн байна. Непалд үрийн үйлдвэрлэл, борлуулалтын талаарх шийдвэр гаргаж буй байдлыг

үзэхэд баян өрхөд эрэгтэйчүүд, дундаж болон ядуу амьдралтай өрхүүдэд эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран шийдвэрээ гаргадаг байна. Баян өрхөд үрийн сонголтыг эрэгтэй нь давамгайлан хийдэг байхад дундаж болон ядуу өрхөд эмэгтэйчүүд ч оролцдог байна. Ургацаа авсны дараахь ажлууд болох цэвэрлэлт, хадгалалт зэрэг нь нийгэм-эдийн засгийн ялгаанаас үл хамааран зөвхөн эмэгтэйчүүд хийдэг ажил юм. Дундаж болон ядуу өрхийн эрэгтэйчүүд улирлын чанартай ажил хийхээр цагаачлан явж байгаагаас жендэрийн үүрэг өөрчлөгдөж, үрийн сонголтод эмэгтэйчүүд илүүтэй оролцох болжээ.

Хятадын судалгаа мөн л хөдөө аж ахуйн сургалт дахь эмэгтэйчүүдийн мэдлэг, туршлагад анхаарал хандуулж, тэд аливаа зүйлийг өөрөөр хийх зориг гаргасан тухай дурдсан. Тэд дээрээс доош чиглэсэн, нийлүүлэлтийг голлосон аргыг доороос дээш чиглэсэн, эрэлтэд тулгуурласан үйлчилгээ болгохыг зорьж, судалгааны үйл явцад маш идэвхтэй оролцжээ. Вьетнамын сургалтын зарим ажилтнууд энэхүү аргыг сонирхон судалж байна.

Зургаан судалгаа бүгд нийгмийн харилцаа нь байгалийн нөөцийн менежментийн оршин буй тухайн практикт хэрхэн нөлөөлж байгааг өрхөөс эхлэн тосгон, түүнээс дээшхи түвшинд авч үзжээ. Эрэгтэйчүүд цагаачлан явах нь олон газар түгээмэл болоод байгаа Хятадын жишээ үүний нэг тодорхой тохиолдол юм. Ийнхүү эрэгтэйчүүд нь цагаачлан явж байгаагаас хөдөө аж ахуйтан, фермийн аж ахуй гэдэг нь эмэгтэйчүүдийн толгойлсон, эмэгтэйчүүдийг ажиллуулдаг аж ахуй болоод байна. Эмэгтэйчүүд нөөцөөс хүртэх боломжоо дээшлүүлэхийн тулд нийгмийн шинэ харилцаанд хэрхэн идэвхтэй оролцож байгааг судалгаанууд дурджээ. Тухайлбал, Нагаландийн эмэгтэй худалдагчид зах зээлийн харилцаанд идэвхтэй оролцож, Монголын малчин эмэгтэйчүүд хамтын менежментийн хороодтой харилцдаг болсон байна.

Хэдийгээр Нагаландэд ихэнх эмэгтэй зах зээлд анхлан хөл тавьж буй боловч тэд бусадтай найз нөхөд болж, бие биеэсээ ч суралцаж байна. Кохимад цагаа өнгөрөөж байгаа нь эмэгтэй худалдагчдад бусад хотын бизнесийн талаар мэдэж авах, жишээлбэл, хүнсний зүйлийг хаана илүү үнэ хүргэн борлуулж болохыг олж мэдэхэд тус

дөхөм болдог. Вьетнамд хөдөө аж ахуйн шинэ практикийг туршин үзэх, сургалтанд хамрагдах, зөвлөгөө авах, маркетингийн ажиллагаа явуулах зэрэгт эмэгтэйчүүдийн туршилтын бүлгүүд бий болгожээ. Монгол эмэгтэйчүүд бэлчээр, байгалийн бусад нөөцийн хэрэглээ, удирдлагад илүү нөлөөтэй ажиллахын тулд хамтын ментийнн багт нэгдэн орцгоож байна.

Эмэгтэйчүүд судалгааны ажлыг маш их сонирхон, идэвхтэй оролцож байгаа нь судалгааны явцад нийгмийн харилцаа, боломж хэрхэн үүсэн бий болж байгааг харуулсан өөр нэг жишээ гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Хятадад хөдөө аж ахуйн сургалт, ургамал үржүүлэгч, мөн Хятадын Хөдөө аж ахуйн бодлогын төвийн судлаачидтай холбоо тогтоосны үндсэн дээр шинэ мэдээлэл, шинэ үрээс хүртэх боломжтой болсон. Иймэрхүү боломжууд улам өргөжин тэлж байна.

Судалгааны бүх багийн хувьд судалгааны үйл явц нь өөрөө тодорхой үр дүнд хүрэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. Янз бүрийн газар орон дахь (гэр, тариалангийн талбай, зах, мөн төслийн хүрээнд зохион байгуулсан олон төрлийн сургалт, аялал гэх мэт) эмэгтэй, эрэгтэй аж ахуйтнууд, малчидтай нүүр тулан холбогдон ажилласнаар судлаачид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өдөр тутмын амьдрал, тэмцэл, мэдлэг, санаа бодол, сонирхдог зүйл, санаа зовнидог зүйл, бэрхшээлийн талаар илүү сайн ойлголттой болсон. Газар дээр нь очиж ажиллах, сүлжээ, холбоо тогтоон ажилласнаар нээлт хийх, шинэ зүйлийг сурч мэдэх зам нээгдэж байв. “Шинэ” арга, хэрэглүүр ашиглаж, туршиж байсан нь нүд нээж, шинэ санаа сэдэх боломж олгож байв. Аливаа зүйл эсвэл хүмүүсийн талаар судалгаа хийхийн оронд хүмүүстэй хамтран, тэдэнд зориулсан судалгаа руу шилжсэн. Судалгааны шинэ арга барил, практик үүсэн бий болж байна.

Дээрх судалгааны үр дүнд судлаачид хэд хэдэн томоохон сургамж авсан. Үүнд, нийгмийн болон жендэрийн ярвигтай харилцаа нь хөдөө аж ахуйтнуудын дасан зохицол, шинэчлэлд нэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Үүнийг ойлгож, судлахгүйгээр шинжлэх ухаанч, шинэ технологийг нэвтрүүлэх ажил амжилттай явагдаж, хөдөө аж ахуйтнуудад таран түгж чадахгүй билээ. Нийгмийн ба жендэрийн

дүн шинжилгээг нэгтгэн авч үзэх нь үйл ажиллагаанд чиглэсэн аливаа судалгаа, хөгжлийн төслийн үндэс байх ёстой юм (Олон улсын хөгжлийн судалгааны төв, 2004).

Ургамал үржүүлэгчид, хөдөө аж ахуйн сургалтын үйлчилгээ үзүүлэгчид, хөдөө аж ахуй эрхлэгч эрэгтэйчүүд болон бодлого боловсруулагчид гэх мэт чухал сонирхогч талууд жендэрийн илүү мэдрэмжтэй болсон бөгөөд хөдөөгийн хөгжилд гүйцэтгэх эмэгтэйчүүдийн үүрэг, тэдний онцлог хэрэгцээ, сонирхлыг арай сайн ойлгодог болсон байна (Олон улсын хөгжлийн судалгааны төв, 2004).

Өөрчлөлт

Өөрчлөгч чадвар гэдэг нь үүрэг, хариуцлагын талаар яагаад ийм байх ёстой вэ гэдгийг нь асууж, тайлбар өгч, өөрчлөх чадвар бөгөөд аливаа зүйлийг илүү үр ашигтай хийхээс арай өргөн хүрээг хамарна. Энэхүү сүүлд дурдсан хэсэг нь үр өгөөж гэсэн ойлголтод багтана (Кабьер 2003, 174). Жишээлсэн судалгаануудад өөрчлөх зорилго бүхий суралцах явцыг ямар нэг хэмжээгээр хөндсөн. Энэ бол хүмүүс хамтдаа илүү нэгдмэл, хэн нэгнийг орхигдуулаагүй дэлхий ертөнцийг байгуулах арга барил юм. Суралцах үйл явцаар дамжуулан тэд дэлхий ертөнцийн талаарх өөрсдийн ойлголтыг хамтдаа өөрчилнө (Ван дер Вин 2000, Верной, МакДугалл 2003). Нөөцийн менежмент дэх суралцах үйл явцын илрэл нь, тухайлбал, фермийн аж ахуйтан, малчдын гаргаж, амьдрал ахуйдаа хэрэглэж буй шийдвэртэй холбоотой шинэ үнэт зүйлс, зүй тогтол юм. Өөрчлөх зорилго бүхий суралцах явц нь онолоор баталгаажсан практикийг зориуд идэвхжүүлж, түүнийг гадуурхагдан гадуурхагдсан хүмүүсийг эрх мэдэлжүүлэх, хүмүүний системийг сайжруулахад ашигладаг.

Сонирхлын бүлгийг бий болгосон, үйлдвэрлэл, борлуулалтын явц дахь эдийн засгийн шинэ нөөцийг бий болгон хөгжүүлэхэд тэдний хүчин чармайлтыг чиглүүлсэн явдал нь дээрх жишээлсэн судалгаануудын өөрчлөгч шинж чанар бүхий хэсэгт хамаарагдана. Тухайлбал, Хятад, Вьетнам, Монголын жишээ. Түүнчлэн хэрэгцээ

болон байж болох шийдлийг илрүүлэх, ач холбогдлын дарааллыг тогтоох, хэрэгжүүлэх боломж олгосон систем, үйл явцад утга учиртай оролцох, өөрсдийн тодорхойлсон хэрэгцээ, ач холбогдлыг тойрон нэгдэх байдал ажиглагдаж байна (нийгэм-улс төрийн хувьд чадавхийг бэхжүүлэх). Өөрөө өөртөө эзэн болох буюу эрх мэдэлжих энэхүү хоёр хэлбэрийн талаар дараачийн хэсгүүдэд дурдах болно.

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ НӨӨЦ, БОЛОМЖУУД

Судалгааны хэд хэдэн баг ядуурлыг бууруулах нэг алхам болгон нэмэлт орлого олох эдийн засгийн шинэ боломжийг эрэлхийлж байна. Түүнчлэн эдгээр санаачлага нь эмэгтэйчүүдийн бие даасан эдийн засгийн агент байх чадавхийг сайжруулах зорилготой. Непал, Хятадад хийгдсэн үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа нь үрийг зах зээлд нийлүүлэх асуудалд голлон анхаарсан бол Монголын жишээ малын уламжлалт бүтээгдэхүүнд боловсруулалт хийн өртөг нэмэхэд, харин Вьетнамын судалгаа гахай, нугас зэрэг тодорхой төрлийн барааг сонгон үйлдвэрлэл, борлуулалт явуулахад чиглэсэн. Энэ бүх үйл ажиллагаа нь зөвхөн эдийн засгийн агуулгатай байсангүй. Хийнгээ суралцах явцдаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, хэлэлцээ хийх, хөнгөвчилж өгөх, харилцах гэх мэт нийгэм, улс төрийн олон шинэ ур чадварыг хөгжүүлж, сайжруулсан байна.

Хятадын нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээ бүхий үйл ажиллагаанд чиглэсэн судалгааны баг фермийн аж ахуйтан олон эмэгтэйг чадавхижуулж, тэдний бүлгийг бэхжүүлсэн байна. Эдгээр эмэгтэй өрх гэртээ, нутаг орныхоо түвшинд нийгэм, эдийн засгийн олон том үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцдог болоод байна. Үрийн үйлдвэрлэл, борлуулалтанд оролцдог болсноор эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэл нэмэгдэж, чадавхи нь дээшлэн, ганц нэгээрээ ч, бүлгээрээ ч өрхийн болон нутаг орныхоо түвшинд орлогын шинэ эх үүсвэр бий болгох болон бусад үйл ажиллагаа явуулахад илүү идэвхтэй, санаачлагатай хандах болжээ (Олон улсын хөгжлийн судалгааны төв, 2004).

Фермийн аж ахуйтнуудыг үр сонгох, чанарын хяналт тавих чадвартай болгох нь чанартай үр олж авах явдлыг дээшлүүлэх анхны алхам юм. Нутгийн олон нийтэд түшиглэсэн байгууллагуудын чанарын хяналт тавих чадавхийг бэхжүүлснээр үр үйлдвэрлэлийн тогтвортой хөгжил хангагдана. Түүнчлэн орон нутгийн чанартай үрийн зах зээлийг бий болгох нь фермийн аж ахуйтнуудад хөшүүрэг болж, орон нутгийн биологийн төрөл зүйлийг хадгалахад хувь нэмэр оруулж байна (Олон улсын хөгжлийн судалгааны төв, 2004).

ХАМТАРСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Хувь хүний чадавхийг бэхжүүлэх нь нэн чухал, гэхдээ нийгэмд өөрчлөлт авчрах, жендэрийн тэгш байдлыг дэмжихэд хамтын үйл ажиллагаа хичнээн хүчтэй вэ гэдгийг бид энэхүү номноос харлаа. Кабиэрийн (2003:194) тэмдэглэсэнчлэн, энэ нь жижиг хэмжээний өөрчлөлтийг илүү өндөр түвшинд институтчилах чухал арга зам ажээ. Зарим үед эдгээр хамтын үйл ажиллагаа нь улс төрийн түвшинд ч явагдаж болох юм. Монголын судалгаанд дурдагдсан хамтын менежментийн ярилцлага, хэлэлцээрт оролцож буй малчин эмэгтэйчүүд үүний нэг тод жишээ билээ. Хэдийгээр улс төрийн үйл явдлын тавцан дээр явагддаггүй боловч тэдгээр үйл ажиллагааны агуулга улс төрийн шинжтэй бөгөөд Вьетнам, Хятадын эмэгтэйчүүдийн бүлгүүд үүний тодорхой жишээ болж байна. Аливаа зүйлийг өөрөөр хийх, үйлдвэрлэл, маркетингийн одоо оршин буй зүй тогтол, практикийг өөрчлөн сайжруулахын тулд эмэгтэйчүүд өөрсдөө зохион байгуулалтанд орж байна. Нагаландийн эмэгтэй худалдагчид хүнсний ногоогоо борлуулах өдөр тутмын тэмцлийнхээ хүрээнд улс төрд оролцож байна.

Олон талын сонирхогч бүлгийнхний хамтын ажиллагаа маш чухал үүрэгтэй, гэхдээ үүнийг хэлэхэд амархан, хийхэд хэцүү. Улаанбаатар дахь Олон улсын хоёрдугаар семинарын үеэр (1 дүгээр бүлгийг харна уу) энэ асуудлыг дараахь үндсэн алхмын хэлбэрээр тоймлов билээ. Үүнд:

1. Сонирхогч талуудыг татан оролцуулах

2. Сонирхогч талуудын нарийвчилсан шинжилгээг хийх (гүйцэтгэх үүргийг тодорхойлох, нэгдмэл буюу хамтын зорилгоо тодорхойлох)
3. Сайн дурын оролцоо
4. Нэгдмэл сонирхол, өөриймсөг хандах байдлыг хөгжүүлэх
5. Гэрээг албан ёсоор “байгуулах” (жишээлбэл, Монгол дахь хамтын удирдлагын гэрээ)
6. Байнга эргэн нягталж, тохируулга хийж байх
7. Өргөн хүрээнд түншлэл, сүлжээ бий болгох

Хамтын ажиллагаа зөв чиглэлд явагдаж байгаа эсэхийг тогтоохын тулд үйл явцыг системтэй баримтжуулж байх нь чухал. Харгалзан үзэх ёстой хоёр үндсэн асуулт бол хэн хамтран ажиллаж байна вэ, хэрхэн хамтран ажиллаж байна вэ гэсэн асуулт юм. Ерөнхийдөө, зургаан баг бүгд эдгээр алхмыг даган мөрдөх тухайд тодорхой ахиц гаргаад байгаа боловч хэд хэдэн жишээний хувьд тодорхой сонирхогч талыг татан оролцуулж, хамтран ажиллах тал дээр илүү анхаарах шаардлагатай.

Монголын багийн хувьд байгалийн нөөцийн менежментэд нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг анх удаа хийсэн бөгөөд судлаачид бусад багийнхний туршлагаас маш их зүйлийг олж мэдсэн. Хамтлагийн гишүүд, орон нутгийн засаг дарга нар жендэрийн илүү мэдрэмжтэй болж, байгалийн нөөцийн менежментэд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийн талаарх тэдний ойлголт өөрчлөгдөөд байна. Нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээ хийсний дараа эмэгтэйчүүдийн бүлгүүдийн зүгээс нутгийн олон нийтэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн үйл ажиллагааг санаачилж, шийдвэр гаргах үйл явц, хамтын удирдлагын гэрээнд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх зорилготой ажиллах болсон байна. Эмэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагыг тусгах зорилгоор хамтын менежментийн гэрээнд ч өөрчлөлт оруулжээ. Ийм үйл ажиллагаанд эмэгтэйчүүд оролцох нь нэмэгдсэн. Тэд улам бүтээлч болж, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг өрхүүдэд орлого бий болгох болон бусад үйл ажиллагаануудыг санаачилжээ (Олон улсын хөгжлийн судалгааны төв, 2004б).

Хятадын баг дараахь зүйлийг тэмдэглэн хэлж байна. Үүнд: Хөдөө аж ахуйтнууд өөрсдөө зохион байгуулалт/менежментэд орох, бие даасан чадавхитай байх нь маш чухал гэдгийг манай жишээлсэн судалгааны эмэгтэйчүүдийн бүлэг мөн харуулсан. Тэд тухайн явагдаж буй үйл явцад өөрөө өөрсдөө зам гарган, өөрсдийгөө авч явж байна. Хятадын нөхцөл байдалд эмэгтэйчүүдийн болон фермийн аж ахуй эрхлэгч бусад бүлэг, нутгийн олон нийт буюу хамтлагийг бэхжүүлэх нь өөрөө өөрсдийгөө зохион байгуулах, бие даан чадавхиа бэхжүүлэх анхны алхам болж өгдөг. Эмэгтэйчүүдийн бүлэг болон анхан шатны түвшинд хөдөө аж ахуйн сургалт явуулагчдын хамтын ажиллагаа нь хөдөө аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд системтэй дэмжлэг авах, албан ёсны (судалгаа шинжилгээ, үр гэх мэт) тогтолцоотой холбоотой байх боломжийг бүрдүүлж өгдөг (Олон улсын хөгжлийн судалгааны төв: 2004а).

Тоймлон Дүгнэхүй

Өмнөх бүлэгт дурдагдсан фермийн аж ахуй эрхлэгч эмэгтэй, эрэгтэй хүмүүс, түүнчлэн малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн өнцгөөс харахад нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээ гэдэг нь юуны өмнө дараах хоёр асуултыг асууна гэсэн үг юм. Газар, ус, ой, ан амьтнаа хамгаалахын зэрэгцээ амьжиргаагаа бид яаж сайжруулж зохистой түвшинд хүргэх вэ? Орон нутгийнхаа нийгэм-эдийн засаг, нийгэм-улс төрийн амьдралд хэрхэн утга учиртай оролцож сурах вэ? Эдгээр суурь асуултаас бусад асуултууд урган гарна. Байгалийн нөөцөө бид яаж хамгийн зохистойгоор ашиглаж, удирдах вэ? Гэр бүлээ хооллож ундлах, хувцаслах, хүүхдүүддээ боловсрол олгох, магадгүй бага хэмжээний мөнгийг хадгалах, эсвэл хөрөнгө оруулах боломжтой байхын тулд бид яаж орлого олох вэ? Үүнийг хэрэгжүүлэхийн тулд бид өөрсдөө яаж зохион байгуулалтанд орох вэ? Ажлаа эхлүүлэхдээ бид ямар үүрэг, хариуцлага хүлээх ёстой вэ?

Дүн шинжилгээ талаас нь харвал, жишээлсэн судалгаануудад дурдсанаар нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээ хийнэ гэдэг нь хөдөлмөрийн хуваарь болон жендэр, анги, давхарга, яс үндэс, нас зэрэг нь түүнд хэрхэн нөлөөлж байгааг судална гэсэн үг. Түүнчлэн институцийн байгалийн нөөцийн менежментийн дүн шинжилгээ

буюу бүтээгдэхүүн, орлогын тухайд мөрдөж буй дүрэм журам, эрх, үүрэг, эрх мэдэл, тавьж буй хяналт зэргийг тодорхойлон судалж, хөдөөгийн амьжиргаа, ялангуяа байгалийн нөөцийн менежментэд нөлөөлж буй бодлогын үйл явцыг шүүмжлэлт өнцгөөс судлан үзэх оролдлого хийгдэв. Түүнийг хэрэгжүүлэхдээ туршилтын эсвэл сонирхлын бүлэг байгуулах, шинэ буюу олон талын оролцогчдын холбоо үүсгэх, чадавхи бэхжүүлэх болон чадавхийг бэхжүүлэх стратегийг хэрэгжүүлэх, ухуулга сурталчилгаа гэх мэт янз бүрийн арга замаар бодлогод мэдээлэл өгч, түүнд нөлөөлөх зэрэг оролцоон суурилсан үйл ажиллагаанд чиглэсэн судалгааны олон арга ашигласан байна.

Хэд хэдэн шинж чанар түгээмэл ажиглагдаж, сонирхол татаж байв. Юуны өмнө, зах зээлийн либералчлал, хувьчлал, хамтрал тарсан, бүтцийн шинэчлэл хийгдсэн, хүн амын өсөлт, хотжилт зэрэг олон хүчин зүйлийн улмаас байгалийн нөөцөд учрах дарамт нэмэгдсэн байна. Хэдийгээр зургаан судалгаанд эдгээр хүчин зүйлийн шинж байдал нь өөр өөрөөр илэрч буй боловч ерөнхийдөө өрсөлдөөнт орчин үүссэн, нөөцийг ашиглах боломж хязгаарлагдмал болсон, ашиг тусыг хувааж хүртэхгүй байгаа зэрэг түгээмэл хандлага ажиглагдаж байв. Хэд хэдэн судалгаанд энэхүү хандлагыг сөрөн зогсож, эмзэг бүлгийнхэнд арай илүү боломж олгох оролдлого хийсэн. Суурь нөөц хумигдаж байгаа нь эргээд тухайн үйлдвэрлэлийн цаана оршин буй нийгмийн хүчин зүйл өөрчлөгдөхөд хүргэж байна.

Хоёрдугаарт, дээр дурдсан хүчин зүйлс нь нийгэмд илүү ялгарал гарахад хүргэж, эсвэл түүнийг дагалдан үүсч байна. Энэ нь янз бүрийн хэлбэрээр илэрч байгаа юм. Тухайлбал, баян ядуугийн, хот хөдөөгийн, үндэсний олонхи болон цөөнхийн хоорондох ялгаа гүнзгийрэх; хөдөө аж ахуйд үндсэндээ эмэгтэйчүүд л ажилладаг болох (Хятадын жишээн дээр илүү тодорхой харагдсан) зэрэг юм. Ийнхүү ялгаа гүнзгийрч байгаа нь газар, ус, бусад нөөцөд илүү дарамт учрахад хүргэж байгаа бөгөөд тухайлбал, ядуу хүн өөр аргагүй учраас ийнхүү нөлөөлж байгаа бол баян хүн хэрэгцээ нь өссөнөөс байгаль орчинд илүүтэй дарамт учруулж байна.

Гуравдугаарт, амьдрах хэв маяг, үнэт зүйлс, баримталдаг дүрэм журам зэрэг ястан үндэстний асуудал нэлээд чухал нийгмийн хүчин зүйл болоод байна. Жишээлсэн судалгаануудад үзүүлсэнчлэн, энэ асуудал байгалийн нөөцийн менежментэд олон талаар нөлөөлдөг боловч судалгаа, бодлого зэрэгт ихэвчлэн дутуу тусгадаг эсвэл орхигдуулдаг байна.

Дөрөвдүгээрт, дээрээс доош чиглэсэн хатуу бодлого үргэлжилсээр байгаа нь орон нутгийн бодит амьдралд нөлөөлж, нэлээд олон тохиолдолд фермийн аж ахуйтан, малчдын амьдралыг хүндрэлтэй болгож байна. Гэхдээ бодлогын хувилбар, засгийн газар болон иргэний нийгмийн хооронд шинэ түншлэл бий болгох боломж бүрдүүлэх зэрэг чиглэлээр эрэл хийгдэж байгаа нь харагдаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Хятадын Жишээлсэн Судалгааны Тайлан (Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төв, 2004, Оттава)
- Монголын Жишээлсэн Судалгааны Тайлан, (Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төв, 2004, Оттава)
- Непалийн Жишээлсэн Судалгааны Тайлан (Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төв, 2004, Оттава)
- Кабир Н Мянганы Хөгжлийн Зорилтууд. Ядуурлыг Бууруулахад Жендэрийн Үзэл Баримтлал, Бодлого Боловсруулагчид Болон Бусад Оролцогч Талуудад Зориулсан Гарын Авлага, Амьжиргааны байдлын нарийн бичгийн дарга нарын газар, Лондон, Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төв, Канадын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, 2003, Оттава
- Van der Veen, R. (2000). Learning Natural Resource Management. In M. Loevinsohn, J. Berdegué and I. Guijt, eds, *Deepening the Basis of Rural Resource Management, Proceedings of a Workshop, 16-18 February 2000*, pp. 15-22, The Hague: International Service for National Agricultural Research; Santiago: RIMISP.
- Vernooy, R. and C. McDougall (2003). Principles for Good Practice in Participatory Research: Reflecting on Lessons from the Field. In B. Pound, C. McDougall and A. Braun, eds, *Managing Natural Resources for Sustainable Livelihoods: Uniting Science and Participation*, pp. 113-41. London: Earthscan; Ottawa: International Development Research Centre.

9

НИЙГЭМ БОЛОН ЖЕНДЭРИЙН СУДАЛГААГ ЗАЙЛШГҮЙ ТУСГАХ ШААРДЛАГАТАЙ БОЛОХ НЬ



ЗУРАГ АВСАН: РОННЫЙ ВЕРНОЙ

РОННЫЙ ВЕРНОЙ БОЛОН ЛИНШҮ ЗАН НАР

ЧАДАВХИ БЭХЖҮҮЛСЭН АМЖИЛТУУД БОЛОН ЦААШИД ШИЙДВЭРЛЭВЭЛ ЗОХИХ АСУУДЛУУД

Тус номонд орсон зургаан жишээлсэн судалгаа нь дүрслэн үзүүлэх шинж чанар бүхий нийгмийн болон жендэрийн судалгаанаас эхлээд өөрчлөн хувиргах шинж чанар бүхий үйл ажиллагаанд чиглэсэн судалгааг хүртэл өргөн хүрээтэй ажлыг хамран тусгасан билээ. Тэдгээр судалгаанд түгээмэл тохиолдож буй зүйл бий ч ялгаатай зүйл ч их байна. Тэрхүү ялгаа нь судалгааны суурь дэвсгэр (түүх, газар зүй, судлаачдын мэдлэг, ур чадвар, фермийн аж ахуй эрхлэгч болон малчдын мэдлэг туршлага) судалгааны асуулт, аргын хоорондын харилцан үйлчлэлээс үүдэлтэй юм. Түүнчлэн хүмүүсийн нэгдэл, нийгмийн ялгарал, өөрчлөгдөн буй нөхцөл байдал чухал үүрэгтэй гэдгийг харуулж өгсөн. Жендэрийн хүчин зүйл яс үндэс, анги давхарга, нас зэрэг нийгмийн бусад хүчин зүйлтэй хэрхэн харилцан үйлчилж байгааг дэлгэн үзүүлэв. Нийгмийн тэдгээр хүчин зүйлээс үүдэлтэй тэгш биш байдлыг гэрчлэн харуулахын зэрэгцээ нийгэмд өөрчлөлт хийсэн өөдрөг жишээг ч дурджээ.

Төгсгөлийн энэхүү бүлэгт зургаан судалгаанд оролцсон судлаачид болон бусад хүмүүсийн чадавхийн тухайд ямар амжилтанд хүрснийг тэмдэглэх бөгөөд цаашид шийдвэрлэвэл зохих бэрхшээлтэй асуудлыг товч авч үзэх юм. Гэхдээ эхлээд анх хаанаас эхэлснээ эргэн саная. Бидэнд байгалийн нөөцийн менежмент, түүний дотор биологийн төрөл зүйлийн судалгаанд нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ хийхэд тулгарах олон бэрхшээл (1 дүгээр бүлэг), Суралцах санаачлагаар дамжуулан тэдгээрийг шийдвэрлэх гэсэн хүсэл л байсан.

1. Байгалийн нөөцийн менежментийн судлаач болон судалгааны менежерүүдийн дунд нийгмийн ухааны шинжлэх ухааны судалгааны мэдлэг, туршлагатай хүн цөөн байв.
2. Ихэнх судалгаанд нийгмийн шинжлэх ухааны бүрдэл хэсэг нь байгалийн шинжлэх ухааны бүрдэл хэсгээсээ ихэвчлэн саланги явагдаж байв.
3. Судлаач, судалгааны байгууллагуудын нийгмийн болон

жендэрийн асуудлын талаарх мэдлэг туршлага, сонирхол ялгаатай байв.

4. Судалгаа болон судалгааны бодлогод жендэрийн асуудлыг тусгахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх нь сул байв.
5. Богино хугацааны сургалт үр дүн муутай байв.
6. Азид нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ, байгалийн нөөцийн менежментэд зарцуулах хөрөнгө нөөц дутмаг байв.
7. Сүлжээ бий болгох нь ашиг тус авчрах боломжтой боловч амьдрал дээр хэрэгжүүлэхэд хэцүү байв.

Энэхүү бүлэгт дурдсан амжилт, бэрхшээлийг дээрх долоон асуудалтай хялбар холбогдох юм.

Чадавхийг Бэхжүүлэх Арга Замууд

Оролцооны арга, хэрэглүүрийг ашигласан судалгааны шинэ хэлбэр, фермийн аж ахуйтан бие биедээ, малчид өөр хоорондоо зааж сургах хөдөө аж ахуйн сургалт (тухайлбал, Вьетнам, Хятад, Монгол), орон нутаг дахь хөгжлийн ажил зэрэг нь дүрслэн үзүүлэхээс өөрчлөн хувиргах хүртэлх замын дунд хавьд оршин буй амжилтууд юм. Багууд оролцооны аргаар хийсэн хөдөөгийн үнэлгээнээс эхлээд чанарын судалгааны техникүүд хүртэл судалгааны төрөл аргуудыг ашигласан. Судалгааны багийнхны сонирхож байсан судалгааны өөр өөр асуултад хариулахын тулд өөр хоорондоо ялгаатай арга шаардагдаж байв.

Байгалийн нөөцийн менежментийн судлаачид, судалгааны менежерүүдийн нийгмийн шинжлэх ухааны мэдлэг, туршлагыг нэмэгдүүлэхэд бидний авч үзсэн жишээлсэн судалгаа бүгд хувь нэмэр оруулсан билээ. Нийгмийн шинжлэх ухааны бүрдэл хэсгийг байгалийн шинжлэх ухааны бүрдэл хэсэгтэй нэгтгэн авч үзэхийн тулд багууд ихээхэн хүчин чармайлт гаргасан. Энэ нь цуглуулсан мэдээлэлд триангуляц хийх боломж олгохын зэрэгцээ судлаачид хийнгээ суралцах чухал арга хэмжээ болж чадсан. Цаашид дадлагаа

нэмэгдүүлснээр цаашид чадвараа улам хөгжүүлэх, орон нутгийн онцлогт тохируулан арга, хэрэглүүрээ боловсронгуй болгох боломжтой юм.

Жишээлсэн судалгаанд оролцогч багууд нийгмийн суралцах үйл явцад татагдан оролцлоо. Нийгмийн суралцах үйл явц гэдэг нь байгалийн нөөцийн тухайд өөр өөр сонирхол бүхий нийгмийн хэд хэдэн оролцогч тал янз бүрийн түвшинд хамтран ажиллах явц юм (Рулинг, 2002). Энэ бол бие биеэсээ суралцах явц юм. Бүх зургаан баг нийгмийн суралцах явцын учир холбогдлыг ойлгох, яаж хэрэгжүүлэх талаар нэлээд амжилтанд хүрсэн. Энэхүү амжилт нь судалгааны оролцсон судлаачдын хэлэлцээ хийх (Нагаланд), аж ахуй эрхлэх, менежментийн туршлага (Непал, Нагаланд, Хятад, Вьетнам, Монгол), зохицуулан зохион байгуулах ур чадвар (Монгол, Хятад), оролцооны аргаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх суурь ур чадвар (Монгол, Вьетнам, Хятад), сурталчилгаа хийх ур чадвар (Нагаланд, Монгол, Хятад) зэрэг олон талыг хамарсан. Судалгааны багуудад тустай бусад ур чадвараас дурдвал харилцааны ур чадвар (бүх багууд, ялангуяа Сикким/Баруун Бенгалын баг), сургалт явуулах ур чадвар (Вьетнам, Монгол) зэрэг орно. Бүх багууд судалгааны туршид хөгжүүлж сайжруулсан сүлжээ байгуулан ажиллах ур чадвараа үнэлж байгаа билээ.

Вьетнамын баг сэтгэгдлээ дараах байдлаар илэрхийллээ. Үүнд:

Бид харилцааны төрөл бүрийн хэрэгсэл болон хяналт, үнэлгээ зэрэг оролцооны аргууд ашигласан. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр бид хөдөө аж ахуйтнуудын оролцоо нэмэгдэж, ийнхүү оролцоо нэмэгдэхийн хэрээр гарсан үр дүнг хүлээн авах нь хялбар, түгээмэл болж байв. Түнчлэн хөдөө аж ахуйтнууд хялбар арга техникийг илүү хурдан сурдагийг бид ажигласан. Тэд судлаачдад итгэдэг болсноор судлаачдын дэвшүүлсэн саналыг ойлгон хүлээн авч, өөрсдөө ч санаагаа нээлтэй илэрхийлдэг болсон. ... Оролцооны арга нь эмэгтэйчүүдийн үүрэг, хэрэгцээг анхааран авч үзэхэд тус дөхөм болсон. Эрэгтэйчүүд ярьж байх хооронд эмэгтэйчүүд л ихэвчлэн талбай дээр ажиллаж байдаг. Хөдөө аж ахуйтнуудын оролцоо нь судалгааны үр дүнг үнэлэхэд ч тустай байлаа. Бүлгийн хурал, ферм дээрх семинар зэрэг нь тэдэнд өөрийн үнэлгээ

хийх боломж олгосон (тус номын 6 дугаар бүлгээс).

Сикким/Баруун Бенгалын баг дараах зүйлийг тайландаа дурдсан.
Үүнд:

Сүлжээ, Олон улсын хөгжлийн судалгааны төвийн дэмжлэг маш тустай байсан. Сүлжээний анхны семинар (Бээжинд, 1 дүгээр бүлгийг харна уу) дээр төслийн санал боловсруулах талаар олж мэдэж, дэмжлэг авсан нь уг саналаа тодорхой, ойлгомжтой болгоход ихээхэн тус боллоо. Хоёрдугаарт, Олон улсын хөгжлийн судалгааны төвийн хөтөлбөрийн ажилтнууд газар дээр нь ирж ажиллаж байсан нь чухал бөгөөд судлаачдад бэрхшээл, асуудлаа хуваалцах боломж олгож байв. Ажлын явц, орхигдсон зүйл, тулгарч буй бэрхшээлийн талаар ярилцаж байсан нь асуудлыг шийдэж, шаардлагатай шийдлийг олоход тус болсон. Гуравдугаарт, сүлжээний бусад багуудад ажлын ахиц, явцын талаар харилцан мэдээлж, танилцуулж байсан нь судлаачдад урам өгч, шинэ санаа төрүүлж байв. Эцэст нь, Улаанбаатарт болсон хоёрдугаар семинар (1 дүгээр бүлгийг харна уу) дээр судалгааны багууд болон Олон улсын хөгжлийн судалгааны төвийнхөн уулзаж, хүрсэн үр дүнгээ танилцуулснаар ажлаа хэрхэн сайжруулах, юуг нь сайжруулах вэ гэдэг талаар маш их зүйл мэдэж авсан. Түүнээс гадна талбар дээр болсон явдал, туршлагаасаа сүлжээнийхэнтэйгээ нүүр тулан уулзаж ярилцах боломжийг уг семинар олгосон юм (Олон улсын хөгжлийн судалгааны төв 2004г).

Судлаачид энэхүү судалгааг хийснээр маш их зүйлийг сурч авахын зэрэгцээ тэдэнтэй хамтран ажилласан фермийн аж ахуйтан эрэгтэй, эмэгтэй хүмүүс, малчид, худалдаачид мөн л их зүйлийг мэдэж авсан. Тухайлбал, Хятад, Непал, Нагаландийн хувьд маркетингийн ур чадвар, Хятад, Непалын хувьд ургамал үржүүлгийн ур чадварыг эзэмшсэн. Түүнчлэн сонирхлын бүлэг буюу судалгааны бүлэг бий болгон удирдах гэх мэт цоо шинэ ур чадвараас суралцсан (Хятад, Вьетнам, Монгол). Нагаланд, Хятад, Вьетнам, Монгол, магадгүй Непалын жишээнээс харахад бодлого боловсруулагчид (ядуу) эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээ, сонирхлыг илүү анхаарал тавих болжээ.

Нагаландийн баг дараах зүйлийг бичсэн байна. Үүнд:

Сонирхогч талуудын зүгээс нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээний аргачлалын суралцаж, чадавхиа бэхжүүлэх үйл явц нь янз бүрийн түвшинд явагдсан. Тэдэнтэй харилцаж байх явцад хүн бүр л тодорхой хэмжээгээр ямар нэг зүйлийг сурч мэдсэн нь илт байв. Зарим нь нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээний талаар мэдрэмжтой болсон бол зарим нь хэлэлцээ хийх талаар ойлголттой болсон. Мөн зарим сонирхогч тал урт хугацааны төлөвлөлтийн үйл явцдаа нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг нэгтгэн авч үзэж байна. Үйл ажиллагаанд чиглэсэн, нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг харгалзан үзсэн судалгаа хийснээрээ бид судалгааны ур чадвараа дээшлүүлж, судалгаагаар шийдэх асуудалд хандах хандлага маань илүү системтэй болж ирсэн. Бид бодит орчин нөхцөлийг илүү сайн ойлгодог болж, анхдагч түвшний сонирхогч талууд, ялангуяа янз бүрийн мөлжлөг, зүй бус харилцаа, дарамтанд өртөх эрсдэл өндөртэй худалдагч нарт тулгарч буй асуудал илүү мэдрэмжтэй хандах боллоо. Хагас орон тоогоор ажилладаг эдгээр худалдагч нар фермдээ үйлдвэрлэсэн хамгийн сайн бүтээгдэхүүнээсээ бага зэрэг ашиг олохын тулд маш их бэрхшээлтэй тулгардаг. Судалгааны явцад эмэгтэй худалдагчид болон бидний дунд сэтгэл санааны дотно харилцаа үүссэн бөгөөд энэ нь бидний харилцааг улам бэхжүүлсэн. Бид шийдвэр гаргагч нарт нөлөөлөхийн тулд хэлэлцээр хийх ур чадвараа хөгжүүллээ. Түүнчлэн худалдагч нарын дуу хоолойг олон нийтэд хүргэхийн тулд хэвлэл мэдээллийг ашиглаж, бодлогын шийдвэр гаргагчидтай ажиллах болсон (Олон улсын хөгжлийн судалгааны төв 2004б).

Сүлжээ үүсгэн ажиллах нь олон талын ашиг тус авчирсан. Түүнчлэн хийнгээ сурах нь маш чухал ач холбогдолтой гэдэг нь туршлагаас харагдаж байна. Тулгарч буй бэрхшээлийг даван туулахын тулд газар дээр нь байнгын дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөн, явцын дунд практикийг онолын (оролцоог хангасан) суурь хүрээтэй холбон авч үзэж байв. Тухайн явагдаж буй үйл явцыг өөрчлөн сайжруулахын тулд хамт олны дунд сүлжээ бий болгох, хийгдсэн зүйлээ эргэн нягтлах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, бүсийн болон орон нутгийн түвшинд тухайн аль нэг чиглэлээр “хамт олон” бий болгон ажиллах нь чадавхийг бэхжүүлэх маш хүчтэй арга хэрэгсэл юм. Гэхдээ хийнгээ суралцах, тухайн чиглэлээр ажиллаж буй хүмүүсийн “хамт олон” бий болгох нь цаг хугацаа, хөрөнгө нөөц

шаардсан ажил билээ.

ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Өмнөх хэсгүүдэд бид судалгааны явцад чадавхийг бэхжүүлэх талаар хүрсэн амжилтынхаа талаар тоймлон дурдлаа. Ийм амжилтанд хүрсэн боловч цаашид суралцах зүйл бас бий. Энэхүү төгсгөлийн бүлэгт бид тулгарч буй гурван бэрхшээлтэй асуудлын талаар авч үзэв.

БАЙГУУЛЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ, НИЙГМИЙН БА ЖЕНДЭРИЙН СУДАЛГААГ ҮНДСЭН ҮЙЛ ЯВЦАД НЭГТГЭН АВЧ ҮЗЭХҮЙ

Ойлголт нэмэгдүүлэх байнгын хүчин чармайлт, идэвхтэй харилцаа, хөшүүргүүд, идэвхтэй “манлайлагчид”, сайн практикийн жишээ, үр дүнтэй хяналтын систем зэрэг нь нийгмийн болон жендэрийн судалгааг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын өдөр тутмын практикт шингээхэд нэн чухал бүрдэл хэсгүүд юм. Судалгааны зургаан баг эдгээрийн аль нэг эсвэл хэд хэдэн бүрдэл хэсэг дээр ажиллаж байгаа боловч бүгдийг нь хамт авч үздэг болтол цаг хугацаа шаардагдах нь дамжиггүй. Судалгааны багууд болон судалгааны байгууллагуудын нийгэм, жендэрийн асуудлаар бэлтгэгдсэн байдал, сонирхол, туршлага харилцан адилгүй бөгөөд багууд дотроо ч туршлага, санаачлага, сонирхлын хувьд ялгаатай байх явдал ажиглагдаж байна. Байгууллага хооронд, судалгааны багууд хооронд гэж ярихаас өмнө байгууллага болон судалгааны баг дотроо ч хамтын зүтгэл, чармайлт бий болгох нь бэрхшээлтэй асуудал хэвээр байна.

Судалгааны бүх баг өөр өөрсдийн байгууллагадаа илүү их зүйл хийх хүсэлтэй байгаа бөгөөд Олон улсын хөгжлийн судалгааны төв, бусад хандивлагчдаас үргэлжлүүлэн дэмжлэг авах сонирхолтой байна. Энэ чиглэлээр дорвитой туршлага хуримтлуулсан судалгааны байгууллага бараг байхгүй тул тэдний ийнхүү сонирхох нь гайхмаар зүйл биш юм. Одоо судалгааны багууд өөрсдөө энэ талаар юу гэж бичсэнийг сонирхоё. Хятадын баг зарчмаа тодорхойлсон. Үүнд:

Энэхүү жишээлсэн судалгаа нь нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээ бол хийж ч болох, хийхгүй ч байж болох зүйл биш, харин үндсэн үйл явцад хэн нэгнийг орхигдуулж, гадуурхахгүйн тулд жендэрийн мэдрэмжтэй бодлого/журам боловсруулж, хэрэгжүүлж, удирдахад зайлшгүй хийгдэж байх ёстой зүйл юм (Олон улсын хөгжлийн судалгааны төв 2004а).

Сикким/Баруун Бенгалын баг тулгарсан зарим саад тотгорын талаар дурдсан. Тухайлбал,

Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг судалгааны үйл явцад нэгтгэх авч үзэх нь практикт тулгарч буй асуудлыг шийдэх, бэрхшээлтэй нөхцөл байдлаас гарах үйл ажиллагааны төлөвлөгөө/төсөл боловсруулахад ерөнхий, нэгдмэл дүр зураг гарган өгдгөөрөө чухал ач холбогдолтой. Гэхдээ нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг судалгааны салшгүй нэг хэсэг болгох нь ярвигтай, хэцүү асуудал юм. Учир нь бараг бүх тохиолдолд жендэрийн дүн шинжилгээг зөвхөн оношлогооны түвшинд л хийж байна. Түүнчлэн ихэнхдээ эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарийг дүрслэн үзүүлэхээс хэтэрч чадахгүй байна. Жендэрийн болон нийгмийн илүү чухал, ярвигтай харилцааны талаар шинжилгээ хийгдэхгүй байна. Үүний учир шалтгаан нь чадавхи хүрэлцэхгүй байгаагаас гадна олон нийт, хамт олон, байгууллага, хувь хүмүүс, тэр ч байтугай судлаач нарын дунд “жендэрийн хараагүйдэл” байгаа, жендэрийн асуудлыг ялган харж чадахгүй байгаатай холбоотой. Олон судлаач хүйсээс шалтгаалсан ялгаатэй зорилго, төсөөлөл, үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрч, харгалзан үзэж тэр бүр чаддаггүй. Тэд нэг бол үл хайхардаг, эсвэл огт харалгүй орхигдуулдаг. Энэ бол нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг судалгааны ертөнцөд нэгтгэн шингээхэд тохиолдож буй гол бэрхшээлдүүдийн нэг билээ (Олон улсын хөгжлийн судалгааны төв 2004г).

Непалын баг бодлого боловсруулах асуудлыг хөндсөнөөрөө асуудлыг арай өөр өнцгөөс харжээ.

Бодлогын түвшинд ажиллагчидтай харилцана гэдэг бол амаргүй ажил. Уулзалтын цаг авахад ч бэрхшээлтэй. Мөн тус концепцын талаар дутуу дулимаг ойлгох явдал их гардаг. Ярилцлага жендэрийн гэхээсээ эмэгтэйчүүдийн асуудлын тухай болж хувирах нь элбэг. Бид үе үе

ярианыхаа чиглэлийг буцааж байранд нь авчрах хэрэг гардаг. Энэ бүхнийг өндөр түвшний эрх мэдэлтнүүд тэр бүр ойлгодоггүй (Олон улсын хөгжлийн судалгааны төв, 2004в).

Нийгмийн ба жендэрийн асуудлыг хариуцдаг институцийн зохих бүтэц, байгууллага байхгүй байгаа нь судалгааны үйл явцад тулгарсан томоохон бэрхшээлийн нэг байв. Хөдөө аж ахуйн судалгаа, хөгжлийн байгууллагуудын зүгээс нийгмийн ба жендэрийн асуудлаар хийж буй ажил энд тэнд хуваагдан тархсан, зохих баримтжуулалт хийгдээгүй байна. Зөв хүнээ олж уулзах, хэрэгтэй бичиг баримтаа олоход цаг их зарцуулж байв.

Судалгаанаас илт харагдахгүй байгаа боловч анхаарал хандуулбал зохих өөр нэг бүрдэл хэсэг бий. Энэ бол судалгааны үр дүнг хөдөөгийн хөгжлийн асуудлаар ажилладаг бусад хүмүүс, тухайлбал, хөдөө аж ахуйн сургалт, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид, сургалтын мэргэжилтнүүд зэрэгт танилцуулж түгээх явдал юм. Энэхүү ном нь судалгааны хүчин чармайлт, үйл явдал, амжилт, бэрхшээлийг харуулах зөвхөн нэг л арга зам юм. Гэвч өөр бусад ямар боломж байгааг нээн илрүүлэх нь цаашид хийгдэх ёстой нэг ажил. Зарим баг тус номыг орон нутгийн хэл рүү орчуулах (жишээлбэл, Хятад), мөн түүний зарим нэг бүлгийг сургалтанд ашиглах (жишээлбэл, Хятад, Вьетнам) гэх мэт шинэ санаа олоод байна.

Тэгш Бус Байдал Болон Эмэгтэйчүүдийн Чадавхийг Бэхжүүлэх

Нэлээд хэдэн жишээнд шийдвэр гаргалт, нөөцийг ашиглах боломж, хяналт зэрэгт эрэгтэйчүүд давамгайлсан хэвээр, түүнийг нь соёл заншлын хэм хэмжээ, улс төрийн систем улам дэмжиж байгааг баримтжуулсан. Тухайлбал, Сикким/Баруун Бенгал, Непал, мөн Вьетнам, Монголын судалгаа багтана. Хятадын жишээнээс хөдөө аж ахуйд эмэгтэйчүүд ажиллах нь олширч, хэдийгээр эрэгтэйчүүд байхгүй байгаа нь тэдэнд зарим боломж, бололцоог нээж өгч буй боловч тэдний нуруун дээр буух ачаа нэмэгдэж байгааг харсан билээ. Нөөцөөс хүртэх байдал, хүмүүсийн наад захын чадавхи, өөрөө

өөрсдөө хөдөлмөрийнхөө эзэн болох, ялангуяа зах зээлд нэвтрэх боломж зэргийн тухайд жендэрийн тэгш биш байдлын янз бүрийн хүчин зүйл нөлөөлж байгааг зургаан судалгаанаас харж болохоор байна.

Сикким/Баруун Бенгалын жишээг эс тооцвол судалгаанууд бүгд аажим боловч ямар нэг өөрчлөлтөнд хүргэсэн. Өөрөө өөртөө эзэн байх буюу эрх мэдэлжих явцын үндсэн элементүүд бол нөөцийг ашиглах боломж, хяналт болон шийдвэр гаргалтанд үгээ хэлдэг, нөлөөлдөг байх явдал юм. Жишээнээс харахад эмэгтэйчүүдийн бүлгийг зохион байгуулах (Монгол, Хятад) сонирхлын бүлгийг бүрдүүлэх (Вьетнам), эсвэл аль аль нь байх; орон нутгийн түвшинд болон сүлжээгээр дамжуулан чадавхи бэхжүүлэх (Непал, Хятад, Вьетнам); янз бүрийн түвшин дэх оролцогч талуудтай түншлэл тогтоох (Непал, Хятад, Монгол); зах зээл, зах зээлийн сүлжээг бэхжүүлэх замаар байгалийн нөөцийн менежментийг тогтвортой амьжиргаатай холбох (Нагаланд, Непал, Хятад, Монгол); бодлого боловсруулах явц, бодлого боловсруулагчидтай холбох (Хятад, Монгол) гэх мэтээр өөрөө өөртөө эзэх болох янз бүрийн стратегийг ашигласан байна.

Улаанбаатарын семинарын үеэр чадавхи бэхжүүлэх асуудлыг үргэлжлүүлэн авч хэлэлцсэн бөгөөд дараах алхмуудыг тодорхойлов. Үүнд:

1. Нэг ба хэд хэдэн чиглэлээр (анги, давхарга, яс үндэс, газар эзэмшил, баялаг, мал өмчлөл) эмзэг бүлгийг тодорхойлон гаргах
2. Нийгмийг идэвхжүүлэгчдийг тодорхойлон гаргах (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд)
3. Хэрэгцээний үнэлгээ: зөвхөн хэрэгцээг төдийгүй хүмүүсийг өөртөө итгэлтэй болгох боломж, бололцоог судлах
4. Оролцоонд тулгуурласан үйл ажиллагааны төлөвлөгөө: хэн, юуг, хэрхэн, хаана, хэзээ?
5. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт
6. Оролцоон тулгуурласан хяналт-шинжилгээ, үнэлгээ (шалгуур үзүүдэлт, орон нутаг өөриймсөн хандах байдал,

олон төрлийн оролцогч талуудад тулгуурласан байдал, өрх доторх харилцаа, үүрэг)

7. Оролцоонд тулгуурласан үр нөлөөний үнэлгээ: хүссэн үр дүнд хүрээгүй бол төлөвлөгөө, үйл явцаа эргэн харж нягтлах
8. Баримтжуулалт, тархаан түгээлт: амжилттай хэрэгжсэн тохиолдлууд, алдаа дутагдал, эерэг болон сөрөг хүчин зүйлс, олон нийтийн “дуу хоолой”.

Гол асуулт бол хэнийг чадавхижуулах стратеги вэ гэсэн асуулт юм. Судалгааны стратегитэй нэгэн адил энэхүү өөрөө өөртөө эзэх байх стратеги бол оролцооны шинж чанарын хувьд харилцан адилгүй бөгөөд зөвлөлдөөнөөс хамтын ажиллагаа хүртэл, судлаачийн удирдлагаас фермийн аж ахуйтан/малчдын удирдлага хүртэл, эмэгтэйчүүдэд төвлөрсөн арга барилаас (“Эмэгтэйчүүд ба хөгжил” хандлага) аливаа тэгш биш харилцаанд (“Жендэр ба хөгжил” хандлага) төвлөрөн анхаарах хүртэл янз бүрийн түвшинд хэрэгжиж байна. *Ямар* эмэгтэй, эрэгтэй нь оролцож (ямар нь оролцож чадахгүй) байна вэ гэдэг нь илүү нарийвчлан анхаарах ёстой судалгааны асуулт юм.

Өөрөө өөртөө эзэн болох гэдэг бол үргэлжилсэн үйл явц юм. Жишээнүүд өөр хоорондоо ялгаатай боловч адил төстэй зүйлс ч байна (тухайлбал, Непал, Хятадын жишээнд эмэгтэйчүүд үрийн зах зээлийг бэхжүүлж буй байдал). “Хэний чадавхийг бэхжүүлэх болон “хэний мэдлэгийг бий болгох” тухай яригдаж байна вэ гэсэн асуудал аль ч жишээнд чухлаар тавигдаж байв. Судалгааны багууд үйл ажиллагаанд чиглэсэн байдлыг хэрхэн гүнзгийрүүлэх, нийгэм-эдийн засаг, нийгэм-улс төрийн тэгш биш байдлыг хэрхэн шийдвэрлэх талаар болон нийгмийн өөрчлөлтийг хурдасгах судлаачийн нарийн төвөгтэй үүргийн талаар эргэцүүлэн судалж байна.

Оролцооны Чанарыг Сайжруулах

Оролцоонд тулгуурласан үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа нь дүн шинжилгээ хийх, ярилцах, хэлэлцээр хийх талбар болохын зэрэгцээ санал бодлоо солилцох, санаа санаачлагаа төлөвлөхөд хувь

нэмэр болно. Энэ бол утга учиртай оролцох боломж бий болгох нь яагаад чухал вэ гэдгийг тайлбарлан өгч байгаа бөгөөд үүнийг бүхий л жишээлсэн судалгаа харуулж байна. Итгэлцэл бий болгох нэн чухал, гэхдээ үүнд цаг хугацаа, тэвчээр шаардагдана. Зохион байгуулалт хийх явцад дүрэм журмын тодорхойлолт дээр нэлээд маргаан гардаг бөгөөд судлаачид үүнд татагдан орж болох талтай. Харамсалтай нь, жишээнүүдийн ихэнх нь энэхүү татагдан орох асуудлыг хэрхэн шийдэхийг тодорхой авч үзсэнгүй. Нагаландийн судалгаанд дурдагдсан асуудал бусад судалгаанд ч хамаатай боловч нэмэлт баримтжуулалт, дүн шинжилгээ шаардлагатай. Энэхүү бүлгийн эхэнд дурдсан ишлэлийн сүүлчийн хэсгийг одоо толилуулъя.

Энэхүү судалгаа нь эмэгтэй худалдагч болон бидний хооронд сэтгэл санааны ойр дотно байдал үүссэн. Бид шийдвэр гаргагчдад нөлөөлөх хэлэлцээ хийх чадвараа сайжруулсан. Бид олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, бодлогын шийдвэр гаргагчидтай ажиллах замаар худалдагч нарын “дуу хоолойг” олон нийтэд хүргэж эхэлсэн (Олон улсын хөгжлийн судалгааны төв 20046).

Үүнээс харахад оролцоо бол өөрөө судалгааны нэг сонирхолтой сэдэв хэвээр байна. Тухайн үйл явцаас түр зуур холдож, юу болоод байна, яаж явагдаж байна вэ гэдгийг шүүмжлэлт байр сууринаас харах нь тийм ч хялбар ажил биш. Хэдийгээр оролцоог хангах тухайд ихэнх судалгаа харьцангуй богино хугацаанд маш их ахиц гаргасан боловч оролцооны чанарыг сайжруулах тал дээр сайжруулах зүйл нэлээд байна. Вьетнамын багийн ажигласанчлан (6 дугаар бүлэг), хүмүүс дуу хоолойгоо илэрхийлэх орчин бүрдүүлэхийн тулд энэ чиглэлээр ажиллагчид зохих ур чадвар, туршлага, хандлагатай байх шаардлагатай. Эмэгтэйчүүд, ялгаварлагдсан хүмүүсийн оролцооны чанарыг сайжруулах нь бэрхшээлтэй асуудал хэвээр байна.

Мэдээлэл, мэдлэг бол үнэ цэнэгүй зүйл биш гэдгийг санаж, зарим мэдээлэл, мэдлэг нь зарим хүмүүсийг чадавхижуулж байгаа боловч заримыг нь орхигдуулж байж болзошгүй гэдгийг анзаарч байх нь зүйтэй. Мэдлэг бол хэзээд нийгэм дотор бий болж байдаг. Оролцооны өөр өөр хэлбэр нь судалгааны дүнд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэн шинжилж, эргэцүүлэн бодох хэрэгтэй байна. Оролцооны урлаг, шинжлэх ухааныг эзэмших нь насан туршийн

ажил билээ.

Макро Хүчин Зүйлсийн Нөлөө

Орон нутгийн иргэдэд хувьчлал, төрийн шинэчлэл, даяаршил зэрэг нийгмийн ерөнхий түвшинд явагдаж буй үйл явц хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаанууд янз бүрийн дүр зургийг харуулсан билээ. Хятадын судалгаа Дэлхийн худалдааны байгууллагын (тус орон саяхан уг байгууллагад нэгдэн орсон нь чухал асуудал юм) талаар дурдаад, хөдөө аж ахуйтнууд, ялангуяа ядуучууд bevaoured болсон эсэхийг асуулт болгон тавьсан байна. Вьетнамын судалгаа нь макро-эдийн засгийн амжилт өндөр, тодорхой хугацаагаар үргэлжилж байгаа боловч ядуурал буурахгүй хэвээр байгаа бөгөөд хөгжлийн нэг чухал асуудал болоод байгааг тэмдэглэсэн. Түүнчлэн ядуурлыг бууруулах асуудлыг байгалийн нөөцийн менежменттэй хослуулах нь зөвхөн нутгийн иргэдэд төдийгүй улс үндэсний хувьд чухал асуудал гэдгийг онцлон дурдсан билээ. Хятад, Непалын хувьд ч дээрхтэй адил төстэй дүгнэлт хийж болох юм.

Орон нутгийн хамтлаг болон үндэсний түвшний байгууллага, бодлого боловсруулагчдын хооронд холбоо тогтоох нь орон нутгийнхан өөрсөддөө илүү хэрэгтэй үйлчилгээг шаардах, бодлогын асуудалд нөлөөлөхөд (харилцан адилгүй хэмжээгээр) тусалдаг болохыг судалгаанууд харуулж байна. Үүнд орон нутгийн төлөвлөлтийн үйл явцад засгийн газрыг оролцуулах замаар орон нутгийн сонирхол, асуудлыг тусгах явдал багтана. Мөн туслалцаа дэмжлэг, мэдлэг туршлага дамжуулах явдлыг өөрчлөн чиглүүлэхэд ч хувь нэмэр оруулна.

Хэдийгээр цаашид гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийх шаардлагатай ч дээр дурдсан үйл явц нийгмийн болон жендэрийн хувьд төвийг сахисан байж чадахгүй байгааг судалгаанууд харуулж байна. Түүнчлэн эдгээр үйл явц угаасаа яг адил биш, илэрч буй хариу үйлдэл ч янз бүр байна. Энэ бол онолын хөгжилд нэмэр болон чухал эмпирик үр дүн юм. Учир нь өдөр тутмын амьдралд гарч буй

ялгаа нь хэдий жижиг ч түүнийг харгалзан үзэх шаардлагатай билээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Олон улсын хөгжлийн судалгааны төв (2004а). Хятадын жишээлсэн судалгааны төгсгөлийн тайлан, Оттава: Олон улсын хөгжлийн судалгааны төв
- (2004б). Нагандийн жишээлсэн судалгааны төгсгөлийн тайлан. Оттава: Олон улсын хөгжлийн судалгааны төв
- (2004в). Непалын жишээлсэн судалгааны төгсгөлийн тайлан. Оттава: Олон улсын хөгжлийн судалгааны төв
- (2004г). Сикким/Бенгалын жишээлсэн судалгааны төгсгөлийн тайлан. Оттава: Олон улсын хөгжлийн судалгааны төв
- Рулин, Н. (2002). Хувь хүний хүсч буй зүйлээс цааш даван гарах нь: Нөөцийн асуудалд олон талт мэдлэгээс тархмал мэдлэгт шилжихүй.

Зохиогчид болон хянан тохиолдуулагчдын талаарх хэдэн үг

Энэхүү Номыг Зохиогчийн Тухайд

Ронный Верной бол Канадын Оттава дахь Олон улсын хөгжлийн судалгааны төвийн байгаль орчин, байгалийн нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн юм. Тэрээр Нидерландын Уагенингений их сургуулиа хөдөөгийн хөгжлийн социологийн чиглэлээр докторын хамгаалсан бөгөөд тус төвд 1992 оноос хойш ажиллаж байгаа юм. Түүний судалгааны сонирхол бол хөдөөгийн хөгжил, байгалийн нөөцийн менежмент (хөдөө аж ахуйн биологийн төрөл зүйл), фермийн аж ахуйтнууд болон малчдын туршилт, зохион байгуулалт, оролцоонд тулгуурласан үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа, түүний дотор, нийгмийн ба жендэрийн дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ зэрэг юм. Доктор Верной Никарагуад хөдөөгийн хөгжлийн хэд хэдэн төслийг хэрэгжүүлж, удирдсан бөгөөд одоо Хятад, Куба, Монгол, Вьетнамд олон нийтэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн судалгаанд тусалж байна.

Ронный Верной судалгааны олон тооны өгүүллэгээс гадна хэд хэдэн ном зохиож, хамтран бичиж, хянан тохиолдуулсан байна. Үүнд *Хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн тогтвортой менежментийн талаарх оролцоонд тулгуурласан судалгаа, хөгжил: эх сурвалж* (хамтран хянан тохиолдуулсан, 2003), *Үр тарианы үр шим: оролцоонд тулгуурласан ургамлын үржүүлэг* (2003), *Чадавхийн хөгжлийг үнэлэхүй: олон улсын судалгаа, хөгжлийн байгууллагуудын туршилагаас* (хамтран зохиосон, 2003), *Байгаа юмаа хайрлан амьдрахуй: Никарагуагийн Карибын эрэг дэх оролцоонд тулгуурласан байгалийн нөөцийн менежмент* (хамтран зохиосон, 2000) зэрэг багтана.

Энэхүү Номыг Бичилцсэн Хүмүүсийн Талаар

Э.Булган хэл шинжлэлийн чиглэлийн мэргэжилтэн. Тэрээр 2001 оноос Байгаль орчны яам болон Олон улсын хөгжлийн

судалгааны төвийн хамтарсан төсөл болох “Монгол дахь хамтын эзэмшлийн байгалийн нөөцийн тогтвортой менежмент” төслийн нарийн бичгийн дарга, судалгааны туслах ажилтнаар ажиллаж ирсэн. Түүний сонирхон судалдаг судалгааны сэдэв нь нутгийн иргэдэд түшиглэсэн бэлчээр болон байгалийн нөөцийн менежмент, оролцоонд тулгуурлсан судалгаа, байгалийн нөөцийн менежмент дэх нийгмийн болон жендэрийн судалгаа зэрэг болно. Тэрээр 2005 оноос Тайланд улсын Чанг-Майн их сургуульд тогтвортой хөгжлийн чиглэлээр магистрын судалгаанд суралцаж байна.

Лиз Фажбер бол Олон улсын хөгжлийн судалгааны төвийн Нью Дели дэх Зүүн Азийн бүсийн төвийн ахлах ажилтан юм. Тэрээр хөдөөгийн хөгжил, байгалийн нөөцийн менежментийн хөтөлбөрүүдэд илүү идэвхтэй оролцдог. Түүний сонирхдог чиглэл гэвэл нийгмийн болон жендэрийн тэгш эрх, нөөцийг ашиглах боломж болон эзэмшлийн асуудлууд, орон нутгийн болон уугуул иргэдийн мэдлэг, технологи, оролцогч олон талыг хамарсан арга хандлага, хэрэглээний судалгаанд олон нийтийг оролцуулах, тэд судалгаанаас ашиг хүртдэг байх тухай асуудал зэрэг юм. Тэрээр МакЖиллийн их сургуульд антропологиин чиглэлээр суралцаж магистрын зэрэг авсан байна.

Чанда Гурунг Энэтхэгийн Жавахарлал Неругийн Их сургуулийн Олон улс судлалын сургуулиас магистр, докторын зэрэг хүртсэн. Түүний судалгааны ажлын гол чиглэл нь хөгжилд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, эмэгтэйчүүдийн эрх, тэднийг ялгаварлан гадуурхаж буй асуудал юм. Одоогоор Непалын Катмандуд ажиллаж байгаа бөгөөд жендэр (байгалийн нөөцийн менежмент, хөдөө аж ахуй болон уугуул иргэдийн мэдлэг), тогтвортой амьжиргаа, оролцоонд тулгуурласан судалгаа ба хөгжлийн чиглэлээр олон төсөлд судлаач, зөвлөхөөр ажиллаж ирсэн. Тэрээр зүүн Гималайн бүс (Непалын зүүн, Энэтхэгийн зүүн хойд хэсэг), Непалд ажиллаж, туршлага хуримтлуулжээ. Жендэр, хөдөө аж ахуйн асуудлаарх хэд хэдэн бүтээлээс гадна хөдөө аж ахуйн салбарт оролцооны аргыг

ашиглах талаар бүтээлээ хэвлүүлсэн байна. Түүнчлэн байгалийн нөөцийн менежмент, амьжиргаан дахь эмэгтэйчүүд, жендэрийн асуудлаар голлон ажилладаг төрийн бус байгууллага болох Зүүн Гималайн Уугуул Эмэгтэйчүүдийн сүлжээ гэдэг байгууллагыг үндэслэгчдийн нэг бөгөөд зохицуулагчаар нь ажиллаж байна.

Навраз Гурунг Энэтхэгийн Худалдааны яаманд хөдөө аж ахуйн сургалт хариуцсан ажилтнаар хөдөлмөрийн гараагаа эхэлсэн бөгөөд одоо Сикким дэх Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй таримал ургамлын хөтөлбөрийн зохицуулагчаар ажилладаг. Мөн Зүүн Гималайн санаачлага гэдэг төрийн бус байгууллагад зохицуулагчаар ажиллаж байна. Оролцоонд тулгуурласан технологийн хөгжил болон аргачлалын асуудал бол түүний сонирхон ажилладаг чиглэл юм.

Хоанг Ти Сен ойн аж ахуй, хөдөө аж ахуйн мэргэжилтэн. Тэрээр Тайландын Чиан Майн их сургуулиас байгалийн шинжлэх ухааны магистр цол хүртсэн бөгөөд Швейцарын Хөдөө аж ахуйн их сургуульд докторын зэрэг авахаар суралцаж байна. 1995 оноос хойш төслийн болон хөгжлийн ажилтнууд, хөдөө аж ахуйтнуудад оролцоонд тулгуурласан судалгааны талаар сургалт явуулж ирсэн. Одоогийн байдлаар хөдөө аж ахуйтнуудын оролцоо бүхий судалгаа, жендэрийн дүн шинжилгээг илүү сонирхон ажиллаж байна. Тэрээр нийгмийн болон жендэрийн судалгаа хийнэ гэдэг бол тухайн нөхцөл байдлыг ойлгоод зогсохгүй тэр нутгийн хүмүүсийг чадавхижуулж, хөрөнгийг нэмэгдүүлнэ гэсэн үг гэж үздэг байна.

Чозулье Кики Энэтхэгийн Нагаландийн Таримал ургамлын яаманд Сургалтын хэлтсийн дэд даргаар ажилладаг. Тэрээр анхан шатны түвшний эмэгтэйчүүдтэй ажилладаг бөгөөд тэдэнд хөдөө аж ахуйн хаягдал бүтээгдэхүүнийг ашиглан гэрээр хүнсний зүйл боловсруулах, органик хүнсний ногоо тарих, мөөг тарих зэргээр орлогоо нэмэгдүүлэхэд нь тусалдаг. 1996-2000 онд Нагаландийн Байгаль хамгаалал, эдийн засгийн хөгжлийн төслийн жендэрийн

асуудал хариуцсан зохицуулагчаар ажилласан бөгөөд уг төслийн 15 ажилтнаас зөвхөн Чожуле эмэгтэй байв. Тэрээр төслийн хүрээнд жэндэрийн асуудлаар хуримтлуулсан туршлага, мэдлэгээ үндэсний болон олон улсын түвшинд танилцуулсан. Одоо уг төслийн хоёр дахь шатны хүрээнд фермийн аж ахуйтнуудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд Кохима, Перен мужийн Ангами, Зелиан омгийнхны тогтвортой амьжиргааг хангах зорилготой юм. Тэрээр Пунжабын Хөдөө аж ахуйн их сургуульд байгалийн шинжлэх ухааны чиглэлээр суралцаж, бакалаврын зэрэг авсан байна. Мөн Дели, Бангалор, Соланд хүнсний үйлдвэрлэл, мөөг ургуулах чиглэлээр, Японд органик бүтээгдэхүүн тарьж ургуулах чиглэлээр сургалтанд хамрагджээ.

Ли Ван Ан Вьетнамын Хью хөдөө аж ахуй, ойн аж ахуйн их сургуулийн ахлах багш. Тэрээр мал аж ахуйн мэргэжилтэн бөгөөд Швейцарын Хөдөө аж ахуйн их сургуулиас саяхан докторын зэрэг хүртсэн (өмнө нь тус сургуульд суралцаж байгалийн шинжлэх ухааны магистр цол авсан байв). Мөн Хью их сургуулийн гадаад харилцаа хариуцсан захирлаар ажилладаг бөгөөд хөдөөгийн хөгжил, амьжиргааны асуудлыг сонирхон судалдаг. Анхаарлын гадуур орхигдон үлдсэн хүмүүстэй хамтран оролцоонд тулгуурласан үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа хийх нь түүний сонирхдог нэг онцлог чиглэл юм. Швейцарын олон улсын хөгжлийн агентлаг, Форд сан, Олон улсын хөгжлийн судалгааны төв зэрэг хандивлагч байгууллагаас санхүүждэг судалгааны хэд хэдэн төсөл дээр зохицуулагчаар ажиллаж байна.

Венгота Накро Энэтхэгийн Нагаландийн Хөрс, усны хамгаалал хариуцсан яаманд орлогч даргаар ажилладаг. Мөн “Эдийн засгийн хөгжлөөр дамжуулан хүмүүсийн чадавхийг бэхжүүлэх” гэдэг төслийн гишүүн. Түүний ажлын гол чиглэл нь хөдөө аж ахуйд ажиллагчид тогтвортой амьжиргаагаа хангахад нь хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх явдал юм. Одоогоор Коньяк омгийн хүмүүстэй хамтран ажиллаж байна. Пунжабын их сургуулиас хөдөө аж ахуйн

чиглэлээр бакалаврын зэрэг, Германы Гёттингений их сургуулиас байгалийн шинжлэх ухааны магистр цол хүртсэн.

Б.Наранчимэг Монгол улсын их сургуулийн Эдийн засаг, менежментийн сургуулийг төгссөн. Одоо тус сургуульд магистрын зэрэг авахаар суралцаж байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй тус сургууль дээр байгуулагдсан Хүн амын сургалт, сурталчилгааны төвд судлаачаар ажилладаг. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны багийн нэг идэвхтэй гишүүн байсан. Түүний судалгааны гол чиглэл нь жендэр, хөгжил, хүн ам зүйн асуудлууд, мөн ядуурал, байгаль орчин, хүүхдийн хөдөлмөр зэрэг юм.

Ц.Одгэрэл нийгмийн ухааны чиглэлээр ажилладаг бөгөөд Монгол улсын их сургуулийн Нийгмийн ухааны факультетэд суралцан, магистрын зэрэг хамгаалсан. Монгол Улсын Их Хурлын Судалгааны төвийн нийгэм, эдийн засгийн секторт эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллан хөдөлмөрийн гараагаа эхэлсэн. Жендэр, нийгмийн ялгарал, эмэгтэйчүүдийн хөдөлмөр, байгалийн нөөцийн менежмент дэх эмэгтэйчүүдийн оролцоо, оролцооны судалгаа, оролцооны хяналт шинжилгээ үнэлгээ зэрэг сэдвийг сонирхон судалдаг. Зохистой хөгжлийн жендэр төвд судлаачаар ажиллаж байсан.

Питамбер Шреста нийгмийн ухааны чиглэлээр ажиллаж ирсэн. Хөдөөгийн хөгжил, ялангуяа хөдөөгийн иргэдийг чадавхижуулах, орон нутагт институцуудыг бий болгох, анхан шатны түвшний байгууллага, бүтцийг хөгжүүлэх зэрэг асуудлаар мэргэжсэн. Түүнчлэн оролцоонд тулгуурласан ургамал үржүүлгийн чиглэлээр 1992 оноос хойш сонирхон ажиллаж иржээ. Одоо Непалын “Агро-биологийн төрөл зүйлийг хадгалах шинжлэх ухааны үндсийг бэхжүүлэх нь” төслийн ажилтан. Уг төсөл нь Ромд төвтэй Олон улсын ургамлын генетикийн нөөцийн хүрээлэнгээс хэрэгжүүлж буй олон улсын төслийн нэг бүрдэл хэсэг бөгөөд хөдөө аж ахуйн

биологийн төрөл зүйлийг тогтвортой хадгалан хамгаалахын тулд нутгийн иргэдэд түшиглэсэн биологийн төрөл зүйлийн менежментийн зөв практикийг нэвтрүүлэх зорилготой юм.

Дина Сингх таримал ургамал үржүүлэгч мэргэжилтэй. Тэрээр хөдөө аж ахуйн биологийн төрөл зүйл, байгалийн нөөцийн менежмент, оролцоонд тулгуурласан болон үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа, жендэрийн судалгаа, ургамлын үржүүлэг зэргийг сонирхон судалдаг. Ихэвчлэн Непалд судалгаагаа явуулдаг. Бангалорын Хөдөө аж ахуйн их сургуульд суралцсан бөгөөд 2003-2004 онд “Агро-биологийн төрөл зүйлийг хадгалах шинжлэх ухааны үндсийг бэхжүүлэх нь” төсөл дээр ажилласан. Одоо Непалын Хөдөө аж ахуйн судалгааны зөвлөлд судлаачаар ажиллаж байна.

Ючин Сон хөдөөгийн хөгжил, фермийн аж ахуйтнуудын (эмэгтэй) зохион байгуулалт, хөдөө аж ахуйн сургалтын асуудлыг голлон судалдаг. Нидерландын Уагениген их сургуульд харилцаа, шинэчлэлийн чиглэлээр суралцан докторын зэрэг хүртсэн. Оролцоонд тулгуурласан ургамал үржүүлгийн талаар өргөн мэдлэгтэй бөгөөд фермийн аж ахуйтнуудын үрийн систем болон Хятадын засгийн газрын хооронд хамтын ажиллагаа бий болгох зорилго бүхий судалгааны төслийн удирдагчаар ажиллаж байсан. Одоо Бээжин дэх Хятадын Хөдөө аж ахуйн бодлогын судалгааны төвд ахлах судлаачаар ажиллаж байна. Хэд хэдэн сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэхийн зэрэгцээ хэд хэдэн номыг хамтран зохиожээ.

Анил Субеди хөдөө аж ахуйн сургалтын чиглэлээр мэргэжсэн. Хөдөөгийн хөгжил, байгалийн нөөцийн менежмент, хөдөө аж ахуйн биологийн төрөл зүйл, үрийн албан бус систем, хөдөөгийн иргэдийн зохион байгуулалт болон сүлжээ, оролцоонд тулгуурласан судалгааны аргачлал, тохиромжтой технологи, шинэчлэл зэрэг асуудлыг сонирхон судалдаг бөгөөд ихэвчлэн Непал, Өмнөд Азид тулгуурлан судалгаагаа хийдэг. 1971-1995 оны хооронд Ламле Хөдөө аж ахуйн судалгааны төвд, 1996-2003 онд “Агро-биологийн төрөл

зүйлийг хадгалах шинжлэх ухааны үндсийг бэхжүүлэх нь” төсөлд оролцон ажилласан. Харин 2003 оноос хойш Непалын Технологийн хөгжлийн бүлэгт захирлаар ажиллаж байна.

Х.БХанбай Монгол улсын Байгаль орчны яамны Ой/бэлчээрийн бодлого, зохицуулалтын газрын даргаар ажилладаг. Тэрээр “Нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн тогтвортой менежмент” төслийн судалгааны багийн ахлагч юм. Тус төслийг Олон улсын хөгжлийн судалгааны төвийн дэмжлэгтэй хэрэгжүүлж байна. Тэрээр Санкт Питербургийн Ойн инженерийн академийг төгссөн бөгөөд тус академээс байгалийн нөөцийн эдийн засгийн чиглэлээр докторын зэрэг хүртсэн. Түүнчлэн Харвардын их сургуулийн байгаль орчны эдийн засаг, макро эдийн засгийн бодлого байгалийн нөөцийн менежментийн сургалтанд хамрагджээ.

Линшу Зан Хятадын Шинжлэх ухааны академийн Хөдөө аж ахуйн бодлогын төвийн ахлах судлаач бөгөөд орлогч дарга юм. Тэрээр хөдөөгийн хөгжлийн бодлогын судалгааны чиглэлээр 20 гаруй жил ажиллаж байгаа бөгөөд газар өмчлөх эрх болон түүний жендэр, нөөцийн менежментэд нөлөөлж буй байдал, хөдөөгийн ажиллах хүчний зах зээлийн хөгжил, жендэр ба ядуурал, хөдөө аж ахуй болон хөдөө нутаг дахь улсын хөрөнгө оруулалт зэрэг чиглэлийг сонирхон судалдаг. Англи, Хятадын сэтгүүлдүүдэд нэлээд олон бүтээлээ нийтлүүлжээ.

Азий орнуудын нийгэм , эдийн засаг нь янз бүр байгаад зогсохгүй даяарчлал, өмч хувьчлал зэрэг асар худацтай өөрчлөлтүүдийг даван туулж байгаа билээ. Жендер, нийгмийн давхарга, хэл соёл, шашин шүтлэг зэрэг нийгэм дэх олон асуудлууд нь байгалын нөөцийн менежмент, түүнтэй холбогдох харилцаа, шийдвэр гаргах үйл ажиллагаа зэрэгт гол үүрэгтэй болж байна. Нийгмийн бодит байдлыг зөвөөр ойлгох энэхүү шаардлага нь шударга хуваарилалт бий болгох мөн бодлогыг хөгжүүлэхэд оролцоог нэмэгдүүлэхийг нөхцөлдүүлж байна.

Энэхүү ажилд бичигдсэн өгүүлэлүүд ба үзэл санааны тусалууд нь Хойд болон Зүүн Хойд Азид хэрэгжүүлэгдэж буй нийгмийн болон жендерийн судалгааг эрхлэх байгалийн нөөцийн менежментийн судлаачидын ажлын үр дүн болно. Бодит туршлага дээр тулгуурласан энэхүү зургаан судалгааны ажил нь Энэтхэг, Непал, Хятад, Вьетнам болон Монгол зэрэг орнуудад хийсэн юм.

Эдгээрт:

- Нийгэм ба жендерийн асуудлуудыг макро ба микро түвшинд авч үзсэн
- Санал болгохуйц газар дээр нь очиж судалсан олон янзын судалгааны аргуудыг нийгэм ба жендерийн шинжилгээний судалгаандаа нэгтгэсэн мөн энэхүү ажилд нөлөөлөх бүхий хүчин зүйлүүд бололцоо нөхцөлийг тоймлож тодотгосон
- Бэлчээрийн менежмент ба тогтвортой хөгжил, газар тариалангийн салбарт дахь ургац болон хөдөө аж ахуйд малын тоо толгойн өсөлт, мөн биологийн төрөл зүйлийн хамгаалалт зэрэг олон асуудлуудыг тал бүрээс нь дүрслэн үзүүлсэн
- Чадавхыг бэхжүүлэх асуудлыг олон талт байдлаар нь туршин судалсан зэргийг харах боломжтой.

Энэ ном нь мөн дээрх зургаан судалгааны ажилд харьцуулалттай шинжилгээ хийж дүгнэлт өгсөн болно. Тэдгээр асуудлуудад байгууллагын өөрчлөлт, нийгэм болоод жендерийн асуудал, эмэгтэйчүүдэд тулгарч буй тэгш бус харилцаа, мөн оролцооны чанарыг дээшлүүлэх зэрэг нэн чухал зүйлүүд хөндөгдсөн юм. Эдгээр Азийн таван оронд тулгуурласан туршлага болоод шинжлэх ухааны судалгааны бүтээлийг агуулсан энэ ном нь хөдөөгийн хөгжил болон байгалийн нөөцийн менежментийг судалдаг оюутан болон мэргэжилтнүүдэд ихээхэн түлхэц болохуйц чухал материал болно. Сэдвийн хувьд өргөн хүрээг хамарсан – газар тариалангийн маркетингаас эхлэн эмэгтэйчүүд ба хөгжил , байгаль орчин ба нийгэм судлал зэргийг багтаасан -тул эрдэмтдэн, мэргэжилтнүүдийн сонирхолыг татахуйц бүтээл болж чадсан билээ.

Ронный Верной нь Канад улсын Оттава хот дахь Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төвийн Байгаль Орчны ба Байгалийн Нөөцийн Хөтөлбөрийн Ахлах Мэргэжилтэн юм.

Дэмжин тусалцаа үзүүлсэн

Е. Булган • Лиз Фажбер • Чанда Гурунг • Навраж Гурунг • Хоан Ти Сен • Чозүле Кики • Ле Ван Ан • Венгота Накро • Б. Наранчимэг • Ц. Одгэрэл • Питамбер Шреста • Дипа Сингх • Ичин сон • Анил Сүбэди • Ронный Верной • Х. Ыханбай • Линшу Жан

Хавтасны загварыг Шибаны Баббар, Суяна Далайа нар болон хавтасны фото зургийг Ронный Верной (ОУХСТ) бүтээв.

ISBN 978-99929-0-118-7



9 789992 190118 2 >